



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ
ДУНД БҮЛЭГ



УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ	2
1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц	2
1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя	2
1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ	8
2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай	8
2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол	10
2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй	12
ГУРАВ ДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	21
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IX САР	21
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР	31
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР	38
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XII САР	49
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - I САР	60
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР	71
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - III САР	87
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IV САР	103
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР	115

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц

Энэхүү гарын авлага нь сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөр болон долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрийг ойлгох, ухагдахуунуудыг тайлж уншихад дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд багш нарт онолын мэдлэг, арга зүйн чиглэл, практик жишээ, зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжилд чиглэсэн чанартай сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх чадварын хөгжлийг дэмжих зорилготой.

Та бүхэн гарын авлагатай танилцахын зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөрөөс философи, онол, арга зүйн үндэс, суурь зарчим, бүтцийг сайтар судлаарай. Мөн долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрөөс бүтэц, чадвар, суралцахуйн үр дүн, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэсгүүдийг уялдуулан харах хэрэгтэй.

Багшийн гарын авлагын Нэгдүгээр бүлгээс суралцахуйн үр дүн болон бусад гол ухагдахуунуудын талаар цэгцтэй, дэлгэрэнгүй ойлголт авахын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэрхэн жил, сар, долоо хоногоор төлөвлөхийг харах боломжтой.

Хоёрдугаар бүлгээс сургалтын хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс, хэрэгжүүлэх арга зүй нь сургалт, үйл ажиллагааны төлөвлөлттэй хэрхэн уялдаж байгаатай танилцана уу.

Гуравдугаар бүлгээс жил, сар, долоо хоногийн төлөвлөлтөд хэд хэдэн чиглэлийн суралцахуйн үр дүнг хэрхэн нэгдмэл байдлаар авч хэрэгжүүлж болох жишээтэй танилцаарай. Жишиг сарын төлөвлөлтөөс хичээлийн жилийн турш суралцахуйн үр дүнгүүдийг (НСХ 3.1а, МАТ3.2а гэх мэт) нэгтгэж харах, төлөвлөх, хянах боломжтой. Энэ бүлэг дэх нэгдмэл үйл ажиллагаанууд нь та бүлгийнхээ хүүхдүүдийг тодорхой суралцахуйн үр дүнд хүргэхийн тулд санаа авч хэрэгжүүлж болохуйц арга, ажиллагааны жишиг гэдгийг сайтар санаарай. Эдгээр жишиг үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөх, санаа авч өөрсдийнхөөр шинээр төлөвлөх боломжтой юм.

Мөн энэхүү гарын авлагаар хүүхдийн суралцахуйг анги танхимаас гадна эцэг эхтэй хамтран гэр бүлд нь хэрхэн үргэлжлүүлж болох талаар жишиг санааг тусгаж өгсөн.

Багш нар гарын авлагаа ашиглан хамтран төлөвлөх, харилцан хичээлд суух, эргэцүүлэх, туршлагаа хуваалцах замаар мэргэжлийн тасралтгүй хөгжлөө дэмжих боломжтой бөгөөд энэхүү гарын авлага нь шинэ, залуу багш нарыг сургах, чиглүүлэхэд тохиромжтойгоор боловсруулагдсан.

1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя

Чадамжид суурилсан хөтөлбөр

Чадамж гэдэг нь 1. Мэдлэг (юуг мэдэх), 2. Чадвар (яаж хийх), 3. Хандлага (ямар үнэт зүйл, зан төлөвтэй байх) гурвын нэгдлийг хэлнэ. Хөтөлбөр чадамжид суурилна гэдэг нь хүүхэд ямар нэгэн мэдээллийг цээжлээд өнгөрөх төдий бус харин амьдралд хэрэглэх мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сэтгэлгээний арга барил эзэмшихэд чиглэнэ гэсэн үг юм.

Сургалтын хөтөлбөр нь хүүхдийг оюун санааны дархлаатай, аз жаргалтай насан туршдаа суралцах чадамжтай болгохыг гол зорилгоо болгосон. Хөтөлбөрийн агуулга, арга

зүй нь хүүхэд бүрийн оролцоонд суурилсан үйл ажиллагаагаар дамжуулан ирээдүйд суралцах суурь чадвар бүхий бие хүн болгож төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөр, гарын авлагын уялдаа

Багш нь сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлагыг хамтад нь хослуулан хэрэглэнэ. Ингэхдээ сургалтын хөтөлбөрөөс хүүхдүүдийн ямар чадамжийг хөгжүүлж ямар суралцахуйн үр дүнд хүргэхээр зорьж байгаагаа харна. Харин багшийн гарын авлага дээрх санал болгосон жишгүүдээс арга зүйн санаа авна.

Сургалтын хөтөлбөрөөс харах зүйлс	Багшийн гарын авлага дээр хэрхэн буусан бэ?
Хөтөлбөрийн үзэл баримтлалд тулгуурлан эзэмшүүлэх чадамж, суралцахуйн зорилт, хөгжлийн ай, дэд ай, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.	Хөтөлбөр дахь суралцахуйн зорилтод чиглэсэн нас, хөгжлийн онцлогт тохирсон жишиг арга зүй, өдөр тутмын үйл ажиллагаа санал болгосон.
Суралцахуйн үр дүн бүрээр 2-5 настай хүүхдэд хөгжлийн 4 түвшнийг тодорхойлсон.	Түвшин бүрд жишиг үйл ажиллагаа санал болгохын зэрэгцээ СҮД-гүүдийн залгамж холбоог хангах арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
Сургалтын долоон чиглэлийн хүрээнд нэгдмэл арга зүй баримтлахаар боловсруулсан.	Сургалтын чиглэл дэх айнуудыг сэдэвт үйл ажиллагаагаар нэгтгэж болох жишээ санал болгосон.

Сургалтын хөтөлбөр, гарын авлагын бүтэц

Нэн түрүүнд сургалтын долоон чиглэл, эдгээрт тодорхойлсон хөгжлийн дөрвөн түвшин, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгууруудыг нарийн танилцаж ойлгох нь чухал юм.

Сургалтын чиглэл. Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн хөгжлийн чиглэлд үндэслэн дараах 7 чиглэлээр боловсруулсан. Үүнд: 1) Нийгэм-сэтгэл хөдлөл; 2) Хөдөлгөөн, эрүүл мэнд; 3) Хэл яриа; 4) Байгаль, нийгмийн орчин; 5) Математик; 6) Зураг, урлал; 7) Хөгжим; зэрэг юм.

Хөтөлбөрийн сургалтын чиглэл бүр нь чадвар, тухайн чадварын ай, дэд айгаас бүтнэ. Дэд ай бүр 1-4 түвшинд тодорхойлогдсон суралцахуйн үр дүнтэй. Жишээ нь: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын чиглэл *"Хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмж, харилцаа, хүмүүнлэг байдлын талаар ойлголт мэдлэгтэй бусадтай эергээр харилцах, хамтрах, зан үйлээ хариуцлагатайгаар удирдан зохицуулах чадвартай, өөрт болон бусдад төдийгүй нийгэмдээ энэрэнгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй хандлагатай болж төлөвших"* чадварыг эзэмшүүлэхийг зорих бөгөөд үүний тулд 1. Өөрийгөө таних; 2. Бусадтай харилцах; 3. Харилцан хамаарал гэсэн гурван айтай, ай тус бүр гурван дэд айн хүрээнд нийт 36 суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна.

Суралцахуйн үр дүн (СҮД). Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийн хувьд хүрэх үр дүнг "Суралцахуйн үр дүн" гэж нэрлэсэн. Тиймээс "Суралцахуйн үр дүн" нь мөн сургалтын хөтөлбөрийг амжилттай эзэмшсэн суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх түвшингийн илэрхийлэл болно.

Суралцахуйн үр дүнгийн хүрэх түвшин. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд эзэмшүүлэх чадварыг дөрвөн түвшинтэй боловсруулсан. Энэхүү хөтөлбөрөөр эзэмшүүлэх чадварын түвшин нь сургуулийн өмнөх боловсролын зохион байгуулалтын түвшингээс тусдаа ойлголт болно. Өөрөөр хэлбэл, хүүхэд бүрийн хөгжлийн хурд, явц ялгаатай учраас эзэмших чадварын 4 түвшин нь бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт дүйцэх албагүй юм.

Суралцахуйн үр дүн ба чадамж. Суралцахуйн үр дүнгүүд нь хүүхдийн ерөнхий болон суурь чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-д чиглэнэ. Ингэхдээ хүүхдийн өмнөх мэдлэг, төсөөлөл, амьдралын туршлагад тулгуурлан аливаа зүйлийг сонирхон судалж, эргэцүүлэн таамаглаж тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадамж хандлагыг хөгжүүлэх юм.

Нэгдмэл арга зүй. Суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд багш нэгдмэл арга зүйг хэрэглэнэ. Нэгдмэл арга зүй нь сургалтын хэд хэдэн чиглэлийг хамарсан, олон талт, нарийн нийлмэл, оролцоонд тулгуурласан хэлбэртэй байна. Нэгдмэл арга зүйд ямар сургалтын загвар, хэлбэрийг авч ашиглах нь багшийн өөрийн шийдэл боловч энэхүү гарын авлагын хүрээнд дараах дөрвөн арга зүйг жишээ болгон авч үзсэн. Үүнд: Тоглоомд суурилсан; Зохиолд суурилсан; Сонирхон судлахад суурилсан; Төсөлд суурилсан зэрэг болно. Эдгээр арга зүйгээр өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, өдрийн хуваарьт (хүлээн авалт, тойргийн цаг, чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, төвийн үйл ажиллагаа, зугаалгын цаг, хөгжөөн баясах үйл ажиллагаа, номын цаг ... гэх мэт) цагуудад зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг цогцоор нь багтаасан.

Багш та төлөвлөлтөө хийхдээ өдрийн хуваарьт үйл ажиллагааг бүтцийн дагуу зохион байгуулахад анхаараарай. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлогийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлог

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны онцлог
Тойргийн цаг	Өдрийг амжилттай эхлэхийн нэг үндэс нь өглөөний тойргийн цагт хийгдэж буй ажлын төлөвлөлт байдаг. Тухайн өдрийн судлах зүйлийн талаар суурь ойлголт авах боломж олгодог. Тойргийн цаг нь: - Мэндчилгээ - Ярилцлагаас бүрдэнэ.
Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багшийн заавар, тодорхой зорилго, аргачлалтайгаар танин мэдэхүй, хэл яриа, бие бялдар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг. - Тоолох, ангилах, ялгах - Туршилт хийх - Сонсох, ярих, санаа бодлоо үйл явдлын дагуу үргэлжлүүлэн зохиох, - Зураг, наамал, барих, зохион бүтээх
Төвийн үйл ажиллагаа	Бие даасан байдал, асуудал шийдвэрлэх, бүтээлч оролцоог дэмждэг. Багш чиглүүлэхээс илүү ажиглагч, дэмжигчийн үүрэгтэй. Хэдэн төвтэй, ямар тоглоомтой байхыг багш төлөвлөж тоглоомын аргачлал, тоглох заавар зэргийг зургаар илэрхийлж хайрцаг, саванд байрлуулж, хүүхэд аль төвд ажиллах сонголт хийнэ. Төв нь: Хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сонголт хийх боломжтой байна. - Туршилт танин мэдэхүйн төв - Математикийн төв - Хэл яриа-номын төв - Тоглоомын төв
Зугаалга	Хүүхдийг байгальтай танилцуулах, орчноо ажиглах, туршин судлах, хөдөлгөөнийг дэмждэг өдөр тутмын үйл ажиллагааны хэлбэр юм. Зугаалга нь: - Ажиглалт - Хөдөлмөр - Тоглоом
	Хүүхдийн хэл яриа, уран дүрслэл, сонсох чадвар, анхаарал төвлөрөл,

Номын цаг	төсөөллийг хөгжүүлэх үлгэр, номын зохиол уншиж, ярилцана. Чиглүүлэх асуултаар баяжуулна. <ul style="list-style-type: none"> - Үлгэр унших - Зурагт ном тайлбарлах - Дүрд тоглох - Үлгэрийг үргэлжлүүлэх
Өөртөө үйлчлэх цаг	Хүүхдийг өдөр тутмын хувийн хэрэгцээг хангахад чиглэсэн. <i>Эх сурвалж: Бямбадорж.П, Гандолгор.Ш., (1994). "Бага насны хүүхдийн хөдөлмөр, зурагт сургах арга зүй"</i> <ul style="list-style-type: none"> - Гар, нүүр угаах - Хувцас өмсөх/эвхэх - Ор хураах, засах гэх мэт
Хөгжөөн баясах цаг	Хүүхдийг хөгжөөн баясахад, чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа, үлгэр зохиолын дүрд хувирах, хөгжилтэй хөдөлгөөн, хөнгөн дасгал, хөгжимт тоглоомоор сэргээнэ. Хөгжөөн баясах цаг: <ul style="list-style-type: none"> - Үлгэр зохиол танилцуулах, дүрд хувирах - Хөгжмийн хэмнэлээр бүжиглэх - Хөгжөөнт тоглоом - Хөгжилтэй дасгал

1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх

1. Үйл ажиллагааны сэдэв сонгох

Гарын авлагад "Сэдэв" гэх ойлголтыг нэг сарын хугацаанд хэд хэдэн суралцахуйн үр дүнг нэгтгэх, арга зүйг нэгдмэл байдлаар хооронд нь уялдуулах зорилгоор оруулж ирсэн. Багш нар хүүхдүүдээ хөгжүүлэхээр зорьж буй суралцахуйн үр дүн, орон нутгийн онцлог, хүүхэд, эцэг эхийн хүсэл сонирхол, өөрийн боломж, давуу тал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж төлөвлөлтийн сэдвийг тодорхойлно. Сэдэв нь дотроо хэд хэдэн дэд үйл ажиллагааг агуулах бөгөөд нэгдмэл арга зүйгээр хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, багш үйл ажиллагааг суралцахуйн чиглэл тус бүрээр салангид явуулах бус харин хүүхдүүдийн хувьд утга учиртай, нэгдмэл байдлаар төлөвлөх, зохион байгуулахад "сэдэв" чиглэгдэх юм.

2. Сэдэв, үйл ажиллагааны хүрээнд эзэмших СҮД-гүүдийг нарийвчлан уялдаа холбоог сайжруулах

Сэдвийн хүрээнд төлөвлөхдөө сургалт, үйл ажиллагааны СҮД-гүүдийн уялдаа холбоог шалгахын зэрэгцээ нийт жилийн сургалт, үйл ажиллагаанд нэг СҮД хэт олон давтагдах эсвэл орхигдож байгаа эсэхийг лавлаарай. Мөн нөгөө талаас бүх үйл ажиллагаанууд тухайн СҮД-д чиглэж байгаа эсэх, зорилтот СҮД-гүүд хангагдаж байгаа эсэхийг байнга нягталж байх хэрэгтэй. Тухайлбал, дараах үйл ажиллагаанд Нийгэм-сэтгэл хөдлөлийн есөн СҮД-гээс нэгийг нь эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.

Бага бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Ангитай танилцъя	НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг	Өөрт таатай, таагүй байгааг биеийн хэлэмж, үгээр хэлэх, заах Орчныхоо тоглоом, эд зүйлсийг сонирхон ажиглах, тоглох, нэрлэх Ангийн тоглоомоос нэг тоглоом сонгон тоглох

	тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ.	
--	-------------------------------------	--

Дунд бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Олоорой	НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.	Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоор тоглох Өөрийн таних тэмдгийг таних, бусдынхтай харьцуулах Ойр орчмын дуу чимээ танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх.

Ахлах бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Миний зуны амралт	ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. ЗУ2.2а. Зураас, дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцоно.	Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт харилцан яриаг эхлүүлэх Дугуй дүрс, цэг зураасаар дүрсэлж зурах Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

Дээрх жишээнд ахлах бүлгийн эхний сарын зарим үйл ажиллагаануудыг хоёрдугаар түвшний СҮД-гийн хүрээнд төлөвлөсөн байна. Энэ нь хүүхэд бүлэг шилжих үед СҮД-гийн түвшнийг уусгах, шилжилтийг хүүхдэд хялбарчлах зорилготой. Мөн эндээс та бүхэн СҮД-гийн түвшин сургалтын зохион байгуулалтын түвшин буюу бүлэгтэй заавал тохирох албагүй байгааг харж болно.

Бэлтгэл бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Би-миний найзууд	БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана. НСХ4.3в. Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.	Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох

3. Сар, долоо хоногийн төлөвлөгөө зохиох

Гарын авлагад хичээлийн жилийн эхнээс буюу 9-өөс 5 дугаар сарын нийт есөн сарын жишиг төлөвлөлтийн загвар оруулсан. Ингэхдээ сар бүрийн эхний хоёр долоо хоногийн үйл ажиллагааны төлөвлөлтийг жишиг болгосон. Эндээс багш нар санаа авч тухайн сарын 2 долоо хоногийг үргэлжлүүлэн төлөвлөх зориулалттай юм. Сар бүр нэгдсэн сэдэвтэй бөгөөд цааш долоо хоногийн дэд сэдэв, үйл ажиллагаагаар төлөвлөгдсөн.

Жишээ нь: Бага бүлгийн 9 дүгээр сар *"Шинэ орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал нэг, хоёрдугаар долоо хоногууд

"Ангитайгаа танилцъя", "Миний хөөрхөн гар, нүүр", "Дуулцгаая" гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Дунд бүлгийн 9 дүгээр сар "Хамтдаа тоглоё" сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног "Зогсоорой", "Олоорой", "Алгаа ташаарай", "Олсоор наадъя", "Гараа угаацгаая" гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Ахлах бүлгийн 9 дүгээр сар "Миний танил орчин" сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног "Миний зуны амралт", "Миний нэг өдөр", "Авхаалжтай хүүхэд" гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Бэлтгэл бүлгийн 9 дүгээр сар "Хөгжилтэй найзууд" сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудад задрах бөгөөд тухайлбал нэгдүгээр долоо хоног "Би-миний найзууд", "Бид хамтдаа", "Хамтдаа хийгээрэй" гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Дээрх жишиг төлөвлөлтүүдээс дараах асуултад хариулт авах боломжтой. Үүнд:

- Үйл ажиллагаа, арга зүйг хэрхэн сонгож сарын төлөвлөлт хийх вэ?
- Тухайн сард ямар СҮД-гүүдийг сонгон авч хэрхэн хооронд нь уялдуулах вэ?
- Долоо хоног, өдрийн төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?
- Сургалтын чиглэл хоорондын уялдааг хэрхэн хангах вэ?
- Шаардлагатай дасгал, үйл ажиллагааны давтамжийг хэрхэн тодорхойлох вэ?
- Сургалтын долоон чиглэлийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангах вэ?

Сэдвийн хүрээнд тоглох, үлгэр, зохиол унших, турших, төсөл хэрэгжүүлэх, дуу, хөгжим, хөдөлгөөн, зурах, бүтээх гэх мэт бүх төрлийн үйл ажиллагааг хослуулахыг хичээгээрэй. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх арга зүйн үндэс нь **тоглох үйл ажиллагаа** байгаа учраас бүлгээр, хамтран, зэрэгцэн, чөлөөт сонголттой хэлбэрүүдийг тэнцвэртэй оруулбал зүйтэй. Эдгээр үйл ажиллагаа, тоглох үйл явцуудыг хүүхдийн сонирхол, хэрэгцээ, хөгжлийн түвшинд тохируулан сонгож төлөвлөнө.

4. Хэрэгжүүлэх, ажиглах, үнэлэх, эргэцүүлэх

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн хэлбэр нь тасралтгүй ажиглалтад суурилсан албан бус үнэлгээ юм. Зорилтот СҮД-д баримжаалан хүүхдийн ахиц, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор үнэлгээг хийнэ. Багш өөрийн хэрэгцээ, нөөц боломжид тулгуурлан улирал, жилээр үнэлгээг нэгтгэж хүүхдийн ахицыг тодорхойлж дараагийн төлөвлөлтөд тусгана. Ингэхдээ багш нар үнэлгээний шалгуурын хүрээнд ажиглалтын хуудас, эргэцүүлэл, шалгах хуудас зэрэг хэрэгсэл ашиглана.

Гарын авлага нь багшид мэргэжлийн хөгжлийн хөтөч болох давхар ач холбогдолтой. Үүний тулд багш нар сэдэв бүрийн төгсгөлд амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, шалтгаан, сайжруулах шаардлагатай үйл ажиллагааны талаар эргэцүүлээ бичиж хэвших хэрэгтэй. Мөн эргэцүүллийн хүрээнд бусад багш нартай хэлэлцүүлэг өрнүүлж санал

бодлоо солилцвол илүү үр дүнтэй. Эдгээрт тулгуурлан багш үйл ажиллагаануудыг төлөвлөж цаашид хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол болон орон нутгийн онцлогтой уялдуулан сайжруулахын зэрэгцээ өөрөө мэргэжлийн ур чадварын хувьд өсөж хөгжих юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай

Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэх нь дасан зохицох чадвар юм. Дасан зохицох чадвар нь сэтгэц-физиологи, гүйцэтгэх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, хүмүүсийн харилцаа хандлагад дасах үйл явцыг агуулна. Тиймээс хүүхэд цэцэрлэгт дасан зохицох чадвар нь нийгмийн орчинд дасан зохицож буй нэг хэлбэр бөгөөд цэцэрлэгийн орчинд хүүхэд бие бялдар, сэтгэлзүйн хувьд аюулгүй тайван байх мэдрэмж юм.

Хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох чадварт тэдний сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн онцлогоос гадна дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- Хүүхдийн амьдралын өөрийн туршлага
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийн цэцэрлэгт итгэх итгэл
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ итгэх итгэл
- Цэцэрлэгийн багшийн хүүхдэд анхаарал хандуулах, итгэлцлийн харилцаа

Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинд авч үзсэнийг дараах хүснэгтэд харуулъя.

Хүснэгт 2. Хүүхдийн дасан зохицох түвшин

Дасан зохицох чадвар сайн	Дасан зохицох чадвар дунд	Дасан зохицох чадвар сул
<ul style="list-style-type: none"> - 10-15 хоногийн дотор хүүхэд хэвийн байдалд орж хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага байна. - Хичээлийн агуулга хөтөлбөрийг хялбархан бүрэн эзэмшинэ. - Төвөгтэй асуудлыг шийдвэрлэнэ. - Хичээнгүй, багшийн заавар тайлбарыг анхаарч сонсоно. Хяналт шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг биелүүлнэ. - Цэцэрлэгт явах дуртай, багшийн шаардлагыг зохистой хүлээж авна. - Бие даан ажиллах чадвар сайн. - Нийгмийн идэвх өндөр, хариуцлагатай уриалгахан байна. 	<ul style="list-style-type: none"> - Ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, жин нь түр зуур хасагдаж, “өвдөх” болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрнэ. - Цэцэрлэгт явахдаа дургүйцдэггүй. - Багш хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгож авна. - Томчуудын хяналт дор даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгэнэ. - Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө. - Ангийн олон хүүхэдтэй нөхөрлөнө. 	<ul style="list-style-type: none"> - 2-6 сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд байн байн өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, биеийн болон сэтгэл санааны хямралд ордог. - Цэцэрлэгтээ явах дургүй. - Сэтгэл зүйн хувьд дарамттай. - Ангийн дүрэм журмыг дагаж мөрдөхгүй. - Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчлэн ойлгоно. - Бие дааж ажиллах чадвар сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ. - Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, тусламж шаардлагатай. - Дотно найз нөхөдгүй, цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ.

Түүнчлэн хүүхдийн бие махбод, өөрийгөө илэрхийлэх, орчноо мэдрэх чадвар, гэр бүлдээ эзлэх байр суурь, гэр бүлийн уур амьсгал зэрэг нь дасан зохицолд нь нөлөөлдөг. Оюун

ухааны хөгжил сайтай, сэтгэл хөдлөлийн хувьд тогтвортой хүүхдэд дасан зохицоход бэрхшээл тулгардаггүй бол сэтгэл хөдлөлийн тогтворгүй хүүхдүүдэд хүндрэлтэй байдаг. Хүүхдийн хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал зэргээс шалтгаалан шинэ нөхцөлд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг ч дасан зохицох тодорхой үе шатыг туулдаг. Тухайлбал, З.Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо түгшүүрийн үе, дайчлах үе, дасан зохицох эсвэл үл дасан зохицох гэсэн 3 үе шатыг дамждаг бөгөөд дасан зохицохын тулд хичээж, тайван юм уу тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж үздэг байна. Үүнд:

Түгшүүрийн үе: Энэ үе шат нь айх, түгших, сандрах, зөрүүдлэх, зэрэг сэтгэл санааны тогтворгүй байдлаар илэрдэг. Энэ үед хүүхдэд дарамттай мэдрэмж зонхилж, жин нь хасагдах, хоолонд дургүй болох, ойр ойрхон өвдөх, дадал болсон зүйлээ мартах, дүрэм журам зөрчих зэрэг шинж тэмдэг болно. Энэ үе шат хүүхдийн дасан зохицох чадвараас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд үргэлжилнэ.

Дайчлах үе: Энэ үе шат нь сэтгэл санаагаа тайвшруулах, айдсаа даван туулах, бусдыг дуурайх, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, бусдад итгэх зэрэгт хүчин чармайлт гаргах үе. Хүүхдийн өсөлт хөгжил удаашралтай тэнцвэрийн энэ үе шат 3-5 сар үргэлжилнэ. Энэ үед хүүхдүүд өөрийн бие махбодыг дээд зэргээр дайчилна.

Дасах эсвэл үл дасах үе: Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, өмнөх удаашралыг нөхөж гүйцдэг. Хэрэв хүч нөөцөө хэчнээн дайчлаад нөлөөллийг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд орно. Ийм тохиолдолд хүүхдийн сурч, хөгжих боломжид саатал гарах магадлалтай. Харин дасан зохицлын хувьд хэвийн хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч цэцэрлэгтээ дасан зохицож, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

Цэцэрлэгийн бүлгийн багшаас хүүхдийн дасан зохицож буй чадварыг өглөөний хүлээн авалтын үед 14 хоногоос дээш хугацаанд хүүхдэд илрэх шинж, үйлдлийг дараах байдлаар ажиглаж, 1-5 хүртэл үнэлгээг хийж болно.

Үнэлгээний асуулт	Үнэлгээний дүгнэлт
Эцэг эхээсээ салж үлдэх үед уйлах	Цэцэрлэгт хүүхдээ хүргэж өгөхөд эцэг эх, асран хамгаалагчдаасаа салж, үлдэхэд удаан хугацаа зарцуулдаг
Салах үед эцэг эхээсээ "дүүжлэгдэх"	Цэцэрлэгт хүүхдүүдтэй хамтран хийх үйл ажиллагаа болон тоглоомд оролцдоггүй
Өдрийн турш уйлах	Өдрийн турш хоол идэхээс татгалзаж, бусад хүүхэдтэй харилцдаггүй
Үйл ажиллагаа, тоглоомд оролцож байгаа түвшин сул	Оройн таралтын үед эцэг эх, асран хамгаалагчдаас хүүхдэдээ санаа зовсон үйлдэл гаргадаг
Дүрэм журмыг дагахгүй байх	Оройн таралтын үед эцэг эх, асран хамгаалагчдаа хараад хүүхэд уйлдаг
Эцэг эхтэйгээ орой уулзах үедээ уйлах	Цэцэрлэгийн орчинд байгаа насанд хүрэгчидтэй харилцаа үүсгэж ярилцдаггүй байдал хүүхдэд хоёр долоо хоногоос илүү хугацаагаар үргэлжилсэн, бусад сөрөг шинж тэмдгүүд илэрсэн

Иймээс хүүхдийг цэцэрлэгт дасгахын тулд дараах ажлыг зохион байгуулж болно.

- Цэцэрлэгт эцэг эх, асран хамгаалагчдын дэргэд хүүхэд байх хугацааг бий болгож бага багаар дасгах;

- Цэцэрлэгт хүүхдээ хүргэж өгсөн үедээ эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл санааны таагүй байдал мэдрэмж бий болсон бол багш, сэтгэл зүйчтэй ярилцах;
 - Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн цэцэрлэгийн орчинтой танилцах боломжийг бүрдүүлэх;
 - Цэцэрлэг нь байгууллагын хүний нөөц болон материаллаг боломжид тулгуурлан хүүхдийн дасан зохицох чадвар, нийгэмшүүлэхүйн үйл явцыг дэмжих ажлыг зохион байгуулах;
 - Насанд хүрэгчдээс цэцэрлэгт явагддаг үйл ажиллагаатай холбоотой үлгэр, зохиолыг хүүхдэд уншиж өгөх;
 - Багш нар болон туслах ажилтнуудаас хүүхдийг зохион байгуулсан үйл ажиллагаанд хүчээр оролцуулах, явуулахыг албадахгүй байх;
 - Цэцэрлэгт итгэж, аюулгүй байдал, хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмжийг бий болгох.
- Цэцэрлэгт эцэг эх, асран хамгаалагчдын итгэх итгэл нэмэгдэхэд хүүхэд цэцэрлэгийн орчинд таатай байх, бусад хүүхдүүдтэй харилцах зэрэгт ахиц гардаг болохыг судалгаагаар баталсан байдаг. Иймд дасан зохицож байгаа нь дараах шинжээр илэрч болно. Үүнд:
- Хүүхэд хооллох дуршилтай болдог;
 - Хурдан унтдаг, цагтаа босдог;
 - Бусадтай эерэг сэтгэл хөдлөлөөр харилцдаг;
 - Амархан тоглодог, хамтардаг.

2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол

Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулахыг Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан.

Зан үйлийн болон танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хэд хэдэн хүчин зүйлийг илүү чухалчилж үздэг. Тухайлбал, зан үйлийн онолууд нь хүрээлэн буй орчны нөлөө, ялангуяа өдөөлт ба сэдэлжүүлэлтийн онцлог, түүний зохион байгуулалт, хэлбэр, мөн хүүхдийн үзүүлэх зан үйлд багшийн хариу үйлдэл, орчныг онцгой чухалчилдаг (Dale, 2012). Зан үйлийн онолын гол төлөөлөгчид нь Джон Ватсон (John Watson), Б. Ф. Скиннер (B. F. Skinner) нар юм. Тэд зан үйлийн зөв дадал төлөвшихөд дотоод сэтгэлгээ бус, орчны нөлөө чухал үүрэгтэй гэж үзээд нөхцөлт үйл, эерэг хариу үйлдлээр хүүхэд эерэг зан үйлд суралцана гэж үзжээ. Энэ онолын үүднээс суралцах үйл, дадал нь орчноос ирэх хариу үйлдлийн үр дүн хэмээн үздэг бөгөөд эерэг, сөрөг хариу үйлдэл, давталт нь хүүхдийн суралцах зан үйлийг бэхжүүлэх ба энэ нь хүүхдийн сурах хандлага, оролцоонд шууд нөлөөлдөг (Schindler et al., 2019). Өөрөөр хэлбэл, хүүхэд орчноос ирэх нөлөөлөл буюу орцоор суралцах үйлд сэдэлждэг бөгөөд эдгээрийг хүүхэд хэрхэн боловсруулдаг үйл явцыг танин мэдэхүйн онол тайлбарладаг.

Танин мэдэхүйн онолууд нь хүрээлэн буй орчноос ирэх хариу үйлдэл хүүхдийн суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг (Dale, 2012). Багшийн мэдээлэл, өдөөлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг нь хүүхдэд орчноос ирж буй суралцахуйн орц юм. Эдгээр орцууд нь хүүхдэд суралцах чадварыг бүрэн өгдөггүй (David et al., 2015). Танин мэдэхүйн онолын гол төлөөлөгч нь Ж. Пиаже, Ж. Брунер нар бөгөөд хүүхэд орчноо хүртэж, танин мэдэхдээ оюуны идэвхтэй үйл хийдэг. Харин тэдгээрийг хүүхэд ажиглах, дуурайх, давтах, залруулах зэрэг идэвхтэй үйлээр боловсруулж байдаг нь суралцахуйд хөтөлж, чиглүүлж

байдаг. Хүүхэд орчноос ирж буй орцыг (багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг) анхаарах, ажиглах, дүрслэх, хувиргах, кодлох, хадгалах, өөрт шинэ мэдлэгийг бүтээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн өөрийнх нь сонирхол, бодол санаа, итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийн үүргийг чухалчилдаг.

Дээрх хоёр чиглэлийн онолоос гадна хүүхдийн сурах арга барил, хандлага төлөвшихөд чиглэсэн конструктивист (Constructivist) онолууд нь хүүхэд мэдээлэл хүлээн авагч бус, мэдлэгийг өөрийн үйл ажиллагаа, туршлагаар бүтээгч хэмээн үздэг, хүүхдийг идэвхтэй суралцагч хэмээн үздэг. Конструктивист онолчид шинжлэх ухааны цор ганц, туйлын үнэн байдаг гэсэн ойлголтоос татгалзаж, үнэн олон талтай, эргэлзээтэй үнэнийг олон янзаар нээж, баталж болно хэмээн үздэг (Dale, 2012). Энэ олон талт үнэнийг илрүүлэх арга зам нь асуулт тавих, ажиглах, асуудлыг олж харах, бодох, уялдаа холбоог олох, шийдвэр гаргах зэрэг идэвхтэй үйл ажиллагаа юм. Энэ идэвхтэй үйл ажиллагаа нь хүүхдийн тоглох үйл юм. Хүүхэд тоглох явцдаа ертөнцийг танин мэдэх, төсөөлөн бодох, нийгэмших, хэл ярианы чадвараа хөгжүүлдэг. Тоглох явцдаа юмс үзэгдлийн мөн чанар, логик уялдааг ойлгож, асуудлыг олж харах, шийдэх чадвартай болдог.

Аливаа үйл ажиллагааг хүүхэд өөрийн хүсэл сонирхлоор, зорилготой, сонголтоор хийх (үүнийг хүүхэд төвт үйл ажиллагаа гэж хэлдэг) ба багш орчныг сонирхолтой байдлаар төлөвлөж зохион байгуулах, хүүхдийн үйл ажиллагааг ажиглах, чиглүүлэх, шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг. Энэ нь хүүхэд өөрийн хурдаар тааваараа, сонирхолдоо хөтлөгдөн, учир утга зорилготой үйл ажиллагаанд оролцох, улмаар бие даасан байдал, шүүн тунгаах, асуудал шийдвэрлэх чадварт суралцах боломжийг бүрдүүлдэг (Farquhar & White, 2014).

Бага насны хүүхдийн суралцахуйг дэмжих, хөтлөн чиглүүлэхэд багшийн анхаарах зүйлсийг суралцахуйн онолтой холбон үзье.

Хүснэгт 3. Суралцахуйн онол

Суралцахуйн онол	Зорилго	Багшлахуй
Зан үйлийн онол	Хүүхдийн суралцах үйл ажиллагааг сэдэлжүүлэх, нөлөөлөх (суралцахуйн орц)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдэд эерэг зан үйл төлөвшихөд чиглэсэн давтамжтай, эерэг хариу үйлдэлт, чиглүүлэгтэй орчин бүрдүүлэх. - Хүүхдийн зан үйлд тохирсон эерэг хариу үйлдэл (урамшуулал, чиглүүлэг, дэмжлэг гэх мэт) үзүүлэх, сөрөг зан үйлийг залруулах. - Эерэг зан үйлийг давтах, бататгах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг ажиглах, үнэлэх.
Танин мэдэхүйн онол	Хүүхдийн суралцахуйг идэвхжүүлэх, суралцахуйн дадалд хөтлөх (мэдээлэл боловсруулах, суралцах үйл явц)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг дэмжих нээлттэй асуулт асуух, сорилттой дасгал даалгавар өгөх. - Хүүхдийн анхаарах, ажиглах, дүрслэх, төсөөлөх, илэрхийлэх, дүгнэх үйлийг дэмжсэн үйл төлөвлөх. - Суралцах үйл ажиллагаанд багш мэдээлэл дамжуулагч бус, чиглүүлэгч, хамтрагч байх.

Конструктивист онол	Хүүхдийн сурах арга барил эзэмшихэд чиглүүлэх, суралцах хандлага төлөвшүүлэх (суралцахуйг хөтлөх үйл, үр дүн)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн идэвхтэй үйл ажиллагаа, оролцоог дээдэлсэн, бие даан мэдлэг бүтээх орчныг бүрдүүлэх (зохиолд суурилсан, тоглоход суурилсан, төсөлд суурилсан, судлан шинжлэх). - Хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурласан, утга учиртай, зорилготой үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах. - Хамт олонтойгоо харилцах боломжийг нэмэгдүүлэх, хамтын суралцахуйг дэмжих.
---------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Бага насны хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжихдээ багш зан үйлийн, танин мэдэхүйн, конструктивист онолуудад тулгуурлах нь багшлах үйл ажиллагаа үр дүнтэй болох шинжлэх ухааны үндэслэл болно. Хүүхдийн зан үйлд тохирох эерэг хариу үйлдэл үзүүлэх, оюуны болоод нийгэм-сэтгэл хөдлөл, бие даасан бүтээлч сэтгэлгээг дэмжих нь суралцах үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн үр дүнтэйгээр удирдахад чухал ач холбогдолтой. Иймээс суралцахуйн онолуудын уялдаа холбоог ойлгож, багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн мэргэжлийн чадамжийн нэг чухал бүрэлдэхүүн болдог.

2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн талаарх дараах чиглэлийг тусгасан. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт, үйл ажиллагаанд тоглоом, зохиол, шинжлэн судлах, төсөлд суурилсан арга зүйг хүүхдийн насны онцлог, эзэмших чадамж суралцахуйн үр дүн, сургалтын чиглэлийн онцлогтой холбон бүтээлчээр хэрэглэнэ.
- Монгол суралцагчийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд суралцахуйн чиглэлийн онцлог бүрийн оруулах хувь нэмрийг тусгасан бөгөөд үүнийг нэгдмэл уялдаатай, хүүхэд төвтэй байхуйц суралцахуйн арга зүйгээр зохион байгуулна.

Түүнчлэн дээрх арга зүй нь үйлээр дамжиж чадамжид хувь нэмрээ оруулах бөгөөд үүнийг дараах хүснэгтээр танилцуулъя.

Хүснэгт 4. Эзэмших чадамж

Монгол суралцагчийн эзэмших чадамж	Суралцахуйн арга зүйг хэрэгжүүлэх явцад хүүхдийн хийх үйлийн хувилбар	
	2-4 хүртэлх настай хүүхдийн хийх үйл	4-5 настай хүүхдийн хийх үйл
<i>Бүтээлчээр сэтгэх</i>	Гол санааг олох, дүрд хувирах	Төсөөлөх, бүтээл, биеийн хэлэмжээр өөрийгөө илэрхийлэх, шинэ санаа гаргах
<i>Шүүн тунгаах</i>	Ажиглах, асуулт тавих, зөв бурууг таних	Зөв, бурууг таних, учир шалтгааныг олох
<i>Суралцахуйд суралцах</i>	Асуулт асуух, хариулах, идэвхтэй сонсох, үйл ажиллагаанд оролцох	Шийдэл олох, учир шалтгааныг ойлгох, танин мэдэх, өөрийгөө удирдах
<i>Харилцах</i>	Бусдыг сонсох, биеийн хэлэмж, хэл яриагаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх	Ялгаатай байдлыг хүндэтгэх, ээлжээ хүлээх, дүрэм баримтлах, зөрчлийг шийдвэрлэх


Хамтран ажиллах	Бусдын тоглохыг ажиглах, хамтран тоглох, бусдад туслах	Багаар тоглох, хамтран үйл хийх, ээлжээ хүлээх, бусдад туслах
Нийгэм, сэтгэл хөдлөл	Бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх, таних, дүрмийг мөрдөх,	Бусдад туслах, хамтрахад суралцах, өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, эрх тэгш харилцах
Үндэсний болон дэлхийн өв соёл	Зан заншлаас таньж мэдэх	Соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх

Монгол суралцагчийн эзэмших чадамжийн хүрээнд хийх үйлийг суралцахуйн арга зүйтэй холбон авч үзсэн бөгөөд арга зүй тус бүрийн онцлог, үе шатыг цааш дэлгэрүүлэн авч үзье.

Сургуулийн өмнөх насны 2-4 хүртэлх насны хүүхэд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт хэрэгжүүлэх арга зүйн онцлогийг авч үзье.

Тоглоомд суурилсан арга зүй: Суралцахуйн онолын үзэл, чиг хандлагын ихэнх бүтээлүүдэд хүүхдийн үндсэн үйл ажиллагаа тоглоом бөгөөд түүгээр дамжуулан тэд суралцаж, хөгжиж, танин мэдэж, бусадтай харилцаж, насанд хүрсэн үеийн танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлох авч үзсэн байдаг. Тухайлбал, Жан Пиаже хүүхдийн тоглох үйл нь танин мэдэхүйн хөгжилд онцгой хамаатай бөгөөд тэд машин барих, гал тогоо сэдэвт тоглоомын наадгайгаар хоол хийх зэргийг харснаа даган дуурайж аливаа зүйлс хэрхэн ажилладгийг ойлгож эхэлдэг. Мөн Жан Пиаже “өөрөө мэдлэгээ бүтээх нь бусдаар заалгахаас хавь илүү гэж үзэж тоглохыг суралцахуйн гол арга зам” гэсэн санааг дэвшүүлсэн байна. (Жанет Гонзалез -Мина, 2024)

Зураг 1. Тоглоомд суурилсан арга зүйн онцлог



Сургуулийн өмнөх насны 2-4 хүртэлх насны хүүхэд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт тоглоомд суурилсан арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа хүүхдийн сэтгэлзүйн болон тоглох онцлогийг харгалзахаас гадна тоглоом нь тэднийг үл таних зүйлст бэлтгэх сайн арга гэдгийг анхаарч, дараах санаатай танилцаарай.

- *Тоглоом, наадгайг тогтсон “байр” тай байлгах:* Хайрцаг дотроос хэрэгтэй тоглоом наадгайг олж авах нь хоёр настай хүүхдэд ихээхэн хүндрэлтэй ба юмсын эмх цэгц, дэс дараалал өөрчлөгдөхөд бухимдах тул тоглоом нь намхан тавиур дээр тогтсон “байр” тай байх нь чухал.
- *Тоглоом, наадгайг сонгоход туслах:* Тоглох үйл явцад бүрэн оролцож чадахгүй байгаа хүүхдэд зориулан наадгайг сонгоход тусалж анхаараарай. Тухайлбал, харах чадвар сул хөгжсөн хүүхэд мэдэрч хүртэхүйн чадварыг сайжруулах наадгайг өгч тоглуулах нь эд зүйлсийн шинж чанарыг тодорхойлох туршлага хуримтлагдаж, хүртэхүйн тусламжтайгаар гадаргуу болон хэлбэр дүрсийн талаарх ойлголт, мэдээлэл үүсдэг.

- *Тоглоом, наадгайг хамтдаа хураах, цэгцлэх:* Хүүхэд тоглож дуусаад наадгайг хураах, зөвхөн хураасны дараа өөр наадгайгаар тоглох чадварыг багшаас суралцах тул үлгэрлэн харуулах нь үгээр заахаас илүү үр дүнтэй.
- *Хүүхэдтэй хамтдаа тоглох:* Багш та хүүхэдтэй хамтран тоглохдоо тэд ямар төрлийн тоглоом сонирхож байгаа болон сонирхохгүй байгааг ажиглах, цаашид хэрхэн хөгжлийг дэмжих гарцаа ч олж харах боломжтой.
- *Арга зүйг хослуулан хэрэглэх:* Бүлгийн сургалт, үйл ажиллагааг тоглоом болон бусад арга зүйтэй хослуулан, тухайлбал, зохиолд, шинжлэн судлахад, төсөлд суурилсан арга зүйтэй хослуулсан хэлбэрээр зохион байгуулж болно.

Чөлөөт тоглоомын үед хүүхэд насанд хүрэгчдийн хөндлөнгийн оролцоо, чиглүүлэггүйгээр юугаар, хэрхэн тоглохоо сонгох боломжтой. Чөлөөт тоглоом нь хүүхдийн нийгэм, сэтгэл хөдлөл, хэл яриа, бүтээлч сэтгэлгээ зэрэг чадвар хөгжихөд эергээр нөлөөлөхөөс гадна өөрийн сонирхлоо танин мэдэх, хөгжүүлэх боломжийг олгодог. Харин чиглүүлэгтэй тоглоом нь насанд хүрэгчээс хүүхдийн тоглох үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар удирдан чиглүүлэх хэлбэр бөгөөд шинэ мэдлэг, чадварт суралцахад бичиг үсэг, тоо бодох, байгаль шинжлэл гэх мэт тодорхой чиглэлээр хүүхдийн суралцахуйг дэмжихэд (Bergen, D., & Fromberg, D. , 2009) эергээр нөлөөлдөг.

Тоглоомд суурилсан арга зүйн мөн чанарыг ойлгох, санаа сэдэл төрүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор багш танд зохион байгуулах хувилбарыг танилцуулъя.

Хүснэгт 5. Сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн хувилбар

<p>Үйл ажиллагааны нэр:</p> <p>Бөмбөг шидээрэй</p>	<p>Хэрэглэгдэхүүн:</p> <p>Гурав хүртэл өнгийн жижиг бөмбөг, наадгай сагс, хөгжмийн ая</p>	<p>Суралцахуйн үр дүн:</p> <p>ХЭМ1.1а. Гарын сарвууг атгах, тэнийлгэх, сэгсрэх, базах хөдөлгөөнийг жижиг тоглоом, эд зүйлийг ашиглан тоглоно.</p> <p>ХЯ1.2а. Харилцан яриаг ажиглан үг, өгүүлбэрийг дуурайж, оролцоно.</p> <p>НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд юмсыг байранд нь хураана.</p>
<p>Аргачлал: Хөгжмийн аянд багш, хүүхдүүд хамтдаа алхаж, сагснаас бөмбөг авч барьж, тэмтэрнэ. Хөгжмийн ая зогсоход багш “шидээрэй” гэж хэлж хамтдаа бөмбөгийг нүхтэй бай руу шидэж оруулахыг эрмэлзэнэ. Хамтдаа “нэг хоёр гурав” гэж хэлж бөмбөгийг шидэж ч болно. Хүүхдүүд үгийг дуурайж хэлэхэд багш урамшуулна. Газарт өнхөрсөн бөмбөгийг багш, хүүхдүүд хамтдаа цуглуулж өнгийн сагсанд ялган хийнэ.</p>		
<p>Тайлбар: Хүүхэд бөмбөгийг барьж атгах, шидэх, өнхрүүлэх дуртай бөгөөд энэ нь зориулалт, өнгө, хэмжээ зэргийг танин мэдэх гэсэн хүсэл, сонирхолтой холбоотой. Багшийн тусламжтайгаар тооны нэрийг даган хэлж, дуурайх эрмэлзлээс гадна тооны үг хэллэг мэддэг болох алхам болж байна.</p> <p>Багш тоглоом, наадгайг хураахыг хүүхэд хараад “энэ чухал бөгөөд сонирхолтой, гоё ажил байна” гэж ойлгодог. Заримдаа хүүхэд тоглоомоор тоглохоос илүү буцааж хураах дуртай байх ба багшийг тоглоом хураахыг өдөр бүр хараад дуурайж суралцаж эхэлнэ.</p> <p>Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагааны цагт зохион байгуулагдаж байгаа ч дараагийн үйл ажиллагааны бэлтгэл, үргэлжлэл байж болно. Тухайлбал, тойргийн цагт хүүхдүүд “алаг бөмбөг” дууны аянд тойргоор бүжиглэх, хайрцгийн дугуй хэлбэртэй нүхтэй хэсэгт гараа хийж бөмбөгийг гаргаж авах зэргээр үргэлжлүүлэн тоглож болно.</p> <p>Энэхүү үйл ажиллагаа нь суралцахуйн үр дүн, арга зүйн уялдааг хангахаас гадна тархины хөгжил, нүд-гарын хөдөлгөөний зохицлыг дэмжих зэрэг эерэг нөлөөтэй юм.</p>		

Зохиолд суурилсан арга зүй: Зөвхөн үлгэр, зохиол, хүүхдийн яриа, өгүүлэмжийг сонсгож, ярих бус, тэдгээрийн дүр, үйл явдал, юмс үзэгдлээр тэдний суралцахууд сэдэлжүүлэх, бодит амьдралтай уялдуулах гүүр болгож ашигладаг онцлогтой. Бэлэн үлгэр, зохиолоос гадна хүүхдийн өөрийн өгүүлэмж яриаг суралцах үйлийн эх сурвалж болгон ашигладаг онцлогтой. Багш, хүүхэд үлгэр зохиол, өөрт тохиолдсон явдлаа яриад зогсохгүй, асуулт асууж харилцан ярилцах, үлгэрийн дүрд тоглох, дүр үйл явдлыг урлан бүтээх, үлгэрийн төгсгөлийг өөрөөр бодож бүтээх зэрэг идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог. Энэ нь хүүхэд мэдээлэл хүлээн авах бус, мэдлэг “бүтээж” суралцах боломжтой болдог.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд үлгэр, зохиолын дүрийн харагдах байдал болон үйл явдлын шууд утгыг ойлгож хүлээн авах, баатрын зан үйл, хөдөлгөөнийг дуурайх, эд юмсын хэлбэр дүрс, өнгө, онцлог шинжийг ялган таних, мөн үйл явдлын дэс дарааллыг тогтоох байдлаар суралцах онцлог илэрдэг.

Хүснэгт 6. Хүүхдийн хөгжилд зохиолд суурилсан арга зүйн үзүүлэх эерэг нөлөөллийн хувилбар

Хүүхдийн хөгжил	Хүүхдийн суралцах үйл
Танин мэдэхүй	<ul style="list-style-type: none"> • Үлгэрийн үйл явдлыг шууд ойлгож, дүрүүдийг таних, нэрлэхэд суралцдаг. Жишээ нь: Энэ охин нь, энэ ээж нь. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Шалтгаан-үр дагаврыг энгийн түвшинд ойлгоно. Жишээ нь: Хүү нь уйлсан болохоор ээж нь аргадсан. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Өөрийн туршлагатай холбож ойлгодог. Жишээ нь: Намайг уйлахад ээж бас аргаддаг. (<i>Л. С. Выготскийн Нийгэм соёлын онол</i>)
Сэтгэл хөдлөл	<ul style="list-style-type: none"> • Дүрийн мэдрэмжийг өөрийнхөөрөө мэдэрч, баярлах, гуниглах, айх зэрэг энгийн сэтгэл хөдлөлийг ялгаж эхэлдэг. Жишээ нь: Хүү нь гунигтай байсан. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Үлгэрийн дүртэй сэтгэл санааны холбоо үүсгэж, аюулгүй мэдрэмж авдаг. Жишээ нь: Би үлгэрт гардаг хүү. (<i>Ж. Боулбийн Ээнэгшлийн онол</i>)
Нийгэмшихүй	<ul style="list-style-type: none"> • Дүрд орж, үлгэрийн баатрыг дуурайдаг. Жишээ нь: Хүү нь ингэж гунигладаг. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Үлгэрийн баатрыг шууд дуурайж туршина. Жишээ нь: Би ч бас тоглоомоо найздаа өгнө. (<i>А. Бандурагийн Нийгэм суралцахуйн онол</i>)

Зохиол сонгоход анхаарах зүйлс

1. Үйл явдал энгийн, богино байх (1-2 үйл явдал);
2. Үйл явдал, үг хэллэг давталттай байх (шүлэглэсэн хэсэгтэй байвал сайн);
3. Сэтгэл хөдлөл тод илэрхийлэгдсэн байх;
4. Дуу авиа ашиглах боломжтой байх;
5. Ном сонгох бол дүрийн зураг тод, үйл явдлын дүрслэлтэй байх.

Сургуулийн өмнөх 2-4 настай хүүхдүүд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт тус арга зүйг дараах ерөнхий бүтцийн дагуу хэрэгжүүлж болно. Үүнд:

- 1- р үе шат: Зохиолоо сонсох ба дүрүүд, үйл явдалтай нь танилцах;
- 2- р үе шат: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар зохиолтой давтан танилцах;
- 3- р үе шат: Дүрд тоглох ба бүтээлчээр оролцох;
- 4- р үе шат: Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг интеграцчилан хэрэгжүүлэх.

Арга зүйн зөвлөмж

- Үлгэр, зохиолыг ярихдаа хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан тэдний мэдэх үгээр, хурдаа тохируулан ярих: Давтан ярихдаа жүжигчлэн тоглох, орчин, хэрэглэгдэхүүний сонголт өөр байх нь хүүхдийн сонирхлыг татах, анхаарал удаан төвлөрөх нөхцөлийг бүрдүүлдэг.
- Зохиол ярих явцдаа хүүхдийг оролцуулах: Зохиолын эхэнд номын хавтсыг харуулж “Энэ юу вэ?”, “Энэ зохиолд хэн хэн гарах юм шиг байна?”, “Ямар өнгөтэй байна?” зэрэг богино асуултаар хүүхдийн анхаарлыг татаж, харилцан ярилцах боломж олгоно.
- Хөдөлгөөнт тоглоом, үйл хөдлөлтэй хослуулах: Хүүхдийн ойлголтыг бататгах, үйл явдлыг ойлгоход тустай. Жишээ нь, амьтны дуу авиаг дуурайх, баатрын хөдөлгөөнийг дагах, гараараа дүрслэх зэрэг нь хүүхдэд хөгжилтэй, ойлгомжтой байдаг.
- Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг уялдуулах: Зохиолын дүр, үйл явдал, зохиолд гарсан юмс үзэгдлийг ашиглах суралцахуйн бусад чиглэлийн чадварыг эзэмших үйл ажиллагааг зохион байгуулах нь хүүхдийн танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэх, зохиолын дүр, үйл явдлыг эргэн санах, бататгах, юмс үзэгдлийг холбоо хамаарлыг ойлгоход тустай.

Хүснэгт 7. Зохиолд суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллагааны нэр	Сургалтын хэрэглэгдэхүүн		Суралцахуйн үр дүн
Манжин үлгэр	<ul style="list-style-type: none"> - Зурагт том ном, үлгэрийн дүрүүдтэй зурагт картууд, аудио бичлэг, ширээний театр - Дүрд тоглох хэрэгслүүд, байгалийн материал: навч, чулуу, хөрс гэх мэт - Зургийн хэрэгсэл 		ХЯ1.3а.Номыг сонирхож үзнэ. НСХ2.1в.Уурлаж тавгүйтсэн шалтгааныг нь асууж ярилцахад тайвширдаг болно.ХЭМ1.1д.Сэдэвт алхалт, гүйлтийг багшийн зааврын дагуу даган дуурайж гүйцэтгэнэ.
Үе шат	Суралцахуйн үйл	Хүүхдийн хийх үйл	Багшийн хийх үйл
1-р үе шат: Зохиолоо сонсох ба дүрүүд, үйл явдалтай танилцах	Зохиол сонсох	<ul style="list-style-type: none"> - Сонсох, зураг ажиглах - Багшийн хэлж буй үг, хөдөлгөөнийг дагах 	Үлгэрийг тод дуугаар унших,дуу авиа хөдөлгөөнөөр баяжуулах
2-р үе шат: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар зохиолтой давтан танилцах	Өөр хэлбэрээр давтан сонсох	<ul style="list-style-type: none"> - Зураг харж дүрүүдийг нэрлэх, хөдөлгөөнийг даган гүйцэтгэх, дууг аялах 	Ширээний театр, хуруун хүүхэлдэй, зурагт үзүүлэн зэргийг ашиглан дахин үлгэрийг өгүүлэх
3-р үе шат: Дүрд тоглох ба бүтээлчээр оролцох	Дүрд тоглох, бүтээлчээр оролцох	<ul style="list-style-type: none"> - Дүрийн үйлдлийг хийж үзэх, биеэр мэдрэх байдлаар оролцох Жнь: Татъя, татъя гэж хэлээд урагш хойш татах хөдөлгөөн хийнэ. 	Орчныг бий болгох, баяжуулах, Хүүхдийн оролцоог зохион байгуулан дүр хуваарилах, хүүхдийн сэтгэл хөдлөлийг нэрлэж дэмжих, хүүхдээ ажиглаж чиглүүлэх, хамтдаа хийх

4-р үе шат: Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг интеграцчилан хэрэгжүүлэх	Интеграцчлан хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Дүрүүдийг болон манжинг өнгөөр ялгаж зурж будах, баримал барих, байгалийн материалаар ногооны талбай хийх - Хэн эхэлж ирсэн бэ дарааллыг биеэр зогсож илэрхийлэх - “Найзаа би чамд тусалъя” дүрд орж тоглон бие биедээ туслах 	Интеграцчилагдсан тоглоом, үйл ажиллагааг зохион байгуулах, өмнөх мэдлэгийг сэргээх, сонирхол төрүүлэх асуулт асууж хүүхдийн сурах, давтан хийх эрмэлзлийг идэвхжүүлэх, хүүхдээ ажиглаж үнэлэх
--------------------------------------------------------------------------------------------	-----------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Тайлбар: “Манжин” үлгэрийг зохиолд суурилсан арга зүйгээр хэрэгжүүлэхэд хүүхэд сонсох, ойлгох, дүрслэх, хамтран оролцох, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, сэтгэл хөдлөлийг таних зэрэг олон чадамжийг зэрэг хөгжүүлдэг. Ингэхдээ хүүхэд дүрийн үйлдлийг “хийж үзэх”, “биеэр мэдрэх” байдлаар оролцдог. Тиймээс 2-3 настайчуудыг үлгэрийн үйл явдалд биеэр оролцох, хөдөлгөөнөөр илэрхийлэх боломж олгох нь чухал. Эхлээд богино хэсгээр /эмгэн ба өвгөн/ эхэлж, дараа нь бүх дүрийг нэгтгэн тоглуулна. Үлгэрийн “Хамтдаа хийвэл бүтнэ, бие биедээ тусална гэсэн гол санааг хөдөлгөөн, мэдрэхүй, тоглоомоор мэдрүүлэх нь хамгийн үр дүнтэй юм.

Шинжлэн судлахад суурилсан арга зүй: Энэ нь асуулт асуух, ажиглах, мэдээлэл цуглуулах, баримт нотолгоонд тулгуурлан хамтран дүгнэлт гаргах замаар мэдлэг, нээлт, эргэцүүлэн бодох сэтгэлгээг хөгжүүлж, хүүхдэд төрөлхийн сониуч зангаар асуудлынхаа шийдлийг хайж, сэтгэн бодоход нь тусалж, суралцах үйл явцыг илүү сонирхолтой болгодог. Сургуулийн өмнөх 2-4 хүртэлх насны хүүхдүүд юмсыг мэдрэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан танин мэддэг тул шинжлэн судлах арга зүйг шууд хэрэгжүүлэхээс илүүтэй мэдрэхүйд суурилсан тоглоом, орчны туршлагаар суурийг тавих нь чухал. Шинжлэн судлах үйл хүүхдийн юмсыг барих, амсах, түлхэх, унагах зэргээр орчинтой танилцах үйлдлийг дэмжиж хөгжүүлдэг.

Бага насны хүүхдүүд “яагаад?” асуултаар сониуч зан тодорч, шалтгаан-үр дагаврыг ойлгох анхны оролдлогууд гарч ажиглах, харьцуулалт хийх, энгийн таамаглал гаргах зэргээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй. Энэ насны хүүхэд бусдаас ялгаатайгаар бүтээж, туршиж үзэхийг хүсдэг тул бүтээлчээр сэтгэх чадвар хөгжиж эхэлдэг онцлогтой.

Хүснэгт 8. Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх үе шат

Үе шат	Суралцахуйн үйл	Багшлахуйн дэмжлэг
Оролцох үе шат (Өмнөх мэдлэгийг сэргээн сануулах)	<ul style="list-style-type: none"> - Ажиглах - Асуулт асуух - Сонирхох 	Асуултаар эхлэх
		Хүүхдүүд сэдвийг бодох, өөрсдөө асуулт асуух, хариулахад дэмжлэг болно.
Шинжлэн судлах үе шат (Идэвхтэй эрэл хайгуул хийх боломж олгох)	<ul style="list-style-type: none"> - Эрэл хайгуул хийх - Туршилт хийх 	Эрэл хайгуул хийхийг зөвшөөрөх
		Сонирхол татсан асуулт, хариултын дараа хүүхдэд бие даан сонирхох, боломжийг

		олгоход тусална.
Тайлбарлах үе шат (Эргэцүүлсэн ойлголтоо илэрхийлэх боломжийг олгох)	<ul style="list-style-type: none"> - Сонирхон, нээн илрүүлэх - Харилцан ярилцах 	<i>Туршилтын үр дүнг хэлэлцэх</i>
		Хүүхдүүд өөрийн үгээр ярих, тайлбарлахад урамшуулж дэмжиж, ойлгоход тусална.
Нарийвчлан судлах үе шат (Илүү сайн нарийвчлан боловсруулах)	<ul style="list-style-type: none"> - Харьцуулах - Өөрийн үгээр ярих - Хийсэн үйлээ нэрлэх, бататгах 	<i>Хэрэглэгдэхүүн, нэмэлт эх сурвалжаар хангах</i>
		Хүүхдэд хэрэглэгдэхүүн, наадгайг нэмэлтээр хангаж, хэрэглэх боломжтой бөгөөд энэ нь ойлголтыг бататгахад тусалдаг.
Үнэлэх үе шат (Өөрсдийн ойлголтыг үнэлэх боломжийг олгох)	<ul style="list-style-type: none"> - Бүтээл үйлээ өөрөө тайлбарлах, ярихыг оролдох - Санал гарах 	<i>Сурсан мэдсэнээ нэгтгэн дүгнэх</i>
		Сургалт, үйл ажиллагааны төгсгөлд сурсан зүйлээ дүгнэх нь мэдээллийг эргэн санахад тусалдаг.

Хүснэгт 9. Шинжлэн судлахад суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллаганы нэр:	Хэрэглэгдэхүүн:	Суралцахуйн үр дүн:	
Хатуу, зөөлнийг ялгаж.	Хатуу: модон халбага, түлхүүртэй цоож, хатуу сам Зөөлөн: даавуу, зөөлөн тоглоом, хуванцар зөөлөн аяга	БНО2.1в.Ойр орчны эд зүйлс, тоглоомын шинжийг мэдэрч нэрлэн, зориулалтаар нь ашиглана. ХЯ2.1а.Бусдын яриаг анхаарч, үг өгүүлбэрээр ярина. НСХ2.1.а.Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.	
Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх аргачлал			
Үе шат	Суралцахуйн үйл	Хүүхдийн хийх үйл	Багшийн хийх үйл
Оролцох үе шат	Ажиглах ба сонирхох	Эд зүйлсийг ажиглаж, хүрч үзэх, барих	Энгийн асуулт тавих: энэ юу вэ,? хатуу юу, зөөлөн үү, чи юу гэж бодож байна вэ ?
Шинжлэн судлах үе шат	Турших	Хүүхэд цохиж, хөдөлгөж, дуугаргаж, үнэрлэж, нугалж үзэх, хатуу, зөөлөн ялгааг биеэр мэдрэх	Аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн хийж буй үйлийг чиглүүлэх: энийг дарахад юу мэдэрч байна вэ?, энэ нугарах уу?

Тайлбарлах, ойлголтоо илэрхийлэх үе шат	Харьцуулах ба нэрлэх	Хоёр зүйлсийг харьцуулж Энэ хатуу, энэ зөөлөн гэсэн богино өгүүлбэрээр хариулна.	2 эд зүйл үзүүлж “энэ хоёрын алин нь зөөлөн бэ? гэж асууна.
Нарийвчлан судлах, дүгнэх үе шат	Таньж мэдсэн зүйлээ зориулалтаар ашиглах	Эд зүйлийг ангилж, хайрцагт хийнэ. Үгээр болон үйлдлээр өөрийн ойлголтоо илэрхийлнэ.	Хоёр хайрцагт эд зүйлийг Хатуу, зөөлнөөр ангилж хийх даалгавар өгнө. Хүүхдүүдийн сонголтыг ажиглаж, зөв хариултыг бататгана.

Тайлбар: Шинжлэн судлах арга зүй нь хүүхэд хүрээлэн буй орчноо мэдрэхүй, хөдөлгөөн, туршилт, ажиглалтаар танин мэдэх, ингэхдээ асуулт тавих, ямар учиртай вэ гэж сонирхох, хариуг өөрийн туршлагаар олох үйл явц тул хүүхдэд эд зүйлсийг үзүүлэхдээ “Хүрээд үз, ямар байна вэ, нугарч байна уу, зөөлөн мэдрэгдэж байна уу гэх мэтээр аливаа зүйлийг ажиглан өөрийн гараар туршиж үзэх боломж олгоно. Багшийн зүгээс хүүхдийн сонирхлыг ажиглах, Өөрөөр яаж үзэх билээ?, Хатуу аяга, зөөлөн даавуу хоёр юугаараа ялгаатай вэ? гэх мэтээр дахин судлах туршилтад чиглүүлэх, Бид юу олж мэдсэн бэ? гэж ярилцан дүгнэлт хийлгэнэ. Хүүхдийн хэлсэн санааг багш бататган үгийг зөв хэллэгээр давтаж өгөх хэрэгтэй. Хэрэв хүүхэд ихээр сонирхож байвал тухайн эд зүйлсийг Ангийнхаа туршилтын тавиур дээр тавьж дахин судлуулж болно.

Төсөлд суурилсан арга зүй: Үе тэнгийнхэн эсвэл бусадтай харилцах, суралцах үйл явцад төвлөрдөг бөгөөд дараах зорилготой.

- Хамтдаа суралцах, багаар ажиллах, харилцаа холбоог чухалчилдаг.
- Багш бүх үйл ажиллагаанд чиглүүлэн оролцдог.
- Бодит амьдрал дээрх сорилт, асуултууд дээр суурилдаг.
- Нээлттэй, үр дүн нь урьдчилан тодорхойлогдоогүй шинэ зүйл байдаг.

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа багш Та дараах санааг анхаараарай.

- Бодитой байх: Хүүхэд өдөр тутамд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж, мэдлэгээ бодит байдалд ашиглах, хэрэглэх чадварыг нэмэгдүүлдэг.
- Нотолгоонд суурилсан байх: Хүүхдээс асуулт асуух, судлахад дэмжлэг үзүүлэхэд суурилах нь сониуч зан, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлдэг.
- Хугацааг төлөвлөх: Богино, дунд, урт хугацаагаар хэрэгжүүлэх боломжтойгоор төлөвлөх нь хүүхдэд дахин судлах, эрэл хайлт хийх, сонирхох, ярилцах зэрэг ур чадварыг хөгжүүлэх боломжийг олгодог.
- Хүүхэд төвтэй байх: Хүүхдүүд хамтран юу судлахаа шийдэх нь тэдний сониуч занг өдөөж, мэдэх, хийх хүсэл эрмэлзлийг төрүүлж, оролцоо, урам зориг өгдөг.
- Нэгдмэл байх: Сургалт, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн сургалтын чиглэлүүдийг нэг цогц болгон нэгтгэдэг.
- Өөрийгөө удирдах: Хүүхэд суралцахуйн явцдаа өөрийгөө хянах, хариуцлага хүлээх чадварт суралцаж эхэлдэг.
- Хамтын ажиллагаатай байх: Хүүхдүүд бусадтай ярилцаж, хамтрах, туслах, дэмжих замаар асуудлыг шийдэж, харилцах чадварын эхлэл тавигддаг.

- Түүнчлэн хүүхдүүдийн харилцан ярилцлага, тоглоомын явцад гарсан санаа зэргийг баримжаалан сэдэв, санааг гаргаж болно.

Хүснэгт 10. Төсөлд суурилсан арга зүйг хэрэгжүүлэх багшлахуй, суралцахуй

Суралцахуй	Багшлахуй
<p>Ажиглах, турших:</p> <ul style="list-style-type: none"> - Байгальд гарсан өөрчлөлт (ургамал, цаг агаар гэх мэт)ийг ажиглах - Туршилт (барих, үнэрлэх, амтлах өөрөө хүртэж мэдрэх) - Хүн, амьтан, юмсын үйлдлийг ажиглах - Бодит орчныг ажиглах <p>Тоглох:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд өөрөө хийж үзэх, бусдын дэмжлэгтэй, даган дуурайж, бие даан тоглох - Дүрсэлж үзүүлэх тоглоом (амьтны хөдөлгөөн дуу авиаг дуурайх) - Барьж бүтээх тоглоом - Судалж буй агуулгад тохирсон хөдөлгөөнт, хөгжимт тоглоом тоглох <p>Бүтээх, урлах:</p> <ul style="list-style-type: none"> - Зурах, наах, зохион бүтээх - Байгалийн болон дахин боловсруулах материалаар бүтээл хийх - Шавар, элсээр бүтээх - “Энэ юу вэ? хаана байна вэ?” гэх мэт асуулт асуух - Бусдыг даган дуурайх, асуусан асуултад үйлдлээр хариулах, заах, нэрлэх - Төсөлтэй холбоотой дуу, шүлэгт суралцах <p>Төслийн үр дүнг танилцуулах:</p> <ul style="list-style-type: none"> - Хийсэн бүтээлээ харж баярлах - Хийсэн зүйлээ бусдад үзүүлэх - Баярлаж буйгаа үйлдлээр илэрхийлэх - Хамтдаа үзэсгэлэн гаргах - Хамтын бүтээлээ бусдад үзүүлэх 	<p>Сонирхлыг өдөөж, сэдэлжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Асуудал дэвшүүлж, “Энэ юу вэ?” гэх мэт асуултаар өдөөх - Хүрч мэдрэх боломжийг олгох (барьж, тэмтрэх, үнэрлэх, амтлах) - Сэдэвт тохирсон ном, зураг, бодит материал ашиглан сонирхлыг нэмэгдүүлэх <p>Төслийн үе шат бүрд чиглүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - багш эхлээд биечлэн хийж үзүүлэх, хамтдаа хийх боломжийг олгох, чиглүүлэх - хүүхэд оролцох боломжтой зүйлийг өөрөө хийж, туршиж үзэхэд чиглүүлэх - Цаг хугацаа болон орчныг зөв зохион байгуулах <p>Хүүхдийн оролцоог дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - туршиж үзэх, өөрөө хүрч мэдрэх боломжийг олгох - Алдах, дахин оролдох үйлийг дэмжих - Хийсэн зүйлийг магтах, бүтээлч байдлыг дэмжих - Нэрлэсэн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, шинэ үг хэлж сурахад чиглүүлэх - Зурагт ном, зурган зааварчилгааг заах, нэрлэх, үйлдлээр илэрхийлэх оролдлогыг дэмжих <p>Хөгжлийг дэмжих, урамшуулах</p> <ul style="list-style-type: none"> - Туршилт, ажиглалт хийх орчин бүрдүүлэх (ус, элс, байгалийн материал) - Хөдөлгөөн оролцсон үйл ажиллагаа төлөвлөх - Зурах, барих, өрөх, хөдөлгөөн хийхэд дэмжих - Хүүхдийг ажиглаж тэмдэглэх - эцэг эх, асран хамгаалагч, багш хамтран хүүхдийн бүтээлийг танилцуулах, үзэсгэлэн гаргах, бусадтай хуваалцах

Хүснэгт 11. Төсөлд суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллагааны нэр	Хэрэглэгдэхүүн	Суралцахуйн үр дүн
Усны шинж чанарыг танин мэдье Хугацаа: 7 хоног	Тунгалаг шилэн сав, аяга, ус, жижиг сав, юүлүүр, мөс, халуун, хүйтэн ус, соруул, Цаас, бийр, усан будгийн багц, усны зураг, усны амьтад	БНО2.1г.Байгалийн үзэгдлийг ялгаж таних, ажиглаж ярилцана. ХЯ2.2в.Юмсын өнгө,хэмжээ, байрлал заасан үгээр ярина. ЗУ2.2а.Зураас дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ.

Суралцахуйн үйлүүд	Үйл ажиллагаа	Багшлахуйн дэмжлэг
Ажиглах	Цэвэр ус, бохир ус, мөс, буцалж буй ус, өнгөт усыг ажиглана. Усны өнгө, үнэр, хэлбэр, хөдөлгөөнийг анзаарна. Ус урсаж, дусалж байгааг сонсоно.	Ус ямар өнгөтэй байна вэ?, Хүйтэн байна уу?, урсаж байна уу, уур гарч байна уу?, урсаж байна уу? гэсэн асуултаар хүүхдийн анхаарлыг төвлөрүүлнэ. Багшийн асуулт: Яагаад ус халуун байна вэ?, Яагаад ус хүйтэн байна вэ?
Турших	Урсаж байгаа мөн хүйтэн усанд гараа дүрэх, мөс барих, ус халуун, хүйтэн үед ямар байдлаар өөрчлөгдөхийг харна. Усанд өнгө нэмж үзнэ, хөвдөг, живдэг зүйлсийг туршина.	Ямар зүйл живж байна вэ?, яагаад мод хөвж байна вэ? асуулт тавьж аюулгүй орчин бүрдүүлэн хүүхдээр үйлдэл хийлгэнэ.
Тоглох	Ус юүлж, хувингаар зөөж, шанагаар хутгаж, аягалж, шилэн дотор хийх, хоолойгоор ус урсгаж тоглох Хөөс, саван ашиглан тоглох	Хүүхдийг чөлөөтэй оролцуулан тоглуулах орчин бүрдүүлэх, усаа юүлье, хөөс болгон үлээе, ус хувингаар зөөцгөөе, хоолойгоор урсгаж тоглоё гэх мэт оновчтой үгээр чиглүүлэх
Бүтээх, урлах	Гол, горхины ус будах, усны дусал будах, хөөсөөр үүл наах, бороотой өдөр гэх мэт сэдэвт зураг зурах	Төрөл бүрийн материалаар туршиж, өөрийн санаагаар бүтээж урлахыг сэдэлжүүлэх Загвар зурж, дүрсэлж чиглүүлэх Багшийн үүрэг: ажиглагч, чиглүүлэгч, орчныг бэлдэгч, хамтран тоглогч, туршигч
Төслийн үр дүнгээ танилцуулах	Өөрийн бүтээл, туршилтаа найзууддаа үзүүлж нэрлэх, туршилтаа өөрийн үгээр тайлбарлах оролдлого хийх	Чи юу хийсэн бэ?, Яагаад ингэж бодсон бэ? гэх мэтээр асууж хэл яриагаар өөрийгөө илэрхийлэхийг дэмжиж чиглүүлэх

Уг төсөлд ажлаар усны шинж чанарыг туршиж мэдэх, хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, байгальтай харилцах зөв дадлыг төлөвшүүлэх зорилготой. Багш нь хүүхдийг ажиглах, чиглүүлэх, аюулгүй орчныг бүрдүүлэх, дэмжих, бие даан турших, тоглох боломж олгох үүрэгтэй. Ажиглах, турших, тоглох, бүтээх, хийсэн зүйлээ танилцуулах нь хүүхдийн үүрэг юм.

Төслийн үе шат нь 3-5 өдөр үргэлжилж болно. Энэ насны хүүхдийн хэл ярианы хөгжил харилцан адилгүй байдаг тул үг, дохио, зураг, үзүүлэн, бодит материал ашиглан ойлголцоно. Төслийг багшийн идэвхтэй оролцоотой, бүлгээр хэрэгжүүлэх ба биеийн мэдрэмж, мэдрэхүйн туршлага давамгайлсан үйл ажиллагаа байхад багш нар анхаарах хэрэгтэй.

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IX САР

ХАМТДАА ТОГЛОЁ

Хүүхдийн эзэмших чадамж :

Бүтээлчээр сэтгэх: Тоглоом, үйл ажиллагааны явцад хүүхдийн төсөөлөх, дүр бүтээх зэрэг үйлийн явцад хувь нэмрээ оруулна.

Харилцах: өөрийн бүтээл, тоглоомын тухай тайлбарлах, бусадтай харилцах зэрэг суралцахуйн үйлүүд хувь нэмрээ оруулах болно.

Аюулгүй байдлын зөвлөмж: Тоглоом, наадгайн овор хэмжээ хүүхдэд тохирсон эсэх, хүүхдийн суралцах үйлийг дэмжихүйц байхаар материаллаг болон үйлийн орчныг бүрдүүлсэн байна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Багш та хүүхдүүдтэй тоглож, тэднийг ажиглаж, шаардлагатай чиглүүлэг, тохируулгыг хийгээрэй.

Төвийн үйл ажиллагаа:

- Хүүхдүүд найзаа нэрлэх, ярилцах, хурууны дардсаар бүтээл хийх зэрэг үйлийг дэмжин урамшуулаарай. Өөрийн бүтээлээ тайлбарлах боломжийг олгож, хүүхдийн яриаг анхааралтай сонсоорой.

Зугаалга:

- Хүүхдүүд гадаа талбайд хөлийн мөр дээр гишгэж тоглох, хамтдаа ажиглах, сонирхох үйлийг дэмжээрэй.

Багш та бүлгийн өдрийн хуваарь, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтөө баяжуулаарай.

Боломжууд: Хүүхдүүд үйл ажиллагаанд оролцох, хамтрах явцад тэдний үг, үйлдлийг ажиглаж, бүтээлч, сонирхолтой байх, шинэ нөхцөл байдал, сорилтыг давах, хүүхэд асуудлаа өөрөө шийдвэрлэхэд нь чиглүүлээрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЭМ2.1б.Суугаа байрлалд шагайн үеэр эргүүлэх, өлмий ба өсгийг нийлүүлэх, салгах хөдөлгөөнийг гүйцэтгэнэ. БНО2.2а. Нэр, насаа хэлж, өөрийн болон бусдын эд зүйлс, тоглоомыг ялгана.	<ul style="list-style-type: none"> - Өөрийн нэр, насаа хэлэх - Суугаа байрлалд өлмий өсгийг салгаж, нийлүүлэх, хөлөө өргөн дүрс зурж тоглох - Найзынхаа эд зүйлийг олж өгөх 	Зогсоорой
НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.	<ul style="list-style-type: none"> - Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоор тоглох - Өөрийн таних тэмдгийг таних, бусдынхтай харьцуулах - Ойр орчмын дуу чимээ танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх. 	Олоорой
ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. ХЯ2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна.	<ul style="list-style-type: none"> - Дууны аянд хөдөлгөөн хийх - Мэдрэмжээ илэрхийлэх - Хөдөлгөөнт дууг дагаж дуулах 	Алгаа ташаарай
ХЯ2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна. ХЭМ 1.2 а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр хамтран хийнэ.	<ul style="list-style-type: none"> - Гарын хуруу, хумс дээр зурах, угаах - Бодит болон зурагт үзүүлэн ашиглан гар угаах тоглоом тоглох - Ойр орчны дуу чимээ, танил үг өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх 	Гараа угаацгаая
ХЭМ2.1г. Алхаж, гүйхдээ гар хөлийн хөдөлгөөнөө хослуулан хурдан, удаан гүйцэтгэнэ. ХЭМ2.1б. Суугаа байрлалд шагайн үеэр эргүүлэх, өлмий ба өсгийг нийлүүлэх, салгах хөдөлгөөнийг гүйцэтгэнэ. МАТ2.1а. 5 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолох, олон ба цөөн тооны тоглоом, юмсыг зааж, хэлнэ.	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн хэмнэлийн дагуу урагш хойш алхах, хөлөө товших. - Хөлөө зөрүүлэн тавьж, тэнцвэрээ олж зогсох. - Гараа урагш сунгаж бөхийх, эгцрэхдээ гараа нугалан татах - Юмсыг нэг тоогоор нэрлэж, тоолох 	Олсоор наадъя
ХЯ 2.1а Бусдын яриаг анхаарч	<ul style="list-style-type: none"> - Ойр орчны дуу чимээ, танил үг 	Ямар өнгийн

<p>сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна. МАТ2.16. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна. ЗУ2.3в. Өрж байгуулах, эвлүүлж угсрах аргаар бие дааж тоглоом, эд юмсыг зохион бүтээнэ.</p>	<p>өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх</p> <ul style="list-style-type: none"> - Өрж байгуулах тоглоом, тараах материалын байрлалыг ажиглах, байрлуулах - Хоёр өөр өнгийн ижил хэмжээтэй тоглоомын давтамжтай өрөх 	<p>машин авах вэ?</p>
<p>ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ ХЯ2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна.</p>	<ul style="list-style-type: none"> - Дууны аянд хөдөлгөөн хийх - Мэдрэмжээ илэрхийлэх - Хөдөлгөөнт дууг дагаж дуулах - Ойр орчны дуу чимээ, танил үг өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх 	<p>Таш таш</p>
<p>БНО2.2б. Гэр бүлийн гишүүдийн талаар ярьж, тэдний ажил мэргэжил хэрэглэдэг хувцас, ажлын багаж хэрэгслийг ялган танина. НСХ2.16. Өөрийн хэрэгцээг илэрхийлдэг болно. ХЯ2.1а. Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна.</p>	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн гишүүдээ нэрлэх, дуу сонсох, дуулах - Гэр бүлийн гишүүдийг зураг, биет үзүүлэнг ашиглан нэрлэх - Дуу утгыг асуултын дагуу ярих, дагаж хэлэх - Зохиомжийг сонсож, асуултын дагуу ойлгосноо ярих, дагаж хэлэх 	<p>Хуруун гэр бүл</p>
<p>БНО2.2б. Гэр бүлийн гишүүдийн талаар ярьж, тэдний ажил мэргэжил хэрэглэдэг хувцас, ажлын багаж хэрэгслийг ялган танина. ХЭМ2.2б. Цэвэр болон бохирдсон хувцсыг ялгана.</p>	<ul style="list-style-type: none"> - Хэн юу өмссөн бэ? тоглоом тоглох - Хэнийх вэ? тоглоом тоглох - Хэрэглэсэн зүйлээ хураах, цэгцлэх 	<p>Хувцасны загвар</p>

9 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Зогсоорой	Зугаалга	Хүүхдүүд гадаа үүл байгаа эсэх, ямар хэлбэр өнгөтэйг ажиглаж, ярилцана. Мөн олбог дээр тойрог болон суугаад, багшийн заавраар хөлийн өлмий өсгийг нийлүүлэх, салгах хөдөлгөөн хийж тоглоно.	Том, жижиг хөлийн хэв бүхий бэлдэц.	Хөлөө нийлүүлээрэй. Нэрээ хэлээрэй. Өсгийгөө нийлүүлээрэй. Хамгийн том нь хэний хөл вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Юмсын хэлбэр, өнгийг ажиглах, ярилцах, төсөөлөх	Тэнгэрийн байдлыг ажиглаж цэлмэг, бүрхэг гэж ялгаж нэрлэдэг. Хөлийн өлмий, өсгийг салгаж, нийлүүлэх хөдөлгөөн хийдэг.
Олоорой (Ижлийг олоорой)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоос сонгож, өгсөн зүй тогтол бүхий тараах материалыг дараалуулан байрлуулж тоглоно.	Таних тэмдэгтэй наадгай, леги, усан будаг, зургийн дэвтэр	Чи аль зургийг сонгох вэ? Чиний зурагтай ижил байна уу? Чи найзуудтайгаа хамт тоглоход баяртай байдаг уу?.	Бүтээлчээр сэтгэх: Зүй тогтлыг ажиглаж, дуурайх Харилцах: Тэмдэг тэмдэглэгээг таних	Өөрийн болон бусад хүүхдийн таних тэмдгийг танин ялгадаг. Зүй тогтлын дарааллыг ажиглаж дуурайдаг.
Олоорой (Хэлээд зураарай)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Толинд харж багштай хамт нүүрний хэсгүүдийг (царай, нүд, хамар, ам) нэрлэж илнэ. Усан будаг ашиглан гарын хэв гаргаж нүд, хамар, амаа зурна.	Усан будаг, зургийн дэвтэр, толь	Толинд нүүрээ харахад юу юу харагдаж байна вэ? нэрлээрэй, царай, хамар, уруулаа илээрэй.	Бүтээлчээр сэтгэх Алга, хуруугаар зурах. Харилцах: Бусдын яриаг анхаарч сонсох, хариулах	Нүүрэн дээр эрхтнээ нэрлэж, эрхтнүүдийн үүргийг нь мэддэг. Гарын алга, хурууны даралтаар хэв гарган зурдаг.
Алгаа ташаарай (инээгээрэй, тоглоорой, бүжиглээрэй)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа / Зугаалгын цаг / Хөгжөөн баясах цаг	Хөгжимт хөдөлгөөнийг зурагт үзүүлэнгийн дагуу хийж, бүжиглэнэ. Элс (гурил)-ний хайрцаг дотор гарын хэвийг дуурайлган үүсгэж тоглоно. Хөгжим зогсоход сэтгэл хөдлөлийн зурагт	Зурагт үзүүлэн (алга таших, алхах, инээх үйлдэл бүхий), хөгжмийн ая, алгаа нийлүүлсэн хэв бүхий бэлдэц, элс, гурил.	Дагаад хамтдаа хийх үү? Чи гараа элсэнд дүрж үзэх үү? Энэ ямар царай вэ? Чи ямар үед инээдэг вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хөгжмийн ая, хэмнэлд тохирсон хөдөлгөөн хийх Харилцах: Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх	Зурагт заасан үйлдлийг дуурайж хийдэг. Хөгжимт хөдөлгөөнийг аянд тохируулан дагаж хийдэг. Гарын хэвийг дуурайлган үүсгэдэг.

		картад тохирсон нүүрний хувирлыг хийж үзүүлнэ.				
Гараа угаацгаая	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Багш хүүхдүүдийн гар дээр цэг зурна.Цэг зурсан хэсгүүдийг аргачлалын дагуу угааж туршина.(хурууны завсар, хумс, эрхий хурууг угаах).	Эсгий бал Гар угаахад хэрэглэгдэх зүйлс (угаагуур, саван, алчуур)	Хурууны завсар хэсэгт эсгий балаар цэг зурвал болох уу? Одоо гараа угааж үзэх үү? Гаран дээр зурсан цэгүүд арилсан байна уу?	Бүтээлчээр сэтгэх: Асуудлаа өөрөө шийдвэрлэх Харилцах: Гар угаах тоглоом тоглох, аргачлалыг сонсох	Гарыг аргачлалын дагуу угаадаг.
Олсоор наадъя (Алгаа ташаарай)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Олсны хоёр талд хоёр эгнээ болж хөгжмийн хэмнэлээр урагш, арагш алхаж хөлөө хөдөлгөөн хийж тоглоно. "Нэг" дохиогоор нэг хөл дээр, "Хоёр" дохиогоор хөлөө зөрүүлэн тавьж тэнцвэрээ олж зогсоно.	Урт олс, дугуй дүрс, хөгжмийн ая.	Урагшаа, арагшаа алхаарай Тэнцвэрээ хадгалан зогсоорой	Бүтээлчээр сэтгэх: Шинэ нөхцөл байдал, сорилтыг давах (тэнцвэрээ олох). Харилцах: Хамтран ажиллах	Урагшаа, арагшаа ухарч алхдаг. Нэг хөл дээр болон зөрүүлэн тавьсан байрлалд тэнцвэрээ хадгалан зогсдог.
Олсоор наадъя (Олс/Олсон зам)	Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа	Тойргоор сууж олсоо барин, баруун, зүүн тийш хазайх, гараа өргөж буулгах, сэлүүрдэх хөдөлгөөн хийж тоглох, мөн урт олсыг газар янз бүрийн хэлбэр үүсгэн, олсон дээгүүр цуварч алхах, давж үсэрч тоглоно.	Урт олс	Живэхгүйн тулд бид яах ёстой вэ? Олсыг яаж хөөлгөвөл давлагаа болох вэ?	Бүтээлчээр сэтгэх: Дүр бүтээх, төсөөлөх	Зааврын дагуу хөдөлгөөнийг бусадтай хамтран зэрэг гүйцэтгэдэг.
Ямар өнгийн машин авах вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дүрсүүдийг тойруулан өрж байгуулах тоглоомоор зам өрөх ба замтайгаа ижил өнгийн машин сонгож замаар явуулна. Мөн өөр дуртай зүйлээ бүтээж	Өрж байгуулах тоглоом, өнгө өнгийн машин, өнгө өнгийн дүрс бүхий тараах материал.	Замыг яаж өрөх вэ? Энэ замаар ямар өнгийн машин явах вэ? Өөр юу зохион бүтээх вэ?	Бүтээлчээр сэтгэх: Өрж байгуулах, эвлүүлж угсрах, бие дааж тоглоом, эд юмсыг зохион бүтээх	Өрж байгуулах тоглоомоор зааврын дагуу болон өөрөө сэтгэж зохион бүтээдэг.

		ТОГЛОНО.				
Хуруун гэр бүл (Манай гэр бүл/Итгэл хүү)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Гэр бүл" дууг сонсож, хуруун хүүхэлдэйг өмсөн гэр бүлийн гишүүдийн дүрд хувирч, жүжигчлэн тоглоно. Мөн "Итгэл хүү" зохиомжийг сонсож, хүүхдүүд хэнээс яагаад тусламж авах хэрэгтэйг мэдэж авна.	Гэр бүлийн сэдэвт хуруун хүүхэлдэй, зурагт карт, "Итгэл хүү" зохиомж	Эрхий хуруу гэр бүлийн ямар гишүүнийг төлөөлж байна вэ? Ээж хуруугаа заагаарай? Танай гэрийнхнээс хэн чамд тусалдаг вэ?. Зураг дээр ямар хүмүүс байна вэ? Эмч ямар хүмүүст тусалдаг вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Хуруун хүүхэлдэйгээр дүр бүтээх. Харилцах: Гэр бүлийн гишүүдээ нэрлэх, зохиомжийг сонсож, ойлгосноо ярих, өөрийн хэрэгцээг илэрхийлэх.	Хуруун хүүхэлдэй ашиглан дүрд хувирч тоглодог. Тусламж авах хэрэгтэй хүмүүсийг мэддэг.
Хувцасны загвар	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд шоо орхиж, буусан хувцсыг сагснаас сонгон авч, өмсөж загварын шоу үзүүлнэ. Үйл ажиллагаа дуусахад хувцсаа тайлж, эвхэж хураана.	Хувцасны зурагтай гурван ширхэг шоо, цамц, өмд, дашинз, дээл, хантааз зэрэг хувцасны зураг хийсэн 3 сагс	Хэн ямар хувцас өмссөн бэ? Дээл өмсөхөд ямар байсан бэ? Чамд ямар хувцас хамгийн гоё байсан бэ?.	Бүтээлчээр сэтгэх: Хувцас өмсөж дүр, загвар бүтээх Харилцах: Хамтран тоглох дүрмийг тайлбарлах, хэрэглэсэн зүйлээ хураах, цэгцлэх	Хувцсыг тохируулж өмсдөг болохыг мэддэг.

9 дүгээр сарын I долоо хоног

ЗОГСООРОЙ

Шинэ үг: Хөлийн өлмий, өсгий, шагайн үе

Үйл ажиллагаа 1. Дагаад хийгээрэй (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Том, жижиг хөлийн хэв бүхий бэлдэц

Аргачлал: Хүүхдүүд зугаалгаар гадаа тоглоомын талбайд гарна. Тэнгэрт үүл байгаа эсэхийг ажиглана. Хэрэв үүл байвал ямар хэлбэртэй, ямар өнгөтэй байгааг хэлнэ. Үүлний талаар ярилцана. “Дагаад хийгээрэй” тоглоом тоглоно. Олбог дээр тойрог болон сууна. Багшийн заавраар хөлийн өлмий өсгийг нийлүүлэх, салгах, өлмийг эргүүлэх хөдөлгөөн хийж тоглоно.

Багшийн чиглүүлэг заавар:

- Хөлөө нийлүүлээрэй
- Нэрээ хэлээрэй
- Өлмийгөө нийлүүлээрэй
- Насаа хэлээрэй.
- Өсгийгөө нийлүүлээрэй.
- Хамгийн том нь хэний хөл вэ?
- Хөлийн жижиг нь хэнийх вэ?

ОЛООРОЙ

Үйл ажиллагаа 1. Ижлийг олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Таних тэмдэгтэй наадгай, леги, усан будаг, зургийн дэвтэр

Аргачлал: Хүүхдүүдийн таних тэмдгийг өрж байгуулах тоглоом, наадгай дээр наасан байна. Хүүхэд бүр тоглоомоос сонгон авч багшийн өгсөн зүй тогтол бүхий тараах материалыг дараалуулан байрлуулж тоглоно. Өөрийн сонгосон тараах материалыг зөв дуурайн хийсэн бол өөр төрлийн тараах материал сонгон авч болно.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Чи аль зургийг сонгох вэ?
- Тоглоомыг ажиглаарай. Чиний зурагтай ижил байна уу?
- Чи найзуудтайгаа хамт тоглоход баяртай байдаг уу?

Үйл ажиллагаа 2. Хэлээд зураарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хамтдаа тоглоё. Усан будаг ашиглан зургийн дэвтэр дээр гарын хэв зурна. Толинд өөрийгөө харна. Багш хүүхдүүд “царай” гэж хэлээд хурууны үзүүрээр өөрийнхөө нүүрний хэсгийг тойруулан илнэ. “Нүд” гэж хэлээд, нүдээ толинд заана. “Хамар” гэж хэлээд, хоёр гараараа хамраа доороос дээшээ илнэ. “Ам” гэж хэлээд уруулаа хоёр гараараа илнэ. Зургийн дэвтэр дээрх гарын дардас дээр нүд, хамар, амаа зурна.

АЛГАА ТАШААРАЙ

Хэрэглэгдэхүүн: Алга таших, дороо алхах, инээх үйлдэл бүхий

зурагт үзүүлэн, хөгжмийн ая, алга нийлүүлсэн хэв бүхий бэлдэц, элс, гурил

Үйл ажиллагаа 1. Инээгээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хананд байрлуулсан алга таших, дороо алхах, инээх үйлдэл бүхий зурагт үзүүлэнг ажиглана, хамтдаа дуурайна. “Алгаа таш” хөгжимт хөдөлгөөнийг хамтдаа хийж ая, хэмнэлд тохируулан бүжиглэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Дагаад хамтдаа хийх үү?
- Чамд ямар байна вэ?

Үйл ажиллагаа 2. Тоглоорой (Зугаалгын цаг)

Аргачлал: Алгаа салгасан, нийлүүлсэн хоёр гарын дардас бүхий хэв бүхий тараах материалыг хүүхэд бүрд тарааж өгнө. “Алгаа таш” дууны аяыг тавьсан байна. Багш хүүхдүүд элс (гурил)-ний хайрцаг дотор гарын хэвийг дуурайлган үүсгэж тоглоно. Хүүхдүүд дууг дагаж дуулж болно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи гараа элсэнд дүрж үзэх үү?
- Гарын хэв гарсан байна уу?
- Зурагтай адилхан байна уу? Инээж үзүүлэх үү?
- Одоо тоглож дуусаад гараа угаах уу?
- Чамд хамт тоглоход ямар байсан бэ?
- Чи уурласан уу? инээсэн үү?

Үйл ажиллагаа 3. Бүжиглээрэй (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: “Алгаа таш” дууны аянд хүүхдүүд тойргоор бүжиглэнэ. Хөгжмийн ая зогсоход багш сэтгэлийн хөдөлгөөний зурагт карт өргөнө. Хүүхдүүд зургийг ажиглаж, тохирсон нүүрний хувирлыг хийж үзүүлнэ. Дахин хөгжмийн аянд хүүхдүүд бүжиглэнэ. Хөгжмийн ая зогсоход нэг хүүхэд сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зурагт картыг өргөж, бусад хүүхдүүд нүүрний хувирлыг үзүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хамтдаа бүжиглэх үү?
- Энэ ямар царай вэ?
- Та нар царайгаараа үзүүлээч?
- Яагаад ууртай байгаа юм бол оо?
- Чи ямар үед инээдэг вэ?

ГАРАА УГААЦГААЯ

Үйл ажиллагаа 1. Гараа угаацгаая (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Эсгий бал

Аргачлал: Багш, хүүхдүүд зүүн гарын хурууны завсар, хумс, эрхий хуруун дээрээ эсгий балаар цэг зурна. Цэг зурсан хэсгүүдийг арилгах байдлаар гарыг аргачлалын дагуу угааж үзнэ.

- Хурууны завсар зурсан цэг: Гараа угаахдаа нэг гарын алган доор нөгөө гарын ар хэсгийг байрлуулж, доод гарын хуруун завсраар дээд гарын хуруунуудыг байрлуулж, угаана.
- Хумсан дээр зурсан цэг: Нэг гарын алган дээр нөгөө гарын хуруунуудыг байрлуулж угаана.
- Эрхий хуруун дээрх цэг: Нэг гараар нөгөө гарын эрхий хурууг барьж, үрж угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хурууны завсар хэсэгт эсгий балаар цэг зурвал болох уу?
- Эрхий хуруу нь хаана байна вэ?
- Одоо гараа угааж үзэх үү?
- Гаран дээр зурсан цэгүүд арилсан байна уу?.

ОЛСООР НААДЪЯ

Сургалтын хэрэглэгдэхүүн: Урт олс, дугуй дүрс, хөгжмийн ая

Үйл ажиллагаа 1. Алгаа ташаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Талбайн голд урт олс байрлуулж, олсны хоёр талд хүүхдүүд хоёр эгнээгээр, өөд өөдөөсөө харж, 2 метрийн зайтай зогсоно. Хөгжмийн хэмнэлийн дагуу урагш гурав алхаад, алгаа ташна. Арагш гурав алхаад, хөлөө дороо товшино.

Даалгавартай гүйлт: Хүүхдүүд талбайд чөлөөтэй гүйнэ. Багшийн “Нэг” гэсэн дохиогоор нэг хөл дээр зогсоно. “Хоёр” гэсэн дохиогоор хөлөө зөрүүлэн тавьж, тэнцвэрээ олж зогсоно.

Үйл ажиллагаа 2. Олс (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхэд бүр урт олсноос барьж тойргоор хөлөө жийж сууцгаана. Олсоо барьж баруун, зүүн тал руу хазайна. Олстой гараа өргөж буулгана. Олстой гараа урагш сунгаж бөхийж, эгцэрнэ. Дээш харж хэвтэн хөлөө өргөж, сэгсэрч суллана.

Сэлүүрдээрэй: Урт олсноос барьж сууцгааж, бид усан онгоц дээр хөвж явна. Живэхгүйн тулд бид яах ёстой вэ? Сэлүүрдэнэ. Сэлүүрдэх хөдөлгөөнийг багш биечлэн үзүүлнэ. “Сэлүүрдээрэй” дохиогоор гараа урагш сунгаж бөхийх, эгцрэхдээ гараа нугалан татах байдлаар сэлүүрдэх хөдөлгөөн хийнэ.

“Далайн давлагаа гарлаа” дохиогоор хүүхдүүд баруун зүүн тал руу хазайна. Мөргөлдөхөөс болгоомжилж хүүхдүүд зэрэг баруун/зүүн гэж хэлж зэрэг гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 3. Олсон зам (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Урт олсыг газар янз бүрийн хэлбэр үүсгэж байрлуулна. Багшийн “Муруй замаар аялцгаая” дохиогоор:

- Олсон дээгүүр цуварч явна.
- Гар гараасаа хөтлөлцөн олсон дээгүүр хажуу талаараа хавсарч алхана.
- Олсны хоёр талд давж үсрэхдээ 1-4 хүртэл тоолно.

Тайвшруулах дасгал. Хүүхдүүд хөлөө жийж суугаад, амьсгалын дасгал хийнэ

9 дүгээр сарын II долоо хоног

ЯМАР ӨНГИЙН МАШИН АВАХ ВЭ?

Шинэ үг:

Хэрэглэгдэхүүн: Өрж байгуулах тоглоом, өнгө өнгийн машин, өнгө өнгийн дүрс бүхий тараах материал

Аргачлал: Өрж байгуулах тоглоомыг хүүхдүүдэд өгнө.

- Ширээн дээр хоёр дүрсийг байрлуулсан байна.
- Хүүхдүүд өрж байгуулах тоглоомоор дүрсээ тойруулан зам өрнө.
- Хүүхдүүд замтайгаа ижил өнгийн машин сонгон авч замаар явуулна.
- Өрж байгуулах тоглоомоор хүүхдүүд өөр дуртай зүйлээ бүтээж тоглоно.

ЭЛСЭЭР ТОГЛОЁ

Үйл ажиллагаа 1. Элсэн бөмбөг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Элс, ус

Аргачлал: Хүүхдүүд элс рүү усыг тохируулан хийгээд элсэн бөмбөг хийж тоглоно. Элсэн бөмбөгөө тавиур дээр байрлуулна. Хатахаараа өнгө нь хэрхэн хувирч байгааг ажиглаж, ярилцана.

Үйл ажиллагаа 2. Элсэн дээр зуръя (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Элсэн самбар, хуванцар халбага эсвэл жижиг сойз.

Аргачлал: Хүүхэд өөрийн хүссэн дүрсийг зурна. (Нар, мод, байшин, амьтан гэх мэт) Хүүхдүүдийг юу зурсныг асууж ярилцана. Тоглоомын дараа салхи үлээлээ гэж гараараа зөөлөн тараан элсэн дээр зурсан зургаа арилгаж тоглоно. Гадаа зугаалгаар гарсан үед элсэн дээр хөлийн мөр гаргаж тоглож болно.

ХУРУУН ГЭР БҮЛ

Хэрэглэгдэхүүн: Гэр бүлийн сэдэвт хуруун хүүхэлдэй, зурагт карт, “Итгэл хүү” “зохиомж

Үйл ажиллагаа 1. Манай гэр бүл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхдүүд тойргоор зогсоно. “Гэр бүл” дууг сонсож, утгыг ярилцана.

“Гэр бүл” дууг сонсож, багшийн хөдөлгөөнийг дуурайна.

Багшийн бэлтгэсэн хуруун хүүхэлдэйнээс нэгийг авч “би аав” гэж хэлээд, эрхий хуруундаа өмсөнө. Хүүхдүүд хуруун хүүхэлдэйнээс сонгон авч хуруундаа өмсөнө. Хамтдаа гэр бүлийн гишүүдийн дүрд хувирч, дуу хоолойг жүжигчлэн тоглоно.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Эрхий хуруу гэр бүлийн ямар гишүүнийг төлөөлж байна вэ?
- Ээж хуруугаа заагаарай? Ээж инээж байна уу?
- Аав инээж байна уу? Дүү хурууг нэрлээрэй гэх мэтээр ярилцана.
- Танай гэрийнхнээс хэн чамд тусалдаг вэ?
- Чи гэрийнхэндээ тусалдаг уу?

Үйл ажиллагаа 2. Итгэл хүү (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхэд бүр гэр бүлийн гишүүд, эмч, цагдаа, багшийн зурагт картаас өөрийн сонголтоор авна. Багш “Итгэл хүү” зохиомж ярьж өгнө.

Итгэл хүү дэлгүүрт төөрчээ. Хүү айсандаа яах бол? Итгэл хүү айсандаа уйлж гэнэ. Гэхдээ хүү хэнээс тусламж авах вэ? гэж боджээ. Та нар Итгэлд хэнээс тусламж аваарай гэж зөвлөх вэ?

Хүүхдүүд багшийг асуухад картаа өргөнө. Яагаад гэдгийг тайлбарлана.

Хүүхдүүд итгэж болох хүмүүст хэн хэн ордгийг мэдэж авна.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Зураг дээр ямар хүмүүс байна вэ? Нэрлээрэй.
- Эмч ямар хүмүүст тусалдаг вэ?
- Цагдаагаас хэн тусламж хүсэж болох вэ?
- Чи ямар үед аав ээжээсээ тусламж хүсэх вэ?.

ХУВЦАСНЫ ЗАГВАР

Үйл ажиллагаа 1. Хувцасны загвар (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: “Гэр бүл” хуруун хүүхэлдэй, “Хуруун гэр бүл” хүүхдийн дууны бичлэг. Хувцасны зурагтай гурван ширхэг шоо, цамц, өмд, даашинз, дээл, хантааз зэрэг хувцасны зураг хийсэн 3 сагс, хүүхдийн хэрэглэдэг эд юмсын зураг

Аргачлал: Хүүхдүүд гурван баг болж зогсож, гурван шооноос сонгож авна.

Хүүхдүүд шоогоо орхиж, буусан хувцсыг сагснаас сонгож авна. Сонгосон хувцсаа өмсөж загварын шоу үзүүлнэ. Улаан, хөх, ногоон өнгийн туузан замаар загварын алхаагаар алхана. Үйл ажиллагаа дуусахад хувцсаа тайлж, эвхэж хураана.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Хэн ямар хувцас өмссөн бэ?
- Дээл өмсөхөд ямар байсан бэ?
- Найз нь ямар өнгийн хувцас өмссөн байна вэ?
- Чамд ямар хувцас хамгийн гоё байсан бэ?

Сонсьё, дэмжье/ Туслалцаа

- Нэмэлт дэмжлэг шаардлагатай хүүхдэд зургаа олоход тусалж, харилцан ярилцана. Чи энэ зураг дээр байна уу? Чи мөн үү? заагаарай зэргээр дэмжинэ.
- Багш хүүхдийн гараас хөтлөн, хөлийн хэв бүхий тараах материал дээр гишгэж мэдрэх боломжтой сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Эцэг эх, эхтэйгээ хамтаръя:

- Гэр бүлийн фото альбом үзэж, хэн байгааг нэрлэх, зургийг ажиглаж, тухайн хүний сэтгэл хөдлөлийг хүүхэд үг, үйлдлээр илэрхийлэхэд дэмжинэ.
- Гэртээ хүүхэдтэйгээ нэр, насыг нь асууж, ярилцана.
- Хамт тоглохдоо хүүхдийн үйлдэлд тохируулан урамшуулна.
- Хүүхэд гэртээ амаа зайлах, гар шүдээ угаах зэрэг үйлийг багшийн заавар, аргачлалын дагуу хийхэд дэмжлэг үзүүлэх, хамт хийж үлгэрлэнэ.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
 Амжилттай хэрэгжүүлсэн:
 Сул хэрэгжүүлсэн:.....
 Цаашид сайжруулах:.....
 Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

**СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР
 ХАМТДАА ТОГЛОЁ**

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Сонгож авсан тоглоом, наадгайн өнгөний давтамжийг олох, өрөх, хэв гаргаж тоглох, хурууны дардсаар бүтээл хийх зэрэг үйл хувь нэмрээ оруулна.

Харилцах: Зургийг тайлбарлах, мэдрэмжээ илэрхийлж тоглох зэрэг үйл хувь нэмрээ оруулна.

Аюулгүй байдлын зөвлөмж: Тоглоом, наадгайн овор хэмжээ хүүхдэд тохирсон эсэх, хүүхдийн суралцах үйлийг дэмжихүйц байхаар материаллаг болон үйлийн орчныг бүрдүүлсэн байна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа: Багш та хүүхдүүдтэй тоглохдоо тэднийг ажиглаж, шаардлагатай чиглүүлэг, тохируулгыг хийгээрэй.

Төвийн үйл ажиллагаа: Хүүхдийн найзаа нэрээр нь дуудах, ярилцах, хурууны дардсаар бүтээл хийх зэрэг үйлийг дэмжин урамшуулаарай. Бүтээлээ тайлбарлах боломж олгож, яриаг нь анхааралтай сонсоорой.

Зугаалга: Гадаа талбайд хүүхдүүд хамтдаа хөлийн мөр дээр гишгэж тоглох, сонирхох, ажиглах үйлийг дэмжээрэй.

Багш та сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтөө бүлгийн өдрийн хуваарь, нөхцөл байдалд тохируулан баяжуулаарай.

Боломжууд: Хүүхдүүд үйл ажиллагаанд оролцох, хамтрах явцад тэдний үг, үйлдлийг ажиглаж, бүтээлч, сонирхолтой байх, шинэ нөхцөл байдал, сорилтыг давах, хүүхэд асуудлаа өөрөө шийдвэрлэхэд нь чиглүүлээрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл	Үйл ажиллагааны нэр
НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. БНО2.2а. Нэр, насаа хэлж, өөрийн болон бусдын эд зүйлс, тоглоомыг ялгана. ЗУ2.2в. Бие дааж толбо, дардсаар зурна.	- Хүүхэд нэр, насаа хэлэх - Хурууны дардсаа үүсгэх - Хүүхэд тухайн цаг мөчид ямар сэтгэгдэл төрсөн байгааг хэлэх - Зургийн багаж хэрэгслээ цэвэрлэж хураах үйлийг хамтран хийх	Энэ бол би
ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. ХЯ 2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна.	- Дууны аянд хамтдаа хөдөлгөөн хийх - Хүүхэд өөрт төрсөн мэдрэмжээ ярилцах - Хөдөлгөөнт дууг хамтдаа дуулах	Алгаа ташаарай
ХӨГ2.1а. Байгаль, эд юмсын дуу чимээг таньж ялгана. ХӨГ2.1б Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл	- Амьтдын дуу авиаг сонсох - “Дуу чимээ таагаарай” тоглоом тоглох - Хөгжмийн хэмнэлт дасгал хийх - “Дуулья, дагая” тоглоом хамтдаа тоглох - “Дагаад хийгээрэй” тоглоом	Анх удаа

хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.	тоглох - Хүүхэд мэдрэмж илэрхийлсэн үг хэлэх	
ЗУ2.3в. Өрж байгуулах, эвлүүлж угсрах аргаар бие дааж тоглоом, эд юмсыг зохион бүтээнэ. БНО1.1в Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. ХЭМ1.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр хамтран хийнэ.	- Багшийн дэмжлэгтэй гараа угаах - Элс, гурилан зуурмагаар бай онох, хэв гаргаж тоглох - Зүй тогтлын дагуу тараах материалыг байрлуулж, сонгох	Элсээр тоглоё
ХЭМ1.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр хамтран хийнэ ХЯ2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна	- Цаасыг жижиглэн урах үйлийг хийх - Ам, хамар, гуурсаар цаас үлээж хамтдаа тоглох - Хогийн саванд жижиг цаасыг хаях - Ойр орчны дуу чимээг дуурайх, танил үг өгүүлбэрийг сонсож давтан хэлэх	Хамраараа үлээе
ЗУ2.2в. Бие дааж толбо, дардсаар зурна. ХЭМ1.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр хамтран хийнэ.	- Шүдний хорхой зурах - Шүдний хэв ашиглан хамтдаа тоглох - “Алим” тоглоом хамтдаа тоглох	Шүдээ угаацгаая
НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно ХЯ2.1а Бусдын яриаг анхаарч сонсоно, үг богино өгүүлбэрээр хариулна. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.	- Сэтгэл хөдлөлийн зурагтай картыг ажиглах, нэрлэх - Шоо орхиж, мэдрэмжээ илэрхийлж тоглох - Нэрлэсэн зүйлийн давтамжийг тоглоом олох, өрөх	Инээгээрэй
ХЭМ2.1а. Гарын сарвууг өргөх, буулгах, татах, түлхэх, бугуйн үеэр эргүүлэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ. ХЭМ2.1г. Алхаж, гүйхдээ гар хөлийн хөдөлгөөнөө хослуулан хурдан, удаан гүйцэтгэнэ. ХЭМ2.1д. Сэдэвт алхалт, гүйлтийг хэрэглэл ашиглан гүйцэтгэнэ. ХЭМ2.1к. Өргөсөн гараас дээш 5 см өндөр зүйлд үсэрч хүрнэ. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно.	- Чиглэлээ өөрчлөн алхах - Дасгалыг хамтдаа зэрэг хийх - Байрандаа алхах, алга таших, хөлөө өндөр өргөх - Өргөсөн гараас дээш өндөр зүйлд үсэрч хүрэх - Нэгийн цуваагаар олсны дундуур гүйх, хөнгөн үсрэх - Вандан сандал дээр гараа тулж, хоёр тал руу давж алхаж буух	Хамтдаа

10 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Энэ бол би (хаана бана вэ?, юу зурах вэ?)	Тойргийн цаг Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн аянд хөдөлгөөн хийж, ая зогсоход өөрийн фото зургийг хайж олно. Зургийн ард хурууны дардсыг үүсгэж, харандаагаар баяжуулан зурна.	Хөгжмийн ая, фото зураг, усан будаг	Чи зургаа олсон уу? Чи зураг дээрээ инээсэн байна уу? Найз нь инээсэн байна уу? Чи хурууны дардас дээрээ юу нэмж зурах вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хурууны дардсаар бүтээл хийх, зурах	Сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлдэг. Хурууны өндөг, алгаар дардаслаж зурдаг.
Алгаа ташаарай (инээгээрэй, тоглоорой, бүжиглээрэй)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Зугаалгын цаг Хөгжөөн баясах цаг	Хөгжимт хөдөлгөөнийг зурагт үзүүлэнгийн дагуу хийж, бүжиглэнэ. Элс (гурил)-ний хайрцаг дотор гарын хэвийг дуурайлган үүсгэж тоглоно. Хөгжим зогсоход сэтгэл хөдлөлийн зурагт картад тохирсон нүүрний хувирлыг хийж үзүүлнэ.	Зурагт үзүүлэн (алга таших, алхах, инээх үйлдэл бүхий), хөгжмийн ая, алгаа нийлүүлсэн хэв бүхий бэлдэц, элс, гурил.	Дагаад хамтдаа хийх үү? Чи гараа элсэнд дүрж үзэх үү? Энэ ямар царай вэ? Чи ямар үед инээдэг вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хөгжмийн ая, хэмнэлд тохирсон хөдөлгөөн хийх Харилцах: Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх	Зурагт заасан үйлдлийг дуурайж хийдэг эсэх Хөгжимт хөдөлгөөнийг аянд тохируулан дагаж хийдэг. Гарын хэвийг дуурайлган үүсгэдэг.
Анх удаа (сонсоорой, хамтдаа хийгээрэй, алгаа ташаарай)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдийн уйлах, инээх чимээг сонсож, тохирох зургийг өргөнө. “Анх удаа” дууны аянд хөдөлгөөн хийнэ. Хэмнэлийн зурагт үзүүлэнгийн дагуу үгийг даган хэлж алгаа ташна.	Хүүхэд уйлж, инээж байгаа аудио бичлэг, зурагт үзүүлэн	Хүүхэд уйлсан уу, инээсэн үү? Хүүхэд юу хийж байна вэ? Хэмнэлийг сонсоод яаж дуурайх вэ? Хамтдаа үгээ хэлээд, алгаа ташихад бэлэн үү?	Бүтээлчээр сэтгэх: Хэмнэлийн зүй тогтлыг ажиглаж, үг, үйлдлээр илэрхийлэх Харилцах: Уйлах, инээх чимээг ялган сонсох, мэдрэмж илэрхийлэх	Бусдын яриаг сонсоод өөрт төрсөн мэдрэмжээ үгээр илэрхийлдэг. Дууны аянд тохируулан дуулж хөдөлгөөн хийдэг.
Элсээр тоглоё (элсэн бөмбөг, элсээр зуръя)	Зугаалгын цаг Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Элс (гурил) зуурч, элсэн бөмбөг хийнэ, бай онож тоглоно. Чийгтэй элсэн самбар дээр гарын хэв гаргаж, зүй тогтолтой картыг дуурайлгаж зурах эсвэл өөрсдөө зохиож зурна.	Элс, элсэн хайрцаг, ус, зурагт карт, онох бай	Зуурмагаар яаж бөмбөг хийх вэ? Энэ хэний гарын хэв бэ? Чи элсэн самбар дээр юу зурсан бэ?	Бүтээлчээр сэтгэх: Өрж байгуулах, эвлүүлж угсрах аргаар бие дааж тоглоом, эд юмсыг зохион бүтээх болон зургийн зүй тогтлыг дуурайх, өөрсдөө зохиож зурах	Элс (гурилан)-аар бөмбөг хийж чаддаг. Гараа бохирдсон үед өөрийн санаачилгаар угаадаг. Элсэн самбар дээр зургийг дуурайж

						дүрсэлдэг.
Хамраараа үлээе (нусаа нийе, хийстэл үзлээе)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Амны цаасыг жижиглэн урж, хамраараа үлээж тоглоно. Мөн өнгийн цаасны давтамжийг ажиглаж, ижил давтамжтай байрлуулж хамар, амаараа үлээж нусаа цэвэрлэнэ.	Амны цаас, өнгийн цаас, хавчаар, урт дээс.	Сандал дээрх жижиг цаас руу хамраараа үлээгээрэй. Цаас руу үлээхэд ямар санагдсан бэ? Хамраа яаж цэвэрлэх вэ?	Хамтран ажиллах: Зүй тогтлыг ажиглах, дуурайн хийх. Цаасыг жижиглэн урах.	Хамраа битүүрсэн үед өөрийн санаачилгаар цэвэрлэдэг. (нусаа нийх, арчих)
Шүдээ угаацгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шүдний зураг дээрх цэг, зураасыг шүдний сойзоор аргачлалын дагуу угааж, арилгаж тоглоно.	Шүдний хэв, зурагт үзүүлэн, шүдний сойз	Зураг дээр шүд хаана байна вэ? Шүдэнд наалдсан хоолны үлдэгдлийг яаж арилгах вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хувийн ариун цэврийг сахих (асуудлыг шийдвэрлэх)	Насанд хүрэгчдийн дэмжлэгтэй шүдээ угаадаг.
Хамтдаа (салхи, найзууд, амьтад болж үсэрье, тэнцвэр)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Салхи тоглоом: Тойрог хэлбэрээ алдахгүйгээр багшийг даган чиглэлээ өөрчлөн алхана. Амьтад болж үсэрье: Амьтдын нэр хэлж, дүрд орж, хөдөлгөөнийг дуурайж (жишээлбэл, эрвээхэй, туулай) гүйнэ, үсэрнэ. Тэнцвэр: Вандан сандал дээр гараа тулж, хоёр тал руу нь давж алхана.	Хөгжмийн ая, урт олс 2 ширхэг, вандан сандал/тавцан, тэнцвэрийн хавтан 3 ширхэг	Ямар амьтан үргэлж үсэрч явдаг вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнийг дуурайж алхаж, гүйж, үсэрч харуулах; Харилцах: Багшаас тусламж хүсэх, бусдыг ажиглах, энгийн хариу үйлдэл үзүүлэх	Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.

10 дугаар сарын I долоо хоног

ЭНЭ БОЛ БИ

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, фото зураг, усан будаг

Үйл ажиллагаа 1. Хаана байна вэ? (Тойргийн цаг)

Аргачлал: Хүүхэд бүрийн фото зургийг тойргоор байрлуулсан сандал дээр тавьсан байна. Хөгжмийн аянд багш, хүүхдүүд хамтдаа дуртай хөдөлгөөнийг хийж, сандлыг тойрч алхах, бүжиглэх зэрэг хөдөлгөөн хийнэ. Хөгжмийн ая зогсоход хүүхэд өөрийн зургийг хайж олж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи зургаа олсон уу?
- Чи зураг дээрээ инээсэн байна уу?
- Найз нь инээсэн байна уу?

Үйл ажиллагаа 2. Юу зурах вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхдүүд фото зургаа харж, юу хийж байгаагаа тайлбарлана. Багш асуултаар хүүхдийн ярих чадварыг дэмжинэ. Хүүхэд бүр фото зургийн ард хурууны дардас үүсгэж, харандаагаар бүтээл болгож баяжуулан зурна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Найз нь ямар тэмдэгтэй сандал дээр сууж байна вэ?
- Чи хурууны дардас дээрээ юу нэмж зурах вэ?

АЛГАА ТАШААРАЙ

Шинэ үг: Гарын хэв

Хэрэглэгдэхүүн: Алга таших, дороо алхах, инээх үйлдэл бүхий зурагт үзүүлэн, хөгжмийн ая, алгаа нийлүүлсэн хэв бүхий бэлдэц, элс, гурил.

Үйл ажиллагаа 1. Инээгээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хананд байрлуулсан алга таших, дороо алхах, инээх үйлдэл бүхий зурагт үзүүлэнг багш хүүхдүүд хамтдаа ажиглана. “Алгаа таш” хөгжимт хөдөлгөөнийг хамтдаа хийж ая, хэмнэлд тохируулан бүжиглэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ зургийг хараарай.
- Дагаад хамтдаа хийх үү?

Үйл ажиллагаа 2. Тоглоорой (Зугаалгын цаг)

Аргачлал: Алгаа нийлүүлсэн, салгасан хоёр гарын дардас бүхий тараах материалаас хүүхдүүд сонгож авна. “Алгаа таш” дууны аяыг тавьсан байна. Хүүхдүүд элс (гурил)-ний хайрцаг дотор сонгосон гарын хэвээ дуурайлган, хэв үүсгэж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи гараа элсэнд дүрж үзэх үү?
- Гарын хэв гарсан байна уу?
- Зурагтай адилхан байна уу? Инээж үзүүлэх үү?
- Одоо тоглож дуусаад гараа угаах уу?
- Чамд хамт тоглоход ямар байсан бэ?
- Чи уурласан уу? инээсэн үү?

Үйл ажиллагаа 3. Бүжиглээрэй (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: “Алгаа таш” дууны аянд хүүхдүүд тойргоор бүжиглэнэ. Хөгжмийн ая зогсоход багш сэтгэл хөдлөлийн зурагт картаас сонгож өргөнө. Хүүхдүүд зургийг ажиглаж, тохирсон нүүрний хувирлыг хийж үзүүлнэ. Хөгжмийн ая дахин эхлэхэд хүүхдүүд бүжиглэж, ая зогсоход сэтгэл хөдлөлийн зурагт картаа өргөхөд бусад хүүхдүүд нүүрний хувирлыг нь дуурайна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хамтдаа бүжиглэх үү?

- Энэ ямар царай вэ?
- Та нар царайгаараа ийм болгож үзүүлээч?
- Яагаад ууртай байгаа юм болоо?
- Чи ямар үед инээдэг вэ?

АНХ УДАА

(Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд уйлж, инээж байгаа аудио бичлэг, “Анх удаа” дууны утга санааг харуулах зурагт үзүүлэн

Аргачлал:

1. Сонсоорой: Хүүхдийн уйлах, инээх чимээ сонсож, тохирох зургийг өргөнө. Хүүхэд ямар чимээ сонссоноо нэрлэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хүүхэд уйлсан уу, инээсэн үү?

2. Хамтдаа хийгээрэй: Хүүхдүүд тойргоор зогсож “Анх удаа” дууны аянд хөдөлгөөн хийнэ. Мөлхөөрэй гэхэд мөлхөнө, алхаарай гэхэд дороо алхана, сонсоорой гэхэд чихнийхээ ард гараа барьж, хоёр тийш найган хөдөлнө.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хүүхэд юу хийж байна вэ?
- Хамтдаа хийж үзэх үү?

3. Алгаа ташаарай: Хүүхдүүд хэмнэлийн зурагт үзүүлэнг ажиглана. Багш зураг дээр үзүүлсэн урт богино хэмжээнд тохируулан алга ташиж үзүүлнэ.

Аав гэж хэлээд, 1 удаа алга ташна (*эрэгтэй хүний зургийн доор нэг урт зураас байна.*)

Өвөө гэж хэлээд, 2 удаа алга ташна (*настай эрэгтэй хүний зургийн доор хоёр богино зураас байна.*)

Ээж гэж хэлээд, 1 удаа алга ташна (*эмэгтэй хүний зургийн доор нэг урт байна.*)

Э-мээ гэж хэлээд, 2 удаа алга ташна (*настай эмэгтэй хүний зургийн доор хоёр богино зураас байна.*)

Хүүхдүүдийг дагуулан хэмнэлийн хэсэг бүрийг 2-3 удаа давтана. Зургийн дарааллыг өөрчилж, дахин хийнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Багштайгаа хамт алгаа таших уу?
- Хамтдаа үгээ хэлээд, алгаа таших уу?

10 дугаар сарын II долоо хоног

ЭЛСЭЭР ТОГЛОЁ

Шинэ үг: Бай онох

Хэрэглэгдэхүүн: Элс, элсэн хайрцаг, ус, зурагт карт, онох бай

Үйл ажиллагаа 1. Элсэн бөмбөг (Зугаалгын цаг)

Аргачлал: Багш хүүхдүүд хамтран элс (гурил) зуурна. Цэвэрхэн усаар, хэтэрхий шингэн биш зуурахад багш дэмжлэг үзүүлнэ. Хүүхдүүд элсээ (гурил) атгаж, гурваас доошгүй бөмбөг хийж тоглоно. Бөмбөг шидэх аргачлалыг багш биечлэн үзүүлж, байг ононо. Хүүхэд бүр бөмбөгөө шидэж, байг онохыг эрмэлзэнэ. Тоглоомын дараа багшийн дэмжлэгтэйгээр гараа угаана.

Үйл ажиллагаа 2. Элсээр зуръя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхдүүд чийгтэй элс (гурилан) самбар дээр гарын хэв гаргана. Хүүхдүүд гарынхаа хэвийг ажиглаж, харьцуулан ярилцана. Мөн дараалан байрлуулсан зураас бүхий зүй тогтолтой картыг ашиглан элсэн дээр дуурайлгаж зурна. Хүүхэд өөрөө зохиож

зурж болно. Элс (гурил)-ээ асгахгүй, цэвэр нямбай зурахад багш дэмжлэг үзүүлнэ. Тоглоомын дараа гараа угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ хэний гарын хэв бэ?
- Чи элсэн самбар дээр юу зурсан бэ?

ХАМРААРАА ҮЛЭЭ

Шинэ үг: Нусаа нийх

Хэрэглэгдэхүүн: Амны цаас, өнгийн цаас, хавчаар, урт дээс.

Үйл ажиллагаа 1. Хүчтэй үлээе (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Аргачлал: Багш, хүүхдүүд амны цаасны хэсгийг жижиглэн гараараа урж, сандал дээр тарааж байрлуулна. Үлдсэн амны цаасаа хоёр гартаа барьж, үлээхээс сэргийлж амаа хаасан байна. Сандал дээрх тараасан жижиг цаасыг хамраараа үлээж, газарт унагаж тоглоно. Хүүхэд, багш нус гарахад амны цаасаараа арчиж, бохирдсон цаасыг хогийн саванд хаяна.

- Сандал дээрх жижиг цаас руу хамраараа үлээгээрэй.
- Хамраараа үлээхэд нус гарвал амны цаасаар арчаарай.
- Арчсан цаасаа хогийн саванд хийгээрэй.
- Газарт унагасан цаасыг түүж хогийн саванд хийгээрэй.

Үйл ажиллагаа 2. Хийстэл үлээе (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Аргачлал: Урт дээсэнд хоёр өнгийн цаасыг давтамж үүсгэн сөөлжүүлэн өлгөсөн байна. Ширээн дээр өнгийн цаас байна. Хүүхдүүд өлгөсөн цаастай ижил давтамж үүсгэн ширээн дээрх цаасыг байрлуулна. Хүүхдүүд цаасанд хүрэхгүйгээр ам, хамрын аль нэгээр үлээж тоглоно. Тоглох үед нус гарвал амны цаасаар арчина.

- Өнгийн цаасыг ажиглаарай.
- Ширээн дээрээс ижил өнгөтэйг олж аваарай.
- Хэцэн дээрх өнгийн цаас руу үлээгээрэй.
- Цаас руу үлээхэд ямар санагдсан бэ?

ШҮДЭЭ УГААЦГААЯ

(Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Шинэ үг: Зураас зурах

Хэрэглэгдэхүүн: Шүдний хэв, зурагт үзүүлэн, шүдний сойз

Аргачлал: Хүүхдийн амаа ангайж, шүдийг нь харуулсан зурагтай тараах материалыг уутанд хийж, хүүхэд бүрд өгнө. Хүүхдүүд шүдний зураг дээр эсгийн балаар цэг, зураас зурна.

Багш шүдний хэв дээр эсгийн балаар цэг зурна. Энэ нь хоол идсэний дараа шүдэн дээр наалдсан хоолны үлдэгдэл болохыг тайлбарлана. Хүүхдүүд шүдний сойзоор дээрээс нь доошоо, доороос нь дээшээ угаах хөдөлгөөн хийж, цэг, зураасыг арилгана. Шүд угаах аргачлалын дагуу хөдөлгөөн хийж байгаа эсэхийг багш ажиглаж, чиглүүлнэ.

ХАМТДАА

Шинэ үгс: Давж үсрэх, саад

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, урт олс 2 ширхэг, вандан сандал/тавцан (10-15 см өндөр), тэнцвэрийн хавтан 3 ширхэг.

Үйл ажиллагаа 1. Салхи (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хүүхдүүд гар гараас барьж тойргоор зогсоно. Багш “Би салхи” боллоо гээд тойргийн голд зогсож, салхийг тойргоос гаргаж болохгүй шүү хэмээн тоглох дүрмийг тайлбарлана. Багш “Салхи гарлаа” гээд үлээж, урагш алхахад хүүхдүүд тойрог хэлбэрээ алдахгүйгээр араас

нь дагаж алхана. Багш баруун/зүүн тал руу чиглэлээ өөрчлөн үлээж алхахад хүүхдүүд салхийг тойргоос гаргахгүйгээр хамтдаа дагаж алхана. Салхи болох хүсэлтэй хүүхэд байгаа эсэхийг асууж, үргэлжлүүлэн тоглоно.

2. “Найзууд” дасгал: Хөгжимт гимнастикийн 4-6 найман тоот зохиомжит дасгалыг багшийг даган дуурайж хамтдаа гүйцэтгэнэ.

3. Амьтад болж үсэрье: Талбайн голд байрлуулсан 2 олсны дундуур хүүхдүүд нэг цуваагаар алхалт, гүйлт, үсрэлтийг олон хувилбартай гүйцэтгэнэ. Хүүхдийн нэрлэсэн амьтныг дуурайж дүрд орж хөнгөн алхах, гүйх, үсрэх хөдөлгөөнийг бүтээлчээр сэтгэж илэрхийлнэ.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Олсон дундуур яаж алхах /үсрэх, гүйж/-ыг хүсэж байна вэ? хүүхдийн мэддэг, хүссэн алхалтыг хийнэ.
- Ямар амьтан үргэлж үсэрч явдаг вэ? тухайн амьтныг дуурайж үсэрнэ.
- Ямар амьтан нисдэг вэ? тухайн амьтны дүрд орж нисэх мэт гараар дээш доош дэвж хөнгөн гүйнэ.

4. Тэнцвэр: Хүүхэд вандан сандлын захад хөлөө салган сууна. Сандал дээр гараа тулж хөлөө урагш алхан гулсана. Гулсаж дуусаад гурван өнгийн тэнцвэрийн хавтанг жижгээс том руу нь давхарлаж тавина. Вандан сандал дээр гараа тулж, сандлын хоёр хажуу талд давж алхана. Хүүхдийн гүйцэтгэх чадвараас хамаарч тоглоомыг хүндрүүлж болно. Хэрэглэгдэхүүнээ багшийн зааврын дагуу хамтдаа хураана.

Тайвшруулах дасгал: Хүүхдүүд дээш харж хэвтэнэ. Багш дасгалыг нэрлэхэд хүүхдүүд хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг гүйцэтгэнэ.

- Гараа өргөөд сэгсрээд буулгаарай.
- Хөлөө өргөөд сэгсрээд буулгаарай.
- Гар хөлөө зэрэг өргөж, сэгсрээд буулгаарай.
- Баруун/зүүн тал руу эргээд босоорой.
- Тойргоор алхаарай.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

- Биеэ хөдөлгөөнөө удирдаж чадвар сул, хариу үйлдэл удаан, харах чадвар сул зэргээс үүдэн бүжиг, хөдөлгөөнт тоглоомд оролцохоос зайлсхийдэг, дургүй хүүхдүүдийг үйл ажиллагаанд оролцуулахдаа яг юу чадахгүй, ямар чадвар нь хөгжөөгүй байгаа зэргийг ажиглана.

Эцэг эх, эхтэйгээ хамтаръя:

- Гэр бүлийн фото альбом үзэж, хэн байгааг хамтдаа нэрлэх, зургийг ажиглаж, тухайн хүний сэтгэл хөдлөлийг үг, үйлдлээр илэрхийлэхэд дэмжин ажиллана.
- Гэр бүлийн орчинд хамтдаа тоглохдоо тэдний үйлдэлд тохируулан урамшуулна.
- Хүүхэд гэртээ амаа зайлах, гар, шүдээ угаах зэрэг үйлийг цэцэрлэгт сурсан аргачлалын дагуу хамт хийж, хүүхдийн хөгжилд гарсан ахицын тухай багштай ярилцаж мэдээлэл солилцоно.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР

УЛААН ЛООЛЬ

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг янз бүрийн аргаар илэрхийлэх

Шүүн тунгаах: Хүнсний ногооны ялгаа, ижил төстэй байдлыг ажиглах, харьцуулах, ангилах, асуудал шийдэх

Харилцах: Бусадтай ярилцах, тоглох

Суралцахуйд суралцах: Сонирхсон зүйлээ асуух, анхааралтай сонсох, нэг хийж байгаа зүйлдээ төвлөрөх

Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, тайлбарлах, сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах

Хамтран ажиллах: Бусдад туслах, хуваалцах, хүндлэл, хүлээцтэй байх.

Аюулгүй байдлын зөвлөмж:

- Баримал, усан будаг зэрэг хэрэглэгдэхүүнүүдийг (багажийн загвар, жижиг тоглоом) амандаа хийхгүй байхыг сануулаарай.
- Тоглоом багаж хэрэгслийг бүлгээр хуваан өгч, булаацалдах, зөрчилдөхөөс урьдчилан сэргийлээрэй.
- Тойрогт суух, тоглох үед хүүхэд хоорондын зайг тааруулах (мөргөлдөх, түлхэлцэхээс сэргийлэх).

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Хүүхдүүд гэр бүлийн гишүүдийнхээ, ажил мэргэжлийн тухай ярилцах, бусадтай харилцахад нь урамшуулж, нээлттэй оролцох боломж олгоорой. Мэдрэмжээ хөдөлгөөн, үг, үйлдлээр илэрхийлэх, найзаа сонсох дадалд дэмжлэг үзүүлээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Хүүхдүүдийг хамтран тоглох, хөдөлгөөн даган дуурайх, дуу дуулж өөрийгөө илэрхийлэхэд нь урамшуулан дэмжээрэй. Хүүхдийн хүсэл сонирхлыг хүндэтгэж, сонголтыг нь дэмжин тоглох боломж олгож харилцан ярилцахад туслаарай.

Зугаалгын цаг: Хүүхдүүд орчноо ажиглаж, энгийн даалгавар гүйцэтгэх дадал олж авна. Энгийн зааврыг дагаж биелүүлэхэд нь дэмжиж, хамтран тоглох, ярилцах боломж олгоорой.

Номын цаг: Багш та [Let's Read | Children's Books | Free to Read Download Translate](#) цахим номыг ашиглан зохиолыг уншиж өгөөрэй. Ажиглаж, ойлгож, хамтдаа сонсох дадлыг төлөвшүүлэхэд нь дэмжээрэй.

Хөгжөөн баясах цаг: Хүүхдүүд дүрд тоглож, сэдэвт тоглоомд бүтээлчээр оролцох, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломжтой. Бусдын үйлдлийг ойлгож хүлээцтэй байхад нь тусалж, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэхэд нь дэмжээрэй.

Боломжууд:

- Зохиолын эхлэл, өрнөл, төгсгөл гэсэн байдлаар загвар гаргаж хөгжүүлээрэй.
- Хүүхдээс гарч буй санаа, бодож төсөөлөн хийсэн зүйлийг нь дэмжиж, үйл ажиллагаандаа тусган ашиглаарай.

Үйл ажиллагааны 11 сарын төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯ2.2д. Үйл явдлыг тоочиж ярина. ХЭМ2.2в. Жимс, хүнсний ногоог насанд хүрэгчтэй хамтран угааж, хэрэглэнэ.	<ul style="list-style-type: none">- Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих, зураг, хуруун хүүхэлдэй, ширээний театр зэргийг ашиглан дүрд тоглон жүжиглэхэд оролцох, үйл явдлын буруу дарааллыг засах, хамтран ном бүтээж ярих.- Зурагт карт ашиглан эрүүл мэндэд сайн муу хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэх, ялгаж тоглох, ярилцах;	Улаан лооль

<p>ХӨГ2.1б Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна. ХӨГ2.1в Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. МАТ2.1а. 5 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолох, олон ба цөөн тооны тоглоом, юмсыг заах, хэлнэ</p>	<ul style="list-style-type: none"> - “Хамтдаа дуулъя” тоглоом: Багш хүүхэд хамтарч үлгэр, зохиолын дүр, үйл явдлаас сэдэвлэн хөгжилтэй богино дуу зохиож дуулах - “Би хөгжимчин” тоглоом тоглох. Жишээ нь: Хөгжмийн энгийн зэмсгээр сэгсрэх, цохих, хавсрах зэргээр дуугаргах - “Дагаад хийгээрэй” тоглоом тоглох. Жишээ нь: Багшийг даган, хөгжмийн хэмнэлд тохируулан, алга таших, хөл товших, найгах ганхах зэрэг хөдөлгөөнийг хийх; - Нэг ижил өнгө хэмжээтэй (5 ширхэг шар өнгийн том бөмбөг, 3 ширхэг улаан өнгийн жижиг машин гэх мэт) тоглоом, юмсыг зааж тоолох 	<p>Хөгжилтэй хүнсний ногоо</p>
<p>МАТ2.3а. Тоглоом юмсыг тодорхой шинжээр хоёр хэсэгт ангилна. НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Дугуй, дөрвөлжин дүрстэй тоглоомуудыг ялгаж тавих. Тоглоомыг өнгө, хэлбэрээр 2 хэсэгт ангилж байрлуулах; - Тухайн цаг мөчид өөрөө ямар сэтгэл хөдлөлтэй байгаагаа хэлэх. 	<p>Ажилсаг хүүхдүүд</p>
<p>ЗУ2.2г. Баримлын шавраар хоёр хэсгээс бүтсэн зүйлийг бие дааж барина. МАТ2.2а 3 хүртэлх тооны тоглоом юмсыг уртаар нь харьцуулна..</p>	<ul style="list-style-type: none"> - Баримлын шавраар хоёр хэсгээс бүтсэн хүн, эд юмсыг барих; - Харандаа, үдээс, туузын уртыг давхцуулан, урт, богиныг харьцуулж хэлэх. 	<p>Өргөст хэмх</p>
<p>ХЯ2.2д. Үйл явдлыг тоочиж ярина. ЗУ2.2а.Зураас, дүрсээр өөрийн бодол, төсөөллөө илэрхийлнэ. МАТ2.3в. Юмсын байршлыг нэрлэнэ. (дотор, гадна)</p>	<ul style="list-style-type: none"> - Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих; - Харандаа, тосон харандаа, бийрээр зурж буддагийг мэдэх; - Бөмбөгийг хайрцгийн дотор гадна байрлуулж, байршлыг нэрлэх. 	<p>Түмээ хүү</p>
<p>ЗУ2.2б. Бүтээлээ үндсэн өнгөөр бие дааж будна. МАТ2.3а. Тоглоом юмсыг тодорхой шинжээр хоёр хэсэгт ангилна. НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өнгөө сонгож тоглоом эд юмсыг будах; - Өөрийн сонирхлоор тоглоомыг өнгөөр нь ижилсүүлж давхарлан өрөх; - Өөрийгөө толинд хараад нүүрний хувирлаа ажиглаж нэрлэх. 	<p>Түмээгийн ээж</p>
<p>ХЭМ2.1г. Алхаж, гүйхдээ гар хөлийн хөдөлгөөнөө хослуулан хурдан, удаан гүйцэтгэнэ. ХЭМ2.1в. Гараа ташаанд авч, баруун эсвэл зүүн хөлийг тулалтын хөлийн шагайнд нааж тэнцвэр хадгалан (тогоруу) зогсоно. ХЭМ2.1м. Бөмбөгийг дээш шиднэ, барьж авна. НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Саадыг давах болон сүлжиж тэнцвэр хадгалан алхах, гүйх дасгалыг давтах; - Хөлийг зөрүүлэн тавьж зогсох, тэнцвэрийн хавтан дээр тэнцвэр хадгалан зогсох; - Бөмбөгийг хоёр ба нэг гараар (хол, уян дээгүүр, сагс) шидэх дасгалыг давтах; - Өөрийн (даарсан, халууцсан, норсон, өвдсөн) мэдрэмжийг илэрхийлсэн үгсийг хэлэх. 	<p>Тоглоом</p>

<p>ХЯ2.2д. Үйл явдлыг тоочиж ярина. БНО2.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомын шинжийг мэдэрч, нэрлэн, зориулалтаар нь сонгон тоглоно.</p>	<ul style="list-style-type: none"> - Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих, зураг, хуруун хүүхэлдэй, ширээний театр зэргийг ашиглан дүрд тоглон жүжиглэхэд оролцох, үйл явдлын буруу дарааллыг засах, хамтран ном бүтээж ярих; - Эд зүйлс, тоглоомыг дуу чимээ, үнэр, амт, хийсэн материалаар нь ялгаж таних туршилт хийх. 	<p>Эргээд санаарай</p>
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------

Албан хэрэгцээнд

11 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Улаан лооль (бид өнөөдөр, анхааралтай сонсьё, хамтдаа хийцгээе, улаан лоолийг олъё)	Тойргийн цаг, Номын цаг, Өөртөө үйлчлэх хөдөлмөр, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Улаан лооль зохиолтой танилцах, хүнсний ногоог угааж цэвэрлэх, зурагт картаас улаан лоолийг ялгаж олох, ярилцах үйл ажиллагаа хийгдэнэ.	Хүнсний ногооны зурагт үзүүлэн дэлгэц, зохиол, зурагт карт, төрөл бүрийн хүнсний ногооны бодит үзүүлэн, загвар үзүүлэн	Ширээн дээр улаан лооль байсан уу?. Түмээ яагаад улаан лоолийг олохгүй байсан бэ?, Та нар юу гэж бодож байна вэ? Ээж нь Түмээд хэрхэн тусалсан бэ?	Харилцах: Бусадтай ярилцах, тоглох, үйл явдлыг тоочиж ярих	Үйл явдлыг тоочиж ярьдаг. Жимс, хүнсний ногоог насанд хүрэгчтэй хамтран угаадаг.
Хөгжилтэй хүнсний ногоо (дагаад дуулаарай, хэмнэл тоглоё, тоолоорой)	Тойргийн цаг, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Хөгжөөн баясах цаг	Зохиолоос сэдэвлэн хөгжилтэй богино дуу зохиож дуулах, хөгжмийн аянд хөгжимт хөдөлгөөн хийх, хэмнэл тоглох, хүнсний ногоог өнгө, хэмжээгээр нь бүлэглэж тоолно.	Зурагт хуудас, Хэмнэл тоглох зурагт хуудас, шагшуур, дуут мод, төрөл бүрийн хүнсний ногооны зурагт карт.	Багштай хамтарч зохиосон дуунд ямар хүнсний ногоо байсан бэ? Лууван гэхэд хэдэн удаа тогших вэ? Хэдэн төрлийн хүнсний ногоо тоолсон бэ?	Бүтээлчээр сэтгэх: Хөгжилтэй богино дуу зохиож дуулах Харилцах: Дуулах, дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглох	Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулдаг. Дуу, аялгууг мэдэрч, хэмнэлийг тоглодог. 5 хүртэлх эд юмсыг ангилж тоолдог.
Ажилсаг хүүхдүүд (ногоочин хүүхдүүд, хамтдаа хийе)	Төвийн үйл ажиллагаа, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зохиолын үйл явдалтай зурагт картыг дарааллаар байрлуулах, хүнсний ногоонуудыг сэтгэл хөдлөлөөр нь ялгах, хүнсний ногоог дуурайн зурах, ялгаж сагсанд хийж тоолж тоглоно.	Нүүрний хувирлыг илэрхийлэн зурсан хүнсний ногооны зурагт карт, хүнсний ногооны биет үзүүлэн	Түмээ яагаад хүнсний ногоонуудыг андуурсан бэ? Сагсанд хэдэн интоор байна вэ? Аль хүнсний ногоо олон байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Дурын хүнсний ногоог сонгож дуурайн зурах Харилцах: Үйл явдлыг дарааллаар ярихад нь чиглүүлнэ.	Үйл явдлыг дарааллын дагуу байрлуулдаг. Нэрлэсэн жимс хүнсний ногоог ялгадаг.
Өргөст хэмх (барималчин хүүхдүүд, хэмжээрэй, хүнсний дэлгүүр сэдэвт тоглоом)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, хөгжөөн баясах цаг	Өргөст хэмхийг баримлаар бүтээх, хийсэн бүтээлүүдийг утас, үдээсээр урт богиныг хэмжиж, харьцуулах,	Баримлын шавар, хулдаас, хутга, баримлаар хийсэн өргөст хэмх, үдээс, утас, хүнсний ногооны загвар үзүүлэн	Өргөст хэмхийг баримлаар урлахад ямар өнгийн ашиглаж гэж хийсэн бэ? Хэн хамгийн урт	Бүтээлчээр сэтгэх: Өөрийн төсөөллөөр зохион бүтээх Харилцах: Сэдэвт тоглоомд	Баримлын шавраар бүтээл хийдэг. Бүтээлээ утас, үдээс ашиглан урт, богиныг хэмжиж харьцуулдаг.

		"Хүнсний дэлгүүр" сэдэвт тоглоом тоглоно.		өргөст хэмх хийсэн бэ?	бүтээлчээр оролцох	
Түмээ хүү (Эхлээд дараа нь, Түмээ зураач болсон нь, зөв байрлуулаарай)	Номын цаг, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Хөгжөөн баясах цаг.	"Улаан лооль" зохиолын үйл явдлыг сэргээн санаж ярих, сонгосон хүнсний ногоог аргачлалын дагуу зурах, зохиолын эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийг илэрхийлсэн зургийг дарааллаар зөв байрлуулна.	Зохиолын үйл явдлыг илэрхийлсэн том ном, цаас, харандаа, тосон будаг, усан будаг, зохиолын үйл явдлыг илэрхийлсэн бүдүүвч зураг	Эхлээд юу болсон бэ?, дараа нь яасан бэ? Чи ямар хүнсний ногоо зурснаа тайлбарлах уу?, Зургийг үйл явдлын дарааллаар ярина уу?	Бүтээлчээр сэтгэх: Зураас, дүрс ашиглан, өөрийн бодол, төсөөллөөр зурах	Зохиолын үйл явдлыг тоочиж ярьдаг. Аргачлалын дагуу зурж буддаг.
Түмээгийн ээж (Хүүдээ тусласан нь, хүүтэйгээ хамт, ээжийн сэтгэл хөдлөл)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Төвийн үйл ажиллагаа, Хөгжөөн баясах цаг	Ижил өнгөтэй хүнсний ногооны зургийг зэрэгцүүлэн өрж ялгах, хүнсний ногоог төрөл бүрийн аргаас сонгож зурах (цоолбор, хэв дардас, гуурс г.м) Сэтгэл хөдлөлийг нүүрний хувирлаар илэрхийлж тоглоно.	Төрөл бүрийн хүнсний ногооны зурагт карт, поднос, Төрөл бүрийн зураг урлалын хэрэглэгдэхүүн, Хүүхдүүдийн зурсан зураг	Багшийн өргөсөн өнгөний дагуу жимс, хүнсний ногоог өрж чадсан уу? Хүнсний ногоог аль аргаар зурах нь таалагдсан бэ? Зурсан зургуудаа үзэхэд ямар санагдсан бэ?	Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг янз бүрийн аргаар илэрхийлэх Харилцах: Зурсан зургаа үзэхдээ мэдрэмжээ хөдөлгөөн, үг, үйлдлээр илэрхийлэх	Тохирох өнгийн жимсийг өрж байрлуулдаг. Цоолбор, хэв, хавсрах, гуурсаар үлээх, даавуун дээр зурах аргаар дүрсэлж зурдаг. Сэтгэл хөдлөлийг ажиглаж таньдаг.
Тоглоом (Саваа мод, алхаарай, цагариг, сансрын нисгэгч, тайвшраарай)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Саваа модтой дасгал хийх, зиг заг байрлуулсан саваа модны дагуу өлмий, өсгий дээр алхах, цагаригт бөмбөг ойлгох, 1,2 хөл дээр тэнцвэрээ хадгалан зогсох, ижил зурагтай картыг олж ижилсүүлж тоглоно.	Саваа мод, цагариг, дасгалын зурагтай карт	Саваа модоо бариад багшийг дагаж дасгал хийгээрэй, өлмий өсгий дээр яаж алхах вэ?, бөмбөгийг яаж ойлгож шидэх вэ?, чиний зурагтай ижил хүүхдийг олоорой.	Бүтээлчээр сэтгэх: Тэнцвэрээ хадгалах аргыг олох Харилцах: Өөрийн найзаа олж хамтран ажиллах	Саваа модтой дасгал хийдэг. Хөлийн өлмий, өсгий дээр алхдаг. Бөмбөгийг ойлгож шиддэг. Тэнцвэрээ хадгалан зогсдог.
Эргээд санаарай	Чиглүүлэгтэй	Хүнсний ногооны	Төрөл бүрийн	Улаан өнгийн	Харилцах:	Хүнсний ногоог

(Найзтайгаа тоглоорой, улаан лооль)	тоглоом, үйл ажиллагаа, хөгжөөн баясах цаг	загвар үзүүлэнг харж өнгөөр ялган сагсанд хийх, “Улаан лооль” зохилын тухай ярилцана.	материалаар хийсэн хүнсний ногооны загвар үзүүлэн, зохиолын үйл явдлаар оюуны зураглал хийх бүдүүвч зураг, үйл явдлыг тоймлон зурсан багц зурагт хуудас	хүнсний ногоог улаан сагсанд, ногоон өнгийн хүнсний ногоог ногоон сагсанд хийгээрэй. Зохиол яаж эхэлдэг вэ? Зохиолын өрнөл хэсэгт ямар үйл явдал болдог вэ?, зохиол яаж төгсдөг вэ?	Үйл явдлын дагуу асуултад хариулах	өнгөөр ялгадаг. Зохиолын үйл явдлыг дарааллаар нь ярьдаг.
-------------------------------------	--------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------	-----------------------------------------------------------

Албан хэрэгт

11 дүгээр сарын I долоо хоног

УЛААН ЛООЛЬ

Шинэ үг: Улаан лооль, өргөст хэмх, интоор

Үйл ажиллагаа 1. “Бид өнөөдөр” ярилцлага (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүнсний ногооны зурагт үзүүлэн

Аргачлал: Багш хүүхдийг тойрог хэлбэртэй суулгаж харилцан ярилцана. Өнөөдөр бид хүнсний ногооны тухай зохиолтой танилцана. Тэгэхээр бүгдээрээ өөрсдийн мэддэг хүнсний ногоог нэрлэж ярилцъя. Та нар ямар ямар хүнсний ногоо байгааг зургаас нэрлээрэй.

Хүүхэд “Энэ лууван байна. Харин энэ бол улаан лооль.” гэх мэт 1–2 өгүүлбэр хэлж ээлжилж ярилцана.

Үйл ажиллагаа 2. Анхааралтай сонсьё (*Номын цаг*)

Хэрэглэгдэхүүн: Дэлгэц, зохиол, зурагт карт

Аргачлал: “Улаан лооль” зохиолыг уншиж өгнө. Түмээ ээждээ туслахдаа ямар ямар хүнсний ногоог мэдэж авсан талаар ярилцана. Шинэ үгсийн утгыг зурагт карт ашиглан тайлбарлаж өгнө.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ширээн дээр улаан лооль байсан уу?
- Түмээ яагаад улаан лоолийг олохгүй байсан бэ? Та нар юу гэж бодож байна?
- Ээж нь Түмээд хэрхэн тусалсан бэ?

Үйл ажиллагаа 3. “Хамтдаа хийцгээе” сэдэвт тоглоом (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн хүнсний ногооны бодит үзүүлэн

Аргачлал: Багш хүүхдүүдтэй хүнсний ногооны талаар харилцан ярилцсаны дараа эцэг эх, асран хамгаалагч нарын дэмжлэгтэйгээр ангид төрөл бүрийн хүнсний ногоо цуглуулна. Цуглуулсан ногоогоо угааж цэвэрлээд, дэлгэц цаасан дээр жигд өрөөд хатааж тавина.

Үйл ажиллагаа 4. “Улаан лоолийг олъё” тоглоом (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн хүнсний ногооны загвар үзүүлэн, зурагт карт

Аргачлал: Хүнсний ногооны загвар үзүүлэнгээс улаан лоолийг ялгаж олж сагсанд хийж тоглоно. Мөн хүнсний ногооны зурагт картаас улаан лоолийг олж дэлгэц самбарт байрлуулан наана. Улаан лоолийн өнгө, хэлбэрийн талаар ярина.

ХӨГЖИЛТЭЙ ХҮНСНИЙ НОГОО

Шинэ үг: Хэмнэл, хурдан, удаан

Үйл ажиллагаа 1. Дагаад дуулаарай (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт хуудас

Аргачлал: Багш хүүхэд хамтарч үлгэр, зохиолын дүр, үйл явдлаас сэдэвлэн хөгжилтэй богино дуу зохиож дуулна. Хүүхдүүд багшийн бэлтгэсэн зургийг харж үгийг давтан хэлж дурын аян дээр хөгжилдөн дуулж, бүжиглэж, алгаа таших, хөлөө товших гэх мэт хөдөлгөөнтэй хамсран дуулна.

Зохиож дуулах дуу:

- Лууван, лууван төмс
Төмс, төмс лууван
Улаан лооль, интоор
Интоор интоор, улаан лооль
Амин дэмээр баялаг даа
- Манжин манжин, улаан лооль
Улаан лооль, манжин
Байцай байцай, өргөст хэмх
Өргөст хэмх, байцай
Амин дэмээр баялаг даа

Хувилбар 2.

Хөгжмийн аянд “Ногоотой шөл” хөгжимт хөдөлгөөн хийнэ.

Лууван, лууван (2 хуруугаа гозойлгож, лууван болгоно.)

Байцай, байцай (2 гарын хуруунуудыг нийлүүлж байцай хэлбэртэй болгоно.)

Төмс, төмс (2 гарыг атгаж төмс дүрсэлнэ.)

Тогоонд, тогоонд (2 гараа нийлүүлж, тойрог үүсгэн тогоог дүрсэлнэ.)

Хийгээд, хийгээд (нэг гараараа байцай, төмс, луувангаа тогоо руу хийж байгаа хөдөлгөөн хийнэ.) Хоолоо хийж байна. (хоолоо хутгаж байгаа хөдөлгөөн хийнэ.)

Үйл ажиллагаа 2. Хэмнэл тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хэмнэл тоглох зурагт хуудас

Аргачлал: Багш хүүхдүүд хэмнэл тоглох зурагт хуудсыг анхааралтай ажиглаж, шагшуур, дуут мод зэргээр өөрсдөө хэмнэл зохиож тоглоно. (Тухайн цэцэрлэг байгаа хэрэглэгдэхүүнээ хэрэглэж болно)

Хэмнэл тоглох зурагт хуудас:

Лууван, лууван төмс

Төмс, төмс лууван

Улаан лооль, интоор

Интоор интоор, улаан лооль

Амин дэмээр баялаг даа

Манжин манжин, улаан лооль

Улаан лооль, манжин

Байцай байцай, өргөст хэмх

Өргөст хэмх, байцай

Амин дэмээр баялаг даа

Үйл ажиллагаа 3. Тоолоорой (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн хүнсний ногооны зурагт карт

Аргачлал: Багш хүүхдүүдээр хүнсний ногооны зурагт карт харуулж харилцан ярилцана. Хүүхдүүд хүнсний ногооны зурагт картаас өнгөөр болон хэлбэр хэмжээгээр нь бүлэглэж тоолно.

АЖИЛСАГ ХҮҮХДҮҮД

Шинэ үг: Ногоочин, баярлах, гуниглах

Үйл ажиллагаа 1. Ногоочин хүүхдүүд (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нүүрний хувирлыг илэрхийлэн зурсан хүнсний ногооны зурагт карт

Аргачлал:

Хэл яриа: Улаан лооль зохиолыг сэргээн санаж, том ном ашиглан үйл явдлыг дахин ярилцана. Зурган картыг үйл явдлын дарааллаар байрлуулна.

Нийгэм-сэтгэл хөдлөл: Түмээ улаан лоолийг олохгүй олон удаа андуурсан учраас хүнсний ногоонууд зарим нь гайхаж, зарим нь баярлаж, зарим нь гунигласан байна. Хүүхдүүд тэр хүнсний ногоонуудыг сэтгэл хөдлөлийн онцлогоор нь ялгаж тоглоно.

Зураг урлал: Дурын хүнсний ногоог сонгож дуурайн зурна. Хэв дардас ашиглан зурж болно.

Математик: Хүнсний ногооны зурагт картыг тоолно, харьцуулна.

Үйл ажиллагаа 2. “Хамтдаа хийе” дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүнсний ногооны биет үзүүлэн

Аргачлал: Хүүхдүүд тойргоор сууна. Тойргийн голд дэвсгэр дээр хүнсний ногооны биет үзүүлэн байна.

Багшийн зааварчилгаа:

1. Одоо интоорыг ялгаж сагсанд хийцгээе. Сагсанд хэдэн интоор байгааг тоолоорой.

2. Одоо улаан лоолийг ялгаж сагсанд хийцгээе. Сагсанд хэдэн улаан лооль байгааг тоолоорой гэх мэтээр хүнсний ногооны нэрийг хэлж сагсанд хийн, тоолуулна. Аль хүнсний ногоо олон байгааг асууж ярилцана.

ӨРГӨСТ ХЭМХ

Шинэ үг: Урт, богино, худалдагч, худалдан авагч

Үйл ажиллагаа 1. Барималчин хүүхдүүд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, хулдаас, хутга, хормогч, ханцуйвч, улаан лооль, өргөст хэмх бүтээх аргачлал

Аргачлал: “Улаан лооль” зохиол дээр танилцуулдаг жимс, хүнсний ногооноос өргөст хэмхийг баримлаар бүтээнэ. Өргөст хэмхийг баримлаар урлахад ямар байсан тухай сэтгэгдлээ ярина.

Үйл ажиллагаа 2. Хэмжээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлаар хийсэн өргөст хэмх, үдээс, утас

Аргачлал: Хүүхдүүдийн баримлаар хийсэн өргөст хэмхийг хатсаных нь дараа дэлгэц цаасан дээр байрлуулна. Баримлаар хийсэн өргөст хэмхийг утас, үдээсээр урт богиныг хэмжинэ. Хэн хамгийн урт өргөст хэмх хийснийг олно.

Үйл ажиллагаа 3. Хүнсний дэлгүүр сэдэвт тоглоом (Хөгжөөн баясгах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүнсний ногооны загвар үзүүлэн

Аргачлал: Хүүхдүүдийн хүнсний ногооны загвар үзүүлэн ашиглан “Хүнсний дэлгүүр” сэдэвт тоглоом тоглоно. Нэг хүүхэд худалдагч, нэг хүүхэд кассчин болж бусад хүүхдүүд худалдан авагч болж тоглоно. Багш хэрхэн тоглох талаар чиглүүлэг зааварчилгаа өгнө. Өөрөө худалдагч болж хүүхдүүдийг чиглүүлж болно.

11 дүгээр сарын II долоо хоног

ТҮМЭЭ ХҮҮ

Шинэ үг: Эхлээд, дараа нь, үйл явдал.

Үйл ажиллагаа 1. Улаан лооль (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Зохиолын үйл явдлыг илэрхийлсэн том ном

Аргачлал: Хүүхдүүд том номын зургийг харж “Улаан лооль” зохиолын үйл явдлыг сэргээн санаж ярина. Багш хүүхдүүдийг зохиолын үйл явдлыг яриулахдаа:

- Гол дүрийн нэр хэн билээ?
- Түмээд ээж нь ямар хүнсний ногоо аваад өг гэж хэлсэн бэ?
- Түмээ улаан лоолийг олж чадсан уу?
- Улаан лооль ямар өнгө, хэлбэртэй билээ? гэж чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Түмээ зураач болсон нь (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд бүрд цаас, харандаа, тосон будаг, усан будаг

Аргачлал: Хүүхдүүд өөрийн сонирхлоор хэрэглэгдэхүүнээ сонгон авч, дурын хүнсний ногоог аргачлалын дагуу дуурайн зурна. Ямар хүнсний ногоо зурснаа тайлбарлана.

Үйл ажиллагаа 3. Зөв байрлуулаарай (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зохиолын үйл явдлыг илэрхийлсэн бүдүүвч зураг

Аргачлал: Зохиолын эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийг илэрхийлсэн багц зургаас үйл явдлын дарааллыг зөв байрлуулна. Байрлуулсныхаа дараа тайлбарлан ярина.

ТҮМЭЭГИЙН ЭЭЖ

Шинэ үг: Цоолбор, хэв дардас, хавсарч наах, гуурсаар үлээх

Үйл ажиллагаа 1. Хүүдээ тусалсан нь (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн хүнсний ногооны зурагт карт, поднос

Аргачлал: Зургийг ажиглаж ижил өнгөтэй хүнсний ногооны зургийг зэрэгцүүлэн өрнө. Хүүхдүүд өөрийн сонгосон хүнсний ногооны зургийг нэрлэнэ. Багшийн чиглүүлэг: Дагаад

хэлээрэй: “Интоор, улаан лооль 2 хоёулаа улаан өнгөтэй”, “Улаан машин”, “Цагаан малгай” гэх мэт. Багш Түмээгийн ээжийн дүрд орж тоглоомыг удирдана. Улаан өнгө гэхэд улаан жимс, хүнсний ногооны зургийг өргөцгөөе. Ногоон өнгө гэхэд улаан жимс, хүнсний ногооны зургийг өргөцгөөе. Шар өнгө гэж хэлэхэд шар өнгийн жимс, хүнсний ногооны зургийг өргөцгөөе. Хүүхдүүдийн өмнө 4-5 ширхэг хүнсний ногоог зэрэгцүүлэн өрж тоглоно. Хүүхдүүд поднос, сонин зэрэг зүйл дээр улаан, шар өнгийн хүнсний ногооны зурагт картыг ялгаж байрлуулна.

Дэмжлэг үзүүлэх: Багш өнгийг сольж өргөх, тухайн өнгийн хүнсний ногоог өрж чадахгүй байгаа хүүхдэд өнгийн дүрс өгч ажиглуулах, хамт хайх зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Хүүтэйгээ хамт (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн зураг урлалын хэрэглэгдэхүүн

Аргачлал: Хүнсний ногоог төрөл бүрийн аргаар зурна. Ямар аргачлалаар дарж дүрслэхээ хүүхдүүд өөрсдөө сонгоно. Багш Түмээгийн ээжийн дүрээр зураг урлалын төв дээр ажиллах хүүхдүүдийн саналыг харгалзан хуваарилна. Зурахад нь тусална.

- Цоолбороор
- Хэв дардас ажиглах
- Хавсарч наах аргачлалаар
- Гуурсаар үлээх
- Даавуун дээр зурах

Үйл ажиллагаа 3. Ээжийн сэтгэл хөдлөл (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүүхдүүдийн зурсан зураг

Аргачлал: Хүүхдүүдийн зурсан зургийг хананд байрлуулсан байна. Багш хүүхдүүдийг дагуулан уран зургийн галерей үзэж байгаа хэлбэрээр тоглоно. Зураг бүр дээр очиж багш өөрийн сэтгэл хөдлөлийг нүүрний хувирлаар илэрхийлэн үзүүлнэ. Хүүхдүүд багш ямар сэтгэл хөдлөл илэрхийлснийг хэлнэ.

ТОГЛООМ

Шинэ үг: Гүнзгий амьсгаа авах, сансрын нисгэгч, тэнцвэрээ олох

Үйл ажиллагаа 1. Саваа мод

Хэрэглэгдэхүүн: Саваа мод

Аргачлал: Хүүхдүүд хос хосоор саваа модноос барьж зогсож тоглоно. Саваа модоо унагаж болохгүй. Саваа модыг гараа алган дээр тавьж сарвууг атгаж тэнийлгэнэ. Гарын сарвууг доош харуулан саваа модоо ээлжлэн атган тэнийлгэнэ. Саваа модоо хоёр алганы завсар байрлуулж үрэх хөдөлгөөн хийнэ.

Үйл ажиллагаа 2. Алхаарай

Хэрэглэгдэхүүн: Саваа мод

Аргачлал: Саваа модоо хоёр эгнээд тус бүр ширхгийг зиг заг үүсгэн байрлуулна.

Хүүхдүүд 2 цуваагаар:

- Саваа модны дагуу өлмий дээрээ гараа алдлан алхана.
- Саваа модыг давж өсгий дээр гараа ташаандаа авч алхана.
- Саваа модыг давж гүйнэ.

Үйл ажиллагаа 3. Цагариг

Хэрэглэгдэхүүн: Цагариг, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүд 2 баг болж, цуваагаар зогсоно. Баг бүрийн өмнө нэг ширхэг цагариг газарт байрлуулна. Эхний хүүхэд бөмбөгөө хоёр гараар барьж, цагариг дотор бөмбөгийг ойлгоод, багийнхаа ард очиж зогсоно. Дараагийн хүүхэд бөмбөгийг барьж авна. Багш хүүхдүүдэд бөмбөгийг хэт хүчтэй өндөр ойлгож болохгүйг анхааруулна. Энэ мэтчилэн хүүхэд бүр тоглоно.

Үйл ажиллагаа 4. Сансрын нисгэгч

Хэрэглэгдэхүүн: “Сансрын нисгэгч жингүйдээд” дохиогоор хүүхдүүд гар, хөлийг чөлөөтэй удаанаар хөдөлгөнө. Хүүхдүүд багшийн “1” гэсэн дохиогоор нэг хөл дээр, “2” дохиогоор нэг

гар, нэг хөл дээр, “З” гэсэн дохиогоор биеийн гурван мөч дээр тэнцвэрээ олж зогсоно. Тэнцвэрээ хадгалан зогсохдоо анхаарлаа төвлөрүүлнэ.

Үйл ажиллагаа 5. Тайвшраарай

Хэрэглэгдэхүүн: Дасгалын зурагтай карт

Аргачлал: Дөрвөн ширхэг зурган карт дотор хоёр карт ижил дүрстэй байна. Хүүхэд ижил хоёр зурган картыг ижилсүүлэн авч, дасгалын нэрийг хэлж биеэр хийж үзүүлнэ.

ЭРГЭЭД САНААРАЙ

Шинэ үг: Эхлэл, өрнөл, төгсгөл

Үйл ажиллагаа 1. Найзтайгаа тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн материалаар хийсэн хүнсний ногооны загвар үзүүлэн

Аргачлал: Хүүхдүүд төрөл бүрийн материалаар хийсэн хүнсний ногооны загвар үзүүлэнг барьж үзээд шинж өнгөөр нь ялгаж, сагсанд хийж тоглоно.

Багшийн чиглүүлэг: Улаан сагсанд улаан өнгийн хүнсний ногоо, ногоон сагсанд ногоон өнгийн хүнсний ногоог ялгаж хийгээрэй.

Үйл ажиллагаа 2. Улаан лооль (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зохиолын үйл явдлаар оюуны зураглал хийх бүдүүвч зураг, зохиолын үйл явдлыг тоймлон зурсан багц зурагт хуудас.

Аргачлал: Хүүхдүүдийг зохиолын үйл явдлыг сэргээн санаж оюуны зураглал хийх боломж нөхцөлөөр хангасан байна. Хүүхдүүд зохиолын үйл явдлыг харуулсан багц зургийг үйл явдлын дарааллаар байрлуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зохиол яаж эхэлдэг билээ?
- Зохиолын өрнөл хэсэгт ямар үйл явдал гардаг вэ?
- Зохиол яаж төгсдөг вэ?

Эцэг эхтэйгээ хамтаръя.

- Айл гэрийн өдөр тутмын энгийн ажлыг хүүхдэд хамтдаа хийх боломж олгоно (тоглоомоо цэгцлэх, хувцсаа эвхэх, цэцэг услах, хог ангилах гэх мэт).
- Эцэг эх хүүхэдтэйгээ хамтдаа гэртээ жүжигчилсэн тоглоом тоглож, дүрд орж, хөдөлгөөн даган дуурайх боломж олгоно.
- Амралтын өдөр гэр бүлээрээ гадаа гарахдаа навч, чулуу, цэцэг ажиглаж, өнгө, хэлбэрээр нь ярилцана.
- Өдөр бүр хүүхдээсээ “Өнөөдөр юу сурсан бэ?”, “Юу сонирхолтой байсан бэ?” гэж асууж, сонсох дадлыг өөр дээрээ бий болгоно.
- Хүүхдэдээ өдөр бүр богино хугацаанд (5–10 минут) ном уншиж өгнө.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:

Цаашид сайжруулах:

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XII САР

БИД НАЙЗУУД

Хүүхдийн эзэмших чадамж:

Харилцах: Үлгэр зохиолын үйл явдлыг ойлгож, дүрийг зааж нэрлэх, зохиолын тухай бусадтай харилцан ярилцах чадвартай болно.

Хамтран ажиллах: Хүүхдүүд хоорондоо найзлах, хамтран тоглох, найздаа туслах, амьтдын хөдөлгөөний дуурайж хөгжмийн аянд тохируулан биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх чадварыг дэмжинэ.

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хөдөлгөөнт тоглоом болон гадна талбайд тоглох зугаалах үед орчны аюулгүй байдалд анхаарч, тоглоом хэрэглэгдэхүүний бүрэн бүтэн байдлыг шалгана. Зургийн хэрэгсэлтэй ажиллах үед аюулгүй ажиллагааны зааварчилгааг сануулна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Багш болон найз нартайгаа мэндчилгээний самбар болон олон төрлийн мэндчилгээгээр мэндлэх, мөн өөрийн сэтгэлийн хөдлөл ямар байгааг үгээр болон зургаар тайлбарлан илэрхийлэх боломж олгож эерэг уур амьсгал бүрдүүлээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Зохиолтой танилцаж, үйл явдлын тухай өөрийн бодлоо илэрхийлэх, тоглоомын дүрмийг баримтлан тоглох, дуулах, хамтран бүтээл хийх явцад нь хүүхдүүдийг урамшуулан дэмжээрэй. Хүүхэд тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн материалыг өөрөө сонгож хэрэглэх боломжтой орчин нөхцөлийг бүрдүүлээрэй.

Зугаалга: Цэцэрлэгийн гадна талбайн орчинтой танилцаж, цаг агаарын байдал, орчныг ажиглан, хамтдаа энгийн хөдөлмөр хийж, тоглох энгийн зааврыг дагаж чадварыг дэмжээрэй.

Номын цаг: Өөрийн дуртай номыг сонирхож үзэх, номын тухай харилцан ярилцах орчин бүрдүүлж, номын төвд баримтлах жижиг дүрмүүдийг тайлбарлаж өгөөрэй. Чанга уншлагын арга зүйгээр “Авгалдайн найз” зохиолыг уншиж танилцуулаарай.

Хөгжөөн баясах ажил: Хүүхдүүд хормогчин болон ширээний театрт дүрд тоглож, бүтээлчээр оролцох, хөдөлгөөнт тоглоомын үед дүрмийг баримтлан тоглох байдлыг дэмжин, хамтран оролцоорой.

Боломжууд:

Хамтран тоглох үед тоглоомоо булаацалдах, муудалцах тохиолдол гарвал хүүхдүүдэд өөрсдөө шийдвэрлэх боломж олгоорой. Хүүхдэд өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломж олгож, өөрөөр нь сонголт хийлгээрэй. Уурласан бухимдсан үед тайвшрах энгийн аргуудаас тайлбарлаж, зааж өгөөрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ2.3а. Номын зургийг ажиглаж, ялган нэрлэнэ.</p> <p>НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. ХӨГ2.1д. Үлгэр зохиол, дуу хөгжмийн танил дүрийг дуурайж, харилцан тоглоно.</p>	<ul style="list-style-type: none"> - Зураг ажиглан, юу болж байгаа талаар ярих, “Эхлээд юу болсон бэ?”, “Дараа нь юу болсон бэ?” гэх мэт асуултад хариулах, номын зургуудын дарааллыг ойлгох; - Тухайн цаг мөчид өөрөө ямар сэтгэл хөдлөлтэй байгаагаа хэлэх; - Үлгэр зохиолоос дуртай дүрээ сонгож дүрийн онцлог, үйл явдлыг дуурайж, хамтран тоглох. 	<p>Сайн найз</p>
<p>НСХ2.2а. Бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр нэрлэдэг болно.</p> <p>БНО2.1а. Ойр орчны амьтны үр төлийг нэрлэн, ялгаж танина. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй</p>	<ul style="list-style-type: none"> - “Хэнд юу тохиолдсон бэ?” тоглоом тоглож, тухайн хүмүүст төрж буй мэдрэмжийг нэрлэж ярилцах; - Зурагт ном, тоглоом, самбар, дүрс эсвэл бичлэгээс амьтны эх болон үр төлийг ажиглаж, энгийн асуултын дагуу харилцан ярилцах, дуу авиаг дуурайн 	<p>Хөгжилтэй найз</p>

<p>тогтлыг ажиглаж, дуурайна.</p>	<p>тоглох; - Хоёр өөр өнгийн ижил хэмжээтэй тоглоомын давтамжийг дуурайн өрөх .</p>	
<p>ХЭМ2.1д. Сэдэвт алхалт, гүйлтийг хэрэглэл ашиглан гүйцэтгэнэ. ХЭМ2.1и. 2 хөл дээрээ 5 зураас давж үсэрч бууна. (зураас хоорондын зай 35см) ХЯ2.1б. 3-4 үгтэй өгүүлбэрийг давтаж хэлнэ. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ.</p>	<p>- Амьтдыг нэрлэж, тухайн амьтны хөдөлгөөнийг дуурайж алхах, гүйх, үсрэх; - Тоглоом тоглох явцад үгсийг анхааралтай сонсон, авиа, үгсийг удаан, тод, чанга дуурайж хэлэх, 3-4 үгтэй өгүүлбэрийг давтан хэлэх; - Хөгжмийн аянд амьтдын хөдөлгөөнийг биеэр болон хөгжимт хөдөлгөөнийг хэрэгсэл ашиглан дүрслэн тоглох.</p>	<p>Аз жаргалтай найзууд</p>
<p>ХӨГ2.1в. Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ. ХӨГ2.1д. Үлгэр зохиол, дуу хөгжмийн танил дүрийг дуурайж, харилцан тоглоно. ХЯ2.2д. Үйл явдлыг тоочиж ярина.</p>	<p>- Багшийг даган, хөгжмийн хэмнэлд тохируулан, алга таших, хөл товших, найгах ганхах зэрэг хөдөлгөөнийг хийх; - Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих, зураг, хуруун хүүхэлдэй, ширээний театр зэргийг ашиглан дүрд тоглон жүжиглэхэд оролцох.</p>	<p>Эрвээхэй</p>
<p>ЗУ2.3а. Баримлын шавраар хоёр хэсгээс бүтсэн зүйлийг бие дааж барина. БНО2.1а. Ойр орчны амьтны үр төлийг нэрлэн, ялгаж танина. МАТ2.3а. Тоглоом юмсыг тодорхой шинжээр хоёр хэсэгт ангилна.</p>	<p>- Баримлын шаврыг базаж зөөлрүүлэх, хавтгайлах, цувих, сунгах, татах, холбох; - Зурагт ном, тоглоом, самбар, дүрс эсвэл бичлэгээс амьтны үүр, хоол тэжээлийг ажиглаж, энгийн асуултын дагуу харилцан ярилцах, - Дугуй, дөрвөлжин дүрстэй тоглоомуудыг ялгаж тавих.</p>	<p>Ажилсаг хүүхдүүд</p>
<p>БНО2.1а. Ойр орчны амьтны үр төлийг нэрлэн, ялгаж танина. НСХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгодог болно. ХЭМ2.2а. Хувийн ариун цэвэр сахих үйлийг насанд хүрэгчдийн зааварчилгаагаар хийнэ.</p>	<p>- Зурагт ном, тоглоом, самбар, дүрс эсвэл бичлэгээс амьтны эх болон үр төлийг ажиглаж, энгийн асуултын дагуу харилцан ярилцах; - Хоорондоо хамааралтай эд зүйлүүдийг олж тоглох; - Саван эрүүл ахуйн хэрэгслийг нэрлэх, зориулалтын дагуу хэрэглэх.</p>	<p>Нэрлээрэй</p>

12 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Миний найз	Тойргийн цаг	"Найз" гэсэн сэдвийн хүрээнд чиглүүлэг асуултаар баяжуулан ярилцана.	Байхгүй.	Чиний найз хэн бэ?; Найзтайгаа хамт юу хийдэг вэ?; Чи найздаа хэрхэн тусалдаг вэ?	Харилцах: Өөрийн хүсэл, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Найз нарынхаа нэрийг хэлдэг.
Авгалдайн найз	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багш "Авгалдайн найз" дэлгэмэл ном уншиж өгнө. Хүүхдүүд зохиолд гарсан дүрүүдийг нэрлэж, үйл явдлын тухай харилцан ярилцана.	"Авгалдайн найз" дэлгэмэл ном, эсвэл цахим ном, Цахим холбоос 1.	Зохиолд ямар ямар дүр гарсан бэ?; Авгалдайн юу идсэн бэ?; Авгалдай хэнтэй найзалсан бэ?.	Харилцах: Үлгэр зохиолын үйл явдлыг ойлгож, дүрийг зааж нэрлэх	Багшийн дэмжлэгтэйгээр дүрийн нэр, зохиолын үйл явдлыг тухай ярьдаг.
Миний дуртай ном	Номын цаг	Номын төвөөс өөрийн сонирхсон номыг сонгон үзэж, зохиолд гарсан амьтдын дүрүүдийг нэрлэнэ.	Номын төвийн номууд	-Энэ ямар зураг вэ? - Чи ямар ном үзэж байна вэ?	Харилцах: Үлгэр, зохиолыг сонсох, ярилцах	Зураг, номын хуудаснаас нэрлэсэн зүйлийг зааж хэлдэг.
Сайн уу? найзууд аа	Тойргийн цаг	Мэндчилгээний төрлөөс сонгож мэндчилнэ. Сэтгэлийн хөдөлгөөний зургаас өөрийн сэтгэл хөдлөлийн байдалтай тохирох зургийг сонгон самбарт байрлуулна.	Олон төрлийн зурагт мэндчилгээ, Сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн зургууд.	-Ямар нүүрний хувирал гаргасан байна вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг ажиглаж, ялган таних	Баярласан, айсан гэх мэт үгсийг хэрэглэж сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг.
Баярласан уу? гунигласан уу?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зохиолын дүрүүдийн үйл хөдлөл, нүүр царайны хувирлыг дуурайж илэрхийлэн ярилцана.	Авгалдайн найз том ном	Зөгий авгалдайтай найзалсан уу? Яагаад найзлаагүй вэ? Чи юу гэж бодож байна?	Харилцах: Өөрийн мэдсэн ажигласан зүйлээ хуваалцах	Баярласан, айсан гэх мэт үгсийг хэлдэг.

Ижил царай	Хөгжөөн баясах цаг	Сэтгэлийн хөдөлгөөнийг дүрсэлсэн шооны буусан талын зургийг ажиглаж дуурайж илэрхийлнэ.	Хөгжим, бүжгийн ая, сэтгэлийн хөдөлгөөнийг дүрсэлсэн шоо.	-Ямар нүүрний хувирал гаргасан байна вэ? -Хэн адил нүүрний хувирал гаргасан бэ?	Харилцах: Өөрийн хүсэл, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Баярласан, айсан гэх мэт үгсийг хэрэглэж сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг.
Дасгалын цаг	Өглөөний дасгал	Багштай хамтдаа үгийг тод хэлж, хөдөлгөөн хийж дасгал хийнэ.	- Зурагт үзүүлэн	-Байхгүй	Харилцах: Бусдаас тусламж хүсэх, бусдыг ажиглах, энгийн хариу үйлдэл үзүүлэх зэргээр харилцаанд оролцох	Багшийн зааврын дагуу энгийн дасгал хөдөлгөөн хийдэг.
Амьтад	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд шувуудыг нэрлэн, өлмий, өсгий дээр алхахдаа дуу авиаг гарган тоглоно.	Хөгжмийн ая.	-Байхгүй	Бүтээлчээр сэтгэх: Амьтдыг өөрсдөө нэрлээд, хөдөлгөөнийг дуурайж алхаж, гүйж, үсэрч харуулах	Дүрд хувирч хэрэглэл ашиглан алхалт, гүйлтийг гүйцэтгэдэг.
Бон бон	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багш дасгалын гүйцэтгэлийг тайлбарлан, хамтдаа дасгал хийнэ.	Хөгжмийн ая, дэлгэц, Цахим холбоос 2.	-Байхгүй	Харилцах: Бусдаас тусламж хүсэх, бусдыг ажиглах, энгийн хариу үйлдэл үзүүлэх зэргээр харилцаанд оролцох	Дасгалыг багшийн заавраар гүйцэтгэдэг.
Зөгий	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зөгийний дуу чимээ болон хөдөлгөөнийг дуурайн тоглоно.	Цагариг, хөгжим, ая.	-Байхгүй	Хамтран ажиллах: Дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх зэргээр хамтрах, оролцох	Өдөр тутмын тоглоом, үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.
Хэн дуугарсан бэ?	Тойргийн цаг	Зөгий, нохой, муур зэрэг амьтдын дуу чимээг сонсоод асуултад хариулж ярилцана.	Хөгжим, зөгий, нохой, муур дуугарах дуу чимээ.	-Ямар дуу чимээ гарч байна вэ? - Ямар амьтан дуугарсан бэ?	Бүтээлчээр сэтгэх: Дууны аяс, хэмнэлд тохируулан дуу авиагаар туршиж тоглох	Амьтдын дуу авиаг сонсоод нэрлэж хэлдэг.
Эрвээхэйн бүжиг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Эрвээхэй" Дууны аянд тохируулан эрвээхэй болж хөдөлгөөн хийж бүжиглэнэ.	Цахим холбоос 3; Эрвээхэйн далавч, цэцэг навч (нэмэлт).	-Байхгүй	Бүтээлчээр сэтгэх: Дууны аяс, хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийж, өөрийн санаагаа илэрхийлэх	Хөгжмийн ая, хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг дуурайн хийдэг.

Эрвээхэй хэмнэл	Хөгжимт хөдөлгөөн (Үйл ажиллагааны төрөл тодорхойгүй)	Хөгжмийн хэмнэлийн бичлэгийг ашиглан аянд тохируулан эрвээхэй болж далавчаа дэвэх хөдөлгөөн хийнэ. Алга таших, эргэлдэх.	Хэмнэлийн зурагт үзүүлэн; Цахим холбоос 4.	-Байхгүй	Харилцах: Бусдаас тусламж хүсэх, бусдыг ажиглах, энгийн хариу үйлдэл үзүүлэх зэргээр харилцаанд оролцох	Аяыг сонсоод жигд хэмнэлийн дагуу бусадтай хамтарч алга ташдаг.
Жүжиглэж тоглоцгооё	Хөгжөөн баясах цаг	"Авгалдайн найз" зохиолыг жүжигчилж тоглоно.	"Авгалдайн найз" зохиолын дүрийн багууд.	-Зохиолд ямар амьтад гарсан бэ? - Авгалдайн сайн найз хэн бэ?	Хамтран ажиллах: Дүрд тоглох, найзынхаа тусламжтайгаар даалгавар гүйцэтгэх	Багшийн дэмжлэгтэйгээр дүрийн нэр, энгийн үг хэллэгийг хэрэглэж дүрд оролцдог.
Баримлаар урлаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зохиолын дүрээс өөрийн сонирхлоор сонгоно. Аргачлалын дагуу баримлын шавраар бүтээл хийнэ.	Баримлын шавар, баримлын хэрэгслүүд, аргачлалын зургууд, чүдэнзний мод, өнгийн цаас.	-Чи зохиолын аль дүрийг сонгож бүтээх вэ? -Яагаад энэ дүрийг сонгосон бэ?	Хамтран ажиллах: Бусдын тусламжтайгаар хамтран бүтээл хийх оролдох	Баримлын шавар, элс, зуурмагаар хоёр хүртэлх хэсгээс бүтсэн юмсыг бие дааж барьдаг.
Угаацгаая	Ахуйн хөдөлмөр	Зургийн хэрэгслүүдээ арчиж цэвэрлэнэ. Ширээ, шалан дээр ус асгарвал арчиж цэвэрлэнэ.	Хормогч, ханцуйвч, жижиг хувин, алчуур, ус, усан будгийн сав, бийр, нийлүүр, баримлын суурь.	-Ямар	Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглох, биелүүлэх даалгаврыг	Хичээлийн хэрэгслээ цэвэрлэдэг.
Амьтдыг олоорой	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд хөгжмийн аянд эрвээхэйг хайж олох, олсон бүтээлээрээ бүжиглэх тоглоом тоглоно.	Хөгжим, ая, эрвээхэйн зурагтай жижиг зургууд, баримлын бүтээлүүд, хуванцар тоглоом.	Эрвээхэй хаана нуугдсан бэ?	Хамтран ажиллах: Дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх	Тоглоом, үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.
Зугаалцгаая	Зугаалга	Гадаа талбайд зугаалга хийж хамтдаа тоглоно.	Жижиг сав, хүрз, бээлий, хормогч, ханцуйвч.	Юу ажигласан бэ? Модны навч яагаад унасан бэ?	Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглох, биелүүлэх даалгаврыг	Байгалийн үзэгдлийг ялгаж нэрлэдэг.

Цэвэрч хүүхдүүд	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Гар угаах аргачлал, ямар үед угаах тухай үзүүлэн зургуудаас сонгож аваад тайлбарлан ярилцана.	Ус, саван, гар угаах аргачлалын зурагт үзүүлэн	Гар угаахад юу хэрэг болох вэ?; Гараа хэрхэн угаах вэ?; Гараа ямар үед угаах хэрэгтэй вэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Баяр хөөртэй байгаагаа өөрийгөө мэдэрч, илэрхийлэх	Насанд сануулгатайгаар гар, нүүр, шүдээ угааж, хоолой амыг зайлдаг.
Үүрийг олоорой	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд амьтны баг өмсөж, хөгжмийн аянд хөдөлгөөн хийж, үүрийг зөв олж тоглоно.	4 ширхэг урт олс, амьтдын үүрний зураг, хүүхэд бүрд амьтны толгойн баг, хөгжмийн ая.	Энэ ямар амьтан бэ? Аль үүрэнд амьдардаг вэ?	Хамтран ажиллах: Үйлдлийг ажиглаж, даган дуурайх, ээлжээ хүлээж тоглох, нөхөрсөг үг хэрэглэх	Амьтныг нэрлэж, амьдардаг орчныг ялгаж чаддаг.

12 дугаар сарын I долоо хоног

САЙН НАЙЗУУД

Шинэ үгс: Авгалдай, эрвээхэй

Үйл ажиллагаа 1. Миний найз (Тойргийн цаг)

Аргачлал: “Найз” гэсэн сэдвийн хүрээнд чиглүүлэг асуултаар баяжуулан ярилцана.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Чиний найз хэн бэ?
- Найзтайгаа хамт юу хийдэг вэ?
- Чи найздаа хэрхэн тусалдаг вэ?

Үйл ажиллагаа 2. Авгалдайн найз (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Авгалдайн найз” дэлгэмэл ном, эсвэл цахим ном

Аргачлал: Багш зохиолын үйл явдлыг дэлгэмэл ном ашиглан дуу хоолойг хувирган жүжиглэн, сонирхолтойгоор ярьж өгнө. Зохиолын талаар харилцан ярилцана. Хүүхдүүд зохиолд ямар, ямар дүр гарсныг нэрлэж, үйл явдлын тухай харилцан ярилцана. Цахим холбоос 1 (Авгалдайн найз цахим номын линк)

Багшийн чиглүүлэг асуулт:

- Зохиолд ямар ямар дүр гарсан бэ?
- Авгалдайн юу идсэн бэ?
- Авгалдай хэнтэй найзалсан бэ?

Үйл ажиллагаа 3. Миний дуртай ном (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Номын төвийн номууд, “Авгалдайн найз” номын олон төрлүүд (том ном, бяцхан ном, дэлгэмэл ном гэх мэт)

Аргачлал: Номын төвөөс өөрийн сонирхсон номын сонгон үзнэ. Зохиолд гарсан амьтдын дүрүүдийг нэрлэнэ. Номын зураг, үйл явдлыг тайлбарлан ярина.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Энэ ямар зураг вэ?
- Чи ямар ном үзэж байна вэ?

ХӨГЖИЛТЭЙ НАЙЗ

Шинэ үгс: Баярлах, уурлах

Үйл ажиллагаа 1. Сайн уу? найзууд аа (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Олон төрлийн зурагт мэндчилгээ, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн зургууд.

Аргачлал: Өглөө цэцэрлэгтээ ирээд багш болон найзуудтайгаа мэндчилгээний самбар ашиглан дуртай мэндчилгээний төрлийг сонгон мэндчилнэ. (гар барих, алгаараа цохих, тэврэх, гараараа даллах гэх мэт) Мөн сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зургаас өөрийн сэтгэл хөдлөлийн байдалтай тохирох зураг сонгон самбарт байрлуулна.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Ямар нүүр царайны хувирал вэ?

Үйл ажиллагаа 2. Баярласан уу? гунигласан уу? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Авгалдайн найз” том ном

Аргачлал: Зохиолын дүрүүд ямар нүүрний хувирлын гаргасан тухай асуултаар чиглүүлэн зохиолын дүрүүдийн үйл хөдлөл, нүүр царайны хувирлыг дуурайж илэрхийлэн ярилцана.

Багшийн чиглүүлэг асуулт:

Зөгий авгалдайтай найзалсан уу? Яагаад найзлаагүй вэ? Чи юу гэж бодож байна?

Авгалдай ямар нүүрний хувирал гаргасан бэ? Баярласан уу? Гунигласан уу? Аль нь вэ? Царайгаараа харуулаарай гэх мэт асуултаар чиглүүлэн ярилцана.

Үйл ажиллагаа 3. Ижил царай (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, бүжгийн ая, сэтгэлийн хөдөлгөөнийг дүрсэлсэн шоо

Аргачлал: Хүүхдүүд тойргоор зогсоно. Ая эхлэхэд бүжгийн хөдөлгөөн хийж, баруун гар тал руугаа тойргоор алхана. Ая зогсоход багш сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зурагт шоог орхино. Хүүхдүүд шооны буусан талын сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зургийг ажиглаж дуурайн хийнэ. Хүүхдүүд шоогоор ээлжлэн тоглоно.

АЗ ЖАРГАЛТАЙ АМЬТАД

Шинэ үг: Хазайх, өлмий

Үйл ажиллагаа 1. Дасгалын цаг (Өглөөний дасгал)

Хэрэглэгдэхүүн: Авгалдай, аалз, эрвээхэйн зурагт үзүүлэн

Аргачлал: Багш үгээ тод хэлж, дасгалыг тайлбарлан, хүүхдүүдтэй хамт хийнэ.

Алиа хөөрхөн авгалдай - Гараа цээжний өмнө нугалан, сарвууг атгаж, баруун зүүн тал руу хазайна.

Адтай сэргэлэн аалз - Гараа нугалж сарвууг тэнийлгэн хөдөлгөж, дороо эргэнэ.

Алаг эрээн эрвээхэй - Гараа алдлан өргөж буулгах хөдөлгөөн хийнэ.

Аз жаргалтай найзууд - Гар гараасаа барин, дээш өргөнө.

Үйл ажиллагаа 2. Амьтад (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая

Аргачлал:

1. Хүүхдүүд 2-3 (болжмор, хөхөө, хэрээ) шувуудыг нэрлэн, өлмий, өсгий дээр алхахдаа шувуудын дуу авиаг гаргаж дуугарна.

Хөгжмийн аянд багш “Анчин”-ы дүрд орж, хүүхдүүдийг дагуулан хөнгөн гүйнэ.

- Анчин эргэж харахад хүүхдүүд сууж нуугдана.

- Анчин дахин гүйхэд хүүхдүүд араас нь дагаж хөнгөн гүйнэ. Анчин үргэлжлүүлэн тоглохдоо чиглэлээ өөрчлөн алхаж, гүйж тоглоно.

2. “Бон бон”

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, дэлгэц

Аргачлал: Багш дасгалын гүйцэтгэлийг тайлбарлан биечлэн хийж хамтдаа гүйцэтгэнэ. Үүнтэй ижил төрлийн дасгалыг багш зохиомжилж болно. Цахим холбоос 2 дасгалын бичлэг ашиглана.

3. Зөгий

Хэрэглэгдэхүүн: Цагариг, хөгжим, ая

Аргачлал: “Зөгий” тоглоомыг тоглоход талбайн хоёр захад цагаригуудыг цувуулан тавина. Нэг цагаригт 1-3 хүүхэд зогсохоор тооцож байрлуулна. Багш хөгжмийн аяыг эхлүүлэхэд, хүүхдүүд зөгий болж “зий зий зий” гэж дуугаран хөнгөн гүйх, хоёр хөл дээр үсрэх зэрэг хөдөлгөөнийг хийнэ. Хөгжмийн ая зогсоход хүүхдүүд цагариг руу гүйж дотор нь орж зогсоно. Цагаригт багтаагүй хүүхэд зөгий шиг “зий зий зий” гэж дуугарна. Хүүхдүүдийн анхаарал төвлөрөлтийг нэмэгдүүлэх зорилгоор тоглоомыг хэд хэдэн удаа давтана.

Тайвшруулах дасгал: хөгжмийн аянд гурван амьтнаар төсөөлөн иогийн дасгал гүйцэтгэнэ.

12 дугаар сарын II долоо хоног

ЭРВЭЭХЭЙ

Шинэ үгс: Дэвэх, эргэлдэх

Хэрэглэгдэхүүн: Үзүүлэн зураг, дүрс бичлэг.

Үйл ажиллагаа 1. Хэн дуугарсан бэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, зөгий, нохой, муур дуугарах дуу чимээ

Аргачлал: Урьдчилан бэлтгэсэн зөгий дүнгэнэх, нохой хуцах, муур дуугарах дуу чимээг сонсоно. Хүүхдүүд дууг сонсоод ямар амьтан болохыг нэрлэнэ. Эдгээр амьтдаас аль нь “Авгалдайн найз” зохиолд гардаг талаар асууна. Зөгийний тухай ярилцана.

Үйл ажиллагаа 2. Эрвээхэйн бүжиг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хэмнэлийн зурагт үзүүлэн

Аргачлал:

1. Цахим холбоос 3 ашиглан үг Г.Сэсмээ, ая С.Батболд “Эрвээхэй” дууг сонсоно. Дууны утга санааны талаар ярилцана. Эрвээхэй болж ямар хөдөлгөөн хийж болох талаар ярилцана. Дууны аянд тохируулан хөдөлгөөнийг дагуулан хийнэ.

2. Чингэлтэй дүүргийн 5-р цэцэрлэгийн хөгжмийн багш Г.Тэгшбуяны зохиомж “Эрвээхэй” хөгжимт хөдөлгөөнийг хийнэ. Нэмэлтээр эрвээхэйн далавч, цэцэг навчаар орчин бүрдүүлж өгч болно.

3. Эрвээхэй хэмнэл: Цахим холбоос 4 хөгжмийн хэмнэлийн бичлэгийг ашиглан аянд тохируулан эрвээхэй болж 2 гараараа далавчаа дэвэх хөдөлгөөн хийнэ. Алга таших зураг гарах үед 1, 2, 3 гэж тоолон алга ташна. Эргэлдэх сумын дагуу доороо эргэнэ.

Үйл ажиллагаа 3. Жүжиглэж тоглоцгооё (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: “Авгалдайн найз” зохиолын дүрийн багууд

Аргачлалд: Зохиолд гарсан амьтдын дүрүүдийг сэргээн санаж ярилцана. Зохиолын дүрээс өөрт хамгийн их таалагдсан дүрийг сонгон авч, үлгэрийг жүжигчилж тоглоно. Жүжигчилж тоглож байгаа хүүхдүүдэд дэмжлэг үзүүлнэ. Дүр сонгож аваагүй хүүхдүүд найз нарынхаа тоглолтыг үзнэ. Дараагийн удаа бусад хүүхдүүд дүрд хувирч жүжигчилж тоглож болно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зохиолд ямар амьтад гарсан бэ?
- Авгалдайн сайн найз хэн бэ?

АЖИЛСАГ ХҮҮХДҮҮД

Шинэ үг: Ажилсаг, идэш тэжээл, үүр

Үйл ажиллагаа 1. Баримлаар урлаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, баримлын хэрэгслүүд, аргачлалын зургууд

Аргачлал: Зохиолд гарсан бүх дүрүүд ажилсаг хичээнгүй амьтад байсан. Бүгдээрээ хамтдаа зохиолын дүрүүдийг баримлаар бүтээцгээе. Хүүхдүүд аалз, хар хорхой, зөгий, эрвээхэй гэсэн 4 амьтнаас өөрийн бүтээхийг хүсэж буй амьтныг сонгон тухайн багийн ширээнд сууж аргачлалын дагуу бүтээлээ хийнэ. Амьтныг толгой болон их биеийн баримлын шавраар бөөрөнхийлөн хийх хялбар аргачлалыг хүүхэд бүрд харагдахаар байрлуулна. Амьтны нүд, хөл, тэмтрүүл, далавч хэсгүүдийг чүдэнзний мод, өнгийн цаас зэрэг бэлдэц материалуудаар баяжуулан бүтээнэ. Багш болон багшийн туслах нар хүүхдүүдэд тайлбарлан чиглүүлж, дэмжлэг хэрэгтэй хүүхдүүдэд тусална.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи зохиолын аль дүрийг сонгож бүтээх вэ?
- Яагаад энэ дүрийг сонгосон бэ?

Үйл ажиллагаа 2. Угаацгаая (Ахуйн хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, жижиг хувин, алчуур, ус, усан будгийн сав, бийр, нийлүүр, баримлын суурь

Аргачлал: Багш хүүхдүүдэд содатай усыг найруулан бэлтгэж өгнө. Хормогч болон ханцуйвчаа өмсөхөд нь найз нартаа тусална. Өөрийн хэрэглэдэг зургийн хэрэгслүүдээ арчиж, цэвэрлэнэ. Ширээ болон шалан дээр ус асгарвал хуурай алчуураар арчиж цэвэрлэнэ. Өөрийн эд зүйлсээ хайр гамтай хэрэглэх тухай ярилцана.

Үйл ажиллагаа 3. Амьтдыг олоорой (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, ая, эрвээхэйн зурагтай жижиг зургууд, мөн баримлын бүтээлүүд

Аргачлал: Багш үйл ажиллагаа эхлэхийн өмнө эрвээхэй, зөгийний зурагт картууд болон хуванцар тоглоом, хүүхдүүдийн хийсэн баримлын бүтээлүүдийг ангид нууж байрлуулна. Багш хөгжмөөр “Эрвээхэй” дууны аяыг явуулна. Хүүхдүүд хөгжмийн аяыг сонсоод ангиас эрвээхэйн зураг эсвэл тоглоом, баримлын бүтээлийн аль нэгийг олж ширээн дээр авч ирж тавиад “Эрвээхэй” бүжгийн хөдөлгөөн хийж бүжиглэнэ. Хөгжмийн ая зогсоход тоглоом олж

чадаагүй хүүхдүүд хамтдаа тойрог болон зогсож нүдээ анина бусад хүүхдүүд өөрийн олсон тоглоомоо ахин өөр газар нууна. Тоглоомыг ахин давтан тоглоно.

НЭРЛЭЭРЭЙ

Шинэ үг: Ажиглах, гар чийдэн, тусгах.

Үйл ажиллагаа 1. Зугаалцгаая (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Жижиг сав, хүрз, бээлий, хормогч, ханцуйвч.

Аргачлал:

- Гадаа цаг агаар, тэнгэр, үүл болон моднуудыг ажиглаад хамтран ярилцана. Багш хүүхдүүдээс юу ажигласан талаар асууна. Модны навч яагаад унасан тухай ярилцана.
- Хүүхдүүд багш нартайгаа хамтран “Хөшөө” болж тоглоно. Мөн хөгжмийн аянд багшийн нэрлэсэн амьтдын хөдөлгөөнийг хийж тоглож болно.
- Хүүхдүүд гадна талбайн жижиг хэсгийг сонгоод ойр орчны талбайг цэвэрлэнэ. Хэрвээ навч унасан байвал хувиндаа хийж зөөж хаяна. Харин цастай байвал цасыг хувинд хийгээд модны ёроолд асгана. Талбайгаа цэвэрлэж дуусаад багаж хэрэгслээ хураана.

Үйл ажиллагаа 2. Цэвэрч хүүхдүүд (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Ус, саван, гар угаах аргачлалын зурагт үзүүлэн

Аргачлал: Зугаалгаар гарсны дараа хувцсаа сольж, гараа сайтар угаана. Дараа нь хүүхдүүд гар угаах аргачлал, гараа ямар үед угаах тухай үзүүлэн зургуудаас сонгож аваад тайлбарлаж ярина.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Гар угаахад юу хэрэг болох вэ?
- Гараа хэрхэн угаах вэ? Үйлдлийг тайлбарлан хийж үзүүлээрэй.
- Гараа ямар үед угаах хэрэгтэй вэ?

Үйл ажиллагаа 3. Үүрийг олоорой (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: 4 ширхэг урт олс, амьтдын үүрний зураг, хүүхэд бүрд амьтны толгойн баг, хөгжмийн ая.

Аргачлал: Багш зохиолд гарсан амьтдын хоол, тэжээл болон амьдрах орчныг харуулсан богино дүрс бичлэг үзүүлж ярилцана. Ангийн 4 буланд олсоор том цагариг үүсгэн газарт тавиад дотор нь амьтдын үүрний зургийг байрлуулна. Хүүхдүүд ямар амьтан болж тоглохоо өөрсдөө сонгож толгойн багаа сонгон өмсөнө. Хөгжмийн ая эхлэхэд хүүхдүүд амьтдын биеийн хөдөлгөөний илэрхийлэн хөдөлгөөн хийнэ. Хөгжмийн ая зогсох үед өөрийн үүрийг хайж олоод үүрэндээ орж зогсоно. Олон удаа давтан тоглож болох бөгөөд хүүхдүүд толгойн багаа сольж өөрчлөн тоглож болно.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа

- Хэл ярианы орчныг дуу авиатай зурагт ном, товчлууур дарахад дуу гардаг самбар, танин мэдэх, гар хүрч болох бодит зүйл ашиглаж үгийн баялгийг нэмэгдүүлж харилцахад дэмжлэг үзүүлнэ.
- Тоо, хэмжээ, дүрс, биет, байршил зэрэг ойлголтыг тоглоом, мэдрэхүй, хөдөлгөөнтэй хослуулан аажим, сонирхолтой байдлаар, үйлдлийг давтан хийх, бодитоор харьцуулах, үргэлж урам өгч, ахиц гарвал магтах зэргээр суралцахад дэмжлэг үзүүлнэ.
- Хүүхдэд харж мэдрэхэд тохиромжтой зураг эд юмсыг сургалтад ашиглаж харж, барьж мэдэрч зурж, урлах үйлдлийг харуулсан зурган зааварчилгаа болон биеийн үйлдлээр дэмжлэг үзүүлээрэй.

Эцэг эх, эхтэйгээ хамтаръя:

- Мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой ном уншиж өгч, ярилцах, үлгэр зохиолын агуулга, дүрийн талаар хүүхэдтэй идэвхтэй харилцан яриаг өрнүүлэх;
- Амьтан тэжээх, түүнийг хайрлан хамгаалах, тасалгааны ургамал тарих, байгаль, цаг агаарын үзэгдлийг хамтдаа ажиглан ярилцах;
- Дуулах, хөгжимдөх, хөгжимт хөдөлгөөн хийх, дүрд тоглох боломжийг олгож, дэмжиж, зоригжуулах.

Цахим холбоос:

- <https://youtu.be/d8jqUBZ3TLg?list=PLF8JJ1kaIO1SAXJgysnXnlZvqdpGrhV0K>
- <https://youtu.be/EwLvn26ldvE?si=nL4u8NC98FTuL7jJ>
- <https://youtu.be/lufqQgPlns8?si=aWzhWNAxis2mInI6>

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
 Амжилттай хэрэгжүүлсэн:
 Сул хэрэгжүүлсэн:.....
 Цаашид сайжруулах:.....
 Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

**СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - I САР
ӨВӨЛ**

Хүүхдийн эзэмших чадамж

Харилцах: Ажигласан зүйлээ нэрлэх, дууны аялгуунд, хамтдаа дуулж бүжиглэх, бие биедээ асуулт асуух, ярилцах

Суралцахуйд суралцах: Сонирхсон зүйлээ асуух

Бүтээлчээр сэтгэх: Амьтны хөдөлгөөнийг биеэр илэрхийлэх

Хамтран ажиллах: Хүүхэд дүрэм мөрдөх, ээлжээ хүлээж тоглох

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хүүхдийн сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангахын тулд энгийн, ойлгомжтой заавар өгч, хүүхдийн мэдрэмжийг анзаарч дэмжинэ. Зугаалгын үед хүүхдүүдийг гулгамтгай, бартаатай газраас зайлсхийж, тоглоход чиглүүлнэ.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Цаг агаар болон шүдний эрүүл ахуйн талаар ярилцаж, өдрийн турш юу хийж тоглох талаар ярилцана.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Танин мэдэхүй, хөдөлгөөн, дүрд тоглох, дуу хөгжмийн үйл ажиллагаанд хамтран оролцож, хүүхдийн сонирхсон үйл ажиллагааг гүнзгийрүүлэн бүтээлчээр оролцоход тохируулга хийнэ.

Зугаалга: Хүүхдүүд бие даан хувцаслах, малгай бээлийгээ өмссөн байдлыг хянах, орчноо ажиглаж цаг агаарын талаар ярилцах, цасан бөмбөлгөөр тоглож аялна.

Номын цаг: Дуртай номоо сонирхож үзэх, номын тухай ярилцах орчин бүрдүүлж, номын төвд баримтлах энгийн дүрэмтэй танилцана.

Хөгжөөн баясах цаг: Янз бүрийн сонирхолтой хөдөлгөөнтэй тоглоом, дуут хөгжимт тоглоом, дүрт тоглоомоор цагийг хөгжилтэй өнгөрүүлнэ.

Боломжууд:

Багш хүүхдэд шинэ сорилтыг давах, асуудлаа өөрөө шийдвэрлэхэд нь тусалж дэмжинэ.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
----------------------------------------	---------------------------	---------------------

<p>БНО2.1г. Байгалийн үзэгдлийг ялган таньж, ажиглаж ярилцана. ХЯ2.2в. Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярина. ХЯ2.3в. Эрээчиж сараачиж бичнэ. ЗУ2.2д. Бэлдэц дүрсээр бие даан нааж бүтээл урлана.</p>	<ul style="list-style-type: none"> - Аялал зугаалга, гадаа талбайд тоглох явцад цаг агаарын байдлыг ажиглах, ярилцах - Байгалийн үзэгдлийг таних энгийн туршилт хийх - Өдөр тутмын үйл ажиллагааны явцад өнгө хэмжээ, байрлал заасан үгсийг ашиглаж ярих, чиглүүлэг асуултад хариулах - Муруй зураас давхарлан зурах, будах - Наамлаа зурагт наалтаар чимэглэх 	<p>Өвөл</p> <p>Цас</p>
<p>ХЭМ2.2е. Хүрээлэн байгаа орчныг ажиглаж, аюултай байж болох зүйлсийг ялгаж, хүрэхгүй байна. НСХ2.2а. Бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр нэрлэдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Аюул тулгарвал насанд хүрэгчдийг дуудах, тусламж хүсэх - Тоглоом, хувцас, аюултай зүйлс бүхий зурган картуудыг ангилах, ялгаж тоглох - Үлгэр, зохиол ярих аргаар тусламж гэж юу болох, бусдад туслах, бусдаас тусламж авах 	<p>Туслаарай</p>
<p>МАТ2.1а. 5 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолох, олон ба цөөн тооны тоглоом, юмсыг зааж хэлнэ. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж дуурайна. ХЯ2.2б. Бусадтай харилцахдаа энгийн, яриатай холбогдсон асуулт асууна.</p>	<ul style="list-style-type: none"> - Тоглоом, эд юмсыг оноож тоолох - Нэрлэсэн зүйлсийг тоглоомоос олох, зүй тогтол үүсгэж өрөх - Сургалт үйл ажиллагааны явцад өөрийн болон бусдын үйлдлээс төрсөн мэдрэмжээ илэрхийлж, шалтгааныг тодруулан ярилцах 	<p>Тоолж сурцгаая</p> <p>Хурдан саная</p>
<p>ХЯ2.3а. Номын зургийг ажиглаж, ялган нэрлэнэ. БНО2.1а. Ойр орчны амьтдын үр төлийг нэрлэн ялгаж танина</p>	<ul style="list-style-type: none"> - Зураг ажиглан юу болж байгаа талаар ярилцах - Зурагт ном, самбар, эсвэл бичлэгээс амьтны эх болон үр төлийг ажиглаж, энгийн асуултаар ярилцах 	<p>Зурагт номоор аялцгаая</p>
<p>ХЭМ2.1а. Гарын сарвууг өргөх буулгах, татах, түлхэх, бугуйн үеэр эргүүлэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ. ХЭМ2.1о. Бөмбөгийг 1,5м зайд өшиглөх, өнхрүүлнэ ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Сарвууны үеэр өргөх буулгах, татах, түлхэх, сэгсрэх зэрэг хөдөлгөөнийг гүйцэтгэх - Бөмбөгийг өшиглөж хаалга руу оруулах - Дууны аялгууны хурд, хэмнэлийг мэдэрч алхах, гүйх, алгаа таших, гараа эргүүлэх гэх мэт хөдөлгөөнийг дагаж хийх 	<p>Хөлөө товшъё</p>
<p>ХЭМ2.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчийн зааварчилгаагаар хийнэ. ХЯ2.3в. Эрээчиж сараачиж бичнэ. НСХ2.2в. Насанд хүрэгчийн тусламжтай зан үйлүүдийг тустай тусгүйгээр ангилдаг болно</p>	<ul style="list-style-type: none"> - Гар нүүр болон шүдээ угаах дараалал бүхий зурагт картыг зөв байрлуулах - Дэлгэц цаас, самбар дээр төрөл бүрийн зураасыг сараачиж бичих - Тустай үйлдлийн тухай зурагт үзүүлэн, видео контент үзэж ярилцах 	<p>Шүд ба чихэр</p>
<p>ХӨГ2.1б Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна. ХӨГ2.1в Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно. НСХ2.2б. Насанд хүрэгчийн</p>	<ul style="list-style-type: none"> - Үг, аялгууны давталттай богино дууны нэгээс хоёр үетэй үгийг хэлж, дагаж аялах - Дуу чимээний эрэлд туршилт хийх. (цасан дээр гишгэх) - Үлгэр, зохиол ярих аргаар тусламж гэж 	<p>Цасан хүн</p>

тусламжтай бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг анзаарч энэрэх үйлдэл үзүүлдэг болно.	юу болох, бусдад туслах, бусдаас тусламж авах нь бүгдэд хэрэгтэй байдаг тухай ярилцах, дүрд тоглох	
------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------	--

Албан хэрэгцээнд

1 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Өвөл (Өвөл ба зун, цас хайлах, цасан бөмбөлөг)	Тойргийн цаг, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, Зугаалга	Улирлын өөрчлөлт, халуун хүйтнийг ялгаж мэдэх, бичлэг үзэж ярилцах, цас ямар орчинд хурдан хайлдаг талаар энгийн туршилт хийх, цасан бөмбөлөг хийж бай руу шидэж тоглоно.	Улирлын зураг, постер, бичлэг, цас хийх сав, ус, халбага, цас	Ямар улиралд гадаа дулаан/хүйтэн байдаг вэ?, Яагаад бүлээн усанд цас хурдан хайлсан гэж бодож байна вэ?, Өвөл бид юу хийдэг вэ?	Харилцах: Чиглүүлэг асуултад хариулах	Улирлын онцлогийг ялгадаг. Энгийн туршилтад оролцож, юу өөрчлөгдсөн тухай хариулдаг.
Тусламж хүс (Туслаарай)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа.	Гал гарсан үед ам, хамраа чийгтэй алчуураар дарж, гарцын тэмдэглэгээ рүү явах дүрт тоглоом тоглоно.	Хонх, гарцын тэмдэг, чийгтэй алчуур.	Гал гарсан үед бид яах ёстой вэ?. Найз нь гарцын тэмдэг олж хараагүй бол туслах уу?. Яагаад энэ зүйл аюултай гэж бодож байна?.	Харилцах: Тусламж хүсэх, дүрт тоглоомын үед бусадтай хамтрах	Галаас өөрийгөө хамгаалж ам, хамраа дарж гарц руу явдаг.
Тоолж сурцгаая (Цасан бөмбөг, Цасан хүн)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Алчуур дээрх бөмбөгийг унагахгүйгээр сандал хүртэл явах, бөмбөгөө оноож тоолох, мөн нэг нэгээр авч цасан хүний бай руу шидэх, 3 хүртэл тоолж тоглоно.	Жижиг алчуур, бөмбөг, сандал, цасан хүн бүхий бай	Хэний бөмбөг оносон бэ?	Харилцах: Бие биеэсээ асуулт асуух, ярилцах	Бөмбөгийг хамтдаа унагахгүй зөөдөг. 3 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолдог.
Зурагт номоор аялцгаая (Амьтан ба байгаль, Сайхан сэтгэлт баавгай)	Хөгжөөн баясах цаг, Номын цаг	Зураг өргөхөд тохирсон хөдөлгөөнийг хийх, "Сайхан сэтгэлт баавгай" зохиолыг сонсож, дүрийг ялгах, зохиолын талаар ярилцана.	Амьтны зурган карт, цасан ширхэг, цэцгийн үзүүлэн. Зурагт ном, жижиг зураг, цаасан аяга, сагс	Баавгай ямар амьтанд малгайгаа өгсөн бэ?. Хэрвээ чи баавгайн оронд байсан бол яах байсан бэ?	Харилцах: Үйл явдлын талаар ярилцахад Бүтээлчээр сэтгэх: Амьтны хөдөлгөөнийг биеэр илэрхийлэх	Амьтны зургийг ялгаж нэрлэдэг. Тохирсон хөдөлгөөн хийдэг.
Хөдөлгөөнт тоглоом (Хөлөө товшъё, хөгжилтэй дасгал,	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн хэмнэлд цагариг дотор хөлөөр товших, хэрэглэлтэй дасгалын зохиомжийг дагаж хийх, бөмбөгийг	Хөгжмийн ая, жижиг цагариг, теннисний бөмбөг. мөлхөлтийн нум,	Баруун/ зүүн хөлөө хэдэн удаа товшсон бэ? Бөмбөгийг бай руу өнхрүүлж оруулж чадсан уу?	Хамтран ажиллах: Дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх зэргээр	Бөмбөгийг саваа модоор өнхрүүлдэг.

бөмбөгөөр наадъя)		хөлөөрөө, эсвэл саваа модоор бай руу өнхрүүлж тоглоно.	жижиг хаалга, саваа мод, бөмбөг (15-20см)		хамтрах,	
Цас (Давс ба ус, цасан ширхэг)	Хөгжөөн баясах цаг, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Давс ба элсэн чихрийн амтыг мэдрэх, ялгааг ярилцах, давсны уусмалаар цасан ширхэг зурах, зургийн өнгө яагаад өөрчлөгдсөнийг ажиглаж ярилцана.	Давс, элсэн чихэр, аяга, ус, бийр, хөх өнгийн цаас	Та нарыг зурж дуусахад зураг нь ямар өнгөтэй байсан бэ?. Яагаад ийм цагаан өнгөтэй болсон гэж бодож байна?.	Харилцах: Туршилтын явцыг ажиглаж, үр дүнг тайлбарлан ярилцах	Энгийн туршилтад оролцож, юу өөрчлөгдөж, болсон тухай хариулдаг.
Хурдан саная (Том ба жижиг, Зүй тогтол)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, Хөгжөөн баясах цаг	Зургийн хэмжээгээр (том, жижиг) ижлүүдийг сонгох, харьцуулах. Том, жижгээс дараалан байрлуулсан зүй тогтлыг дуурайх, эсвэл өөрөө зохиож тоглоно.	Том ба жижиг хэмжээтэй өвлийн өвгөн, гацуур, цасан ширхгийн зурагт хуудас.	Хамгийн том (жижиг) зураг ямар өнгөтэй байна вэ? Үүсгэсэн зүй тогтлоо цаасан дээр зурж үзэх үү? Өөр ямар зүй тогтол үүсгэж болох вэ? Зурагт үзүүлсэн зүй тогтлоо тоглоомоор хийж үзэх үү?	Бүтээлчээр сэтгэх: Зүй тогтлыг дуурайх, шинэ зүй тогтол үүсгэх. Харилцах: Бусадтай харилцахдаа энгийн, яриатай холбогдсон асуулт асуух.	Нэрлэсэн зүйлийг ажиглаж, дараалан байрлуулсан зүй тогтлыг дуурайдаг.
Амьтдын мөр	Зугаалга	Цасан дээр өөрийн болон амьтдын мөрийг гаргаж, ажиглах, ярилцах, амьтны хөлийн мөрийг даган алхаж, үсэрч, төгсгөлд нь амьтны зургийг тааж тоглоно.	Цас, амьтдын хөлийн мөрийг харуулсан зургууд	Ямар хэлбэртэй байна вэ?. Хэдэн хуруутай байна вэ?. Энэ амьтан хэдэн хөлтэй вэ?.	Харилцах: Ажигласан зүйлээ нэрлэх	Ойр орчны амьтдын мөрийг ажиглан ялгаж таньдаг.
Шүд ба чихэр (Шүдээ цэвэрлээ, хорхой цоорхой)	Тойргийн цаг, Чиглүүлэгтэй тоглоом.	Эрүүл, хорхойтой шүдний зургийг ажиглаж, шүдний зурган дээр эсгий балаар бохирдол зурах, сойзоор угааж арилгах туршилт хийнэ. Шүдэнд сайн, муу хүнсийг ялгаж тоглоно.	Амттаны зурган карт, эрүүл/хорхойтой шүдний зураг, эсгий бал, сойз. шоо (хүнсний зурагтай)	Чихэр идсэнийхээ дараа чи шүдээ угаадаг уу?. Чихэр идсэний дараа шүдээ угаахгүй бол яах вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Дүрслэн зурах	Шүдэнд хортой, хоргүй хүнсийг ялгадаг.
Цасан хүн (Цас ба цасан хүн, дэлдэн туулай, цасан хүний алхаа)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хэмнэлийн ая сонсоод зураглалын дагуу хамтран тоглоно. "Дэлдэн туулай" дууг давтан дуулж, хосоороо гараа барин хөгжимт	Дуу, хэмнэл, хөгжимт хөдөлгөөний ая, цасан хүний зурагт үзүүлэн.	Цасан хүн яаж хөдөлдөг бол?	Харилцах: Дууны аялгуунд, хамтдаа дуулж бүжиглэх.	Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулж, хөдөлгөөн хийдэг.

		хөдөлгөөн хийнэ				
--	--	-----------------	--	--	--	--

Албан хэрэгцээнд

1 дүгээр сарын I долоо хоног

ӨВӨЛ

Шинэ үг: халуун, хүйтэн

Үйл ажиллагаа 1. Өвөл ба зун (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: улирлын онцлогийг харуулсан зураг, постер, номын зураг

Аргачлал: Өхөөрдөм өвөл, завгүй зун видео бичлэгийг цахим холбоос 1-ийг үзэж тайлбарлан ярилцана.

Хүүхдүүдийг хоёр багт хувааж, зураасны ард зогсоно. Багууд өвөл, зуны улирлын онцлогтой зургаас сонгон сагсанд байрлуулж, ээлжлэн тоглоно. Ангилж хийсэн зургууд ямар улиралтай холбоотой болохыг ажиглан, улирлын онцлогийн талаар асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ зураг ямар улирлыг харуулсан байна вэ?
- Ямар улиралд гадаа дулаахан байдаг вэ?
- Ямар улиралд гадаа хүйтэн байдаг вэ?
- Аль зураг дээр цас байна вэ?
- Ямар улиралд цас их ордог вэ?
- Өвөл бид юу хийдэг вэ? (Жишээ: цанаар гулгах, цасан хүн хийх)

Хүүхдүүдийн өгсөн тайлбарыг багш урамшуулна.

Үйл ажиллагаа 2. Цас хайлах. (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: ширээ бүр дээр цастай сав, хүүхэд бүрд жижиг 2 сав, хүйтэн болон бүлээн устай сав, цас хутгах халбага.

Аргачлал: Хүүхдүүд цасны тухай бичлэгийг цахим холбоос 2-ыг үзэж цас ямар орчинд хурдан хайлдаг талаар ярилцана.

2 ижил хэмжээтэй жижиг саванд цас хийж, нэг саванд бүлээн ус, нөгөөд нь хүйтэн ус хийе. Аль савтай цас түрүүлж хайлж байгааг ажиглана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бүлээн ус хийсэн савны цас хурдан хайлсан уу, эсвэл хүйтэн ус хийсэн савных уу?
- Яагаад бүлээн усанд цас хурдан хайлсан гэж чи бодож байна вэ?
- Хэрэв бид цасыг дулаан газар тавиад (гараараа барих, нар туссан газар тавих гэх мэт) юу болох бол? үр дүнгээ ярилцана.

Үйл ажиллагаа 3. Цасан бөмбөлөг (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Цас

Аргачлал: Хүүхдүүд зугаалгаар цэцэрлэгийн орчныг ажиглаж, өвлийн улирал, цаг агаарын талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өвлийн улиралд цаг агаар ямар байдаг вэ?
- Газарт, модон дээр, дээвэр дээр юу байна вэ?
- Цас ямар өнгөтэй харагдаж байна вэ?
- Өвөл хүмүүс ямар хувцас өмсдөг вэ?

Цэцэрлэгийн хашаан дотор байгаа цасаар цасан бөмбөлөг хийж тоглоно. Хүүхэд бүр цасыг бөөрөнхийлж, цасан бөмбөлөг хийнэ. Хийсэн цасан бөмбөлгөө бай руу шидэж тоглоно.

ТУСЛАМЖ ХҮС

Шинэ үг: Галын аюул, гарцын тэмдэг

Үйл ажиллагаа 1. Туслаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дуут дохио өгөх хонх, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, чийгтэй алчуур

Аргачлал: Хүүхдүүд “Гүүмби, Жүүмби хоёрын эрсдэлтэй танилцсан түүх – Түлэгдэх эрсдэл” бичлэгийг цахим холбоос 3-ыг үзсэний дараа багш галын аюулаас хэрхэн сэргийлэх талаар тайлбарлана.

Дүрт тоглоом

- Ангид хонх дуугаргаж, Гал гарлаа! дохио өгч гэрэл асууж унтаана.
- Гал гарсан үед ам, хамраа чийгтэй алчуураар дарсаар гарцын тэмдэглэгээ рүү гүйнэ.
- Багш “Утаа улам их боллоо” гэж дохио өгөхөд уяан доогуур шургаж гарах, мөлхөж гарахыг зааварчилгаа өгч, биечлэн үзүүлж хүүхдүүдийг дагуулна.
- Хүүхдүүд гарцын тэмдэглэгээний дагуу явж чадахгүй найздаа тусалж, хамтдаа гарц руу хүрнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Галын аюулаас хэрхэн урьдчилан сэргийлж болох вэ?
- Гал гарсан үед бид яах ёстой вэ?
- Найз нь уяан доогуур шургаж, гарцын тэмдэг олж хараагүй бол туслах уу?
- Найз нь чийгтэй алчуураа авахаа мартсан бол яаж туслах вэ?

ТООЛЖ СУРЦГААЯ

Шинэ үг: Тоол, тэмтэрч мэдэр

Үйл ажиллагаа 1. Цасан бөмбөг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: алчуур (60х60см), өнгийн жижиг бөмбөг, сандал, скоч

Аргачлал: Сандлыг эгнүүлэн байрлуулж түшлэгт скоч орооно.

Хүүхдүүд жижиг алчуурыг хосоороо хоёр талаас барьж зогсоход багш “Цасан бөмбөг өглөө” гэж хэлээд алчуур дээр жижиг бөмбөг тавина.

Хүүхдүүд алчуур дээрх бөмбөгөө унагахгүйгээр сандал хүртэл явж, түшлэгт нааж байрлуулна. Бөмбөгөө оноож тоолно.

Дараа нь баруун/зүүн гараар ээлжлэн агаарт бөмбөг дүрсэлж дугуй дүрсийг зурж, 3 хүртэл тоолно.

Үйл ажиллагаа 2. Цасан хүн (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Цасан хүн бүхий бай, бөмбөг

Аргачлал: Хүүхэд бүр гурван бөмбөг тоолж аваад сандлын түшлэгт наагаад оноож тоолно. Бөмбөгөө нэг нэгээр авч цасан хүний бай руу шидэж, бие биедээ асуулт тавьж (хэний бөмбөг вэ?, оносон уу?) ярилцана.

- Хүүхдүүд хамтдаа “нэг, хоёр, гурав” гээд бөмбөгөө шиднэ.

Дэмжлэг шаардлагатай хүүхэдтэй зэрэг тоолж давтана.

ЗУРАГТ НОМООР АЯЛЦГААЯ

Шинэ үг: Номын зураг, хавтас

Үйл ажиллагаа 1. Амьтан ба байгаль (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: амьтны зурган карт, цасан ширхэг, цэцгийн биет үзүүлэн

Аргачлал: Хүүхдүүд багшийн хэлсэн үгийг давтан хэлж, хөдөлгөөнийг дуурайна.

Амьтны зураг өргөхөд ижил зургийг сонгон авч, тухайн амьтны хөдөлгөөнийг дуурайна.

Цэцэг - цэцгийн зургийг авч найгаж тоглоно.

Өвөл хүйтэн тий тий - хоёр алгаа үрж, хацартаа наана.

Цас - цасан ширхгийн зургийг авч үлээж тоглоно.

Үйл ажиллагаа 2. Сайхан сэтгэлт баавгай (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт номын үйл явдлыг харуулсан амьтдын жижиг зураг, өвлийн улирлын онцлогийг дүрсэлсэн зураг, цаасан аяга, сагс.

Аргачлал: “Сайхан сэтгэлт баавгай” зохиолыг чангаар уншина. Багш амьтны нэр хэлэхэд хүүхдүүд зургаас ялгаж аваад сагсанд хийнэ, эсвэл аягаараа таглана. Өвлийн онцлогтой

зургаас нэрлэхэд хүүхдүүд сонгож, үйл хөдлөлөөр илэрхийлнэ, ярилцана. Хүүхдүүд сонирхлоороо ээлжлэн чиглүүлэгч болж тоглох боломж олгоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар амьтан тусч, сайхан сэтгэлтэй вэ?
- Баавгай ямар амьтанд малгайгаа өгсөн бэ?
- Яагаад баавгай малгайгаа өгсөн гэж чи бодож байна?
- Хэрвээ чи баавгайн оронд байсан бол яах байсан бэ?
- Баавгайн хийсэн үйл зөв байсан гэж чи бодож байна уу? Яагаад?

ХӨДӨЛГӨӨНТ ТОГЛООМ

Шинэ үг: Хөлөө товших, өнхрөлт

Үйл ажиллагаа 1. Хөлөө товшье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, жижиг цагариг, теннисний бөмбөг.

Аргачлал: Хүүхдүүд тойргоор алхаж цагариггаа авч, газарт байрлуулна.

1. Баруун/зүүн хөлөө цагариг дотор 3 удаа товшино. Хөлөө хавсарч нийлүүлнэ.
2. Хөлийн өсгийг цагариг дотор товшиж давтана.
3. Цагариг дотор дороо алхана, цагариггаа тойрч гүйнэ.

Дараагийн удаа алгаа таших, сэгсрэх хөдөлгөөнийг нэмж зохиомжлон гүйцэтгэнэ.

Теннисний бөмбөгтэй гарын дасгалыг цахим холбоос 4-ийг харж тоглоно.

2. Хөгжилтэй дасгал

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, цагариг, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүд бие биедээ саад болохгүйгээр зогсоно. Хөгжимт гимнастикийн цогц дасгалыг хөгжмийн аянд багшийг дагаж гүйцэтгэнэ. Цагариг, бөмбөгтэй дасгалын зохиомж ашиглаж болно. Цахим холбоос 5.

3. Бөмбөгөөр наадъя

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг (15-20см диаметр), мөлхөлтийн нум, жижиг хаалга, саваа мод.

Аргачлал: Хүүхдүүд ээлжээ хүлээж тоглоно.

- Бөмбөгийг хөлөөрөө бай руу өнхрүүлэх
- Бөмбөгийг саваа модоор бай руу өнхрүүлэх

Тоглоом дууссаны дараа багшийн заавраар хэрэглэгдэхүүнээ хураана.

1 дүгээр сарын II долоо хоног

ЦАС

Шинэ үг: Давс, бийр

Үйл ажиллагаа 1. Давс ба ус (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Давс, элсэн чихэр, аяга, ус, бийр, хөх өнгийн цаас

Аргачлал: Элсэн чихэр болон давсны амтыг мэдэрч амсаж туршина. Ямар ялгаатай байгаа талаар ярилцана.

- Хүүхэд бүр аяганд халбага давс хийж, дээрээс нь ус нэмээд сайтар хутгана.
- Давсны уусмалаар зураг зурах учраас цонхны тавцан дээр өрж тавина.

Үйл ажиллагаа 2. Цасан ширхэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхэд бүр өнгийн цаас, бийр, давсны уусмалаа авна.

Давсны уусмалдаа бийрээ дүрж, өнгийн цаасан дээр цасан ширхэг зурна.

Цаас зөвхөн норсон мэт харагдахаар зураад бүтээлээ цонхон дээр тавьж хатаана.

Давсны уусмалаар зурсан зургаа хүүхэд бүр хэрхэн өөрчлөгдсөнийг ажиглаад ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нарыг зурж дуусахад зураг нь ямар өнгөтэй байсан бэ?
- Өнгө нь яаж өөрчлөгдсөн байна вэ?
- Яагаад ийм цагаан өнгөтэй болсон гэж бодож байна?

Багш давсны уусмал хатсан учраас цагаан өнгөтэй болдог учрыг тайлбарлана.

ТУСЛААРАЙ

Үйл ажиллагаа 1. Аюултай зүйлийг ялгах (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: 3 өнгийн хайрцаг, 3 төрлийн зурган карт (тоглоом, хувцас, аюултай зүйл)

Аргачлал: Хүүхдүүд зурган картыг ажиглана, нэрлэнэ, юунд хэрэглэдгийг ярилцана.

Багш 3 өнгийн хайрцгийг харуулж зориулалтаар ялгах даалгавар өгнө. Хүүхдүүд зурган картаас сонгон авч нэрлээд хайрцагт ангилж хийнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ зураг дээр юу байна вэ?
- Энэ зүйл тоглоом уу?, хувцас уу?, аюултай юу?
- Энэ зурагт байгаа зүйлээ аль хайрцагт хийх вэ?
- Яагаад энэ зүйл аюултай гэж бодож байна?
- Аюултай зүйлсийг бид яах ёстой вэ?

Ангид байгаа сургалт үйл ажиллагааны хэрэглэгдэхүүнийг цэгцэлж аюултай зүйлийг ялгаж тусад нь байрлуулна.

ХУРДАН САНАЯ

Шинэ үг: Дэс дараалал

Үйл ажиллагаа 1. Том ба жижиг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Том ба жижиг хэмжээтэй өвлийн өвгөн, гацуур, цасан ширхгийн зурагт хуудас.

Аргачлал: Самбар дээр том хэмжээтэй 3 зурагт хуудас байрлуулна.

Хүүхдүүд жижиг зургаас самбар дээрх зурагтай адилаар сонгож урдаа тавина. Самбар дээрх зургийн байрыг өөрчлөхөд хүүхдүүд зөв байрлуулсан эсэхийг харьцуулж харна.

Ижил зургийг томоос жижиг рүү, жижгээс том руу дараалуулан байрлуулна.

Үйл ажиллагаа 2. Зүй тогтол (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: Том жижиг 3 хэмжээтэй янз бүрийн зурагт хуудсаар (эсвэл хэлхэж болох зүйлс байж болно) дараах зүй тогтол бүхий загварыг бүтээнэ. ТОМ-ЖИЖИГ-ЖИЖИГ-ТОМ гэх мэт.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хамгийн том (жижиг) зураг ямар өнгөтэй байна вэ?
- Үүсгэсэн зүй тогтлоо цаасан дээр зурж үзэх үү?
- Өөр ямар зүй тогтол үүсгэж болох вэ?
- Зурагт үзүүлсэн зүй тогтлоо тоглоомоор хийж үзэх үү?

АМЬТДЫН МӨР

Шинэ үг: Хөлийн мөр, хэлбэр

Үйл ажиллагаа 1. Амьтдын мөр (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Цас, амьтдын хөлийн мөрийг харуулсан зургууд.

Аргачлал: Хүүхдүүд гадаа цасан дээр өөрийн мөрөө гаргаж ажиглана. Хэний хөлийн мөр том, жижиг байгааг ярилцана.

Мөн амьтны хөлийн мөрийг даган алхаж, үсэрч замын төгсгөлд байрлах амьтны зургийг аваад, тухайн мөр ямар амьтны болохыг таана. Багш амьтны нэрийг тодруулан хэлүүлж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар хэлбэртэй байна вэ?
- Хэдэн хуруутай байна вэ?
- Хумстай байна уу?
- Энэ амьтан хэдэн хөлтэй вэ?

ШҮД БА ЧИХЭР

Шинэ үг: Чихэрлэг, гашуун

Үйл ажиллагаа 1. Шүдээ цэвэрлэе (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Амтаны зурган карт.

Аргачлал: Хоол унд, чихэр, шоколад идсэний дараа идсэн хоолны үлдэгдэл шүдэнд наалдаж үлддэг талаар ярилцана.

- Эрүүл болон хорхойтой шүдний зургийг ажиглуулна.
- Хүүхдүүд шүдний зурган дээр өнгийн эсгий балаар сараачиж, бохирдсон хэсгийг толболон, сараачиж зурна.
- Өөрийн зурсан шүдний зургийн толбыг сойзоор угааж арилгана.
- Шүдээ хэрхэн арчлах талаар ярилцана.

Үйл ажиллагаа 2. Хорхой цоорхой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шооны 6 талд: ааруул, сүү, тараг, чихэр, чипс, газтай ундааны зураг, жижиг карт.

Аргачлал. “Хорхой цоорхой 2” бичлэг үзэж, шүдэнд сайн, муу хүнсний зүйлийн талаар ярилцана. Хүүхдүүд шоо болон жижиг картаас шүдэнд сайн муу хүнсийг ялгаж сагсанд хийж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чихэр идэхдээ аав, ээжээсээ зөвшөөрөл авдаг уу?
- Чихэр идсэнийхээ дараа чи шүдээ угаадаг уу?
- Чихэр идсэний дараа шүдээ угаахгүй бол яах вэ? Та нар юу гэж бодож байна?

ЦАСАН ХҮН

Шинэ үг: Хосоор, цасан хүн

Хэрэглэгдэхүүн: Дуу, хэмнэл, хөгжимт хөдөлгөөний ая, зурагт үзүүлэн.

Үйл ажиллагаа 1. Цас ба цасан хүн (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

1. Хэмнэлийн аяыг сонсоод зураглалын дагуу хамтран тоглоно. Цахим холбоос 6-г харна уу

2. Дэлдэн туулай

Ая Ө.Ариунзул, Үг Г.Тунгалаг “Дэлдэн туулай” дууг бүтэн сонсоно.

- Дууны 1, 2-р бадгийн үгийг мөрөөр нь 2–3 удаа давтан хэлүүлж, дагуулан дуулна.

Цахим холбоос 7-г харна уу.

3. Цасан хүний алхаа

Багш цасан хүний зураг үзүүлээд: Цасан хүн болж тоглоё. Цасан хүн яаж хөдөлдөг бол? гэсэн асуултаар чиглүүлэн алхаж үсрэхдээ хөл, гараа нугалахгүйгээр хөдөлгөөн хийлгэнэ. Хүүхдүүд хосоороо гараа барин зогсож дуулангаа хамтдаа алхана. Багш хэмнэлийн дагуу дараах хөдөлгөөнийг дагуулан хийлгэх ба нэмж зохиомжилж болно. Холбоос 8-ыг харна уу.

Гар гараасаа бариад

Баруун тийшээ эргэе

Гар гараасаа бариад

Зүүн тийшээ эргэе

Өвдгөө цохиод

Алгаа ташаад

Доороо 2 удаа эргэнэ.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа

- Хүүхэд аливаа зүйлийг хүрэлцэхүй болон сонсголоор таньж мэддэг тул сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн нь хурц үзүүр, ирмэггүй байхад анхаарна.
- Тэмтрэх, мэдрэх, хүрэлцэх боломжийг дэмжсэн барзгар гадаргуутай наадгай, хэрэгслийн тусламжтайгаар дэмжинэ.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

- Эцэг эх хүүхэдтэйгээ хамт зурагт ном үзэх, гол дүрийн талаар ярилцах;
- Хүүхдэд тохирсон шүдний оо, сойзыг бэлтгэх, ариун цэвэр сахих үйлийг үлгэрлэх, дагуулж хийлгэх;

- Хүүхдээ сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд урамшуулж, ангидаа хэнтэй юу хийж тоглосон тухайгаа нээлттэй ярихад чиглүүлэх.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
 Амжилттай хэрэгжүүлсэн:
 Сул хэрэгжүүлсэн:.....
 Цаашид сайжруулах:.....
 Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

Цахим холбоос:

1. Маамуу "Өхөөрдөм өвөл" , Маамуу "Завгүй зун"
2. <https://www.facebook.com/watch/?v=2842100915940454>
3. <https://www.facebook.com/watch/?v=1598379093705180>
4. https://www.youtube.com/watch?v=lvdUqw0cbvs&list=PLF8JJ1kaO1SAXJgysnXnlZvqd_pGrhV0K&index=8
5. https://www.youtube.com/watch?v=d8jqUBZ3TLg&list=PLF8JJ1kaO1SAXJgysnXnlZvqd_pGrhV0K
6. <https://youtu.be/8rmFPwUBjGA>
7. https://www.youtube.com/watch?v=vcwTtH35gJM&list=RDvcwTtH35gJM&start_radio=1
8. <https://youtu.be/fRfU7jotAX0>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР НАЙЗДАА ТУСЛААРАЙ

Хүүхдийн эзэмших чадамж:

Шүүн тунгаах: Сонирхсон зүйлээ ажиглаж, асуулт асууна.

Суралцахуйд суралцах: Асуулт асууж, бусдын яриаг анхааралтай сонсож, төвлөрнө.

Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглож, дасгал, даалгавар гүйцэтгэнэ.

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хөдөлгөөнт тоглоомын орчныг аюулгүй байлгаж, хүүхэд гулгах, бүдрэх, мөргөлдөхөөс сэргийлээрэй. Зургийн болон гар урлалын хэрэгслийг зөв ашиглуулах, аюулгүй ажиллагааг сануулаарай. Сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангахын тулд ойлгомжтой заавар өгч, хүүхдийн мэдрэмжийг дэмжээрэй.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Цаг агаар, эрүүл ахуй, тухайн өдрийн үйл ажиллагааны талаар ярилцаж, өдрийн турш юу хийж тоглох талаар танилцуулаарай

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Зохиолын дүрд тоглох, хамтран дуулах, дүрмийг баримтлахыг дэмжих, хүүхдэд хэрэглэгдэхүүнээ өөрөө сонгох, бүтээлчээр оролцох боломжийг олгох.

Төвийн үйл ажиллагаа: Хэсэг бүлгээр ажиллахдаа ээлжээ хүлээх, бие биеэ хүндлэх, нэгэндээ туслах зэрэг үйлийг дэмжин урамшуулаарай.

Номын цаг: Дуртай номоо сонирхож үзэх, зураг, өгүүлбэрийн талаар харилцан ярилцах.

Хөгжөөн баясах цаг: Хүүхдийг дүрд тоглох, наадах, хамтран оролцох үйлд дэмжинэ. Хүүхэд өөрийн санаачилгаар тоглох, хөдөлгөөн хийх боломжтой орчин бүрдүүлнэ.

Боломжууд:

- Хүүхэд тоглох явцдаа үл ойлголцох, булаалдах үед багш оролцохоос өмнө хүүхдэд өөрсдөө шийдвэрлэх боломж олгоно.
- Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, уур бухимдлаа тайвшруулах энгийн аргуудыг зааж, хамт туршина.
- Хүүхдийг шинэ сорилт даван туулах, асуудлаа өөрөө шийдвэрлэхэд урамшуулна.

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЭМ2.1а. Гарын сарвууг өргөх буулгах, татах, түлхэх, бугуйн үеэр эргүүлэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ2.1г. Алхаж, гүйхдээ гар хөлийн хөдөлгөөнөө хослуулан хурдан, удаан гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ2.1з. Байрандаа өлмий дээр хөлөө зөөж эргэнэ.</p> <p>НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно.</p> <p>ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Сарвууны үеэр өргөх, буулгах, татах, түлхэх, сэгсрэх. - Байрандаа алхахдаа алга таших, хөлөө өндөр өргөх, дороо эргэх, тойргоор алхахдаа өлмий, өсгий дээр алхах. - Босоо байрлалд нэг хөлийг урагш тавьж өлмий, өсгийг ээлжлэн товших, хөлийн өлмийг газраас салгахгүйгээр шагайн үеэр эргүүлэх. - Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. - “Дагаад хийгээрэй” тоглоом тоглох. 	<p>Туулай</p>
<p>ХЯ2.2д. Үйл явдлыг дарааллын дагуу ярина.</p> <p>МАТ2.2б. Өөрийн хийдэг үйлийг өглөө, оройтой холбож нэрлэнэ.</p> <p>ХӨГ2.1д. Үлгэр зохиол, дуу хөгжмийн танил дүрийг дуурайж, харилцан тоглоно.</p>	<ul style="list-style-type: none"> - Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих. - Цэцэрлэгтээ хэзээ ирж, гэртээ хэзээ харьдаг тухай хэлэх, өглөө, оройг нэрлэх тоглоом тоглох. - Хөгжмийн аянд байгалийн үзэгдэл болон эд юмсын хөдөлгөөнийг биеэр болон хөгжимт хөдөлгөөний хэрэгсэл ашиглан дүрслэн тоглох. 	<p>Ухаант туулай</p> <p>Жижиг туулайг олоорой</p>
<p>ЗУ2.2б. Бүтээлээ үндсэн өнгөөр бие дааж будна.</p> <p>ЗУ2.2д. Бэлдэц дүрсээр бие даан нааж бүтээл урлана.</p> <p>ХЯ2.2д. Үйл явдлыг дарааллын дагуу ярина.</p>	<ul style="list-style-type: none"> - Өнгөө сонгож тоглоом эд юмсыг будах. - Дүрсийг багшийн дэмжлэгтэйгээр зохиомжлох. - Цуврал зураг, ном, үлгэр зохиолын үйл явдлыг дарааллаар байрлуулж ярих. 	<p>Би зураач</p> <p>Бүтээцгээ</p>
<p>НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно.</p> <p>НСХ2.2б. Насанд хүрэгчийн тусламжтай бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг анзаарч энэрэх үйлдэл үзүүлдэг болно.</p> <p>ХЭМ2.2в. Жимс, хүнсний ногоог насанд хүрэгчтэй хамтран угааж, хэрэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Жижүүр хийх, дасгал хийх гэх мэт хамтын үйл ажиллагаанд оролцох. - Өөр өөр нөхцөл байдалд байгаа унаганы зургийг хараад тухайн унага ямар байгааг багшийн тусламжтайгаар ярилцах. - Зурагт карт ашиглан эрүүл мэндэд сайн муу хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэх, ялгаж тоглох, ярилцах. 	<p>Зочин туулай</p> <p>Гэнэн унага</p>
<p>БНО2.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомын шинжийг мэдэрч, нэрлэн, зориулалтаар нь ашиглана.</p> <p>БНО2.2д. Үндэсний хувцас, цагаан идээ, тоглоом, наадгайг таньж, баяр ёслолын зарим үйлийг даган дуурайна.</p> <p>МАТ2.3а. Тоглоом юмсыг тодорхой</p>	<ul style="list-style-type: none"> - Хувцас, тоглоом, эд зүйлсийг хэмжээ, хатуу, зөөлөн шинжээр нь ялгаж тоглох (“Шидэт уут” барьж тэмтрээд юу байгааг нэрлэх, гараараа мэдэрч шинжийг нь ялгаж хэлэх). - Тоглоом, дүрсийг тэмтэрч мэдэрч таах. 	<p>Мэдэрч таая</p> <p>Зам</p>

<p>шинжээр хоёр хэсэгт ангилна. ХЯ2.2в. Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярина.</p>	<ul style="list-style-type: none"> - Гадна, дотор заасан үг хэллэгийг тохирох зураг, үйл явдалтай холбон илэрхийлэх. - Байрлал заасан үгийг зөв хэрэглэж ярих, даалгавар биелүүлэх, зурах, будах, холбох, оноох зэргээр тоглох. 	
<p>ХӨГ2.1а. Байгаль, эд юмсын дуу чимээг таньж ялгана. ХӨГ2.1б Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна. ХЭМ2.1з. Байрандаа өлмий дээр хөлөө зөөж эргэнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Дуу чимээг сонсоод биеийн хөдөлгөөн, дохио зангаагаар дүрслэх. - Үг, аялгууны давталттай богино дууны нэгээс хоёр үетэй үгийг хэлж, дагаж аялах. - Өлмий дээр зогсож байрандаа хөлөө зөөж эргэх дасгалыг давтах. - Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. 	<p>Таван хөөрхөн</p>
<p>БНО2.2д. Үндэсний хувцас, цагаан идээ, тоглоом, наадгайг таньж, баяр ёслолын зарим үйлийг даган дуурайна. ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Цагаан сарын ёслолын үеийн зураг, зурагт ном, бичлэг үзэж, дээл өмсөн хоорондоо золгож, мэндчилгээ дэвшүүлж тоглох. - Хөдөлгөөнт дууг даган дуулах, хөдөлгөөний тогтоох. 	<p>Үндэсний баяр, хувцас</p>

2 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Бөжингүүд хөлөө товшъё	Өглөөний дасгал	Хөгжмийн аянд цагариг дотор баруун, зүүн хөлөө ээлжлэн товшиж, дороо алхаж, гүйж хэмнэл үүсгэнэ. Алга таших, сэгсрэх хөдөлгөөнийг нэмж удаанаас хурдан гүйцэтгэнэ.	Хөгжмийн ая, хүүхэд бүрд жижиг цагариг.	Хэмнэлээ өөрчлөн хурдан удаан хийхэд хэрхэн гүйцэтгэх вэ?.	Суралцахууд суралцах: Багшийн дохио зангаа, чиглүүлэг асуултыг даган дуурайж гүйцэтгэх, төвлөрөх	Дасгалыг дагаж хийдэг.
Гэр, хөгжилтэй дасгал, шидэт саваа, тэнцвэр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Гарын сарвууг өргөх, буулгах, татах, түлхэх, сэгсрэх зэрэг хөдөлгөөнүүдийг дагаж хийх, саваа модыг барьж унагалгүй дамжуулах, налуу шат руу авирч бууна, вандан сандал дээр тэнцвэрээ хадгалах дасгал хийнэ. Өнгийн туузаар "гэр" болж, хөгжмийн аянд багшийн дохиогоор хөдөлгөөн хийнэ.	Цагариг, бөмбөг, саваа мод (50-60 см урт), Налуу шат, вандан сандал.	"Алхаарай", "Зогс", "Өлмий дээрээ алхаарай", "Гүйгээрэй" гэх мэт дохиог ойлгож гүйцэтгэнэ.	Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглож, дасгал, даалгавар гүйцэтгэх, дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх	Дохиог ойлгож гүйцэтгэдэг. Вандан сандал дээр тэнцвэрээ хадгалан зогсдог.
Хуруугаар наадъя	Хөгжөөн баясах цаг	Гарын сарвууг өргөх, буулгах, татах, түлхэх, сэгсрэх хөдөлгөөнөөр гар хурууны дасгал хийх. Хуруунуудыг нэрлэж өргөн буулгах, бугуйн үеэр эргүүлэх, зөөлөн резинээр тэнийлгэнэ.	Зөөлөн резин, зурагт үзүүлэн.	Хуруугаа нэг нэгээр нь өргөж чадах уу? Хэдэн хуруутай вэ?	Суралцахууд суралцах: Сонирхсон зүйлээ анхаарах, даган дуурайх. Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнийг дуурайх	Хурууны дасгалыг дагаж хийдэг.

Өглөө, орой	Тойргийн цаг	Өглөө, оройн тухай ярилцаж, өдөр тутмын үйлдэлтэй холбоно. Өглөө, орой гэж ээлжлэн хэлж, хоёр гараа өргөх, буулгах хөдөлгөөн хийнэ.	Өглөө оройн зурагт үзүүлэн.	Чи өглөө юу хийдэг бэ? Унага өглөө юу хийсэн бэ? Чи орой юу хийдэг бэ? Унага орой юу хийсэн бэ?	Харилцах: Өглөө, оройн тухай үг хэллэгийг хэрэглэн ярих, харилцан яриаг үргэлжлүүлэх, өөрийгөө идэвхтэй илэрхийлж харилцах	Өөрийн хийдэг үйлийг өглөө, оройтой холбож нэрлэдэг.
Ухаант туулайг олоорой	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Ухаант туулай" үлгэрийн бичлэг үзэж, багшийн асуултын дагуу ярилцана. Үйл явдлын дагуу зургийг байрлуулж наана.	"Ухаант туулай" үлгэрийн бичлэг, дэлгэмэл ном хийх бэлдэц, 3 цуврал зураг.	Үлгэрт ямар ямар амьтан гарсан бэ? Чоно унага дээр өглөө ирсэн үү, орой ирсэн үү?	Шүүн тунгаах: анхаарах, дүрийг таних, нэрлэх Харилцах: Үлгэрийн үйл явдлыг ярих	Үйл явдлыг дарааллын дагуу өглөө, оройтой холбож ярьдаг.
Зургийн дараалал	Номын цаг	"Ухаант туулай" үлгэрийн үйл явдлыг хүүхдүүд өөрсдийн байрлуулсан зургийн дагуу ярина.	"Ухаант туулай" үлгэрийн дэлгэмэл ном, 3 цуврал зураг.	Эхлээд унага юу олсон бэ? Уутан дотроос юу гарч ирсэн бэ?	Суралцахуйд суралцах: Үйл явдлыг хамтарч ярилцах. Харилцах: Үлгэрийн үйл явдлыг дарааллын дагуу ярих, асуултад хариулах	Үйл явдлыг дарааллын дагуу ярьдаг.
Олоорой	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үлгэрт гарсан дүрүүдийн сүүдрийг олж тоглох. Сонгосон амьтны сүүдрийг гуашаар хүссэн өнгөөрөө будаж, хатсаны дараа нүд амыг зурж амьтныг гүйцээж зурна.	Унага, туулай, чононы сүүдэр зураг, гуаш, бийр, харандаа.	Хамтдаа амьтныг олцгооё, Чоно ямар өнгөтэй бэ? Чиний сонгосон амьтан хамгийн эхэнд үлгэрт гарсан амьтан мөн үү?	Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санаа бодлоо бүтээлээр илэрхийлэх. Шүүн тунгаах: Багаж, хэрэгслээ таних, сонгох	Бүтээлээ үндсэн өнгөөр бие дааж будаж зурдаг.
Дүрд хувирч тоглоё	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд өөрсдийн зурж, будсан дүрээ ашиглан дүрд хувирч тоглоно. Багш үлгэрийг ярихад дүрд тоглох, дараа нь өөрсдөө үлгэрээ ярьж тоглох.	Унага, туулай, чононы будсан зураг.	Хамгийн түрүүнд ямар амьтан гарч ирсэн бэ?	Харилцах: Дүрд тоглох явцдаа өөрийн хүсэл, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх. Бүтээлчээр сэтгэх: Дүрийн санаагаа илэрхийлэх.	Үлгэрийн үйл явдлыг үг, үйл хөдлөлөөр дуурайж харуулдаг.

Хамтарья, Хоолны ширээ засья	Өөртөө үйлчлэх цаг	Унага туулайд талархаж, зочинд урьсан тул хамтдаа бүлгийн өрөөний хэсгүүдийг хуваарилан авч цэвэрлэнэ. Хоолны ширээ засах зурагт үзүүлэнгийн дагуу ширээ засаж, бүлээн усаар өтгөрүүлсэн шүүс найруулж тоглоно.	Цэвэрлэгээ зурагт үзүүлэн, тоосны жижиг алчуур, ус (содатай), аяга, халбага, сэрээ, өтгөрүүлсэн шүүс.	Зочин ирэх гэж байгаа учир юу хийх ёстой вэ? Бэлтгэсэн шүүс ямар амттай байна вэ?	Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглож, тохиролцох. Суралцахуйд суралцах: Эрүүл ахуйн дадал, аюулгүй байдлаа ханган үйл ажиллагаанд оролцох.	Өөрт оногдсон хэсгийг арчиж цэвэрлэсэн эсэх, Хоолны ширээ засахад оролцдог эсэх.
Хайгуулчин	Зугаалгын цаг	Үлгэрийг сэргээн санаж ярилцах. Гадаа орчны зүйлсийг (мод, чулуу, ноос, цаас) оньсого тааж, ойр хавиас түүж багшийн уутанд хийнэ.	Өөр өөр материалтай эд зүйлс (ноос, чулуу, мод), тоглоомууд.	Ямар хэлбэртэй байна вэ? Хатуу юу, зөөлөн үү? Ямар өнгөтэй байна вэ?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох, асуулт асуух. Суралцахуйд суралцах: Ажиглаж, судалж мэдлэг олж авах.	Оньсого таадаг.
Мэдэрч нэрлэ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Уутан доторх зүйлсийг харахгүйгээр гараараа тэмтэрч таамаглаж хэлэх, таасан зүйлсийг шинжээр нь (хатуу/зөөлөн/амьтан) ангилж сагсанд хийж тоглоно.	Даавуун уут (доторх нь харагддаггүй), өөр өөр материалтай эд зүйлс, тоглоом.	Ямар хэлбэртэй байна вэ? Хатуу юу, зөөлөн үү? Чулуу ямар мэдрэмж төрүүлдэг вэ?.	Харилцах: Эд зүйлсийн шинж чанарыг (хатуу, зөөлөн) мэдэрч, энгийн үг, өгүүлбэр ашиглан нэрлэх. Суралцахуйд суралцах: Учир шалтгааныг сонирхох.	Мэдэрсэн зүйлээ тааж хэлдэг.
Юу дуугарсан бэ?, Дагаад дуулаарай, Нэрлээд таш тоглоом	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Таван төлийн (тугал, ишиг, унага, хурга, ботго) дуу чимээг сонсоод ямар амьтан болохыг нэрлэнэ. "Ирээрэй" дууг хамтран дуулж, утга санааг ярилцана. Үлгэрийн амьтдын нэрийг үеэр таслан алга ташин хэмнэл тоглоно.	Таван төлийн зураг, дуу, сонсох хөгжмийн бичлэг.	Ямар амьтан дуугарч байна вэ?, Ботгоны дуу авиаг өөрөөр хэрхэн дуугаргаж болох вэ?.	Суралцахуйд суралцах: Дуу чимээг сонсож, анхаарлаа төвлөрүүлэх. Бүтээлчээр сэтгэх: Дуу авиагаар туршиж тоглох, өөрийн санаагаа илэрхийлэх.	Таван хошуу малын дуу чимээг ялган таньдаг, Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулдаг.
Надтай тоглооч хөгжимт хөдөлгөөн	Хөгжөөн баясах цаг	"Надтай тоглооч" дууны аянд хосоороо гараасаа хөтлөн хөгжимт хөдөлгөөн хийнэ. Дахилтад хөлөөр	Дуу, хөгжимт хөдөлгөөний бичлэг.	Найзтайгаа хэрхэн хөгжимт хөдөлгөөн хийх вэ? Хөдөлгөөнөө	Бүтээлчээр сэтгэх: Дууны аяс, хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиох. Хамтран ажиллах:	Дууны аялгууг мэдэрч, хосоороо хөдөлгөөн

		газар товшин дороо эргэнэ.		зохиож чадах уу?	Тоглоомын дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх.	хийдэг.
Үлгэрийн ертөнц	Төвийн үйл ажиллагаа	"Ухаант туулайн үлгэр"-ийн цуврал зургийг эвлүүлж, ярина. Шагайны дөрвөн талыг нэрлэж, үлгэрийн дүрүүдийг шагайгаар тойруулан өрнө (Математик). Дүрүүдийг баримал, наамал, зургийн аргачлалаар бүтээх.	Шагай, өнгө өнгийн шагай, шагайны 4 талыг нэрлэх зурагт үзүүлэн, үлгэрийн цуврал зураг, зураг, урлалын хэрэглэгдэхүүн	Шагайны аль тал нь морь, хонь, ямаа, тэмээ вэ? Ямар дүр хамгийн их таалагдсан бэ?.	Харилцах: Өөрийн зурсан зүйлээ нэрлэж, хураангуй өгүүлбэрээр тайлбарлахыг оролдох. Хамтран ажиллах: Ээлжээ хүлээж тоглох.	Шагайны дөрвөн талын аль нэгийг зөв нэрлэдэг. Үлгэрт гардаг дүр, үйл явдлыг тоочиж хэлдэг.
Хэн ярих вэ?	Тойргийн цаг	"Эхлээд, дараа нь..." гэсэн үгээр чиглүүлэн, үлгэрийн үйл явдлыг сэргээн санаж, зургийг дарааллаар байрлуулан ярилцана.	Үлгэрийн үйл явдлыг илэрхийлсэн зурагт үзүүлэн.	Унагыг чоно идэх гэж байхад ямар амьтан ирж тусалсан бэ?. Ууттай зүйлийг хараад унага юу гэж бодсон бэ?.	Суралцахууд суралцах: Бусдын яриаг анхааралтай сонсох. Харилцах: Бусдаас асууж, хариулах байдлаар харилцан яриаг үргэлжлүүлэх.	Асуултын дагуу үлгэрийн тухай ярьдаг.
Хаана нуусан бэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үлгэрийн дүрийн зургийг өөрийн урд, хойно, дэргэд байрлуулж, байрлалыг нэрлэн тоглоно. Гар, хурууны хөдөлгөөнөөр дүрслэл хийнэ.	Үлгэрийн дүрийн зураг, шагай.	Том чоно байна уу? Жижиг туулай байна уу? Хаана нуусан бэ?.	Харилцах: Юмсын байрлал заасан үгийг хэрэглэн өөрийгөө илэрхийлэх. Юмсын байрлал заасан үгээр ярихад дэмжлэг үзүүлнэ.	Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярьдаг эсэх.
Дүрсээр наадъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Гурвалжин, дугуй, зууван дүрсийг ангилж, дүрсүүдээр туулай, чоно зэрэг үлгэрийн дүр бүтээх.	Гурвалжин, дугуй, зууван дүрс.	Гурвалжин дүрс хаана байна вэ? Ямар амьтан бүтээж болох вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Дүрс ашиглан дүр бүтээх, өөрийн санаагаа илэрхийлэх. Хамтран ажиллах: Хамт тоглож буй хүүхдүүдийн үйлдлийг ажиглаж, даган дуурайх.	Дүрсээр амьтан бүтээсэн эсэх.

Алчуураар наадъя	Хөгжөөн баясах цаг	Хамрын алчуур болон уяа ашиглан шооны зурагт буусан амьтан, эд зүйлийг (шуудай, чоно, туулай) бүтээнэ. Шуудайны зураг буувал 2 хүүхэд хамтран уяж сурна.	Шоо (зурагтай), хамрын алчуур, уяа.	Алчуураар бүтээе. Ямар зураг буусан түүний талаар ярих.	Харилцах: Өөрийн хийсэн зүйлийг хураангуй өгүүлбэрээр тайлбарлаж ярих. Хамтран ажиллах: Хэрэгслээ хуваалцаж эхлэх.	Алчуураар амьтан дүрсэлдэг.
Гэнэн унага	Тойргийн цаг	Унаганы сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүдийг (төөрсөн, олсон, цочсон, баярласан) зураг харан ярилцаж, нүүрний хувирлыг дуурайх. Үлгэрийн хамгийн тусч, муу дүрийг ярилцана.	Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн зурагт үзүүлэн (Унаганы дүрслэлтэй том үзүүлэн).	Хэрвээ чи төөрчихвөл чиний царай ямар болох байсан бэ?, Үлгэрийн хамгийн тусч амьтан нь хэн бэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг анзаарч, ойлгож, энэрэх. Мэдрэмжээ үг, үйлдлээр илэрхийлэх.	Хэлсэн зүйлд тохируулан нүүрний хувирлаа өөрчилж чаддаг. Асуултыг ойлгож хариулдаг.
Баяр ёслолын мэндчилгээ	Тойргийн цаг	Цагаан сар баярын талаар бичлэг үзэж, уламжлалт ёс заншлын талаар ярилцана. Мэндчилгээний үгсийг сонгох самбар ашиглан золгох үгсийг хэлж харилцана.	Цагаан сарын бичлэг (холбоос 6, 7), мэндчилгээний сонголтын самбар.	Цагаан сараар хүмүүс хоорондоо юу гэж хэлж мэндчилдэг вэ?.	Үндэсний өв соёл: Бусадтай мэндчилэх. Харилцах: Үндэсний баярын мэндчилгээний үгсийг сурч, харилцаандаа хэрэглэх.	Баяр ёслолын зарим үйлийг даган дуурайдаг.
Монгол дээл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үндэсний хувцас, эд хэрэглэлтэй (дээл, хөөрөг, малгай)-тэй бодитоор хүрч мэдрүүлэн танилцана. Хувцас, эд хэрэглэлийн зурагтай картаар тоглож, нэрлэнэ. "Хувцасны магтаал" хөгжимт хөдөлгөөн хийнэ.	Дээл, малгай, бүс, гутал, хөөрөг, домбо зурагт үзүүлэн болон бодит эд хэрэглэл.	Энэ хувцсыг юу гэж нэрлэдэг вэ?.	Үндэсний өв соёл: Үндэсний хувцас, цагаан идээ, тоглоом, наадгайг ялган таних, баяр ёслолд оролцох. Бүтээлчээр сэтгэх: Хөгжимт хөдөлгөөнийг даган дуурайх.	Үндэсний хувцас, цагаан идээ, тоглоом, наадгайг таньдаг.

2 дугаар сарын I долоо хоног

ТУУЛАЙ

Шинэ үгс: Дохио, тулж тойрох, өгсөх уруудах.

Үйл ажиллагаа 1. Бөжингүүд хөлөө товшъя (Өглөөний дасгал)

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, хүүхэд бүрд жижиг цагариг

Аргачлал: Хүүхэд бүрийн өмнө цагаригийг газар байрлуулна. Хүүхдүүдийг 2 эгнээ, шатарчилсан болон тойргоор зогсооно.

1-3. Баруун хөлөө цагариг дотор 3 удаа товшино.

4. Хөлөө хавсарч нийлүүлнэ.

5-7. Зүүн хөлөө цагариг дотор 3 удаа товшино.

8. Хөлөө хавсарч нийлүүлнэ.

1-8. Хөлийн өсгийг цагариг дотор товшиж давтана.

1-8. Цагариг дотор зогсож дороо алхаж гараа урагш арагш чөлөөтэй савна.

1-8. Хүүхэд бүр өөрийн цагаригаа тойрч гүйнэ.

Дараагийн удаа алгаа таших, сэгсрэх хөдөлгөөнийг нэмж зохиомжлон хэмнэлээ өөрчлөн удаанаас хурдан гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 2. Гэр (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн тууз (2м урт), хөгжмийн ая (холбоос 1), гимнастикийн хэрэглэгдэхүүн (цагариг, бөмбөг), саваа мод (урт 50-60 см, 2-2,5 см диаметр), налуу шат, 1 ба 2 нарийн зам (5-10см өндөр), эсвэл вандан сандал.

Аргачлал:

1. Туузтай дасгал

“Монгол аялгуу” зохиолын аянд өнгийн туузыг хүүхэд бүр барьж гэр болон зогсоно. “Алхаарай”, “Зогс”, “Өлмий дээрээ алхаарай”, “Үсрээрэй”, “Эргээрэй”, “Гүйгээрэй” гэх дохиогоор удирдана. Хөгжмийн аянд гүйцэтгэнэ. Өнгийн туузын нэг үзүүрийг нийлүүлж нөгөө үзүүрээс хүүхдүүд барьж тойргоор (гэрийн унь мэт) зогсоно.

- Алхаарай гэхэд дороо алхана.

- Зогс гэхэд дороо хөдөлгөөнгүй зогсоно.

- Баруун тал руу эргээд алхаарай гэхэд баруун тал руу тойрч алхана.

- Зогс гэж зогсоогоод зүүн тал руу эргээд алхаарай гэхэд зүүн тал руу тойрч алхана.

Хүүхдийн гүйцэтгэх чадвараас хамаарч алхах, гүйх, үсрэх, сууж босох хөдөлгөөний давтамжийг тохируулна. Багш “Зогс” дохиог хэт чанга хэлэхгүй байх, шүгэл орлуулж хэрэглэхгүй байхад анхаарна.

2. Хөгжилтэй дасгал

Аргачлал: Хүүхдүүд тойргоор (хосоор, шатарчилсан) зогсоно. Хөгжимт гимнастик (4-6 найман тоот) цогц дасгалыг багшийг даган дуурайж хөгжмийн аянд гүйцэтгэнэ.

3. Шидэт саваа

Аргачлал: Хүүхдүүд хос хосоороо зогсож, 1 саваа модоор ээлжлэн гүйцэтгэнэ.

- Саваа модны 1 үзүүрийг газар тулж, өлмий дээрээ тойрч алхана. Эхлээд нэг нэгээрээ ээлжлэн гүйцэтгэнэ. Дараа нь хосоороо баруун/зүүн тал руу тойрч алхана.

Хувилбар: Дасгалыг гүйцэтгэж чадаж байвал дараах хувилбараар баяжуулж болно.

- Хосоороо дундаа 1 саваа модыг газар тулж, 1 нэг алхмын зайд зогсоно. Сул үзүүрийг бие бие рүүгээ ээлжлэн зөөлөн түлхэнэ, унагахгүй барьж авна.

- Хосоороо зогссон байрлалдаа ээлжлэн саваа модноос барьж 4 удаа хөнгөн үсэрнэ. Урдаа зогсож байгаа найзынхаа үсрэлтийг 1-4 хүртэл тоолно. Найздаа саваа модоо дамжуулна.

4. Тэнцвэр

Аргачлал:

- Налуу шатан дээр бусдын тусламжтайгаар авирч гарна, бууна.

- Налуу шат руу гар хөлийн тусламжтайгаар мөлхөж гарна, бууна. Хүүхдүүд бие биеийнхээ гараас хөтлөн налуу шат руу авирч, буухад тусална.

Хувилбар:

- Вандан сандал дээр тэнцвэрээ хадгалан алхана. Хос хосоороо бие биедээ тусалж алхана.
- Тайвшруулах болон сунгалтын дасгал хийцгээе. Хүүхдүүд зурагт үзүүлэнгээс сонгож хамтдаа гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 3. Хуруугаар наадъя (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зөөлөн резин, зурагт үзүүлэн

Аргачлал:

- Гараа алгаар нь ширээ, эсвэл өвдгөн дээрээ тавина. Хуруунуудыг нэрлэж нэг нэгээр нь өргөн буулгана. Мөн бугуйн үеэр тойргоор эргүүлнэ.
- Эрхий болон долоовор хуруундаа зөөлөн резин хийж бусад хуруунуудыг тэнийлгэнэ. Резинийг татаж сунгана. Өөрөө бие даан тоолж давтана.

УХААНТ ТУУЛАЙ

Шинэ үг: Өглөө, орой

Үйл ажиллагаа 1. Ухаант туулайг олоорой (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: “Ухаант туулай” үлгэрийн бичлэг, дэлгэмэл ном хийх бэлдэц, 3 цуврал зураг

Аргачлал:

- Үлгэрийн видео бичлэг үзнэ.
- Багшийн асуултын дагуу ярилцана. Үйл явдлын дагуу зургийг байрлуулж наана.
- Зургийг сайн хараарай.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Үлгэрт ямар ямар амьтан гарсан бэ?
- Унага хаана байна?
- Унаганы ээжийн нэрийг мэдэх үү?
- Туулай хаана байна вэ?
- Туулай шиг үсэрч үзэх үү?
- Чоно унага дээр өглөө ирсэн үү, орой ирсэн үү?

Үйл ажиллагаа 2. Өглөө орой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өглөө, оройн хоногийн хэсгийн зурагт хөлөг, зурган карт хүүхэд бүрд.

Аргачлал:

- Өглөө боллоо. Нар гарлаа. Зургийг олоорой.
- Орой боллоо. Нар унтлаа. Зургийг олоорой.

Өглөө, орой гэж ээлжлэн хэлж, хоёр гараа дээш өргөх, хоёр гараа буулгаж нийлүүлэх зэрэг хөдөлгөөнийг хийнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи өглөө юу хийдэг бэ?
- Унага өглөө юу хийсэн бэ?
- Чи орой юу хийдэг бэ?
- Унага орой юу хийсэн бэ?

Үйл ажиллагаа 3. Зургийн дараалал (Номын цаг)

Аргачлал: “Ухаант туулай” үлгэрийн үйл явдлыг хүүхдүүд өөрсдийн байрлуулсан зургийн дагуу ярина.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Үлгэрт ямар амьтан байсан бэ?
- Эхлээд унага юу олсон бэ?
- Уутан дотроос юу гарч ирсэн бэ?
- Чоно уутнаас гарч ирсний дараа унагыг яах гэсэн бэ?

- Чоно унагыг идэх гэхэд ямар амьтан ирсэн бэ?

БИ ЗУРААЧ

Шинэ үгс: Гуаш, бийр, харандаа

Үйл ажиллагаа 1. Олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Унага, туулай, чононы сүүдэр зураг, гуаш, бийр, харандаа, шуудайны гүйцээж зурах зураг.

Аргачлал:

Ширээн дээр ухаант туулай үлгэрт гарсан дүрүүдийн сүүдэр зургийг бэлтгэсэн байна.

- Үлгэрт гарсан дүрүүдийн сүүдрийг олж тоглоно. Жишээ нь: Чоно гэхэд сүүдэр зургуудаас чононы сүүдэр зургийг олно. Туулай гэхэд туулайны сүүдэр зургийг олох гэх мэтээр тоглоно.
- Сонгон авсан амьтны сүүдрийг хүссэн өнгөөрөө гуашаар будна. Амьтдын сүүдрийг будаж дууссаны дараа хатаана. Хатсаны дараа нүд амыг зурна.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Үлгэрт ямар амьтад гарсан бэ?
- Хамгийн түрүүнд ямар амьтан гарч ирсэн бэ? Хамтдаа тэр амьтныг олцгооё.
- Дараа нь ямар амьтан гарч ирсэн бэ?
- Чиний сонгосон амьтан хамгийн эхэнд үлгэрт гарсан амьтан мөн үү?
- Үлгэрт гарсан амьтдыг чи урьд өмнө хаана харсан бэ?
- Чоно ямар өнгөтэй бэ?

Үйл ажиллагаа 2. Дүрд хувирч тоглоё (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Унага, туулай, чононы сүүдэр зураг, гуаш, бийр, харандаа, шуудайны гүйцээж зурах зураг

Аргачлал: Хүүхдүүд чиглүүлэх тоглоомын цагаар өөрсдийн зурж, будсан дүрийг ашиглан дүрд хувирч тоглоно.

- Хүүхдүүд өөрсдийн зурж, будсан дүрээс хүссэн нэг дүрийг сонгож авна.
- Багш үлгэрийг ярьж өгөхөд өөрийн сонгосон дүрд хувирч тоглоно.
- Дараа нь өөрсдөө үлгэрээ ярьж тоглож болно.

ЗОЧИН ТУУЛАЙ

Үйл ажиллагаа 1. Хамтаръя (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Аяга, халбага, сэрээ, хоолны ширээ засах зурагт үзүүлэн, бүлээн ус, өтгөрүүлсэн шүүс 2-3 төрлийн (чацаргана, аньс, нэрс).

Аргачлал:

- Унага туулайд талархаж, түүнийг гэртээ өдрийн хоолонд урьж гэнэ.
- Зочин ирэх гэж байгаа учир унага, ээжтэйгээ хамт гэрээ цэвэрлэхээр болж гэнэ.
- Цэвэрлэгээ зурагт үзүүлэнг хамтдаа үзэж хүмүүс юу хийж байгааг ярилцана.
- Хүүхэд бүрд тоосны жижиг алчуур өгнө. 4 хүүхдийн дунд 1 савтай ус бэлтгэнэ. (усанд бага зэрэг соод хийж болно)
- Хүүхдүүд хамтран бүлгийн өрөөний хэсгүүдийг хуваарилан авч, цэвэрлэнэ. (Жишээ нь: 1-р баг Тоглоомын төв, 2-р баг Байгалийн төв гэх мэт)

Үйл ажиллагаа 2. Хоолны ширээ засъя (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Аяга, халбага, сэрээ, хоолны ширээ засах зурагт үзүүлэн, бүлээн ус, өтгөрүүлсэн шүүс 2-3 төрлийн (чацаргана, аньс, нэрс).

Аргачлал:

- Туулай удахгүй зочлон ирэх гэж байна. Унага хоолны ширээ засахаар бэлдлээ. Түүнд хамтдаа тусалцаая.
- Зурагт үзүүлэнгийн дагуу хоолны ширээ засна.
- Туулай найздаа зориулаад амттай сайхан шүүс бэлдэцгээе.
- Хэт халуун ус байвал түлэгдэх аюултай !!!

- Хэт хүйтэн ус байвал хоолой өвдөнө !!!
- Иймээс бүлээн усаар шүүсээ найруулна.

Хүүхдүүд бүлээн усан дээр өтгөрүүлсэн шүүснээс нэмж найруулан шүүс бэлтгэнэ. Бэлтгэсэн шүүсээ амсаад, ямар амттай байгааг ярилцана.

МЭДЭРЧ ТААЯ

Шинэ үгс: Хатуу, зөөлөн, хөвсгөр.

Үйл ажиллагаа 1. Хайгуулчин (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Доторх нь харагддаггүй даавуун уут, өөр өөр материалтай эд зүйлс, тоглоом (ноос, бөмбөлөг, тоглоом, мод, хөвөн, чулуу, туулай, чоно, унаганы хэлбэртэй тоглоом). /Ангид байх тоглоом, хэрэглэгдэхүүнийг ашиглана./

Аргачлал: Дотор нь эд зүйлс, тоглоом хийсэн уутаа хүүхдүүдэд харуулж, зохиолын үйл явдлыг эргэн санаж, харилцан ярилцана.

Асуулт:

- “Ухаант туулайн үлгэр”-т ямар ямар амьтан гардаг вэ?
- Унага явж байгаад замдаа юутай таарсан бэ?
- Унага яагаад уутны амсрыг нээсэн бэ?
- Унаганд хэн тусалсан бэ?
- Туулай туслаагүй бол унаганд юу тохиолдох байсан бол? гэх мэт.

Аргачлал: Хүүхдүүд гадаа орчныг харж ажиглана. Гадаа талбайд газраар модны мөчир, чулуу, ноос, цаас гэх мэт зүйлсийг тараан байрлуулсан байна. Багш хүүхдүүдэд өмнө сурсан оньсого таалгана. Таасан хүүхэд ойр хавиасаа тухайн тааврын эд зүйлсийг олж багшийн барьсан уутанд хийнэ.

Оньсого:

- Тэсгэм өвөл нүцгэн мөртлөө, Дэлгэр зун дээлээ нөмөрнө. /Мод/
- Өдөр бүл гишгэгддэг ч гомддоггүй нэгэн. /Чулуу/
- Биднийг бүрхсэн арьс, амьтдыг бүрхсэн үс. /Ноос/ гэх мэт хүүхдийн сайн мэддэг оньсого байна.

Хүүхдүүдийн түүж авчирсан эд зүйлсийн талаар асууна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар хэлбэртэй байна вэ?
- Хатуу юу, зөөлөн үү?
- Ямар өнгөтэй байна вэ?

Үйл ажиллагаа 2. Мэдэрч нэрлэ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Бараан, доторх нь харагддаггүй даавуун уут, өөр өөр материалтай эд зүйлс, тоглоом (ноос, бөмбөлөг, тоглоом, мод, хөвөн, чулуу, туулай, чоно, унаганы хэлбэртэй тоглоом). /Ангид байх тоглоом, хэрэглэгдэхүүнийг ашиглана/

Аргачлал: Багш хүүхдүүдэд уутны зорилгыг тайлбарлана. Жишээ: Энэ уутан дотор өөр өөр зүйлс бий. Та нар зөвхөн гараараа тэмтрээд, юу байгааг таах гэж оролдоно. Тааж хэлэхээс өмнө уутанд байгаа зүйлийг харж болохгүйг сануулна. Хүүхдүүдэд чиглүүлэг өгнө. Жишээ нь: Чулуу ямар мэдрэмж төрүүлдэг вэ? Ноос зөөлөн үү? хатуу юу? гэх мэт.

- Нэг захаас эхлэн ууттай зүйлсийг хүүхдүүдээр тэмтрүүлж таалгана. Хүүхдүүдийн таасан зүйлсийг уутанд буцааж хийхгүй голд байрлуулсан сагснуудад ангилуулж хийлгэнэ. (Багш уутанд бэлтгэсэн зүйлсээс шалтгаалж хэрхэн ангилуулж хийлгэхээ шийднэ.) Жишээ нь: 1 дэх сагсанд хатуу зүйлс, 2 дахь сагсанд зөөлөн зүйлс, 3 дахь сагсанд амьтан гэх мэт.
- Хүүхдүүд уут руу гараа хийж, дотроос нь 1 зүйлсийг сонгож тэмтэрнэ.
- Шууд гаргаж ирэхээс өмнө тэмтрээд юу байгааг таамаглаж хэлнэ. Жишээ нь: Энэ хатуу байна. Бөөрөнхий хэлбэртэй байна гэх мэт.
- Хүүхдүүд өөрсдийн таамгийг ярилцана. Уутнаас эд зүйлийг гаргаж, зөв таасан эсэхийг шалгана.

Багш уутнаас гарч ирсэн зүйлсийн талаар асуулт асууж, нэмэлт мэдээлэл өгнө. Жишээ нь: Үлгэрт гарсан амьтны дүрстэй тоглоомыг олсон бол үлгэрийн үйл явдлыг бататгаж асуух гэх мэт.

Үйл ажиллагааны төгсгөлд хүүхдүүдээс ямар зүйлс хамгийн сонирхолтой байсан тухай асууж ярилцана. Хүүхдүүдийн мэдрэх чадварыг үнэлж, урамшуулна.

Чөлөөт тоглоомын цагаар уутанд зөвхөн 1 зүйлийг хийж зөвхөн гараар мэдрүүлэх бус тухайн зүйлээс гарах дуу чимээ, үнэрийг ажиглах боломжийг олгож мэдрэхүйг хослуулсан байдлаар таалгаж тоглоно.

2 дугаар сарын II долоо хоног

ТАВАН ХӨӨРХӨН

Шинэ үгс: Тугал, ишиг, унага, хурга, ботго

Үйл ажиллагаа 1. Юу дуугарсан бэ? тоглоом (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

1. Таван төлийн дуу

Хэрэглэгдэхүүн: Таван төлийн зураг, сонсох хөгжмийн бичлэг, цахим үзүүлэнгийн холбоос

Аргачлал: Б.Наранбаатарын ятга хөгжимд зориулан зохиосон “Таван хөөрхөн” зохиолыг сонсгоно (холбоос 2).

- Таван төлийн дуу чимээг сонсгоно (холбоос 3).
- Дуу чимээг сонсгоод ямар амьтан дуугарч байгаа талаар ярилцана. Таван төлийн зурагт үзүүлэнгээс аль нь дуугарсан бэ? гэж асуухад заана, нэрлэнэ.

2. Дагаад дуулаарай

Хэрэглэгдэхүүн: Таван төлийн зурагт үзүүлэн, дууны бичлэг

Аргачлал: Алтан ураг хамтлагийн ахлагч, хөгжмийн зохиолч Б.Эрдэнэбатын үг, ая “Ирээрэй” хүүхдийн дуу (холбоос 4).

- Дууны бичлэгийг сонсон утга санааг ярилцана.
- Төл малын дуу авиаг дуучин хүү хэрхэн өөрийнхөөрөө илэрхийлэн дуурайн дуулж байгаа талаар ярилцана.
- Ботгоны дуу авиаг өөрөөр хэрхэн дуугаргаж болох талаар ярилцана.
- “Ирээрэй” дууны 1, 2-р бадгийг заана.
- Дууны үгийг мөр мөрөөр нь дагуулан 2-3 удаа хэлүүлнэ.
- Дууны аялгууг тоглон сонсон дуулж үзүүлнэ.
- Дууг мөр мөрөөр нь дагуулан дуулуулна.

1-р бадаг Үнээ үнээ ирээрэй

Хөөрхөн тугал дуудаад байна

Мөөмөө идмээр байна гээд

Мөөрөн мөөрөн дуудаад байна

Үмбүү үмбүү үмбүү үмбүү

2-р бадаг Ямаа ямаа ирээрэй

Хөөрхөн ишиг дуудаад байна

Мөөмөө идмээр байна гээд

Майлан майлан дуудаад байна

Май май май май

3. Нэрлээд таш тоглоом

Хэрэглэгдэхүүн: Хэмнэлийн зурагт үзүүлэн (чоно 1 алга таших, туулай 2 алга таших, унага 3 алга таших дүрслэлтэй зураг бэлдэх).

Аргачлал: “Ухаант туулайн үлгэр”-т гардаг амьтдыг нэрлэнэ. Нэрлэхдээ үеэр тасалж, үе тутамд алга ташин хэмнэл тоглоно. Чоно, туу-лай, у-на-га.

Үйл ажиллагаа 2. Надтай тоглооч хөгжимт хөдөлгөөн (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: “Надтай тоглооч” хүүхдийн дууг сонсгоно (холбоос 5-ыг харна уу).

- Хүүхдүүдийг хос хосоороо гараасаа хөтлүүлэн зогсооно.

- Дууны бадгийн аянд найзынхаа гарыг хөдөлгөөрэй гэж хэлэх дагуулан хийлгэнэ.
- Дахилтын хэсэгт найзтайгаа хамт хурга, ишиг, тугал, унага, ботго гэх бүрд хөлөөрөө газар товшин дороо эргэнэ.
- Таван удаа давтан бүжиглээд хамтран бүжиглэсэн найздаа баярлалаа гэж хэлнэ.

ҮЛГЭРИЙН ЕРТӨНЦ

Шинэ үг: Шагай, бут, мөчир.

Үйл ажиллагаа 1. Үлгэрийн ертөнц (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шагай, өнгө өнгийн шагай, шагайны 4 талыг нэрлэх зурагт үзүүлэн, шагай өрж тоглох зургууд.

Аргачлал:

- *Хэл яриа-Номын төв.* “Ухаант туулайн үлгэр”-ийн үйл явдлын зарим зургийг хэвлэж бэлтгэсэн байна. Ухаант туулай үлгэрийн цуврал зургийг эвлүүлж, үйл явдлыг тайлбарлан ярина.
- *Математикийн төв.* Унага, чоно, туулайны А4 хэмжээтэй зураг, шагайнууд, олбог. Шагайны дөрвөн талыг нэрлэнэ. Унагатай зургийг шагайны морь буусан байдлаар тойруулан өрнө. Чонотой зургийг шагайны тэмээ буусан байдлаар тойруулан өрнө. Туулайтай зургийг шагайны хонь буусан байдлаар тойруулан өрнө гэх мэт.
- *Зураг, урлалын төв.* Үлгэрийн дүрүүдийг бүтээх баримал, наамал, зургийн аргачлалууд. Хүүхдүүд өөрийн дуртай дүр, хэрэглэгдэхүүнийг сонгон аргачлалын дагуу бүтээл хийнэ.

ЖИЖИГ ТУУЛАЙГ ОЛООРОЙ

Шинэ үг: Өргөөрэй, урд, хойно, хажууд

Үйл ажиллагаа 1. Хэн ярих вэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Унага, чоно, туулайн зурагт үзүүлэн, 5 хүртэл шагай тус бүр хүүхдэд

Аргачлал: Үлгэрийн үйл явдлыг илэрхийлсэн зурагт үзүүлэн бэлтгэсэн байна. Эхлээд, дараа нь... гэсэн үгээр чиглүүлэн хүүхдүүд үлгэрийн үйл явдлыг сэргээн санаж зурагт үзүүлэнг дарааллаар нь байрлуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Унаганд юу тохиолдсон бэ?
- Ууттай зүйлийг хараад унага юу гэж бодсон бэ?
- Гэтэл уутанд юу байсан бэ?
- Дараа нь юу болсон билээ? Унагыг чоно идэх гэж байхад ямар амьтан ирж тусалсан бэ?
- Туулайг хараад унага яасан бэ?
- Туулай чононд юу гэж хэлсэн бэ?

Үйл ажиллагаа 2. Хаана нуусан бэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Олбог, зурагт үзүүлэн хүүхдийн тоогоор.

Аргачлал: Хүүхдүүд олбог дээр тойрч сууна. Үлгэрийн дүрийн зургийг өөрийн урд, хойно, дэргэд байрлуулж тоглоцгооё. Хүүхдүүд зураг харж нэрлэнэ. Багш хүүхдүүд хамтдаа үйл ажиллагаанд оролцоно.

- Жижиг туулайн зургийг өөрийн урд байрлуулцгаая.
- Гарын хурууг нийлүүлцгээе. Яг жижиг туулайн бие шиг.
- Том чононы зургийг өөрийнхөө ард нуугаарай. Хаана нуусан бэ?
- Гараа хоёр тийшээ дэлгээрэй. Яг том чононы бие шиг.
- Унаганы зургийн хажууд таван шагайг морь болгож байрлуулцгаая.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Том чоно байна уу? Өргөөрэй.
- Гар нь том чононы бие шиг болж байна уу?
- Жижиг туулай байна уу? Өргөөрэй.

Хүүхдүүд зурган картаа барьж урд, хойно, дэргэд зогсож байраа олох тоглоом тоглож болно.

БҮТЭЭЦГЭЭ

Шинэ үгс: Шуудай, уяа, алчуур.

Үйл ажиллагаа 1: Дүрсээр наадъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Гурвалжин, дугуй, зууван дугуй дүрснүүдийг хүүхдийн тоогоор бэлтгэнэ.

Аргачлал: Ширээн дээр дүрсүүд бэлтгэсэн байна.

- Дүрсүүдээс дугуй дүрс хаана байна олоорой.
- Гурвалжин дүрс хаана байна олоорой гэх мэтээр дугуй, гурвалжин дүрсийг ангилж тавина.
- Ангилж тавьсан дугуй, зууван дугуй дүрсээр туулай, гурвалжин дүрсээр чоно бүтээж тоглоно.

Үйл ажиллагаа 2: Алчуураар наадъя (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хамрын алчуур, уяа, шоо.

Аргачлал: Шооны зургаан талд чоно, туулай, унага, шуудайны зургийг байршуулан наасан байна. Хамтдаа шоо орхиж тоглоно.

- Хүүхэд бүр хамрын алчуур бэлтгэсэн байна.
- Хүүхдүүд шоог ээлжлэн орхиж тоглоно.
- Шоог орхиход ямар зураг буусан түүний талаар ярих ба хамрын алчуураар тухайн амьтан, эд зүйлийг бүтээж тоглоно.
- Хэрэв шуудайны зураг буувал хоёр хүүхэд хамтран хамрын алчуурыг нэг нь барьж нөгөө нь уяа ашиглан зангидаж уяж сурна.
- Өөрийн хийсэн зүйлийг багшдаа болон найзууддаа тайлбарлаж ярьж өгнө.

ГЭНЭН УНАГА

Шинэ үгс: Туслах - Сайн дураар юм өгч, нэмэр тус болох

Үйл ажиллагаа 1. Гэнэн унага (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Ухаант туулай үлгэрийн унаганы дүрслэлтэй зурагт том үзүүлэн.

Аргачлал:

- Унага унтаж байгаад ээжээсээ төөрчээ. Түүний царай ямар болсон бол? Хэрвээ чи ээжээсээ төөрчихвөл чиний царай ямар болох байсан бэ?
- Унага явж байгаад ууттай зүйл олж гэнэ. Түүний царай ямар болсон бол? Хэрвээ чи ууттай зүйл олбол ямар нүүрний хувирал гаргах байсан бэ?
- Уутны амыг нээтэл дотроос нь чоно гараад иржээ. Түүний царай ямар болсон бол? Хэрвээ чи гэнэт аймаар амьтантай таарвал ямар нүүрний хувирал гаргах байсан бэ?
- Унага туулайтай хамт уутны амыг боож аюулгүй боллоо. Түүний царай ямар болсон бол? Багшдаа дуурайж үзүүлээрэй.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Үлгэрийн хамгийн тусч амьтан нь хэн бэ?
- Яаж тусалсан бэ?
- Үлгэрийн муу дүр хэн бэ? Яагаад?

ҮНДЭСНИЙ БАЯР, ХУВЦАС

Шинэ үгс: Цагаан сар - үндэсний баяр, дээл - үндэсний хувцас.

Үйл ажиллагаа 1. Баяр ёслолын мэндчилгээ (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Мэндчилгээний сонголтын самбар, баяр ёслолын зурагт үзүүлэн, цагаан сар баярын тухай дүрс бичлэг (холбоос 6, 7).

Багшийн чиглүүлэх асуулт:

- Цагаан сар гэж ямар баяр байдаг вэ?
- Цагаан сараар та нар хэн хэнтэй золгодог вэ?

- Золгохдоо юу гэж хэлдэг вэ?
- Цагаан сараар хүмүүс хоорондоо юу гэж хэлж мэндчилдэг вэ?

Аргачлал: Мэндчилгээний сонголтын самбар хийж хүүхдэд ойлгомжтой зургаар чимэглэнэ. Хүүхдүүд зургуудаас сонголт хийж, мэндчилгээний үгс хэлнэ.

- Сайн байна уу?
- Өглөөний мэнд.
- Сайхан амарсан уу?
- Амар байна уу?
- Амархан сайн байна уу?
- Та сайхан шинэлж байна уу?
- Сар шинэдээ сайхан шинэлж байна уу?
- Тарган сайхан өвөлжиж байна уу? зэрэг үгсээс болон хүүхдүүдийнхээ онцлогоос шалтгаалан хөнгөрүүлэх, хүндрүүлэх байдлаар үгсийг өөрчлөн хэлүүлж болно.

Үйл ажиллагаа 2. Монгол дээл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дээл, малгай, бүс, гутал, зарим эд хэрэглэл (хөөрөг, домбо бусад), зурагтай карт, зурагт ном, “Бидний хувцас” дуу (холбоос 8, 9).

Аргачлал:

- Үндэсний хувцас, эд хэрэглэлийг хүүхдүүдэд үзүүлж, бодитоор хүрч мэдрүүлнэ.
- Үндэсний хувцсыг өмсөж харуулан малгай, бүс, гутал гэх мэт бүрдэл хэсгүүдийг тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ хувцсыг юу гэж нэрлэдэг вэ? (Энэ бол дээл. Дээл нь Монголчуудын үндэсний хувцас.)
- Энэ зүйлийг юу гэж нэрлэдэг вэ? (Энэ бол хөөрөг. Хөөрөг нь Монгол ахуйд чухал эдлэл.) гэх мэт.

Цагаан сар тоглоом тоглонгоо үндэсний хувцас, эд хэрэглэл, мэндчилгээний үгийг хэлэх зэргээр бататгана.

- Хүүхдүүдийг 3-4 хүүхэд суусан байхаар тооцож баг болгоно.
- Баг бүрийн голд үндэсний хувцас, эд хэрэглэлийн зурагтай картуудыг бэлтгэн, доош нь харуулан тавьсан байна.
- Хүүхдүүд ээлж ээлжээр картуудыг дээш харуулан сөхөж, гарч ирсэн зураг дээрх зүйлийг нэрлэнэ.
- Багш хүүхдийн хэлж буй үгсийг давтан хэлүүлж, зөв дуудлагыг хэлж өгнө.

“Хувцасны магтаал” хөгжимт хөдөлгөөнийг даган дуурайж хийнэ.

Сонсьё, дэмжье/ Тусалцаа

- Бие бялдрын хөгжлийн ялгаатай хүүхдэд сургалтын хэрэглэгдэхүүний тохируулга хийхэд анхаарна.
- Үйлдлийг харуулсан зурган зааварчилгаа болон биеийн үйлдлээр дэмжлэг үзүүлж, хамтдаа хийнэ.
- Орчны эд зүйлсийн талаар ярилцаж, хүрч болох бодит зүйлс ашиглаж үгийн баялгийг нэмэгдүүлж, харилцахад дэмжлэг үзүүлнэ.
- Дуу авиатай зурагт ном, товчлуур дарахад дуу гардаг самбар хэрэглэнэ.
- Тоо, хэмжээ, дүрс, биет, байршил зэрэг ойлголтыг тоглоом, мэдрэхүй, хөдөлгөөнтэй хослуулан аажим, сонирхолтой байдлаар, үйлдлийг давтан хийх, бодитоор харьцуулах, үргэлж урам өгч, ахиц гарвал магтах зэргээр суралцахад дэмжлэг үзүүлнэ.

Сонсьё, дэмжье/ Тусалцаа

- Хүүхэд аливаа зүйлийг гараар тэмтэрч, сонсголоор таньж мэддэг тул сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн нь хурц үзүүр, ирмэггүй байхад анхаарна.
- Тэмтрэх, мэдрэх, хүрэлцэх зэрэг үйл хийх боломжийг дэмжсэн барзгар гадаргуутай наадгай, хэрэгслийн тусламжтайгаар дэмжинэ.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой ном уншиж өгч, ярилцах;
- Хүүхдийн хөдөлгөөнийг дэмжиж урам зориг өгөх;
- Үлгэр зохиолын агуулга, дүрийн талаар хүүхэдтэй идэвхтэй харилцан ярилцах;
- Амьтан тэжээх, түүнийг хайрлан хамгаалах, тасалгааны ургамал тарих, байгаль, цаг агаарын үзэгдлийг хамтдаа ажиглан ярилцах;
- Тоглоом болон ижил ялгаатай зүйлсийн давтамжийг дуурайж хамтдаа тоглох;
- Хүүхдийн зурах, урлах үйлд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, орчин бүрдүүлэх;
- Дуулах, хөгжимдөх, хөгжимт хөдөлгөөн хийх, дүрд тоглох боломжийг олгож, дэмжиж, зоригжуулах.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
Амжилттай хэрэгжүүлсэн:
Сул хэрэгжүүлсэн:.....
Цаашид сайжруулах:.....
Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

Цахим холбоос:

1. <https://youtu.be/SuHxq0AUTIQ?si=GuotPjvTrZda8E6R>
2. <https://youtu.be/18NlxCpt6T8?si=uRh5m4iVoywazLHK>
3. <https://youtu.be/nQl1Sywk6d0>
4. <https://youtu.be/nINVsHNWPfM?si=vWqC8u4aa-3zMRfA>
5. <https://youtu.be/OxYb1BxUGXU?si=3aYZaNKpjK7wJFht>
6. <https://youtu.be/fggS1E10Lv0?si=N-KTMW7Obr14Ts2Q>
7. https://youtu.be/sQNtofv8yCo?si=djDiQ1_rDnl3cfmK
8. https://www.youtube.com/watch?v=8t67SU-hw-Q&list=RD8t67SU-hw-Q&start_radio=1
9. https://youtu.be/DMW69KSaO4o?si=TRuB2f10Is1_tSsO

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - III САР

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ

Хүүхдийн эзэмших чадамж:

Хамтран ажиллах: Хүүхэд дүрд орж тоглох, ээлжлэх, бусдыг сонсох, өөрийнхөө үүргийг биелүүлэх зэрэг дэмжих үйл хувь нэмрээ оруулна.

Нийгэм, сэтгэл хөдлөл: Гэр бүлийн гишүүдийн ажил, хэрэглэдэг хувцас, багаж хэрэгслийг ялган таних, хүүхэд өөрийн болон бусдын хийх дуртай зүйлсийг ялгах, хүндэтгэх, энгийн хөдөлмөрийн үйл хийх зэрэг дэмжих үйл хувь нэмрээ оруулна.

Аюулгүй байдлын зөвлөмж:

- Хэрэглэгдэхүүнүүдийг (багажийн загвар, жижиг тоглоом) хүүхдийн насанд тохируулан, хурц ирмэггүй, жижиг хэсэг аманд хийхэд аюулгүй байдлыг шалгана.
- Тоглоом багаж хэрэгслийг бүлгээр хуваан өгч, булаацалдах, зөрчилдөхөөс урьдчилан сэргийлнэ.
- Тойрогт суух, тоглох үед хүүхэд хоорондын зайг тааруулах (мөргөлдөх, түлхэлцэхээс сэргийлэх).
- Дүрд орж тоглох үед хүүхэд ээлжээр тоглох, хэрэгслийг зөв барьж хэрэглэхийг зааж, хамтын тоглолтыг зохицуулна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Хүүхдүүд гэр бүлийн гишүүдийнхээ, ажил мэргэжлийн тухай ярилцах, бусадтай харилцахад нь урамшуулж, нээлттэй оролцох боломж олгоорой. Мэдрэмжээ хөдөлгөөн, үг, үйлдлээр илэрхийлэх, найзаа сонсох дадалд дэмжлэг үзүүлээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Хүүхдүүдийг хамтран тоглох, хөдөлгөөн даган дуурайх, дуу дуулж өөрийгөө илэрхийлэхэд нь урамшуулан дэмжээрэй. Хүүхдийн хүсэл сонирхлыг хүндэтгэж, сонголтыг нь дэмжин тоглох боломж олгож харилцан ярилцахад туслаарай.

Зугаалга: Хүүхдүүд орчноо ажиглаж, энгийн даалгавар гүйцэтгэх дадал олж авна. Энгийн зааврыг дагаж биелүүлэхэд нь дэмжиж, хамтран тоглох, ярилцах боломж олгоорой.

Номын цаг: Хүүхдүүд бусдын яриаг сонсож, зурагт номыг хамтдаа сонирхож, ажил мэргэжлийн тухай асуулт асууж, хариулах боломжтой. Ажиглаж, ойлгож, хамтдаа сонсох дадлыг төлөвшүүлэхэд нь дэмжээрэй.

Хөгжөөн баясах цаг: Хүүхдүүд дүрд тоглож, сэдэвт тоглоомд бүтээлчээр оролцох, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломжтой. Бусдын үйлдлийг ойлгож хүлээцтэй байхад нь тусалж, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэхэд нь дэмжээрэй.

Боломжууд:

Хамтын тоглоомын үеэр бусдыг сонсож, хүлээцтэй хандаж сурах, ээлжилж тоглох, хэрэгслийг хуваалцах, бусдын санал бодлыг хүндэтгэж, ойлгож сурах зэрэг боломжийг бүрдүүлэхэд чиглүүлээрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО2.2б. Гэр бүлийн гишүүдийн талаар ярьж, тэдний ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, ажлын багаж хэрэгслийг ялган танина. СХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгодог болно. ХЯ2.2б. Бусадтай харилцахдаа энгийн, яриатай холбогдсон асуулт асууна.	Багш, эмч, цагдаа, айл гэр зэрэг сэдэвт тоглоом тоглох; Ажил мэргэжлийн зураг (эмч, гал сөнөөгч, багш, жолооч) өгч, тэдний хувцас, хэрэглэдэг багаж хэрэгслийг бодит зүйлсээс олж тоглох; Хоорондоо хамааралтай эд зүйлүүдийг олж тоглох; Сургалт, үйл ажиллагааны үед өөрийн болон бусдын хийсэн үйлдэл, түүнээс төрсөн мэдрэмжээ илэрхийлж ярилцах.	Ажил мэргэжлийн ертөнцөөр аялцгаая
ЗУ2.1а. Уран зураг, баримлын бүтээлийг ажиглаж, хүн, амьтан, эд юмсыг ялгаж нэрлэнэ. СХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. ХЯ2.2в. Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярина.	Хүүхдэд уран зургийн бүтээлийг танилцуулж, харилцан ярилцах; Мэдрэмж илэрхийлсэн үгсийг хэлэх; Зураг дээр эд юмсын өнгө, хэмжээг тодорхойлж хэлэх.	Зургийг ажиглая, бүтээцгээе
СХ2.2б. Насанд хүрэгчийн тусламжтай бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг анзаарч энэрэх үйлдэл үзүүлдэг болно. СХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгодог болно. ХЯ2.1а. Бусдын яриаг анхаарч сонсоно, үг өгүүлбээр хариулна.	Үлгэр, зохиолын агуулгаас тусламж гэж юу болох, бусдад туслах, бусдаас тусламж авах нь бүгдэд хэрэгтэй байдаг тухай ярилцах; Өөр өөр нөхцөл байдалд байгаа хүний зургийг хараад тухайн хүн ямар байгааг багшийн тусламжтайгаар ярилцах; Хэрэвбол юу болох вэ гэх мэт асуулт тавьж ярилцах; Богино эхийг сонсоод асуултын дагуу ойлгосноо өөрийн үгээр ярих.	Тусч сэтгэлтэй байя

<p>ХӨГ2.1а. Байгаль, эд юмсын дуу чимээг таньж ялгана.</p> <p>ХӨГ2.1в. Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно.</p> <p>ХЭМ2.1а. Гарын сарвууг өргөх буулгах, татах, түлхэх, бугуйн үеэр эргүүлэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ.</p> <p>ХӨГ2.1б. Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна.</p> <p>ХЯ2.2в. Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярина.</p>	<p>Дуу чимээ сонсоод биеийн хөдөлгөөн, дохио зангаагаар дүрслэх;</p> <p>Нэгээс хоёр үетэй үг, аялгууны давталттай богино дууг дагаж аялах, дуулах;</p> <p>“Дагаад дуулаарай” тоглоом тоглох;</p> <p>Хөгжмийн энгийн зэмсгийг сэгсэрч дуугаргах</p> <p>Сарвууны үеэр өргөх, буулгах зэрэг хөдөлгөөнөөр хэмнэл тоглох;</p> <p>Өдөр тутмын үйл ажиллагааны явцад хэмжээ заасан үгийг ашиглаж ярих.</p>	<p>Хонхтой бойтог</p>
<p>ХЯ2.2г. Үгийн утгыг ойлгож, хураангуй өгүүлбэрээр ярина.</p> <p>ХЯ2.1а. Бусдын яриаг анхаарч сонсоно, үг өгүүлбэрээр хариулна.</p> <p>БНО2.2б. Гэр бүлийн гишүүдийн талаар ярьж, тэдний ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, ажлын багаж хэрэгслийг ялган танина.</p> <p>НСХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгодог болно.</p>	<p>Зургийг ажиглан, үйл явдлыг хэлэх, 2-3 үгтэй өгүүлбэрээр асуултад хариулах;</p> <p>Ном үзээд асуултын дагуу ойлгосноо өөрийн үгээр ярих, дагаж ярих, зургийн дагуу тайлбарлах;</p> <p>“Хэн юу өмсдөг вэ?” дүрэмт тоглоом тоглох: Ажил мэргэжлийн зураг (эмч, гал сөнөөгч, багш, жолооч) өгч, тэдний хувцас, хэрэглэдэг багаж хэрэгслийг зургаас олж зэрэгцүүлэн байрлуулах, наах;</p> <p>Хоорондоо хамааралтай эд зүйлсийг олж тоглох.</p>	<p>Сонирхолтой мэргэжилтэй танилцъя</p>
<p>МАТ2.1а. 5 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолох, олон ба цөөн тооны тоглоом, юмсыг зааж хэлнэ.</p> <p>ХЯ2.2в. Юмсын өнгө, хэмжээ, байрлал заасан үгээр ярина.</p> <p>БНО2.2б. Гэр бүлийн гишүүдийн талаар ярьж, тэдний ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, ажлын багаж хэрэгслийг ялган танина.</p>	<p>Тооны нэр орсон тоглоом тоглох;</p> <p>Өдөр тутмын үйл ажиллагааны явцад өнгө, хэмжээ, байрлал заасан үгс ашиглаж ярих, бодит зүйлс, зураг дээр эд юмсын өнгийг хэлэх, тоглоом тоглох;</p> <p>Дүрслэл ашиглан гэр бүлийн гишүүд болон хийдэг ажил, ашигладаг зүйлсийг нэрлэх, ярилцах.</p>	<p>Өнгө ба мэргэжил</p>
<p>ХЭМ2.1а. Гарын сарвууг өргөх буулгах, татах, түлхэх, бугуйн үеэр эргүүлэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ2.1д. Сэдэвт алхалт, гүйлтийг хэрэглэл ашиглан гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ2.1к. Өргөсөн гараас дээш 5 см өндөр зүйлд үсэрч хүрнэ.</p> <p>МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.</p> <p>ХӨГ2.1г. Дуу, аялгууг мэдэрч, тохирсон хөдөлгөөн хийнэ.</p>	<p>Сарвууны үеэр өргөх, буулгах, татах, түлхэх, сэгсрэх зэрэг хөдөлгөөнийг ойлгож гүйцэтгэх;</p> <p>Дүрд хувирч шулуун, муруй, тойрог хэлбэртэй байрлуулсан олсыг дагаж, саадыг давж, сүлжиж алхах, гүйх;</p> <p>Алхалт, гүйлтийн үед аюулгүй байдалд анхаарч, хоорондын зайг тохируулах;</p> <p>Эд зүйлсийг давтамжтайгаар тавих;</p> <p>Хөгжмийн аянд эд юмсын хөдөлгөөнийг биеэрээ болон хэрэгсэл ашиглан дүрслэн тоглох.</p>	<p>Жолооч болж тоглоё</p>

3 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
“Гэр бүлийн гишүүдийн ажил” ярилцлага	Өглөөний хүлээн авалт	Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжлийн тухай ярилцана.	Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжлийн фото зураг.	Асуулт дурдагдаагүй.	Харилцах: Гэр бүлийнхнийхээ ажлын талаар ярилцах, бусадтай харилцахдаа энгийн, яриатай холбогдсон асуулт асуух	Ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, багаж хэрэгслийг ялган таньдаг.
Мэргэжлийг таая	Тойргийн цаг	Дүрд тоглоход хөдөлгөөнийг ажиглан ажил мэргэжлийг таана.	Төрөл бүрийн ажил мэргэжлийн хувцас, багаж.	Асуулт дурдагдаагүй.	Бүтээлчээр сэтгэх: Дүрд орж, үйл хөдлөл хийж үзүүлэх, асуулт асуух	Яагаад?, юу вэ? гэх мэт үгсийг оролцуулан асуулт асуудаг.
Дүрд орж тоглоё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Сэдэвт тоглоомоор (эмч, жолооч, багш) дүрд орж тоглоно.	Сэдэвт тоглоомууд	Хэн хэн ямар дүрд орж тоглохыг чиглүүлнэ.	Бүтээлчээр сэтгэх: Зохиомжлон ярих, үйл явцыг зохион бүтээх Хамтран ажиллах: Хүүхэд дүрд орж тоглох, ээлжлэх, өөрийнхөө үүргийг биелүүлэх	Ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, багаж хэрэгслийг ялган таньдаг. Яагаад?, юу вэ? гэх мэт үгсийг оролцуулан асуулт асуудаг.
“Мэргэжлийг танья” дасгал	Төвийн үйл ажиллагаа	Төрөл бүрийн ажил мэргэжлүүдийн багаж хэрэгслийг танин мэдэх үйл хийнэ.	Дасгал ажлын бэлдэц цаас /цахим холбоос 1/.	Асуулт дурдагдаагүй.	Шүүн тунгаах: зураг юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгох	Ажил мэргэжил, хэрэглэдэг хувцас, багаж хэрэгслийг ялган таньдаг.
Зургийн утгыг ойлгоё	Тойргийн цаг	Зураач А.Заяасайханы “Эх хүн” хөрөг зургаас ажигласан зүйлээ цөөн үг, үйлдлээр илэрхийлнэ.	Зураач А.Заяасайханы “Эх хүн” зураг, жижиг бөмбөг.	- Зурагт юу юу байна вэ? - Зургийг харахад чамд ямар санагдаж байна вэ? (гоё, муухай) - Зурагт хэдэн хүмүүс байна вэ? - Хүүхдүүд юу хийж байна вэ? - Зурагт ямар ямар өнгө байна вэ?	Харилцах: Ажигласан зүйлээ цөөн үгээр эсвэл үйлдлээр тоочиж ярих. Шүүн тунгаах: Зургаас ажигласан зүйлээ нэрлэх.	Уран зургийг ажиглан өөрт төрсөн мэдрэмжээ хэлдэг,

Өнгөөр сэтгэгдлээ илэрхийлье	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд зураг ажиглаж өнгө танина, сэтгэгдлээ будгаар илэрхийлж зураг зурна.	Зураач А.Заяасайханы “Эх хүн” зураг /цахим холбоос 2/, гуаш, бийр, зургийн цаас, нойтон салфетик.	- Зураг дээр хүн байна уу?, Хэдэн хүн байна вэ? - Хүүхэд байна уу? - Ээж юу хийж байна вэ? - Энэ зурагт ямар өнгө харагдаж байна вэ? - Зураг зурдаг хүнийг хэн гэж нэрлэдэг вэ?	Бүтээлчээр сэтгэх: Зургийг ажиглаад өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлэн будаж зурах. Харилцах: Зурсан зүйлээ нэрлэх	Мэдрэмжээ өнгөөр илэрхийлэн зурдаг.
Өнгөт мэдрэмж	Хөгжөөн баясах цаг	Сонгосон өнгийхөө тухай ярилцаж, тухайн өнгө бүхий эд зүйлсийг ангиас олж, байрлуулж тоглоно.	Өнгийн цаас, олбог, тоглоомууд.	- Чи ямар өнгө сонгосон бэ? - Яагаад энэ өнгийг сонгосон бэ? - “Ямар өнгө баяртай санагдуулж байна вэ? - “Ямар өнгө гунигтай вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хурдан хугацаанд ижил өнгийн эд зүйлсийг олж ангилах.	Уран зургийг ажиглан өөрт төрсөн мэдрэмжээ хэлдэг.
Тусч сэтгэлийг ойлгоё	Тойргийн цаг	"Тусч туулай" үлгэрийг сонсож, тусламжийн талаар ярилцах, бусдад туслах, тусламж авах нь хэрэгтэй тухай ярилцана.	"Тусч туулай" богино үлгэр /цахим холбоос 3/, үлгэрийн зураг.	- Хулганад юу тохиолдсон бэ? - Туулай хулганад яагаад тусалсан юм бол?, Хэрэв туулай туслаагүй бол хулгана яах байсан бэ? Та нар юу гэж бодож байна? - Чамд хэн нэгэн туслах үед ямар мэдрэмж төрдөг вэ?	Харилцах: Үлгэр, зохиолын агуулгаас тусламжийн тухай ярилцах, сэтгэл хөдлөлөө ярих, бусдын мэдрэмжийг ажиглах	Тусламж хэрэгтэй байгааг ойлгодог.
“Бусдад тусалъя” дасгал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд тусламж хэрэгтэй хүн, амьтны зургийг туслах үйлдлийн зурагтай нь тааруулан ялгаж холбож сурна.	Тусламжийн хэлбэрийг харуулсан үйлдэлтэй зурагт үзүүлэн /цахим холбоос 4/.	- Энэ зурагт юу харагдаж байна вэ? - Энэ хүн юу хийж байна вэ? - Ам нь цангаж байгаа хүнд бид яаж	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг анзаарч энэрэх үйлдэл үзүүлэх.	Тусламж хэрэгтэй хүнд өөрийн хэмжээнд туслах тухай мэддэг, тусалдаг.

				туслах хэрэгтэй вэ? - Өлсөж буй нохойд бид яаж туслах вэ?	Шүүн тунгаах: зургийг ялган таних, холбох.	
Сэтгэл хөдлөлийн мод	Өглөөний хүлээн авалт	Өглөө ангидаа ирэхдээ сэтгэл хөдлөлийн байдлаа дүрсээр илэрхийлж, модон дээр нааж байрлуулна.	Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн дүрсүүд, модны зураг.	Асуулт дурдагдаагүй.	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийн байдлыг дүрсээр илэрхийлэх, ялган таних. Харилцах: Сэтгэл хөдлөлөө үгээр тайлбарлаж, өөрийгөө илэрхийлэх.	Тусламж хэрэгтэй байгааг ойлгодог.
“Гэр бүл” ярилцлага	Тойргийн цаг	Гэр бүлийн гишүүд, хамгийн бага гишүүний тухай ярилцана.	Гэр бүлийн зураг	- Гэртээ хэн хэнтэйгээ амьдардаг вэ? - Танай гэр бүлийн хэн нь хамгийн том бэ? - Хэн нь хамгийн жижиг вэ? - Жижигхэн дүүтэй юу? - Жижигхэн дүүгийн өмсдөг гутлыг юу гэж нэрлэдэг вэ?	Харилцах: Асуултын дагуу харилцан ярилцах.	Дуулахдаа нэг ба хоёр үетэй үгийг тод, ойлгомжтой хэлдэг.
Хонхт бойтгийн чимээ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд хонхтой бойтгийн тухай видео үзэж, хонхны дуу авиа ялган сонсоно. “Хонхтой бойтог” дууг аялгуулан дуулж, хонх хөгжмөөр хэмнэл даган тоглож, хөдөлгөөнтэй хавсран хөгжимдөнө.	Бойтгийн зурагт үзүүлэн, теле хичээлийн линк /цахим холбоос 5/, эгшигт хонх, хонхт шигшүүр хөгжмийн зэмсэг, дуу, сонсох хөгжмийн бичлэг, ая.	Асуулт дурдагдаагүй.	Бүтээлчээр сэтгэх: Хөгжмийн ая, хэмнэлд тохируулан гарын хөдөлгөөнөөр хэмнэл тоглох Харилцах: Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулах.	Гарын сарвууны өргөх, буулгах, татах, түлхэх хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэдэг. Хэмнэлийг дуурайн тоглодог.
Ажил мэргэжил	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд хөгжимтэй хослуулан эмч, тогооч, гал сөнөөгч, барилгачин зэрэг мэргэжлийн	Хөгжимт тоглоомын ая /цахим холбоос 6/, эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал сөнөөгч гэх мэт	Асуулт дурдагдаагүй.	Бүтээлчээр сэтгэх: Хөгжмийн аянд ажил мэргэжлийн хөдөлгөөнийг (гал сөнөөгч, тогооч гэх мэт) бүтээлчээр, чөлөөтэй	Дуулахдаа нэг ба хоёр үетэй үгийг тод, ойлгомжтой хэлдэг.

		хөдөлгөөнүүдийг дуурайж, мэргэжлийг таньж нэрлэн хөгжилтэйгөөр тоглоно.	мэргэжлийн хүмүүсийн зураг.		дуурайж гүйцэтгэх.	
Мэргэжлийг ажиглая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд сонгосон мэргэжлийн хүний ажиллах орчин, хэрэглэдэг зүйлсийн зургийг төсөөтэйгөөр тааруулж сонгон авч, холбоо үг болон богино өгүүлбэр зохиож ярина.	Эмч, тогооч, цагдаа, гал сөнөөгч, барилгачны зураг, тэдний хэрэглэдэг хэрэглэгдэхүүн, ажлын орчныг харуулсан тараах материал, сагс.	- Чиний сонгосон хүн юу хэрэглэдэг байна вэ? Сайн ажиглаарай. - Чиний сонгосон хүн юу өмсдөг байна вэ? - Чиний сонгосон мэргэжлийн хүн юу хийдэг вэ?.	Харилцах: Өгүүлбэр, холбоо үг зохиож ярих Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгох.	Ажил мэргэжлийн нэр, багаж хэрэгслийг ялгадаг.
Бидний дуртай ажил мэргэжил	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүд мэргэжлийн хүмүүсийн хар цагаан зурагт тохирох хувцас, багажийн зургийг сонгон нааж, будах замаар "өмсгөж", мэргэжлийн нэр болон холбоо үг, өгүүлбэр хэлж ярилцана.	Эмч, тогооч, цагдаа, гал сөнөөгч, барилгачны хар цагаан бэлдэц зураг, багаж хэрэгсэл, хувцасны зураг, цавуу, будгийн харандаа.	- Хэрэв чи барилгачин /малын эмч, гал сөнөөгч/ байсан бол юу өмсөх байсан бэ? - Хэрэв чи барилгачин /малын эмч, гал сөнөөгч/ бол юу хэрэглэх вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хувцсыг зурах, будах, наах байдлаар дүрслэх. Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Гэр бүлийн гишүүдийн ажил, хэрэглэдэг хувцас, багаж хэрэгслийг ялган таних.	Ажил мэргэжлийн нэр, багаж хэрэгслийг ялгадаг.
Ажил мэргэжлийн тухай ярилцъя	Номын цаг	Ажил мэргэжлийн тухай ном үзэж, ярилцана.	"Ажил мэргэжил" ном	Асуулт дурдагдаагүй.	Суралцахууд суралцах: Бусдын яриаг анхааралтай сонсох, зургийг ажиглах.	Ажил мэргэжлийн нэр, багаж хэрэгслийг ялгадаг.
Өнгийг нэрлээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд мэргэжлийн хүмүүсийн зураг, эд зүйлийг ажиглан өнгийг нэрлэж, ижил өнгийн зураг, тоглоом, бодит зүйлсийг улаан, шар өнгөөр ялган сонгож байрлуулна.	Эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал сөнөөгч мэргэжлийн хүмүүсийн зураг, багаж хэрэгслийн зураг, бодит тоглоом, улаан, шар өнгийн дүрс бүхий тараах материал, сонин, поднос.	Аль нь хар, улаан өнгө вэ?	Харилцах: Эд зүйлсийн өнгө, хэмжээ, байрлалыг мэдэх Шүүн тунгаах: Тоглоомыг ялган таних, ангилах. Бүтээлчээр сэтгэх: Дугуй дүрсүүдийг ашиглан машин бүтээх.	Эд зүйлсийн өнгө, хэмжээ, байрлал заасан үгийг ойлгож, яриандаа хэрэглэдэг.
Хамтдаа ярилцъя	Хөгжөөн баясах цаг	Зурагт картыг зөв байрлуулж, гэр бүлд нь	Эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал	- Эмч байна уу? - Эмч ирэх үү?	Хамтран ажиллах: Дүрд ээлжлэн тоглох, хамтран	Эд зүйлсийн өнгө, хэмжээ, байрлал

		тухайн мэргэжилтэй хүн байдаг талаар ярилцана. Хамтран тоглоно.	сөнөөгч мэргэжлийн хүмүүсийн зураг, багаж хэрэгслийн зураг.		тоглох.	заасан үгийг ойлгож, яриандаа хэрэглэдэг.
Жолоочийн машиныг чимье	Төвийн үйл ажиллагаа	Машины дугуйг нааж, чимэглэж, тоолно.	Машины дүрстэй карт, 5 ширхэг дугуй дүрс, цавуу, цаас.	- Чиний машинд хэдэн дугуй байна? - Ямар өнгөтэй дугуйнууд байна вэ? - Доор байна уу?, дээр байна уу?	Суралцахууд суралцах: Юмсыг тоолох. Бүтээлчээр сэтгэх: Дугуй нааж, чимэглэх.	5 хүртэлх тооны тоглоом, юмсыг тоолдог.
Би жолооч	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цагдаа, жолоочийн дүрд тоглох, урт олсоор шулуун, муруй, тойрог хэлбэрийн зам үүсгэж, цагариг барьж алхаж гүйнэ.	Урт олс, хүүхэд бүрд өнгийн жижиг цагариг, хөгжмийн ая, замын хөдөлгөөний тэмдэг дүрсэлсэн зурган карт, жижиг сандал (10 ширхэг), 5 янзын машины ижил зургууд, цаасан (скоч),	- Ямар ямар машин байдаг вэ? - Ямар ямар өнгөтэй байдаг вэ? - Чи ямар өнгөтэй цагариг авсан байна? - Ямар өнгийн цагаригт хамгийн олон машин байсан бэ? г.м.	Бүтээлчээр сэтгэх: Олс болон цагариг ашиглан зам, машин зохиомжлох. Харилцах: Дүрд хувирч тоглох, хэрэглэл ашиглан алхах, гүйх. Хамтран ажиллах: Тоглоомын дүрэм баримтлах, алхаж гүйхдээ бие биеэ хүлээж, ээлжлэн гүйцэтгэх.	Алхаж, гүйхдээ бие биедээ зай тавьж хөдөлгөөнөө удирддаг. Хөдөлгөөнт тоглоомыг дүрмийн дагуу тоглодог.
Машинаас болгоомжил	Хөгжөөн баясах цаг	Гэрлэн дохио, замын тэмдэгт тохируулан хөдөлгөөн хийх, машинаас болгоомжлох, бултах тоглоом тоглоно.	Хөнгөн жижиг тоглоомын машин (машины зурагт), уяа	Асуулт дурдагдаагүй.	Суралцахууд суралцах: Хөдөлгөөнт байнаас бултаж аюулгүй байдлаа хангах. Харилцах: Үгэн дохиог таньж мэдэх	Хөдөлгөөнт байнаас бултаж чаддаг. Хөдөлгөөнт тоглоомыг дүрмийн дагуу тоглодог.

3 дугаар сарын I долоо хоног

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЕРТӨНЦӨӨР АЯЛЦГААЯ

Шинэ үг: Багаж, хэрэгсэл - хүмүүс ажил хийхдээ ашигладаг зүйлс, ажил мэргэжил – хүмүүсийн хийж буй хөдөлмөр, дүрэмт хувцас – ажил хийхдээ өмсдөг тусгай хувцас.

Үйл ажиллагаа 1. “Гэр бүлийн гишүүдийн ажил” ярилцлага (Өглөөний хүлээн авалт)

Хэрэглэгдэхүүн: Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжлийн фото зураг.

Аргачлал: Багш хүүхдүүдээс гэр бүлийн фото зургийг авч бэлтгэнэ. Өглөө хамгийн эрт ирсэн хүүхдүүдээр тухайн зураг дээр тайлбар хийлгүүлэн, харилцан ярилцана. Хүүхэд “Миний ээж тогооч. Тэр гал тогоонд ажилладаг.” гэх мэт 1-2 өгүүлбэр хэлж ээлжилж ярилцана.

Үйл ажиллагаа 2. Мэргэжлийг таая (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн ажил мэргэжлийн хувцас, багаж.

Аргачлал: Өөр өөр мэргэжлийн хувцас, хэрэгслийг ашиглан багш, эсвэл хүүхэд дүрд тоглоно. Багш төрөл бүрийн ажил мэргэжилтэй хүмүүсийн ашигладаг багаж, хэрэгсэл, хувцсыг бэлтгэсэн байна. Хүүхдүүд болон багш өөрсдийн сонголтоор 1, 1 эд зүйл сонгон авна. Тойрог болон сууж багш өөрийн сонгосон зүйлээрээ үйл хөдлөл хийж үзүүлэхэд хүүхдүүд тухайн хөдөлгөөнийг ажиглаад, таах ба “..... тэгж байна” гэж хариулна. Жишээ нь: “Жолооч машин жолоодож байна” гэх мэт. Хүүхэд бүр өөр өөрсдийн авсан зүйлдээ тулгуурлан ээлжлэн дүрд орж, хөдөлгөөн хийж үзүүлнэ. (Багш өөрийн бүлгийн нөөц хэрэглэгдэхүүнд тулгуурлах ба нэмэлтээр хэрэглэгдэхүүн хийж болно.)

Үйл ажиллагаа 3. Дүрд орж тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Сэдэвт тоглоомууд.

Аргачлал: Багш хүүхдүүдтэй ажил мэргэжлийн талаар харилцан ярилцсаны дараа 3 төрлийн сэдэвт тоглоомоос сонгуулж, тоглуулна. Жишээ нь: Багш, эмч, жолооч гэх мэт. (Амьдарч буй газар, орон нутгийн онцлогоос шалтгаалан сэдэвт тоглоомыг өөрчлөн тоглуулж болно.)

Сэдэвт тоглоомын орчин бүрдүүлж, бэлтгэсэн байна. Хүүхдүүд өөрсдийн сонгосон тоглоомын хэсэгт очсоны дараа хэн хэн ямар дүрд орж тоглохоо сонгоход нь багш чиглүүлэг өгнө. Жишээ нь:

- “Эмч” тоглоомд хэн эмч болох, хэн үйлчлүүлэгч болох;
- “Жолооч” болж тоглоход хэн жолооч болох, хэн хэн зорчигч болох;
- “Багш” болж тоглоход хэн багш болох, хэн хэн сурагч болохыг тус тус чиглүүлнэ. (Хүүхдүүд дүрийн хувцас, хэрэглэгдэхүүнийг булаацалдахаас сэргийлж нөөц материалтай байна.)

Хүүхдүүд өөрсдийн өмнөх туршлагад тулгуурлан тоглож байх явцдаа зохиомжлон ярьж буй яриа, тоглож буй үйл явцыг багш тэмдэглэн авч, зохиол болгоно. Хүүхдийн зохион ярьж, тоглож буй байдалд чиглүүлэг өгч, дэмжихээс гадна тоглоомын явцад ээлжилж тоглуулна.

Үйл ажиллагаа 4. “Мэргэжлийг танья” дасгал (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дасгал ажлын бэлдэц цаас /цахим холбоос 1/.

Аргачлал: Хүүхдүүд төрөл бүрийн ажил мэргэжлийн зургаас 1 зураг сонгоно. Сонгосон зургийн ард талын дөрвөлжин нүдэнд хайчилж бэлтгэсэн зургуудаас холбогдох багаж хэрэгслийг нь олж байрлуулан тоглоно. Түрүүлж хийж дууссан хүүхдүүд өөр зургаас сонгон тоглож болно.

ЗУРГИЙГ АЖИГЛАЯ, БҮТЭЭЦГЭЭ

Шинэ үг: Хөрөг зураг – Хүний зурмал зураг, зураач – зураг зурдаг хүн, өнгө – юмсын харагдах байдал (улаан, шар, ногоон гэх мэт).

Үйл ажиллагаа 1. Зургийн утгыг ойлгоё (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зураач А.Заяасайханы “Эх хүн” зураг, жижиг бөмбөг.

Аргачлал: Хүүхдүүд зураач А.Заяасайханы “Эх хүн” хөрөг зургийг хэсэг хугацаанд сайтар ажигласан байна. Багш хүүхдүүдтэй бөмбөг дамжуулж тоглоно. Бөмбөг очсон хүүхэд зургаас өөрийн ажигласан зүйлээ цөөн үгээр тоочиж ярина, үйлдлээр илэрхийлнэ. Зургийн аль нэг хэсэг байж болно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зурагт юу юу байна вэ?
- Зургийг харахад чамд ямар санагдаж байна вэ? (гоё, муухай)
- Зурагт хэдэн хүмүүс байна вэ?
- Хүүхдүүд юу хийж байна вэ?
- Зурагт ямар ямар өнгө байна вэ? гэх мэт.

Үйл ажиллагаа 2. Өнгөөр сэтгэгдлээ илэрхийлье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зураач А.Заяасайханы “Эх хүн” зураг /цахим холбоос 2/, гуаш, бийр, зургийн цаас, нойтон салфетик.

Аргачлал: Багш зураач А.Заяасайханы “Эх хүн” зургийг дахин харуулж, ажиглуулан ярилцана.

Чиглүүлэх асуулт:

- Зураг дээр хүн байна уу?
- Хэдэн хүн байна вэ?
- Хүүхэд байна уу?
- Ээж юу хийж байна вэ?
- Энэ зурагт ямар өнгө харагдаж байна вэ? (улаан, шар, цэнхэр гэх мэт)
- Зураг зурдаг хүнийг хэн гэж нэрлэдэг вэ? гэх мэт.

Асуултын дагуу ярилцсаны дараа багш жижиг өнгийн картуудыг харуулж:

- Энэ ямар өнгө вэ? (Улаан)
- Зураг дээр улаан өнгө хаана байна вэ? (хүүхдээр заалгуулна)
- Хэн надтай цэнхэр өнгө хайж олох вэ? гэх мэт.

Хүүхдүүд зургийг хараад өөрт төрсөн сэтгэгдлээ будгаар, өнгөөр илэрхийлэн будаж тоглоно. Хүүхдүүд зураг дээрээс харсан өнгийг өөрийн зурагт ашиглана.

Багш хэлнэ:

- Чи ямар өнгө ашиглах вэ?, Энэ ямар өнгө вэ?, Чи хүн зурмаар байна уу? Эсвэл өнгөөр будмаар байна уу? гэх мэт.

Хүүхдүүд зураг зурах нь зурж, зөвхөн будах нь будаж зургаа нэрлэж ярилцана. Энд хүн зурсан, энэ улаан өнгө, ээж, хүүхэд гэх мэт.

Багш нэмэлтээр асуулт асууна. Жишээ нь: Энэ юу вэ?, Чи ямар өнгө хэрэглэсэн бэ?, Энэ том хүн үү? Хүүхэд үү? гэх мэт.

Үйл ажиллагаа 3. Өнгөт мэдрэмж (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас, олбог, тоглоомууд.

Аргачлал: Багш хүүхдүүдтэй тойрог болон олбог дээр сууж, голд нь төрөл бүрийн өнгийн цааснууд тараан байрлуулсан байна. Хүүхдүүдээс 1, 1 өнгийн цаас сонгуулж, харилцан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи ямар өнгө сонгосон бэ?
- Яагаад энэ өнгийг сонгосон бэ?
- “Ямар өнгө баяртай санагдуулж байна вэ?”
- “Ямар өнгө гунигтай вэ? гэх мэт асууна.

Хүүхэд өнгө сонгож “Би шар өнгө сонгосон. Надад нар шиг гоё санагддаг” гэх мэтээр илэрхийлнэ. Дараа нь өөрсдийн сонгосон өнгө бүхий тоглоом, эд зүйлсийг багшийн заасан хугацаанд ангиас олж, өөрийн сууж байсан олбог дээр авч ирж байрлуулна. Хамгийн хурдан, хамгийн олон эд зүйл олохыг эрмэлзэж тоглоно.

ТУСЧ СЭТГЭЛТЭЙ БАЙЯ

Шинэ үг: Тусч – Бусдад тусалдаг, сайхан зан чанар, сэтгэл хөдлөл – баярлах, гуних, уурлах зэрэг мэдрэмж, энэрэнгүй – бусдад хайр, халамжтай ханддаг зан чанар.

Үйл ажиллагаа 1. Тусч сэтгэлийг ойлгоё (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: “Тусч туулай” богино үлгэр /цахим холбоос 3/, үлгэрийн зураг.

Аргачлал: “Тусч туулай” богино үлгэрийг уншиж өгч, ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хулганад юу тохиолдсон бэ?
- Туулай хулганад яагаад тусалсан юм бол?
- Хэрэв туулай туслаагүй бол хулгана яах байсан бэ? Та нар юу гэж бодож байна?
- Чамд хэн нэгэн туслах үед ямар мэдрэмж төрдөг вэ?

Үйл ажиллагаа 2. “Бусдад тусалъя” дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Тусламжийн хэлбэрийг харуулсан үйлдэлтэй зурагт үзүүлэнгүүд /цахим холбоос 4/.

Аргачлал: Хүүхдүүд 2 эгнээ болон өөд өөдөөсөө харан сууна. Нэг талд суусан хүүхдүүдийн өмнө тусламж хэрэгтэй байгаа амьтан хүмүүсийн зураг, нөгөө талд сууж байгаа хүүхдүүдийн өмнө тусламжийн хэлбэрийг харуулсан зургууд байна.

Багшийн чиглүүлэх асуулт:

1. Энэ зурагт юу харагдаж байна вэ?
2. Энэ хүн юу хийж байна вэ?
3. Ам нь цангаж байгаа хүнд бид яаж туслах хэрэгтэй вэ?
4. Өлсөж буй нохойд бид яаж туслах вэ? гэсэн ялган таних асуултууд тавина.

Зургийг үзүүлээд тусламж хэрэгтэй байгаа хүн, амьтан болон тусламжийн хэлбэрийг хооронд нь ялган нийлүүлж тавихыг хүүхдүүдээс хүснэ. Хүүхэд асуултад хариулж зургийг ялгах оролдлого хийнэ.

Үйл ажиллагаа 3. Сэтгэл хөдлөлийн мод (Өглөөний хүлээн авалт)

Хэрэглэгдэхүүн: Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн дүрсүүд, модны зураг.

Аргачлал: Хүүхдүүд өглөө ангидаа ирэхдээ өөрсдийн сэтгэлээ илэрхийлсэн дүрсийг (инээмсэглэл, гуниг, уур гэх мэт) модон дээр нааж, “Би өнөөдөр баяртай байна, яагаад гэвэл ээж минь намайг хүргэж ирсэн.” гэх мэтээр хэлнэ.

ХОНХТОЙ БОЙТОГ

Шинэ үг: Бойтог – Нялх балчир хүүхдийн өмсөх зөөлөн гутал, оймсон гутал, хонх – дуугардаг жижиг төмөр зүйл, эгшиг – хөгжим, хонх зэрэг зүйлээс гарах дуу чимээ.

Үйл ажиллагаа 1. “Гэр бүл” ярилцлага (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Гэр бүлийн зураг

Аргачлал: Гэр бүлийн зургийг ашиглан, асуултын дагуу харилцан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Гэртээ хэн хэнтэйгээ амьдардаг вэ?
- Танай гэр бүлийн хэн нь хамгийн том бэ?
- Хэн нь хамгийн жижиг вэ?
- Жижигхэн дүүтэй юу? гэх асуултаар гэр бүлийн хамгийн бага гишүүний талаар ярилцана.
- Жижигхэн дүүгийн өмсдөг гутлыг юу гэж нэрлэдэг вэ? гэх мэт.

Үйл ажиллагаа 2. Хонхт бойтгийн чимээ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Бойтгийн зурагт үзүүлэн, теле хичээлийн линк /цахим холбоос 5/, эгшигт хонх, хонхт шигшүүр хөгжмийн зэмсэг, дуу, сонсох хөгжмийн бичлэг, ая.

Аргачлал:

1. Багшийн чиглүүлэг:

- Эгшигт хонх болон бойтгийн хонхны дуу чимээг ээлжлэн дуугаргана.
- Дунд бүлгийн хөгжмийн теле хичээлийн хэсгээс үзүүлнэ. /цахим холбоос 5/.
- Хонхтой бойтгийн талаар тайлбарлаж гэр бүлийн хамгийн бага гишүүн өмсдөг. Хөлд ороод алхаж сурахад бойтгийн хонх дуугарч аав, ээж, ах, эгчид нь чимээ өгөх үүрэгтэй байдаг талаар ярилцана.

2. Дагаад дуулаарай

Д.Хоролсүрэнгийн үг, ая “Хонхтой бойтог” дууны 1 дүгээр бадгийг дуулж үзүүлээд шүлгийг мөр мөрөөр нь 2-3 удаа дагуулан хэлнэ.

3. Дуулаад хөгжимдөөрэй

- Хонхт шигшүүр хөгжмийг зөв барих, дуугаргах аргыг биеэр үзүүлнэ.
- Дууны үгийг хэлэнгээ хөгжмийн зэмсгээ хэмнэлийн дагуу дуугаргаж дагуулан хийнэ.
Хонхтой бойтог – гэхэд баруун хөлөө урагш өсгийгөөр нь тавина.
Жин жин жин – гэхэд хоёр гараа тохойгоор нугалан дээш өргөн хонхт хөгжмөө сэгсрэн дуугаргана.
Хойно нь дуугарлаа – гэхэд баруун хөлөө хойш нь өлмийгөөр нь тавина.
Жин жин жин – гэхэд хонхт хөгжмөө сэгсрэн дуугаргана.
Хоёр хоёроороо – гэхэд баруун зүүн тийш биеэр ганхана.
Жин жин жин – хөгжмөө сэгсрэн дуугаргана.
Хоршин дуугаргая – гэхэд хажуудах найз руугаа биеэ эргүүлэн харна.
Жин жин жин – гэхэд өөд өөдөөсөө харж хамтдаа хонхт хөгжмөө сэгсрэн дуугаргана.

Дуулж байх үедээ хөгжим тоглох болон хөгжимт хөдөлгөөн хийхэд хүүхдээс олон чадвар шаарддаг тул 2-3 удаа дагуулан дуулна.

Үйл ажиллагаа 3. Ажил мэргэжил (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжимт тоглоомын ая /цахим холбоос 6/, эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал сөнөөгч гэх мэт мэргэжлийн хүмүүсийн зураг.

Аргачлал: Хөгжмийн аянд ажил мэргэжлийн хөдөлгөөн хийж тоглоно.

- Хөгжим эгшиглэхэд хүүхдүүд хөдөлгөөнөө өөрсдөө сонгож чөлөөтэй бүжиглэнэ.
- Хөгжим түр зогсоход багш нэг мэргэжлийн зургийг зааж, тухайн мэргэжлийн нэрийг хэлэхэд ямар хөдөлгөөн хийж болохыг урьдчилан хийлгэж үзнэ. Жишээ нь: Одоо бүгдээрээ гал сөнөөгчийн хөдөлгөөнөөр хөдөлцгөөе, одоо барилгачид шиг алхъя, тогооч шиг хутгаж үзье, эмч шиг чагнуур барьсан хөдөлгөөн хийе, цагдаа шиг гүйе гэх мэт.
- Хөгжим дахин эгшиглэхэд хүүхдүүд тэр мэргэжлийн хөдөлгөөнөө хөгжимтэй хослуулан хийнэ. Хүүхдүүд чөлөөтэй, бүтээлч байдлаар өөрийн сэтгэж буй хөдөлгөөнийг хийнэ.
- Хөгжим дахин зогсоход багш дараагийн мэргэжлийг хэлнэ. Тогооч → Гал сөнөөгч → Барилгачин → Эмч → Цагдаа гэх мэт. Хүүхэд бүр бүтээлчээр оролцож өөр мэргэжлийн хөдөлгөөнийг ч хийж болно.

Тоглоом 4–5 давталтаар үргэлжилнэ. Эцэст нь хүүхдүүд дуртай хөдөлгөөнөө өөрсдөө сонгон гүйцэтгэж, хийж буй хөдөлгөөнөө ямар мэргэжлийн хөдөлгөөн болохыг бусдадаа таалгаж болно.

3 дугаар сарын II долоо хоног

СОНИРХОЛТОЙ МЭРГЭЖИЛТЭЙ ТАНИЛЦЪЯ

Шинэ үг: Мэргэжил, эмч, тогооч, гал сөнөөгч, цагдаа, барилгачин зэрэг ажил мэргэжлийн нэрс.

Үйл ажиллагаа 1. Мэргэжлийг ажиглая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Эмч, тогооч, цагдаа, гал сөнөөгч, барилгачны зураг, тэдний хэрэглэдэг хэрэглэгдэхүүн, ажлын орчныг харуулсан тараах материал, сагс.

Аргачлал: Хүүхдүүд ажил мэргэжлийн орчин, хэрэглэдэг багаж хэрэгсэл, эд зүйлсийн зургийг тус бүрд нь хийсэн 2 сагснаас сонгож, өгүүлбэр зохиож ярина. Хүүхдүүд өөрсдийн сонголтоор зургийг олж авна.

Багшийн чиглүүлэг: Энд байгаа сагснудад та нарын сонгосон мэргэжлийн хүмүүсийн хэрэглэдэг зүйлс, ажилладаг орчны зураг байгаа. Өөрийн сонгосон мэргэжлийн хүний хэрэглэдэг зүйлс болон ажилладаг газрыг олж аваарай.

- Одоо холбоо үг зохиоё. Дагаад хэлээрэй: “Эмчийн чагнуур”, “Барилгачны малгай” гэх мэт.
- Одоо өгүүлбэр зохиоё.
 - o Чиний сонгосон хүн юу хэрэглэдэг байна вэ? Сайн ажиглаарай.
 - o Чиний сонгосон хүн юу өмсдөг байна вэ?
 - o Чиний сонгосон мэргэжлийн хүн юу хийдэг вэ?.

Үйл ажиллагаа 2. Бидний дуртай ажил мэргэжил (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Эмч, тогооч, цагдаа, гал сөнөөгч, барилгачны хар цагаан бэлдэц зураг, багаж хэрэгсэл, хувцасны зураг, цавуу, будгийн харандаа.

Аргачлал: Хүүхдүүд мэргэжлийн хүмүүст тус бүрийнх нь хувцсыг өмсүүлнэ. Багш урьдчилан мэргэжлийн хүмүүсийн хар цагаан зураг болон өмсгөх хувцаснуудын зургийг бэлтгэнэ. Жишээ нь: эмчийн халаад, барилгачны малгай, гал сөнөөгчийн малгай, барилгын ажилчны хантааз, эмчийн чагнуур гэх мэт.

Хүүхэд хувцсаа өмсгөж байхад нь багш тухайн мэргэжлийн нэрийг давтан хэлүүлнэ. Мөн өөрийг нь болон гэр бүлийнх нь гишүүнийг тухайн мэргэжилтэн байдлаар төсөөлүүлж:

- Би барилгачин /гал сөнөөгч, малын эмч/
- Миний ажлын малгай /ажлын дуулга, эмчийн халаад/
- “Би барилга барьдаг.”, “Би амьтан эмчилдэг.”, “Миний аав гал унтраадаг.” гэх мэтээр холбоо үг, өгүүлбэр зохиож ярилцана.
- Та “Хэрэв чи барилгачин /малын эмч, гал сөнөөгч/ байсан бол юу өмсөх байсан бэ?”, эсвэл “Хэрэв чи барилгачин /малын эмч, гал сөнөөгч/ бол юу хэрэглэх вэ? гэж асууж ярилцана.
- Дээрх мэргэжлийн хүмүүсийн хувцсыг зурах, будах, наах байдлаар хувцаслаж болно.

Үйл ажиллагаа 3. Ажил мэргэжлийн тухай ярилцъя (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Ажил мэргэжил” ном

Аргачлал: Ажил мэргэжилтэй холбоотой хүүхдийн ном, зохиол уншиж өгнө. Жишээ нь: *Хараад давтаж хэл:* “Ажил мэргэжил” номын зургийн дагуу багаж хэрэгсэл, ажил мэргэжлийн нэр, хийж буй үйл явц гэх мэтийг ярилцаж болно.

ӨНГӨ БА МЭРГЭЖИЛ

Шинэ үг: Дөрвөлжин – дөрвөн талтай дүрс, дугуй – тойрог хэлбэртэй дүрс.

Үйл ажиллагаа 1. Өнгийг нэрлээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал сөнөөгч мэргэжлийн хүмүүсийн зураг, багаж хэрэгслийн зураг, бодит тоглоом, улаан, шар өнгийн дүрс бүхий тараах материал, сонин, поднос.

Аргачлал: Зургийг ажиглаж ижил өнгийн эд зүйлийн зургийг зэрэгцүүлэн өрнө. Хүүхдүүд өөрийн сонгосон мэргэжлийн хүмүүсийн эд зүйлсийн зургийг нэрлэнэ. Холбоо үг зохиож багш үзүүлнэ.

Багшийн чиглүүлэг: Дагаад хэлээрэй: “Хар чагнуур”, “Улаан машин”, “Цагаан малгай” гэх мэт.

Хар өнгө гэхэд хар өнгийн зурагт картыг өргөцгөөе. Улаан өнгө гэхэд улаан өнгийн зурагт картыг өргөцгөөе. Улаан өнгө гэж хэлэхэд хүүхдүүд улаан өнгийн дүрсийг сонгон авна. Улаан өнгөтэй тоглоом гэж хэлэхэд хүүхдүүд төвд улаан өнгийн тоглоом авч ирнэ. Шар

өнгө гэж хэлэхэд шар өнгийн тоглоомыг авч ирнэ. Хүүхдүүдийн өмнө 4-5 ширхэг тоглоом, бодит зүйлс өрж тоглоно. Хүүхдүүд поднос, сонин зэрэг зүйл дээр улаан, шар өнгийн бодит зүйлийг ялгаж байрлуулна.

Дэмжлэг үзүүлэх: Багш өнгийг сольж нэрлэх, тухайн өнгийн эд зүйлийг авчирч чадахгүй байгаа хүүхдэд өнгийн дүрс өгч ажиглуулах, хамт хайх зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Хамтдаа ярилцъя (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Эмч, тогооч, цагдаа, барилгачин, гал сөнөөгч мэргэжлийн хүмүүсийн зураг, багаж хэрэгслийн зураг.

Аргачлал: Зурагт картыг ажиглаж, тохирох мэргэжлийн хүмүүсийн царай бүхий өнгийн цаас дээр байрлуулна. Зөв байрлуулсны дараа гэрт нь энэ ажлыг хийдэг хүн байгаа эсэх талаар ярилцана. Байрлуулсан зургаас хүүхдүүд сонгож авч би эмч, би цагдаа, би тогооч зэргээр хэлнэ. Багш, хүүхдүүд бүгд тойрог болж сууна. Багш “Толгой өвдлөө” гэж хэлээд бүгд гараа толгой дээрээ барьж сууна. Эмч байна уу?, Эмч ирэх үү? гэж асуухад эмч болсон хүүхэд бүх хүүхдийн толгойг илнэ. Энэ мэтээр багш хүүхдүүд ээлжлэн тоглоно.

Үйл ажиллагаа 3. Жолоочийн машиныг чимье (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Машины дүрстэй карт, 5 ширхэг дугуй дүрс, цавуу, цаас.

Аргачлал: Хүүхдүүд машиндаа дугуй нааж тоолно (1–4 ширхэг).

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чиний машинд хэдэн дугуй байна?
- Ямар өнгөтэй дугуйнууд байна вэ?
- Доор байна уу?, дээр байна уу? гэх мэт.

ЖОЛООЧ БОЛЖ ТОГЛОЁ

Шинэ үг: Гүнзгий амьсгал – удаан амьсгал авч гаргах, агаарыг уушгиар татаж авах буцааж гаргах, жолооч – машин жолооддог хүн, зорчигч – машиныг жолоодож байгаа хүнээс өөр хүн, машинд суудаг хүн.

Үйл ажиллагаа 1. Би жолооч (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Урт олс, хүүхэд бүрд өнгийн жижиг цагариг.

Аргачлал:

1. Багш цагдаагийн малгай, замын цагдаагийн дохиур барина. Би хэнтэй адилхан байна вэ? гэж асууна. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж болох уу? Өнөөдөр замын цагдаа багштайгаа хамт дүрмээ баримталж тоглоно.

Хүүхдүүд тойргоор алхаж буланд байрлуулсан өнгийн цагаригаас нэг нэгийг сонгож аваад зогсоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар ямар машин байдаг вэ?
- Ямар ямар өнгөтэй байдаг вэ?
- Чи ямар өнгөтэй цагариг авсан байна?, Шар өнгийн цагариг авсан бол шар өнгөтэй машинтай шүү.
- Одоо бүгдээрээ машинтай боллоо.
- Замаа засъя. Хүүхдүүд хамтдаа урт олсоор шулуун, муруй, тойрог хэлбэрүүд үүсгэж газар байрлуулна.

Зассан зам дээрээ “ЖОЛООЧ” болж удаан, хурдан хэмнэл болон чиглэлээ өөрчилж алхана, гүйнэ. Алхалт гүйлтийн янз бүрийн хувилбарыг ашиглан гүйцэтгэнэ.

Тоглоомын дүрэм:

Хүүхэд урдаа барьж байгаа цагаригаар бие биеэ цохих, шүргэх, савах хөдөлгөөн хийж болохгүйг анхааруулна.

Алхаж гүйхдээ бие биеэ хүлээн зогсож байгаад урдуураа гарган араас нь гүйцэтгэнэ.

Тоглоомын дараа цагариг, олсыг багшийн заавраар байранд нь хурааж тавина.

2. Хөгжилтэй жолооч

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн ая, жижиг цагариг, замын хөдөлгөөний тэмдэг дүрсэлсэн зурган карт.

Аргачлал: Хүүхдүүд тойргоор (хосоор, шатарчилж) зогсоно.

Цагдаа багш замын хөдөлгөөний тэмдэг ашиглан удирдан чиглүүлнэ.

- Ногоон гэрлийн зурган карт үзүүлбэл – доороо хурдан алхана.
- Шар гэрэл – гараа алдлан зогсоно.
- Улаан гэрэл – газар тулж сууна.
- “Зогс” гэж хэлэхэд – гараа урагш өргөн хөлөө нийлүүлэн зогсоно.
- Зам чөлөөтэй – байрандаа хөнгөн гүйнэ.
- Бартаатай зам – гараа ташаандаа авч хөнгөн үсэрнэ.
- Хүүхдүүд газар сууж, духан дээрээ гарын сарвууг давхарлан тавина.
 - o машин асаалаа – гүнзгий амьсгал авна.
 - o машин зогслоо – амьсгалаа гаргана гэх мэт хөгжилтэй байдлаар удирдана.

Хүүхдүүд гэрлэн дохио болон багшийн үгэн дохиог таньж мэддэг болсон бол хөгжмийн аянд зохиомжит дасгал хэлбэрээр гүйцэтгэнэ.

3. Жолооч ба зорчигч

Хэрэглэгдэхүүн: Жижиг сандал (10 ширхэг)

Аргачлал: Жижиг сандлыг 2 эгнээгээр зэрэгцүүлэн тавина. Нэг хүүхэд жолооч, бусад хүүхдүүд 2 цуваанд зорчигч болох ба 5 хүүхэд нь сандал дээр сууна.

Жолооч “Машин эргэлээ” гэхэд сандал дээр сууж байгаа 5 хүүхэд зэрэг баруун талын сандал руу эргэж тулаад байраа сольж сууна. Дахин “Машин эргэлээ” гэхэд 1 хүүхэд сууж хамтдаа зэрэг эргэнэ. Энэ мэтчилэн хүүхдүүд зэрэг байраа сольж сууна.

4. Машин цуглуулъя

Хэрэглэгдэхүүн: 5 янзын машины ижил зургуудыг цаасан (скоч) дээр өндөрт нааж байрлуулах, өнгийн цагаригууд.

Аргачлал: Ангийн нэг талд машины зургуудыг хүүхдийн цээжний өндөрт болон гараа дээш өргөхөд хүрэхээр хэт өндөр биш түвшинд тогтооно. Хүүхдүүд 2 цуваагаар алхах, зөөлөн гүйх, жижиг үсрэлтээр үсрэх зэрэг энгийн хөдөлгөөнөөр ээлжлэн явж, машин болгон дээр очиж 1 зураг авч ирнэ. Авч ирсэн зургаа гарааны цэгт газарт байрлуулсан өнгийн цагариг дотор өнгийг тохируулан тавина. Машины зургуудаа байрлуулсан хүүхдүүдэд “машин тээвэрлэсэн” гэж ойлгуулна. Бүх хүүхэд 1–2 удаа дараалан оролцоно. Дараа нь хүүхдүүдтэй ярилцана.

- Ямар өнгийн цагаригт хамгийн олон машин байсан бэ?
- Ямар өнгийн цагаригт харин цөөхөн машин байсан бэ?
- Ямар өнгийн машин 5 ширхэг байна вэ?
- Хамтдаа цагариг бүрд байрлуулсан машиныг тоолж үзье гэж хамтдаа тоолж, өнгийг нэрлэнэ.

Тайвшруулах дасгал:

Босоо байрлалд амьсгалын дасгал, өлмий дээрээ гараа өргөж тэнцвэрээ хадгалан зогсоно.

Үйл ажиллагаа 2. Машинаас болгоомжил (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөнгөн жижиг тоглоомын машин (машины зурагт үзүүлэн)-ыг уяанд уяж өндрөөс унжуулна. Тоглоомын машинд хүүхдийн толгой, нүүр цохигдохоос сэргийлж, аюулгүй байдалд анхаарна.

Аргачлал: Багш тоглоомыг зөөлөн савлах үед машинд хүрэхгүй хэрхэн яаж алхах, гүйх боломжтойг тайлбарлаж биечлэн үзүүлнэ:

- Хүүхдүүд цуваагаар зогсож нэг нэгээр гүйцэтгэнэ.
- Хүүхэд тоглоомд хүрэхгүйгээр хөдөлгөөнтэй байнаас бултаж алхаж, гүйж гарна.
- Ширээн дээр байрлуулсан замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээний дагуу давхцуулан тоглоно.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа



- Зурагт карт, товчлуур дарахад дуу гардаг самбар, дуу авиатай ном зэрэг мультимедиа хэрэглэгдэхүүн ашиглана.
- Үг, өгүүлбэрийг дагуулан хэлүүлэх, давтан хэлүүлэх, үйлдлийг дүрсэлсэн зурган зааварчилгаа, биеийн хөдөлгөөнөөр үзүүлэх, олон дахин давтах, бодит зүйлсээр харьцуулж ойлгуулах зэрэг аргыг хослуулна.
- Сэтгэл хөдлөлөө үгээр болон хөдөлгөөнөөр илэрхийлэхийг урамшуулж, ахиц гарвал магтаж, урам өгч өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд туслахдаа хамтран тоглох хүүхдийг оролцуулах гэх мэт.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Айл гэрийн өдөр тутмын энгийн ажлыг хүүхдэд хамтдаа хийх боломж олгоно (тоглоомоо цэгцлэх, хувцсаа эвхэх, цэцэг услах, хог ангилах гэх мэт).
- Эцэг эх хүүхэдтэйгээ хамтдаа гэртээ жүжигчилсэн тоглоом тоглож, дүрд орж, хөдөлгөөн даган дуурайх боломж олгоно.
- Амралтын өдөр гэр бүлээрээ гадаа гарахдаа навч, чулуу, цэцэг ажиглаж, өнгө, хэлбэрээр нь ярилцана.
- Өдөр бүр хүүхдээсээ “Өнөөдөр юу сурсан бэ?”, “Юу сонирхолтой байсан бэ?” гэж асууж, сонсох дадлыг өөр дээрээ бий болгоно.
- Хүүхдэдээ өдөр бүр богино хугацаанд (5–10 минут) ном уншиж өгнө.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
Амжилттай хэрэгжүүлсэн:
Сул хэрэгжүүлсэн:.....
Цаашид сайжруулах:.....
Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

Цахим холбоос:

№	Цахим холбоос	Код
1	Ажил мэргэжлийн дасгал ажлын зураг https://drive.google.com/file/d/1pC7blslmEdG1QbaM_sZ4CfZP3v5uqE2t/view	
2	Зураач А.Заяасайхан “Эх хүн” зураг https://drive.google.com/file/d/1LcMkeiHvEFOMlG_j49RcwEgQooJsPE-1/view	

3	“Тусч туулай” богино үлгэр https://docs.google.com/document/d/1giGGRvHlbbI_fXcQnZhnLBfJ48hh_Cn-/edit	
4	Тусламжийн хэлбэрийг харуулсан зургууд https://drive.google.com/file/d/1Ev2tpzOaDndwQe8ejxyuVkJ5h5l0qu23/view	
5	Дунд бүлгийн хөгжмийн теле хичээлийн хэсгээс https://econtent.edu.mn/lessons/SUB/dund/hugjim/2380	
6	Хөгжимт тоглоомын ая https://youtu.be/6f15-NUDNVQ?si=qWA2uMp3vsKiTgx-	

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IV САР

БАЙГАЛИА ХАЙРЛАЯ

Хүүхдийн эзэмших чадамж:

Шүүн тунгаах: Хүүхэд орчноо ажиглаж, асуулт тавьж, байгаль дахь өөрчлөлтийг ойлгож, өөрийн бодол, санаагаа илэрхийлнэ.

Нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжил: Хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлж, түүнийг тайвшруулах энгийн аргуудыг хэрэглэж, хамт олонтой эерэг харилцаа тогтоож сурна.

Аюулгүй байдлын зөвлөмж:

Гадаа зугаалгын цагаар цаас, тууз хийсгэх үеэр хүүхдүүд гүйхэд элдэв саадгүй байх, гараараа, хөлөөрөө бөмбөгийг өнхрүүлэх үеэр бие биедээ саад учруулахгүй байх, цэцэг арчлах үйлийг болгоомжтой хийлгэх, хэрэглэгдэхүүн материал нь хүүхдэд тохирсон хэмжээтэй байх зэрэгт анхаарч орчныг бүрдүүлэх

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Ууртай мод, Тэврээд тайвширья үйл ажиллагааны явцад хүүхэд өөрөө амьсгалаа зохицуулж тайвшрахад нь дэмжлэг үзүүлээрэй. Хүүхдийн оролцоог Чи

өөрийгөө тайвшруулж чадлаа, Биеэ дулаацуулаад тайван байж чадлаа, бүгдээрээ шинэ арга туршиж үзлээ гэх мэтээр эерэг үгээр дүгнэж урамшуулаарай.

Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа: Ажигласан модоо зурах, уурыг хэрхэн хөдөлгөөн хийж тайвширч болохыг “Ууртай мод”-оор төлөөлүүлэх, хогоо хогийн саванд хаях зэрэг байгалийг таньж мэдэх замаар байгалиа хайрлах зан үйл төлөвшүүлэхэд голлон анхаарч шаардлагатай чиглүүлэг, тохируулгыг хийгээрэй.

Төвийн үйл ажиллагаа: Бяцхан үрийн нууц, Ургамал ургах дараалал гэсэн хоёр үйл ажиллагааг зохион явуулахдаа “Чи юу ажиглав, энэ мод ямар өнгөтэй байгаасай гэж бодож байна гэх мэтчилэн нээлттэй асуулт тавьж идэвхжүүлж байх. Ургамал ургах дарааллыг зургаар байрлуулахдаа үр, соёо, иш, навчийг нэрлэж, ургамал ургах зүй тогтлыг ойлгуулах, хэсэг бүлгээр ажиллахдаа ээлжээ хүлээх, бие биеэ хүндлэх, нэгэндээ туслах зэрэг үйлийг дэмжин урамшуулаарай.

Зугаалгын цаг: Салхинд цаас сэвэх, туузаа хийсгэх, зөөлөн хүчтэй үлээгээд хөдөлгөөнийг ажиглуулахдаа хүүхдийг чөлөөтэй гүйх, өөрийн санаагаар янз бүрээр туршиж үзэх, санаагаа хэлэх зэрэг үйлийг дэмжээрэй.

Хөгжөөн баясах цаг: Гараа өргөх, буулгах, үлээх, амьсгалын дасгал зэрэг давталттай хөдөлгөөнүүд нь хүүхдийг амархан төвлөрүүлж тайвшруулна. Тиймээс Уурын үүл хөөх, Ус хамгаалагч супер баатрын дүр бүтээх үйл ажиллагаануудыг хөгжилтэй тоглоом, дуу хөгжимтэй хослуулан явуулаарай. Мөн хүүхдийн оролцоог үнэлж урамшуулаарай. Чи үнэхээр супер баатар боллоо, Уурын үүлээ сайн хөөж чадлаа гэх мэт. Хүүхдэд биеэ суллах, инээж баярлах, хөөрөх боломж олгоорой.

Боломжууд: Хүүхдүүд үйл ажиллагаанд оролцох, хамтрах явцад тэдний үг, үйлдлийг ажиглаж, бүтээлч, сонирхолтой байх, шинэ нөхцөл байдал, боломж үүсэхэд багш та шинэ сорилтыг давах, хүүхэд асуудлаа өөрөө шийдвэрлэхэд нь чиглүүлээрэй.

Үйл ажиллагааны 4 сарын төлөвлөлт:

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО2.16. Тасалгааны ургамлын тоосыг арчих, услах үйлд оролцоно. ХЯ2.2а.Энгийн өгүүлбэрээр харилцан ярианд оролцоно. НСХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын холбоо хамаарлыг таньж ойлгодог болно.	<ul style="list-style-type: none"> - Тасалгааны ургамлыг арчлах энгийн хөдөлмөр хийх, оролцох /хатсан навч түүх, цэцэг услах, тэмтэрч мэдрэх, үнэрлэж ялгах мэдрэх боломж олгох - Туршилтын явцад асуулт асуух, асуултад хариулах зэргээр өөрийгөө илэрхийлэн бусадтай харилцан ярилцах, богино үлгэрийн үйл явдлыг тогтоож багштай хамтран харилцан ярих - Юу болох бол? гэсэн энгийн яриа өрнүүлэхэд оролцох 	Ургамал ажиглацгаая
БНО2.1г.Байгалийн үзэгдлийг ялгаж таних, ажиглаж ярилцана. ХЯ2.1а.Бусдын яриаг анхаарч сонсоно, богино үг,өгүүлбэрээр хариулна. НСХ2.3а.Юмс үзэгдлийн хоорондын холбоо хамаарлыг таньж ойлгодог болно. ЗУ2.2в.Бие дааж толбо, дардсаар зурна.	<ul style="list-style-type: none"> - Байгалийн үзэгдлийг таних энгийн туршилт хийх (Салхинд цаас хийсгэж аль нь хол хийсэж байгааг, туузыг хүчтэй, сул үлээхэд хэрхэн хөдөлж байгаа зэргийг ажиглах) - Ойр орчны дуу чимээ, танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсож, дуурайх, үг өгүүлбэрийг давтаж хэлэх, сонссон үгийн утгыг ойлгож хэлэх, таах, үргэлжлүүлэн хэлэх зэрэг тоглоом тоглох - Хэрэв..... бол юу болох вэ? гэх мэт асуулт тавьж ярилцах - Үүссэн модны дүрсний доод хэсгийн хүрэн будгийг хуруугаараа доош зөөлөн сунгаж 	Салхи

	будах, хуруугаараа навчны дүрс дарж үүсгэх	
<p>ХӨГ2.1а.Байгаль эд юмсын дуу чимээг таньж ялгана.</p> <p>ХӨГ2.1б.Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна.</p> <p>ХӨГ2.1в.Жигд хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно.</p> <p>ХӨГ2.1г.Дуу аялгуунд тохирсон хөдөлгөөн хийнэ.</p> <p>НСХ2.3в.Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно</p>	<ul style="list-style-type: none"> - Дууны үгийг анхаарч сонсон утга санааг ойлгох - Үг, аялгууны давталттай богино дууны нэгээс хоёр үетэй үгийг хэлж, дагаж аялах - Дууны хэмнэлд тохируулж биеийн цохилтоор чимээ гаргаж хэмнэл үүсгэж, хамтарч тоглох - Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох 	Цэцэг дэлгэрлээ
<p>НСХ2.1в. Уурлаж тавгүйтсэн шалтгааныг нь асууж ярилцахад тайвширдаг болно.</p> <p>ХЯ2.1а.Бусдын яриаг анхаарч сонсоно, үг өгүүлбэрээр ярина.</p>	<ul style="list-style-type: none"> - Багшийн чиглүүлгээр тайвшруулах болон амьсгалын дасгал хийх - Тоглоом тоглох, дасгалын явцад багшийн үг зааврыг анхааралтай сонсон биелүүлэх, дагаж дуурайж хэлэх 	Өөрийгөө тайвшруулах тоглоомууд
<p>БНО2.2г. Өөрийн тоглоом, эд зүйлсээ зориулалтын дагуу хэрэглэж, ус хэмнэх, хогоо ангилж хаяхдаа бусдын тусламжтай хийнэ.</p> <p>НСХ2.2в.Насанд хүрэгчдийн тусламжтай зан үйлүүдийг тустай, тусгүйгээр ангилдаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Усаа хэмнэх, хогоо хогийн саванд хаях үйлийн ач холбогдлыг ойлгох, ус хэмнэгч, хогоо хогийн саванд хаягч баатрын дүр бүтээж тоглох, ус яагаад хэмнэх хэрэгтэй вэ, хогийг яагаад хогийн саванд хийх хэрэгтэй тухай ярилцах - Хогоо хогийн саванд хаях, ус гоожиж буй дариуд цоргоо хааж сурах зэрэг бусдад болон орчиндоо тустай зан үйлүүдийг ялгаж сурах 	Бидний ногоон дадал
<p>ХЭМ2.1д.Сэдэвт алхалт, гүйлтийг хэрэглэл ашиглан гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ2.1о.Бөмбөгийг 1.5м зайд өшиглөж өнхрүүлнэ.</p> <p>МАТ2.1а. 5 хүртлэх тооны тоглоом, юмсыг тоолох, олон ба цөөн тооны тоглоом, юмсыг зааж хэлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Хөгжимт гимнастик, бие хөгжүүлэх цогц дасгалыг багшийг даган дуурайж гүйцэтгэх, давтах (4-5 найман тоот) - Өшиглөж өнхрүүлж тоглохдоо орон зайгаа мэдэрч бие даан гүйцэтгэх - Гараар болон хөлөөрөө өшиглөж оруулсан бөмбөгөө нэг тоогоор нэрлэж тоолох 	Бие хөгжүүлэх тоглоом, дасгалууд

4 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Ургамал ажиглацгаая (Бяцхан үрийн нууц, ургамал ургах дараалал, цэцэг арчилъя).	Төвийн үйл ажиллагаа, Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Үр ажиглах (вандуй, шош г.м.), ургалтыг ажиглах, "Юу болох бол" гэсэн энгийн яриа өрнүүлнэ. "Бяцхан үр" үлгэр сонсож ярилцах, мод ургах дарааллыг (үр, соёо, иш, навч) зургаар зөв байрлуулж, тайлбарлана. Бяцхан үр ургаж байна" Хуруугаараа толболж будаж бүтээл хийнэ. Тасалгааны цэцгийн тоосыг арчиж усална.	Ургамлын үр, хөвөн, тавиур, ус Ургамал ургах дараалал бүхий цуврал зургууд Таримал цэцэг, хормогч, услагч, цэцгийн тоос авах парлон	Энэ юу вэ -Үр ямар харагдаж байна, чамд барихад ямар санагдаж байна? Өнөөдөр үр өөрчлөгдсөн үү? Юу нэмэгдсэн бэ? Бяцхан үр хаана байсан бэ? Үр юу гэж бодсон бэ? Яагаад үр ургаж эхэлсэн бэ? Эцэст нь юу болсон бэ? -Услахдаа усыг яаж хийх нь зөв бэ?	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өмнөх ба дараах байдлыг харьцуулан өөрчлөлтийг ялгах, холбоо хамаарлыг ойлгох Харилцах: Бусдын яриаг анхаарч сонсох Бүтээлчээр сэтгэх: Дүрсийг өөрийн санаагаар зохиомжлох	Ургамлын ургах дарааллын зургийг зөв байрлуулдаг. Гарын хурууны даралтаар бүтээл хийдэг. Цэцгийн тоосыг арчиж услахад оролцдог.
Салхи (Салхинд хийссэн цаас, Тууз хийсгэе, Мод зурцгаая).	Зугаалга Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхэд бүр нэг цаас сонгоод салхитай газар гарч Аль нь хамгийн хол хийсэж байгааг ажиглана. Тууз үлээгээд хөдөлгөж үзнэ. Хосоороо харилцан үлээж хэний тууз, хурдан, удаан хийсэж буйг ажиглана. Тэнцүү нугалсан цаас өгч өнгийн будаг түрхээд хаагаад зөөлөн дарж нээнэ. Үүссэн дүрсийг мод болгон хуруугаараа зурна.	Цаас (нимгэн, зузаан), өнгийн цаасан тууз, усан будаг, алчуур	Цаас яагаад хийссэн бэ?, Хүчтэй үлээвэл юу болох вэ?, Хэрвээ салхи байхгүй бол юу болох вэ? Тууз яагаад хөдөлж байна вэ? Модны навч хаана байна? Навч нь ямар өнгөтэй вэ? Модны иш урт уу?, бүдүүн үү?	Харилцах: Ажиглалтаа тайлбарлах, Бүтээлчээр сэтгэх: Бүтээлээ зохиомжилж өөрийн санаагаар бүтээлийг дүрслэх	Байгалийн үзэгдлийг ялгаж таних, ажиглаж ярилцдаг. Сонссон үг, өгүүлбэрийг давтаж хэлдэг. Хавсрах аргаар зурдаг.
Цэцэг дэлгэрлээ		"Би цэцэг тарьсан" дууг	Дуу, сонсох	Юуны тухай дуу	Харилцах: Дууны	Дууны аялгууг дагаж,

(сонсоцгооё, дуулцгаая, тоглоцгооё/	Тойргийн цаг Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, Хөгжөөн баясах цаг	сонсож утга санааг ярилцах, дууны үгийг тогтоож, хамтран дуулах, дууны аянд хэмнэл тоглох, "Цэцэг дэлгэрлээ" хөдөлгөөнт тоглоом тоглоно.	хөгжмийн бичлэг, ая	вэ?, Цэцгийг яаж тарьсан бэ?, Хэрвээ бид үр таривал юу болох бол?	аялгууг дагаж, хамтдаа дуулах Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнт тоглоомоор үйл явдлыг бүтээлчээр дүрслэх	хамтдаа дуулдаг. Дуу аялгуунд тохирсон хөдөлгөөн хийдэг.
Өөрийгөө тайвшруулах тоглоомууд (Уурын үүлийг хөөе, ууртай мод, тэврээд тайвширья)	Хөгжөөн баясах цаг Тойргийн цаг Тойргийн цаг	Уурлаж бухимдах үед багшийн чиглүүлгээр амьсгаа авч "Уурын үүлийг хөөх" амьсгалын дасгал (амьсгал авахдаа гараа өргөж, гаргахдаа буулгана). "Ууртай мод" тоглоом, "Тэврээд тайвширья" (өөрийгөө 2 гараараа зөөлөн тэвэрч, мөр гарын дагуу илэх хөдөлгөөн хийнэ.)	Зөөлөн материалаар хийсэн үүл, намуухан ая/хөгжим, Уурласан, тайвширсан царайтай модны зураг, зөөлөн баавгай	Уур чинь хүрэхэд бие чинь яадаг бэ? Мод уурлахаараа яадаг бол гэж төсөөлүүлнэ. Чи өөрийгөө тэврэхэд ямар мэдрэмж төрж байна? Чи хэнийг ингэж зөөлөн тэврэх дуртай вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн биеийн мэдрэмж, өөрчлөлтийг ойлгож өөрийгөө тайвшруулах Харилцах: Зааврын дагаж хөдөлгөөн хийх. Бүтээлчээр сэтгэх: Биеэ суллах, инээж баярлах, хөгжилтэй хөдөлгөөн зохиомжлох	Амьсгал авахдаа гараа өргөж, амьсгал гаргахдаа гараа буулгадаг. Өөрийгөө 2 гараараа зөөлөн тэвэрч, мөр гарын дагуу илж тайвширдаг.
Бидний ногоон дадал (Усаа хэмнэе, Ус хэмнэгч супер баатрын дүр бүтээх Хогоо хогийн саванд хийе)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа Хөгжөөн баясах цаг	Ус хэмнэх (шүд угаахдаа цоргыг хаах, усаа бага гоожуулах) ач холбогдлыг ойлгоно. Ус дусах чимээг сонсмогцоо цоргыг хааж буй хөдөлгөөнийг дуурайж хийнэ. Ус хэмнэгч супер баатрын дүр бүтээж тоглоно. Хөгжмийн аянд өрөөгөөр явж хог түүж саванд хийнэ.	Гар угаасны дараа цоргыг хааж буй бичлэг, ус хэмнэх зурагт үзүүлэн Супер баатрын нөмрөг, усны жижиг дусал бүхий энгэрийн тэмдэг, хөгжмийн ая Хиймэл хог (цаасны тасархай), хогийн сав, хөгжмийн ая	Гар, нүүрээ угаасны дараа усаа хаахгүй бол яах билээ?, Яагаад ус хэмнэх хэрэгтэй вэ?, Хэрвээ хогоо газар унагаавал юу болох вэ?	Шүүн тунгаах: Зөв буруу үйлдлийг ялгах, зөв сонголт хийх Хамтран ажиллах: Зааврын дагуу хөдөлгөөн хийх, бусдыг ажиглаж дуурайх Бүтээлчээр сэтгэх: Дүр өөрийн төсөөллөөр бүтээж тоглох.	Өөрийн тоглоом, эд зүйлсээ зориулалтын дагуу хэрэглэж, ус хэмнэх, хогоо ангилж хаяхдаа бусдын тусламжтай хийдэг.
Бие хөгжүүлэх тоглоом дасгалууд	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Алхалт, гүйлтийн төрлүүдийг ашиглан өнгийн туузаа солилцож,	Өнгийн тууз, алчуур, бөмбөг, бөмбөг өнхрүүлж	Чи хэдэн бөмбөг нүхээр гаргасан бэ?, (Хүүхэд бүрээс	Харилцах: Бусдыг ажиглах, тоглоомын зааврыг сонсон байраа	Алхаж гүйхдээ бие биедээ зай тавьж хөдөлгөөнөө

(Байраа соль, алчууртай дасгал, бөмбөгийг нүхээр оруулах, тайвшруулах дасгал "Амьтны иог")	Өглөөний дасгал	байраа сольж тоглох, Бөмбөгийг гараараа,хөлөөрөө өнхрүүлж, өшиглөн нүхээр оруулах, гаргасан бөмбөгөө тоолж хэлэх, "Амьтны иог" (могой, хавч) дасгалыг хөгжмийн аянд хийнэ.	оруулах нүх, Амьтны иогийн зурагт хуудас	ээлжлэн асууна)	солих, ээлжлэх Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнийг төсөөлөн дуурайж хийх.	удирддаг, ээлжлэн Сэдэвт алхалт, гүйлтийг хэрэглэл ашиглан гүйцэтгэдэг. Бөмбөгийг 1.5м зайд өшиглөж өнхрүүлдэг.
--------------------------------------------------------------------------------------------	-----------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------	-----------------	-----------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------

Албан хэрэгцээ

4 дүгээр сарын I долоо хоног

УРГАМАЛ АЖИГЛАЦГААЯ

Шинэ үг: Үр, иш, соёо

Үйл ажиллагаа 1. Бяцхан үрийн нууц (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ургамлын үр, хөвөн, тавиур, ус, ургамал ургах дараалал бүхий зурагт үзүүлэнгүүд, зургийн цаас, цавуу, өнгийн харандаа

Аргачлал: Туршилт танин мэдэхүйн төв: Үрийг чийгтэй хөвөн дээр тавьж, ургалтыг өдөр бүр ажиглуулна. /вандуй, шош, эрдэнэ шиш, наранцэцэг гэх мэт/ “Юу болох бол?” гэсэн энгийн яриа өрнүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ?
- Үр ямар харагдаж байна вэ? Том уу, жижиг үү, хатуу юу?
- Чамд барихад ямар санагдаж байна вэ?
- Бид үрийг хаана тавьж байна вэ?
- Өнөөдөр үр өөрчлөгдсөн үү?
- Юу нэмэгдсэн бэ?
- Өнгө нь өөрчлөгдсөн үү?

Хэл яриа-Номын төв: “Бяцхан үр” үлгэр сонсож ярилцана. Нэгэн жижигхэн үр газар хэвтэж байжээ. Үр гэнэт “Би хэзээ ургах бол” гэж бодлоо. Удалгүй зөөлөн бороо орж үрийг услав. Үр би удахгүй ургаж эхэлнэ дээ гэж баярлав.

Тэнгэрт нар гарлаа, нар түүн рүү гэрлээ тусгаж дулаацуулав. Өдөр хоног өнгөрөх тусам үр аажмаар соёолж, богино иштэй, жижигхэн навчтай болов. Дараа нь урт иштэй болж, эцэст нь сайхан цэцэг болон дэлгэрлээ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бяцхан үр хаана байсан бэ?
- Үр юу гэж бодсон бэ?
- Яагаад үр ургаж эхэлсэн бэ?
- Бороо зогсоход юу гарч ирсэн бэ?
- Үр яаж өөрчлөгдсөн бэ?
- Эцэст нь юу болсон бэ?

Зураг урлал: “Бяцхан үр ургаж байна” Хүүхэд зөвхөн хуруугаараа толболж будаж бүтээл хийнэ. Цаасан дээр нэг ширхэг үр дүрсэлнэ. Үр бага багаар соёолж шинэ навч гарч байна хэмээн иш, навч, цэцгийг хуруугаар дарж будна. Нар, ус зэргийг хүүхэд өөрийн санаагаар баяжуулан зурж болно. Багшийн зааварчилгаа өгч алхам бүрийг харуулах ба үр ургаж байна, навч гарч байна гэх мэт энгийн ойлгомжтой үг хэллэг ашиглан чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Ургамал ургах дараалал (Чиглүүлэгтэй, тоглоом үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ургамал ургах дараалал бүхий цуврал зургууд

Аргачлал: Багш картуудыг нэг бүрчлэн харуулж тайлбарлахдаа зөв дарааллаар байрлуулна. Эхлээд үр байна, дараа нь соёолж эхэлнэ, дараа нь бяцхан иш навчтай болно. Эцэст нь цэцэг ургана. Хэд хэдэн хүүхэд багштайгаа хамтдаа зургийг дарааллаар нь өрж байрлуулна. Дараа нь зургийг сагсанд хольж хийгээд хүүхдээр бие даалган хийлгэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэн хамгийн эхний зургийг тавих вэ?
- Аль зураг нь хамгийн жижиг, хамгийн эхнийх шиг харагдаж байна вэ?
- Том ургамал болсон зургийг хаана тавих вэ?

Дараа нь “Бяцхан үр” богино үлгэрийг багштайгаа хамт ярьж зургийг дарааллаар нь тавьж тоглоно.

Үйл ажиллагаа 3. Цэцэг арчилъя (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, цэцэг услагч, зөөлөн алчуур, цэцэгтэй сав, жижиг тавиур.

Аргачлал: Багш жижиг савтай цэцэг үзүүлнэ. “Цэцгийг өдөр бүр арчилбал ургадаг” гэдгийг тайлбарлана. Багш ус авчрах, навчийг алчуураар зөөлөн арчих, аажмаар цэцэг услагчаар услах үйлийг дэс дараалалтайгаар хийнэ. Багшийн дараа хүүхдүүдэд жижиг савтай ургамал өгч услах, шороо цэвэрлэх, тоосыг нь арчих зэрэг энгийн хөдөлмөр хийхэд оролцуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Аль нь цэцэг, аль нь навч вэ?
- Ямар өнгөтэй байна вэ?
- Унасан эсвэл шарласан навч байна уу, цэцгийг арчлахад бидэнд юу хэрэгтэй болох вэ?
- Хаанаас нь эхлэх вэ?
- Услахдаа усыг яаж хийх нь зөв бэ?.

САЛХИ

Шинэ үг: Салхи, хийсэх

Үйл ажиллагаа 1. Салхинд хийссэн цаас (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн цаас: нимгэн, зузаан, өнгийн цаас, салфетик.

Аргачлал: Хүүхэд бүр гартаа нэг ширхэг цаас барина. Багш “Салхи исгэрч байна” гэж хэлэхэд хүүхдүүд салхины чимээг дуурайна. Салхинд цаас хийслээ гэж хэлэхэд хүүхдүүд цаасыг сэвэн, өгүүлбэрийг давтан хэлж, цаасны араас гүйнэ. Салхи зогслоо гэхэд бүгд хөдөлгөөнөө зогсоож тоглоно. Дараагийн удаа хүүхдүүдэд өөр өөр материалтай цаас өгнө. /нимгэн, зузаан, өнгийн цаас, салфетик г.м/ Хүүхэд бүр нэг цаас сонгоод салхитай газар гарч “Аль нь хамгийн хол хийсэж байна вэ?” гэдгийг ажиглана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Цаас яагаад хийссэн бэ?,
- Цаас хэр хол хийсэж байна вэ?,
- Яагаад хол нисэв?.

Үйл ажиллагаа 2. Тууз хийсгээ (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Тууз

Аргачлал: Гадаа салхитай үед тууз, цаас эсвэл навч хөдөлж байгааг харуулна. Хүүхдэд “Хараач, салхи байгаа учраас тууз хөдөлж байна” гэж энгийнээр тайлбарлана. Хүүхэд өөрөө туузыг үлээгээд хөдөлгөж үзнэ. Хосоороо харилцан үлээж, хэний тууз удаан, хурдан хийсэж буйг ажиглана. Дараа нь зөөлөн үлээгээд, хүчтэй үлээгээд хөдөлгөөний ялгааг ажиглуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Тууз яагаад хөдөлж байна вэ?
- Хүчтэй үлээвэл юу болох вэ?
- Зөөлөн үлээвэл юу болох вэ?
- Хэрвээ салхи байхгүй бол юу болох вэ?

Гадаа салхигүй үед сэнсээр салхи үүсгэх туршилт хийж болно.

Үйл ажиллагаа 3. Мод зурцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Тэнцүү 2 нугалсан зургийн цаас, ногоон болон хүрэн өнгийн будаг, алчуур.

Аргачлал: Багш цонхоор мод харуулж эсвэл талбайд зогсож ажиглуулж, модны иш, навч, өнгөний талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Модны навч хаана байна вэ?
- Навч нь ямар өнгөтэй вэ?
- Модны иш урт уу?, бүдүүн үү?

Хүүхдүүдэд тэнцүү нугалсан цаас өгнө. Цаасны нэг талд ногоон, хүрэн өнгийн будаг түрхээд хаагаад гараараа зөөлөн дарна. Одоо нээцгээе. Цаасаа нээхэд модны дүрс үүссэн байна. Ногоон будгийн тархсан хэлбэрийн доод хэсгийн хүрэн будгийг хуруугаараа

доош зөөлөн сунгана. Багш “Энэ бол модны иш” гэж хэлнэ. Ногоон будган дээрээ хуруугаараа дарж навчны дүрс үүсгэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чиний мод ямар өнгөтэй байна вэ?
- Навч нь хаана ургаж байна вэ?
- Модны иш ямар хэлбэртэй вэ?
- Чиний мод салхинд хийсэж байна уу?

ЦЭЦЭГ ДЭЛГЭРЛЭЭ

Үйл ажиллагаа 1. Сонсоцгооё (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Дуу, сонсох хөгжмийн бичлэг, ая, нот, даралтат хөгжим, дууны линк.

Аргачлал: “Би цэцэг тарьсан” дууг сонгоно. Хүүхэд ямар дуу сонссоноо хэлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Юуны тухай дуу вэ?
- Эгч юу авчирч өгсөн бэ?
- Цэцгийг яаж тарьсан бэ?

Үйл ажиллагаа 2. Дуулцагаа (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

1. Дуулах

Хэрэглэгдэхүүн: Жижиг сав, шороо, цэцгийн үр, цэцэг услагч

Аргачлал: Хүүхдэд жижиг сав, шороо, үр үзүүлнэ. Хэрвээ бид үр таривал юу болох бол гэж асууна. Д.Содномдоржийн шүлэг, Ц.Сүхбаатарын ая “Би цэцэг тарьсан” дууны 1-р бадгийн үгийг 2-3 удаагийн давталтай хэлж тогтоолгоно.

Цэцгийн үрийг эгч минь

Авчирч өгсөн дөө

Цэвэрхэн саванд

Шороо хийгээд тарьсан даа

2. Тоглоцгооё

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, дууны ая

Аргачлал: “Би цэцэг тарьсан” дууны аянд хэмнэл тоглоно. Алга ташна, өвдөг цохино.

Хүүхдүүдийг дагуулан хэмнэлийн хэсэг бүрийг 2-3 удаа давтана.

Үйл ажиллагаа 3. Цэцэг дэлгэрлээ (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал:

- Хүүхдүүд газар суусан хэвээр цэцгийн үр болно.
- Багш "Бороо орлоо" гэхэд хүүхдүүд алга ташин борооны дусал мэт дуугаргана.
- "Нар гарлаа" гэхэд гараа дээш өргөн аажуухан өндийн босно.
- "Салхи үлээлээ" гэхэд бүх хүүхэд гараа дээш өргөсөн хэвээр найган ганхана.

4 дүгээр сарын II долоо хоног

ӨӨРИЙГӨӨ ТАЙВШРУУЛАХ ТОГЛООМУУД

Шинэ үг: Уур, тайвшрах

Үйл ажиллагаа 1. Уурын үүлийг хөөе (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Цаасан дээр зурсан эсвэл зөөлөн материалаар хийсэн үүл, үүлний зураг, намуухан ая, хөгжим, уурласан, инээж тайвширсан царайтай модны зураг, тоглоомын зөөлөн баавгай, сэтгэл хөдлөлийг дүрсэлсэн зургууд (уурласан, тайвширсан, баярласан царай)

Багшийн чиглүүлэг:

- Өглөө сэрэхэд заримдаа уур хүрэх үе байдаг уу?
- Уур чинь хүрэхэд бие чинь яадаг бэ? /гараа атгах, духаа үрчийлгэх, уруулаа унжуулах, цээжээ тэврэх г.м/

- Бидний дотор уурын үүл байдаг. Өнөөдөр тэр үүлээ хамтдаа үлээж хөөцгөөе. Багш амьсгаа авлаа-хоёр гараа дээш өргөнө, амьсгаа гаргалаа-хоёр гараа буулгана. /3-4 удаа давтана/
- Одоо бүгдээрээ нүүрнийхээ өмнө уурыг үүлээ барьцгаая. Гүнзгий амьсгаа аваад уурын үүл рүү үлээцгээе. Үлээж үүлийг газарт унагаая. Фүү гээд гараа доош буулгана. Одоо бидний уурын үүл алга боллоо, бүгдээрээ инээцгээе, биеэ суллая, хөгжилтэй хөдөлгөөн хийцгээе.

Үйл ажиллагаа 2. Ууртай мод (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн, хөгжмийн ая.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар энэ модыг хар даа. Ямар царайтай байна?

Аргачлал:

- Мод уурлахаараа яадаг бол? гэж төсөөлүүлнэ. Бамбарууш надад хэллээ.
- Мод уурласан үедээ салхинд зөөлөн найгаад тайвширдаг гэнэ. Туршиж үзэх үү?
- Гараа дээш өргөөд мод болцгооё.
- Гүнзгий амьсгаа авцгаая..... одоо гараа зөөлөн найгуулаад салхинд найгаж буй мод шиг байцгаая. /намуухан ая тоглуулна/
- Амьсгаа аваад гараа тайвнаар хөдөлгөхөд мод тайвширдаг шиг бид ч бас тайвширдаг.

Үйл ажиллагаа 3. Тэврээд тайвширъя (Тойргийн цаг)

Аргачлал: Өнөөдөр бид өөрсдийгөө тэврээд тайвширч сурна гэж хэлээд багш үлгэрлэн үзүүлнэ. Хоёр гараараа зөөлнөөр өөрийгөө тэврэрч, мөр гарын дагуу илэх хөдөлгөөн хийнэ. Хүүхдүүд дагаж хийнэ.

Багшийн чиглүүлэг:

- Гүнзгий амьсгал авъя, удаанаар гаргая.
- Одоо мөр, гараа маш зөөлнөөр илж үзье.
- Ингэж зөөлөн илэхэд ямар мэдрэмж төрж байна вэ?
- Бие нь дулаацаж байна уу?
- Чи хэнийг ингэж зөөлөн тэврэх дуртай вэ?
- Өөрийгөө тэврэхэд ямар санагдаж байна вэ?

Уур хүрэх, уйтгарлах, айх үедээ чи өнөөдрийнх шиг өөрийгөө тэврвэл бие чинь тайвширна, энэ бол чи өөрийгөө тайвшруулах нэг арга гэж тайлбарлан хэлнэ.

БИДНИЙ НОГООН ДАДАЛ

Шинэ үг: Цорго, хэмнэх

Үйл ажиллагаа 1. Усаа хэмнэе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нэг ширхэг том хогийн сав, аюулгүй хиймэл “хог” (цаасны жижиг тасархай, бөмбөлөг, хиймэл сав), 2–3 өөр өнгийн сав (ногоон, шар, цэнхэр гэх мэт мөн сав бүрд тохирох зургийг наах) Хогийг төлөөлөх зүйлс (цаас, хуванцар, хүнсний үлдэгдлийг орлох аюулгүй тоглоомын зүйлс)

Аргачлал: Багш дараах код дотор зургуудыг ашиглан гар угаасны дараа цоргыг тэр даруй хаахыг тайлбарлах зурагт үзүүлэнг бэлтгэнэ. Цоргыг хөдөлгөөнт эргэдэг байдлаар хийнэ. Холбоос 2 бичлэгээс санаа авна. А3 болон түүнээс дээш хэмжээтэй байна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бид гар, нүүрээ ямар тохиолдолд угаадаг вэ?
- Бохирдсон үед нь гар, нүүрээ угаахгүй бол яах вэ?
- Гар, нүүрээ угаасны дараа усаа хаахгүй бол яах билээ? гэх мэтээр ярилцана. Усаа тэр даруй хааж, хэмнэж, хайрлах ёстойг тайлбарлаж, ойлгуулна.

Үйл ажиллагаа 2. Ус хэмнэгч супер баатрын дүр бүтээх (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Багшид супер баатрын нөмрөг, хүүхдүүдэд жижиг усны дусал эсвэл энгийн супер баатрын тэмдэг, хөгжмийн ая.

Аргачлал: Супер баатар усыг хэмнэж хайрладаг тухай тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Цоргыг хаахгүй бол юу болох вэ?
- Яагаад ус хэмнэх хэрэгтэй вэ?
- Цоргыг бид өөрөө хааж чадах уу?

Одоо бүгдээрээ Ус хамгаалагч супер баатрууд болцгооно. Ус дусах чимээ гарна. Ус дусаж байна, цоргыг хаацгаая. Гараараа цоргыг хааж буй хөдөлгөөн хийнэ. Хөгжмийн аянд супер баатрын хөдөлгөөнийг дуурайж хөдөлнө. Ус гоожих чимээ сонсмогцоо цоргыг хааж буй хөдөлгөөнийг давтан дуурайн хийцгээж усаа хайрлая, усаа хэмнэе хамтдаа гэж хэлж дээрх хөдөлгөөнүүдээ давтан хийж хөгжилдөнө.

Үйл ажиллагаа 3. Хогоо хогийн саванд хийе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хиймэл хог, хогийн сав, хөгжмийн ая.

Аргачлал:

Хувилбар 1. Өрөөнд хиймэл “хог” тараана. Багш хүүхдүүдэд “Өнөөдөр бид хогоо саванд хийдэг баатар болно” гэж тайлбарлана. Хүүхдүүд хөгжмийн аянд өрөөгөөр явж “хог” түүж, саванд хийнэ. Бүх “хог” саванд орсны дараа хамтдаа алга ташиж баяр хөөртэйгөөр дүгнэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хогийг яагаад хогийн саванд хийх хэрэгтэй вэ?
- Хэрвээ хогоо газар унагаавал юу болох вэ?
- Бид өөрсдөө хогоо хаяж чадах уу?

Хувилбар 2. Хүүхдүүд ээлжлэн хогийг өнгөөр ялгасан саванд хийнэ. Хүүхдэд чи аль хогийн сав руу хийх вэ? гэж асуун зөв сонголт хийх боломж олгоно.

БИЕ ХӨГЖҮҮЛЭХ ТОГЛОМ, ДАСГАЛУУД

Шинэ үг: Өнхрүүлэх, солилцох

Үйл ажиллагаа 1. Байраа сольё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд бүрийн тоогоор нэг ширхэг өнгийн тууз.

Аргачлал: Хүүхдүүд цуваагаар алхаж ангид орж ирээд өнгийн туузаас нэг нэгийг сонгож аваад 2 эгнээнд хуваагдан зогсоно.

- 1 эгнээний хүүхдүүд алхаад 2 эгнээний хүүхэдтэй туузаа солилцоод байрандаа ирнэ.
- 2 эгнээний хүүхдүүд алхаад 1 эгнээний хүүхэдтэй туузаа солилцоод байрандаа ирнэ.
- 2 эгнээний хүүхдүүд зэрэг өөд өөдөөсөө алхаад туузаа солилцоод буцаж эргээд байрандаа зогсоно.
- Алхалт, гүйлтийн төрлүүдээс ашиглаж өөр өөр даалгавар гүйцэтгэж болно.
- Тойргоор зогсож туузаа дээш шидээд газар унагахгүйгээр алхаж, гүйж барьж авч тоглоно.

Үйл ажиллагаа 2. Алчууртай дасгал (Өглөөний дасгал)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд бүрд алчуур, хөгжмийн ая

Аргачлал: Биеийг хөгжүүлэх 8 тоот дасгалыг багш толин үзүүлбэрийн аргаар гүйцэтгэхэд хүүхдүүд даган дуурайна.

- Алчуурын 2 талаас барьж урагшаа, дээш өргөж буулгах
- Нэг гартаа алчуураа барьж ээлжлэн өргөж буулгах
- Гараа урагш өргөн алчуураа баруун/зүүн гартаа дамжуулах
- Алчуурын 2 үзүүрээс барьж эргүүлэн сууж босох
- Суугаа байрлалд алчуурын 2 үзүүрээс барьж урагш бөхийж эгцрэх
- Алчуураа биеийн хажуу талд эргүүлэн үсрэх, алхах
- Амьсгалын дасгал

Үйл ажиллагаа 3. Бөмбөгийг нүхээр оруулах (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дунд зэргийн хэмжээтэй зөөлөн бөмбөг, багшийн хийсэн нүх буюу хаалга

Аргачлал: Хүүхдүүд 2–3 цуваанд зогсоно. Багш бөмбөгийг гарын алгаар, дараа нь хөлөөр өнхрүүлж үзүүлнэ.

Алхам 1. Багш дохио өгнө: Гараараа өнхрүүлнэ. Бэлэн үү? Эхэллээ!

Алхам 2. Хүүхдүүд бөмбөгийг нүх рүү чиглүүлэн гараар өнхрүүлнэ.

Алхам 3. Бөмбөг нүхээр гарна. Өнхөрлөө, сайн байна гэж багш урамшуулна.

Дараагийн үе шатанд Бөмбөгийг хөлөөр зөөлөн түлхэн өнхрүүлнэ.

Багш хүүхэд бүрээс ээлжлэн асууна: Чи хэдэн удаа бөмбөгийг нүхээр оруулсан бэ? Гаргасан бөмбөгөө тоолж хэлнэ.

Тайвшруулах дасгал “Амьтны иог”

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зурагт карт / Могой, хавч, яст мэлхий/, тайвшруулах намуухан ая

Аргачлал: Ангийн зай талбайг харгалзан хүүхдүүдийг тойргоор эсвэл хэд хэдэн эгнээгээр бие биедээ саад болохгүйгээр суулгана.

Багшийн чиглүүлэг:

- Энэ бол могой. Могой гэдсээрээ газар гулсаж явдаг. Одоо бүгдээрээ могой шиг гэдсээрээ хэвтэж үзье.
- Нуруугаа чангалахгүй, биедээ эвтэйхнээр цээжээ багахан дээш өргөөрэй.
- Амьсгалаа удаанаар аваад, удаанаар гаргаж могой шиг шиг гулсаж үзье.

Хавч: Энэ амьтны нэрийг Хавч гэдэг. Далайд амьдардаг жижиг амьтан.

- Хавч зөвхөн хажуу тийш алхдаг гэж үзүүлж богино тайлбар хийнэ.
- Бид Хавч шиг гараа тулж, биеэ өргөөд, зөөлөн хажуу тийш хөдөлж алхъя.

Яст мэлхий: Энэ бол яст мэлхий. Нуруундаа хамгаалалтын бүрхүүлтэй. Яст мэлхий толгойгоо доошоо хийгээд өвдгөө тэвэрч амардаг гэж үзүүлнэ.

- Одоо бүгдээрээ яст мэлхий шиг сууж үзье.

Хүүхдийн амьсгалыг багш чиглүүлэхдээ:

- Амьсгалаа авъя..... удаанаар гаргая.
- Биеэ зөөлнөөр суллаарай, тайван байгаарай

Хэрэв хүүхдэд хийхэд эвгүй байвал зөвшөөрч зогсоож болно.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

- Хөгжлийн онцлогтой хүүхдийг ажиглаж тохирох чиглүүлэг дэмжлэгийг өгч ажиллана. Үүнд: Анхаарал сул хүүхдэд богино хугацаатай даалгавар өгөх, хэлний хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд зураг, дохио, бодит хэрэглэгдэхүүн ашиглах, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт туслах хэрэглэгдэхүүн өгнө.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

- Хүүхэдтэйгээ музей, амьтны хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн зэрэг бодит орчинд хамтдаа аялна, мод ургамлын онцлог шинж чанарыг тайлбарлан ярилцана.
- Мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой ном уншиж өгч ярилцана.
- Багшид хүүхдийнхээ талаар мэдээлэл өгч өгч зөвлөгөө авч хамтран ажиллах

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

Цахим холбоос:

1. https://youtu.be/8J_M3DeEhYU?si=mAt3YEppPNpPhfKT
2. <https://www.pinterest.com/pin/89298005106775072/>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР

УС

Хүүхдийн эзэмших чадамж

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн төсөөлөл санаачилгаар тоглох орчноо бүрдүүлэх, шинэ санаа гаргаж, бусадтайгаа хуваалцах.

Шүүн тунгаах: Юмсын усанд хөвөх живэх нөхцөл байдлыг ажиглах, харьцуулах, асуудал шийдвэрлэх.

Аюулгүй байдлын зөвлөмж: Хүүхдийн сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангахын тулд энгийн, ойлгомжтой заавар өгч, хүүхдийн мэдрэмжийг анзаарч дэмжинэ. Усаар тоглох үеийн аюулгүй байдлын зааварчилгаа өгнө, хамтран тоглоно. Зугаалгын үед хүүхдүүдийг элс, усаар тоглоход нь анхаарч, багаар хамтран тоглоход чиглүүлнэ.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг: Хувийн ариун цэвэр, ус уухын ач холбогдол, усыг ариг гамтай хэрэглэх талаар тайлбарлаж, өдрийн турш юу хийж тоглохыг ярилцана

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа: Танин мэдэхүй, хөдөлгөөн, дүрд тоглох, дуу хөгжмийн үйл ажиллагаанд хамтран оролцож, хүүхдийн сонирхсон үйл ажиллагааг гүнзгийрүүлэн бүтээлчээр оролцоход тохируулга хийнэ.

Зугаалгын цаг: Хүүхдүүд бие даан хувцаслах, шороо чулуу нэг нэг рүүгээ цацах, шидэхгүй байхыг хянах, орчноо ажиглаж цаг агаарын талаар ярилцах, элс, усаар тоглоно.

Өөртөө үйлчлэх хөдөлмөр: Хувийн ариун цэврийг сахихдаа өөрийн таних тэмдэг бүхий эд зүйлсийг хэрэглэхийг сануулна. Усыг хэрэгцээгүй гоожуулахгүй байж, гар, шүдээ угаахдаа аяга хэрэглэж сурна.

Хөгжөөн баясах цаг: Янз бүрийн сонирхолтой хөдөлгөөнтэй тоглоом, дуут хөгжимт тоглоом, дүрт тоглоомоор цагийн хөгжилтэй өнгөрүүлнэ.

Номын цаг: Дуртай номоо сонирхож үзэх, номын тухай ярилцах орчин бүрдүүлж, номын төвд баримтлах энгийн дүрэмтэй танилцана.

Боломжууд:

Багш хүүхдэд шинэ сорилтыг давах, асуудлаа өөрөө шийдвэрлэхэд нь тусалж дэмжинэ.

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
НСХ2.1б. Өөрийн хэрэгцээгээ илэрхийлдэг болно. ХЭМ2.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчийн зааварчилгаагаар хийнэ. ХЯ2.2б. Бусадтай харилцахдаа энгийн, яриатай холбогдсон асуулт асууна.	- Зургуудаас юу хэрэгтэй байгаагаа зааж үзүүлэх, нэрлэх дасгал ажиллах; - Ярилцлагын үед яагаад?, ямар учраас?, юу вэ?, хэрвээ? гэх мэт үгсийг тохируулан ашиглах асуулт хариултын тоглоом тоглох.	Усны амьтад
НСХ2.3а. Юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг таньж ойлгодог болно. ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. МАТ2.3а. Тоглоом юмсыг тодорхой шинжээр хоёр хэсэгт ангилна.	- Өдөр тутмын хүүхдүүдийн ашигладаг эд зүйл хэрхэн бүтдэг тухай товч видео үзэж ярилцах; - Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт асууж харилцан яриаг эхлүүлэх. - Усаа хэмнэх, хог ангилж хаях үйлийн ач холбогдлыг ойлгох энгийн туршилтууд хийх.	Усны туршилтууд

<p>ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог болно. МАТ2.2б. Өөрийн хийдэг үйлийг өглөө, оройтой холбож нэрлэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Сургамжит үлгэр, зохиол, үйл явдлыг тогтоож дүрд хувирч жүжиглэн тоглох, үйл явдлын тухай харилцан ярих. - Тоглоом, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; - Өглөө, оройг нэрлэх тоглоом (зурган картыг хараад хүүхэд цэцэрлэгтээ явж байгаа болохоор өглөө байна гэх мэт) тоглох. 	<p>Усны хэрэглээ</p>
<p>ЗУ2.2б. Бүтээлээ үндсэн өнгөөр бие дааж будна. БНО2.2г. Өөрийн тоглоом, эд зүйлсээ зориулалтын дагуу хэрэглэж, ус хэмнэх, хогоо ангилж хаяхдаа бусдын тусламжтай хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Өнгөө сонгож тоглоом эд юмсыг будах; - Төрөл бүрийн тоглоомууд тоглох. Жишээ нь: Хогийг ангилж хаях “Хэн хогийг хамгийн хурдан зөв хаях вэ?” тоглоом, эд зүйлсийн хэрэглээ бүхий “Болно, болохгүйг харуулсан зургуудаас сонгож тоглох”. 	<p>Бүтээлч хүүхдүүд</p>
<p>ХЭМ2.2г. Өөрийн хоолны хэрэгслийг хэрэглэнэ, хоолны дараа хураана. МАТ2.3в. Юмсын байршлыг нэрлэнэ. (дотор, гадна)</p>	<ul style="list-style-type: none"> - Хооллох дүрмийг дүрийн тоглолт, интерактив тоглоом хэлбэрээр тоглуулах. - Гадна, дотор заасан үг хэллэгийг тохирох зураг, үйл явдалтай холбон илэрхийлэх. 	<p>Ус ба тоглоом</p>
<p>ХЭМ2.1и. Хоёр хөл дээр 5 зураас давж үсэрч бууна (зураас хоорондын зай 35 см) БНО2.2г. Тоглоом, эд зүйлсээ зориулалтын дагуу хэрэглэж, ус хэмнэх, хогоо ангилж хаяхдаа бусдын тусламжтай хийнэ ХЯ2.3а. Номын зургийг ажиглаж, ялган нэрлэнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Хоёр хөл дээр орон зайгаа мэдэрч саадыг давах, сүлжих, цагаригаас цагаригт үсэрч тоглох; - “Болно, болохгүйг харуулсан зургуудаас сонгож тоглох”, “Тоглоомын болон ангийн дүрэмд заагдсан үйлүүдээс буруу, зөв үйлийг зураг дээр ялгах” гэх мэт; - Зураг ажиглан, юу болж байгаа талаар ярих, “Эхлээд юу болсон бэ?”, “Дараа нь юу болсон бэ?” гэх мэт асуултад хариулах, номын зургуудын дарааллыг ойлгон богино түүх зохиох. 	<p>Усан дээгүүр үсэрцгээ</p>

5 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Ус хэрэгтэй юу?	Тойргийн цаг	Амьтны зургийг сонгож нэрлээд, усанд амьдардаг эсэхийг хэлнэ.	Амьтдын зураг эсвэл тоглоом (загас, муур, шувуу, тэмээ).	Усанд ямар ямар амьтад амьдардаг вэ?; Чиний сонгосон амьтан усанд амьдардаг амьтан уу?.	Шүүн тунгаах: Зургийг нэрлэх, зарим дүрийг таних, заах, нэрлэх.	Амьтныг нэрлэж, амьдардаг орчныг ялгаж чаддаг.
Амьтад	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ойн болон усны амьтдын баг, маск өмсөж, хөгжмийн аянд бүжиглэнэ. Багш "Ус" эсвэл "Газар" гэж хэлэхэд амьтад зориулалтын (цэнхэр/бор) даавуун дээр очиж зогсоно.	Амьтдын зурагт үзүүлэн, баг/маск, цэнхэр болон бор өнгийн том даавуу, хөгжим.	Энэ ямар амьтан бэ?; Хаана амьдардаг вэ?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох	Тоглоом, үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.
Загасны хорго	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд багт хуваагдан, хуванцар аяганд ус хийж зөөгөөд, загасны тоглоомтой 5 литрийн савыг усаар дүүргэж тоглоно.	5 литрийн усны сав, хуванцар аяга, загасны хэлбэртэй тоглоомууд, том савтай ус.	Аяганд ус их байна уу?, бага байна уу? Хэрвээ ус асгарвал яах вэ?	Хамтран ажиллах: Дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх, хамтрах, оролдлого хийх	Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог
Ус хаашаа урсдаг вэ?	Зугаалга	Усны хоолой ашиглан урт ба богино замууд хийнэ. Ус урсгаж, цаасан онгоц, завиа хөдөлгөж тоглоно.	Усан хоолой, том, жижиг савнууд, ус, бөмбөг эсвэл цаасан усан онгоц.	Ус хаашаа урссан бэ?; Яагаад энэ саванд орж байна вэ?; Аль зам урт вэ?; Завь аль замаар удаан явсан бэ?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох (Усны урсгал, хөдөлгөөнийг ажиглах);	Энгийн туршилтад оролцож, юу өөрчлөгдөж, болсон тухай хариулдаг..

Усанд уусдаг уу?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Элсэн чихэр, давс, тос, будаа, гурил зэрэг зүйлсийг усанд хийж, хэрхэн хувиралд орж байгааг ажиглана. Багш “Элсэн чихэр уусдаг, харин тос хөвдөг” гэх мэтээр тайлбарлана.	Ус, элсэн чихэр, давс, тос, будаа, гурил, жижиг савнууд.	Усанд хийсэн элсэн чихэр, давс хаачсан бэ? Та нар юу гэж бодож байна? Усанд хийсэн тос харагдаж байна уу?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох, асуулт асуух.	Эд зүйлс, тоглоомыг нэрлэж, шинж чанарыг нь ялгадаг.
Хөвөх үү? Живэх үү?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Усанд хөвдөг, живдэг төрөл бүрийн тоглоом, эд зүйлсийг усанд хийж туршилт хийж, хөвсөн, живсэн тухай ярилцана.	Усанд хөвдөг тоглоомууд, мод, чулуу, цаас, устай том сав.	Хөвж байна уу? Живж байна уу?.	Шүүн тунгаах: Аливаа асуудлыг ажиглах; Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох.	Эд зүйлсийн өнгө, хэмжээ, байрлал заасан үгийг ойлгож, яриандаа хэрэглэдэг.
Усны өдөр	Тойргийн цаг	Усыг өдөр тутамдаа хэрхэн хэрэглэдэг тухай, өглөө сэрээд юу хийдэг тухай ярилцана. Усыг ариг гамтай хэрэглэх тухай сануулна.	Зурагт үзүүлэн.	Өглөө сэрээд гараа угаадаг уу? Бид усаар юу хийдэг вэ?	Шүүн тунгаах: Багшийн зааврыг сонсох, аливаа асуудлыг ажиглах	Болсон, оролцсон үйл явдлын тухай энгийн өгүүлбэрээр давтаж ярьдаг.
Тоглоомоо угаагаарай	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Хүүхдүүд өөрийн хэрэгтэй зүйлсээ цуглуулж, хүүхэлдэй болон бусад тоглоомуудаа саван, усаар цэвэрлэж угаана. Угаах, арчих, хувцаслах зэрэг үйлдлийг хийнэ.	Хүүхэлдэй, хуванцар, зөөлөн тоглоомууд, жижиг усны сав, алчуур, саван, хормогч, ханцуйвч.	Тоглоомоо яагаад угаах хэрэгтэй вэ? Чи юу гэж бодож байна?; Одоо юу хийх вэ?.	Хамтран ажиллах: Дүрэм мөрдөх, ээлжээ хүлээх зэргээр хамтрах, оролцох оролдлого хийх.	Өөрийн тоглоом, эд зүйлсээ зориулалтын дагуу хэрэглэж, ус хэмнэх, хогоо ангилж хаяхдаа бусдын тусламжтай хийдэг.
Усаа хэмнээрэй	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Гар нүүрээ угаах, шүдээ угаах үед усаа хэрхэн хэмнэх тухай зурагт үзүүлэнгээр тайлбарлан, өдөр тутамдаа хэрэгжүүлнэ.	Зурагт үзүүлэнгүүд	Шүдээ угаахдаа ус нээлттэй байлгах зөв үү? Шүдээ угаахдаа аягатай ус хэрэглэгдэг үү?	Шүүн тунгаах: Багшийн зааврыг сонсох, аливаа асуудлыг ажиглах	Шүд угаахдаа усыг аяганд тосож хэрэглэдэг.

Өнгөт ус	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ундааны саван дахь усанд гуаш түрхэж өнгө оруулан тоглоно. Дараа нь "Далайн амьтад" сэдэвт зураг зурна.	Ус, ундааны сав, гуаш, зургийн дэвтэр, бийр.	Ус өнгөтэй байна уу? өнгөгүй байна уу? Чиний ус ямар өнгөтэй болсон байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Юмс үзэгдлийг сонирхож, бүтээж, дүрслэн тоглох; Өөрийн санаа бодлоо бүтээлээр илэрхийлэх.	Бүтээлдээ тохируулан өнгөө сонгож буддаг.
Далайн орчин бүтээцгээ	Төвийн үйл ажиллагаа	Зураг, урлал төвд усны орчныг зурж будна. Хэл ярианы төвд зурагт картаар хамаарлыг ойлгож өгүүлбэр бүтээж ярилцана. Математикийн төвд ус хэмжиж их багыг олно. Байгалийн төвд ургамал услах ажлыг хийнэ.	Усны орчны зурагт ном, цаас, үндсэн өнгийн будгууд, сав, ус хэмнэх тэмдэгтэй сав.	Далайн дотор юу байдаг вэ? Чи аль төв тоглох вэ?	Хамтран ажиллах: Хамтын шийдвэр гаргах, багийн ажилд хувь нэмрээ оруулах	Ургамал арчлахад идэвхтэй оролцдог. Эд зүйлсийн өнгө, хэмжээ, байрлал заасан үгийг ойлгож, яриандаа хэрэглэдэг.
Усны тухай ном	Номын цаг	Багш далай болон усны тухай ном уншиж ярилцана. Хүүхдүүд бяцхан номын бэлдэц ашиглан усны зөв хэрэглээний тухай зурагт хуудас нааж, ном бүтээнэ.	Усны тухай зурагт номууд, бяцхан номын бэлдэц цаас, усны зөв хэрэглээний тухай жижиг зургууд.	Энэ зураг дээр юу байна вэ? Та нар ном хийж байсан уу?	Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санаа бодлоо бүтээлээр илэрхийлэх	Зураг, номын хуудаснаас нэрлэсэн зүйлийг зааж хэлдэг.
Хуурай ба нойтон	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Тоглоом, эд зүйлсийг усны савны дотор, гадна байрлуулж, байршлыг нэрлэнэ. Дараа нь нүдээ аниад тоглоомыг тэмтэрч мэдрээд хуурай, нойтныг хэлж тоглоно.	Усны сав, амьтдын тоглоомууд.	Загас хаана байна вэ?; Нугас усны гадна байна уу?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох	"Дотор", "гадна" гэсэн ойлголтыг зураг, хөдөлгөөнөөр харуулж ойлгож хэлдэг.
Усны кафе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Усны кафе"-д зочин эсвэл үйлчлэгч болж дүрд тоглоно. Ус аяганд хийж аягалах, асгарсан усыг арчих, аяга таваг хураах үйлдлийг хийнэ.	Тоглоомын аяга, халбага, усны сав, ширээ, алчуур, хураах тавиур.	Аягаа хаана тавих вэ?; Халбагаа хураах уу?.	Хамтран ажиллах: Хамтдаа зургаа будах, тоглоом угсрах, дүрд тоглох, найзынхаа тусламжтайгаар даалгавар гүйцэтгэх.	Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.

Усны дэлгүүр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд "худалдагч" эсвэл "хэрэглэгч" болж тоглоно. Хэрэглэгч усыг юунд хэрэглэхээ хэлж, хэрэгтэй зүйлсээ (хоол хийх, усанд орох гэх мэт) худалдаж авна.	Усны сав, хөөс, алчуур, тоглоомын мөнгө, жижиг лангуу.	Та юунд хэрэглэх вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Юмс үзэгдлийг сонирхож, бүтээж, дүрслэн тоглох.	Юмсын хоорондын энгийн хамаарлыг тайлбарладаг.
Үсрээрэй	Зугаалгын цаг	Гадаа талбайд асгасан устай хэсгүүдийн дээгүүр үсэрч тоглоно. Мөн жижиг саваар ус зөөж ойр байгаа моднуудыг усална.	Ус, ус зөөх сав, усны гутал, элсний тоглоомууд.	Цаг агаар ямар байна вэ? Ус хэрхэн бий болсон бэ?.	Хамтран ажиллах: Хүүхэд бусадтай хамтран тоглох, даалгаврыг биелүүлэх оролдлого хийж, багийн гишүүний үүрэгтэй оролцох.	Хоёр хөл дээр үсэрч тоглодог. Байгалийн үзэгдлийг
Усны баатар	Хөгжөөн баясах цаг	Усны зөв хэрэглээ болон хориглох зүйлийн тухай зурагт үзүүлэнг харуулна. Хүүхдүүд "зөв/буруу" тэмдэгтэй карт өргөж хариулна. Төгсгөлд нь "Усны баатар" тэмдэг гардуулна.	Зурагт үзүүлэн, хүүхэд бүрд зөв, буруу тэмдэгтэй өргөдөг карт, усны баатар гэсэн энгэрийн тэмдэг.	Энэ юуны зураг вэ?; Зөв үйлдэл үү? Буруу үйлдэл үү?.	Шүүн тунгаах: Юмс үзэгдлийн өөрчлөлтийг ажиглан ялгааг танихыг оролдох	Зурагт үзүүлэнгээс зөв буруу үйлдлийг олж нэрлэдэг.

5 дугаар сарын I хоног

УСНЫ АМЬТАД

Шинэ үг: Усны амьтад

Үйл ажиллагаа 1. Ус хэрэгтэй юу? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зураг эсвэл тоглоом (загас, муур, шувуу, тэмээ)

Аргачлал: Хүүхэд бүр нэг тоглоом эсвэл зураг сонгож авна. Багш хүүхдүүдээс асуулт асууна. Хүүхдүүд нэг нэгээрээ босож тоглоом дээш өргөж амьтны нэрийг чанга хэлнэ. Бусад хүүхдүүд харин “Загас усанд амьдардаг”, “Муур ус уудаг” гэх мэтээр хариулна.

Багшийн чиглүүлэг асуулт:

- “Усанд ямар ямар амьтад амьдардаг вэ?”,
- “Чиний сонгосон амьтан усанд амьдардаг амьтан уу?”

Үйл ажиллагаа 2. Амьтад (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зурагт үзүүлэн, амьтдын зурагтай баг, маск, цэнхэр болон бор өнгийн том даавуу, хөгжим, ая, далайн болон ойн амьтдын дүрс бичлэг.

Аргачлал: Багш эхлээд том зурагт картуудыг үзүүлж асуулт асууж ярилцана.

Ойн амьтад (баавгай, үнэг, чоно, хэрэм, туулай) усны амьтад - (алтан загас, халим, аварга загас, наймаалж, далайн морь, далайн од гэх мэт) олон амьтдын баг, маск бэлтгэсэн байна. Хүүхдүүд өөрийн дуртай амьтны багийг сонгож өмсөнө. Ангийн 2 талд цэнхэр ба бор өнгийн даавууг дэлгэн байрлуулна. Хөгжмийн ая явах үед хүүхдүүд амьтны хөдөлгөөн хийж бүжиглэнэ. Ая зогсох үед бүгд зогсож анхааралтай сонсоно. Багш “Ус” эсвэл “Газар” гэж чанга хэлнэ. “Ус” гэж хэлбэл усанд амьдардаг амьтны багтай хүүхдүүд цэнхэр даавуун дээр очиж зогсоно, хуурай газрын амьтны багтай хүүхдүүд хөдлөхгүй зогсоно. Харин “Газар” гэж хэлбэл хуурай газар амьдардаг амьтны багтай хүүхдүүд бор даавуун дээр очиж зогсоно, усны амьтны багтай хүүхдүүд хөдлөхгүй зогсоно. Тоглоомын төгсгөлд багш далай болон ойн амьтдын богино бичлэг үзүүлж хамтдаа ярилцана.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Энэ ямар амьтан бэ?
- Хаана амьдардаг вэ?

Үйл ажиллагаа 3. Загасны хорго (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: 5 литрийн усны сав багийн тоогоор, хуванцар аяга хүүхдийн тоогоор, загасны хэлбэртэй тоглоомууд, том савтай ус багийн тоогоор.

Аргачлал: Хүүхдүүд 3-4 багт хуваагдан уралдаж тоглоно. Гарааны хэсэгт ширээн дээр хуванцар аяганд уснууд хийж бэлтгэнэ. 1-2 метр зайд ширээн дээр 5 литрийн усны савны дээд хэсгийг тэгшлэн тайрч бэлтгэсэн байна. Саван дотор загасны тоглоомуудыг хийж тавина. Багийн хүүхдүүд цуваа болон зогсож нэг нэгээрээ том савтай уснаас аягаараа хутган авч усыг асгалгүй зөөж загасны хоргыг усаар дүүргэнэ.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Аяганд ус их байна уу?, бага байна уу?
- Хэрвээ ус асгарвал яах вэ?

УСНЫ ТУРШИЛТУУД

Шинэ үг: Усанд уусах

Үйл ажиллагаа 1. Ус хаашаа урсдаг вэ? (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Усан хоолой, том, жижиг савнууд, ус, бөмбөг эсвэл цаасан усан онгоц.

Аргачлал: Зугаалгын цагаар хүүхдүүд багш нар гадаа тоглоомын талбайд гарч үйл ажиллагааг явуулна.

- Багш хүүхдүүд хамтран усны хоолой ашиглан урт ба богино замууд хийнэ.

- Хоолой руу ус урсгахдаа “Ус хаашаа урссан бэ?”, “Яагаад энэ саванд орж байна вэ?” гэх мэтээр ярилцана. Багш хүүхдийг асуултад хариулан энгийн өгүүлбэрээр хариулахад дэмжинэ. Хүүхэд “Ус доошоо урслаа”, “Ус сав руу орлоо” гэх мэтээр ярилцана.

- Хүүхэд өөрөө замаа сонгож, ус урсгаж завиа хөдөлгөж тоглоно. Багш “Аль зам урт вэ?”, “Завь аль замаар удаан явсан бэ?” гэх мэтээр асууж, хүүхдүүд хариулна. Хүүхэд “Урт замаар завь удаан явлаа”, “Богино зам хурдан дууслаа” гэх мэтээр харьцуулан хэлнэ. Хүүхэд өөрөө туршилт хийж, бие даан дуртайгаар оролцоно. Тоглож дуусаад тоглоом болон хэрэглэгдэхүүнээ байранд нь хураана.

Үйл ажиллагаа 2. Усанд уусдаг уу? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ус, элсэн чихэр, давс, тос, будаа, гурил, жижиг савнууд.

Аргачлал: Хүүхэд эд зүйлсийг усанд хийж, хэрхэн хувиралд орж байгааг ажиглана. “Энэ уусаж байна уу?”, “Яагаад тос хөвж байна вэ?” гэх мэт хамаарлыг танина. Багш “Элсэн чихэр уусдаг, харин тос хөвдөг, гэх мэт тайлбар өгч, хүүхдийг энгийн өгүүлбэрээр хариулахад дэмжинэ. Хүүхэд “Элсэн чихэр алга боллоо”, “Тос хөвж байна” гэх мэтээр харилцан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

Усанд хийсэн элсэн чихэр, давс хаачсан бэ? Та нар юу гэж бодож байна?

Усанд хийсэн тос харагдаж байна уу?

Үйл ажиллагаа 3. Хөвөх үү? Живэх үү? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Усанд хөвдөг тоглоомууд, мод, чулуу, цаас, устай том сав багийн тоогоор

Аргачлал: Усанд хөвдөг, живдэг төрөл бүрийн тоглоом, эд зүйлсийг бэлтгэсэн байна. Хүүхдүүдийг 3-4 баг болон савтай усыг тойрон сууж бэлтгэсэн эд зүйлийг усанд хийж хөвсөн, живсэн тухай ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хөвж байна уу?
- Живж байна уу?

УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Шинэ үг: Усны хоолой, урт, богино

Үйл ажиллагаа 1: Усны өдөр (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн

Аргачлал: Багш хүүхдүүдээс усыг өдөр тутамдаа хэрхэн хэрэглэдэг тухай асууна. Хүүхдүүд өглөө сэрээд юу хийдэг тухай ярилцана. “Би өглөө нүүрээ угаасан”, “Би шүдээ угаалаа” гэх мэт энгийн өгүүлбэрээр ярилцана. Мөн хүүхэд зурагт үзүүлэнг хараад “Би өглөө ус уусан”, “Орой усанд орсон” гэх мэт өгүүлбэр хэлнэ. Усыг хэрэглэхдээ ариг гамтай хэрэглэж байх тухай хэлж сануулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өглөө сэрээд гараа угаадаг уу?
- Бид усаар юу хийдэг вэ?

Үйл ажиллагаа 2. Тоглоомоо угаагаарай (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэддэй, хуванцар, зөөлөн тоглоомууд, жижиг усны сав, алчуур, саван, хормогч, ханцуйвч.

Аргачлал: Хүүхдүүд тоглоомоо цэвэрлэж угаана. “Тоглоомоо угаах хэрэгтэй байна. Бидэнд юу хэрэгтэй вэ?” гэж асууж, хүүхдүүд хэрэгтэй зүйлээ сонгож цуглуулна. Багш зааварчилгаа өгч, хүүхэд тоглоом угаах, алчуураар арчих, хувцаслах зэрэг ариун цэврийн үйлдлийг хамтран хийнэ. Тоглоомын явцад “Тоглоомоо яагаад угаах хэрэгтэй вэ? Чи юу гэж бодож байна?”, “Одоо юу хийх вэ?” гэх мэт энгийн асуулт асууж, хүүхдийг хариулах, өөрөө асуулт тавьж харилцан ярилцаад урамшуулна.

Үйл ажиллагаа 3. Усаа хэмнээрэй (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэнгүүд

Аргачлал: Гар нүүрээ угаах, шүдээ угаах үед усаа хэрхэн хэмнэх тухай зурагт үзүүлэнгээр тайлбарлан, өдөр тутамдаа хэрэгжүүлнэ. Шүдээ угаахдаа аягатай ус хэрэглэх, гараа угаахдаа усаа бага гоожуулах, гараа савандаж хөөсрүүлсний дараа түр усаа хааж байх, зэрэг энгийн үйлдлүүдийг зургаар тайлбарлан үзүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Шүдээ угаахдаа ус нээлттэй байлгах зөв үү?
- Шүдээ угаахдаа аягатай ус хэрэглэгдэг үү?

5 дугаар сарын II хоног

БҮТЭЭЛЧ ХҮҮХДҮҮД

Шинэ үг: давс, бийр

Үйл ажиллагаа 1. Өнгөт ус (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ус, ундааны сав, гуаш, зургийн дэвтэр, бийр.

Аргачлал: Хүүхдүүдэд ундааны саван ус хийж, тагны дотор хэсэгт өнгө өнгийн гуаш түрхэж өгнө. Хүүхдүүд ундааны савыг сэгсрэн өнгө оруулж тоглоно. “Ус цэнхэр боллоо”, “Би улаан өнгө хийлээ” гэх мэт өөрийн хийсэн зүйлийг ярина. Багш зөвхөн чиглүүлж, хүүхдийг бие даан туршилт хийж өнгө үүсгэхийг дэмжинэ. Дараа нь зургийн дэвтэртээ гуаш болон бийрээр “Далайн амьтад” сэдэвт зураг зурна.

Ус өнгөтэй байна уу? өнгөгүй байна уу?

Чиний ус ямар өнгөтэй болсон байна вэ?

Үйл ажиллагаа 2. Далайн орчин бүтээцгээе (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн:

- Усны орчны зурагт ном (загас, нугас, усан ургамал, сав, хог гэх мэт)
- Зурган цаас, усны орчны дүрс бүхий хэвлэмэл зураг
- Улаан, шар, хөх зэрэг үндсэн өнгийн будгууд
- Тоглоомын сав, ус хэмнэх тэмдэгтэй сав

Аргачлал:

Зураг, урлал төв - Хүүхдүүд зурагт үзүүлэн хамтдаа ажиглаж, “Энэ загас байна”, “Энэ усны ургамал” гэх мэтээр ялган нэрлэнэ. Хүүхэд өөрийн усны орчныг зурж, үндсэн өнгөөр бие даан будна. Жишээ нь: “Усыг хөх өнгөөр будна”, “Загасыг шар өнгөөр зурна” гэх мэт Хэл ярианы төв - “Загас усанд амьдардаг”, “Муур ус уудаг”, “Би усаар нүүрээ угаалаа”, “Эгч цэцэг услав” гэх мэтээр хамаарлыг ойлгож зурагт картаар тоглож өгүүлбэр бүтээнэ.

Математикийн төв - Хүүхдүүд олон төрлийн сав болон халбагаар ус хэмжиж аль нь их, бага байгааг олно.

Байгалийн төв - Ургамал, болон амьтдыг услах, хооллох, цэвэрлэх зэрэг ажлыг багшийн тусламжтай хамтран гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 3. Усны тухай ном (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Усны тухай зурагт номууд, үзүүлэн тараах материал, бяцхан номын бэлдэц цаас, усны зөв хэрэглээний тухай жижиг зургууд, цавуу

Аргачлал: Багш хүүхдүүдэд далай болон усны тухай ном уншиж, үйл явдлын тухай харилцан ярилцана. Дараа нь хүүхдүүд бяцхан номын бэлдэц ашиглан усны тухай ном бүтээнэ. Хүүхдүүд бяцхан ном хийхдээ усны зөв хэрэглээний тухай зурагт хуудсаас сонгон номын хуудсандаа наана. Мөн өөрөө нэмж зурж, дүрслэн чимэглэж болно.

УСААР ТОГЛОЁ

Шинэ үг: дэс дараалал

Үйл ажиллагаа 1: Хуурай ба нойтон (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн:

Аргачлал: Хүүхэд амьтад болон эд зүйлсийг усны савны дотор эсвэл гадна байрлуулж тоглоно. Багш “Загас хаана байна вэ?”, “Нугас усны гадна байна уу?” гэх мэтээр асууж, хүүхдийг байршлыг нэрлэхэд дэмжинэ. Хүүхэд “Загас усны дотор байна”, “Нугас савны гадна байна” гэх мэтээр ярилцана. Дараа нь тоглоомуудаа өөрийнхөө урд байрлуулж тавиад нүдээ чанга аньж тоглоомоо нэг нэгээр нь тэмтэрч мэдрээд ямар нэртэй тоглоом болох нойтон эсвэл хуурай аль нь байгааг хэлж тоглоно.

Үйл ажиллагаа 2. Усны кафе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Тоглоомын аяга, халбага, усны сав, ширээ, алчуур, хураах тавиур
Аргачлал Хүүхэд “Усны кафе”-д зочин эсвэл үйлчлэгч болж тоглоно. Усыг аяганд хийж аягална. Ус асгасан бол алчуураар арчиж цэвэрлэнэ. Ус уух, аягаа барих, хоолны хэрэгслээ зөв хэрэглэж, тоглоом дуусмагц хураах үйлдлийг хийнэ. Багш “Аягаа хаана тавих вэ?”, “Халбагаа хураах уу?” гэх мэтээр чиглүүлнэ. Хүүхэд “Аягаа хураалаа”, “Халбагаа тавиур дээр тавилаа” гэх мэтээр энгийн өгүүлбэр хэлж, тоглоомд бие даан оролцоно.

Үйл ажиллагаа 3. Усны дэлгүүр сэдэвт тоглоом (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Усны сав, хөөс, алчуур, тоглоомын мөнгө, жижиг лангуу.

Аргачлал: Хүүхдүүд “Усны дэлгүүрийн худалдагч” эсвэл “хэрэглэгч” болж тоглоно. Хэрэглэгч дэлгүүрт очоод худалдагчид хандан “Ус авъя” гэж хэлнэ. Худалдагч “Та юунд хэрэглэх вэ?” гэж асууна. Хэрэглэгч өөрийн хийх гэж байгаа зүйлээ хэлээд хэрэгтэй зүйлүүдээ худалдаж авна. Жишээ нь: Хоол хийх бол ус, хүнсний ногоо мах зэрэг зүйлүүд, Жимсний шүүс хийх бол ус, жимс жимсгэнэ, хэрвээ усанд орох гэж байгаа бол ус, саван, алчуур, шампунь авах гэх мэт өөрсдөө найруулан тоглоно.

УСАН ДЭЭГҮҮР ҮСЭРЦГЭЭ

Шинэ үг: Усны дусал

Үйл ажиллагаа 1. Үсрээрэй (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Ус, ус зөөх сав, усны гутал, элсний тоглоомууд, хэв гаргах тоглоомууд

Аргачлал: Зугаалгын цагаар гадаа талбайд ус асгаж бэлтгэсэн байна.

- Цаг агаарын байдлыг ажиглаж ярилцана. Мөн тоглоомын талбайд юу өөрчлөгдсөн байгаа талаар асуултуудын дагуу ярилцана.

- Талбайн устай хэсгүүдэд “Усанд битгий гишгээрэй” гэж хэлээд усны дээгүүр үсэрч тоглоно. Хүүхдүүд өөрөө бие даан оролцоно.

- Жижиг саваар ус зөөж ойр байгаа моднуудыг усална.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Цаг агаар ямар байна вэ? Дулаан байна уу? Хүйтэн байна уу?
- Тэнгэр ямар байна вэ? ажиглаарай.
- Өглөө цэцэрлэгтэй ирэхэд ус байсан болов уу? Ус хэрхэн бий болсон бэ?

Үйл ажиллагаа 2. Усны баатар (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэнгүүд, хүүхэд бүрд зөв, буруу тэмдэгтэй өргөдөг карт, усны баатар гэсэн энгэрийн тэмдэг

Аргачлал: Багш усны зөв хэрэглээ болон хориглох зүйлийн тухай зурагт үзүүлэнг харуулж асуулт асууна. Хүүхдүүд зургийг тайлбарлаад зөв эсвэл буруу аль болохыг зурагт картаа өргөж илэрхийлнэ. Бүх зургуудыг тайлбарлаж ярилцсаны дараа хүүхдүүдэд усны баатар тэмдэг гардуулж усаа хайрлан гамнаж байхыг уриална.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Энэ юуны зураг вэ?
- Зөв үйлдэл үү? Буруу үйлдэл үү?

Сонсьё, дэмжье/ Туслалцаа

- Хүүхэд аливаа зүйлийг хүрэлцэхүй болон сонсголоор таньж мэддэг тул сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн нь хурц үзүүр, ирмэггүй байхад анхаарна.
- Тэмтрэх, мэдрэх, хүрэлцэх боломжийг дэмжсэн барзгар гадаргуутай наадгай, хэрэгслийн тусламжтайгаар дэмжинэ.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

- Эцэг эх хүүхэдтэйгээ хамт зурагт ном үзэх, гол дүрийн талаар ярилцах
- Хүүхдэд тохирсон шүдний оо, сойзыг бэлтгэх, ариун цэвэр сахих үйлийг үлгэрлэх, дагуулж хийлгэх
- Хүүхдээ сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд урамшуулж, ангидаа хэнтэй юу хийж тоглосон тухайгаа нээлттэй ярихад чиглүүлэх

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

Албан хэрэгжээнд

